

БУРХАН МИНЬ, ТА ХААНА БАЙНА?!

ЦӨЛ ДУНД
ЗОРИЛГОЙ
БӨГӨӨД ХҮЧТЭЙ БАЙХ



ЖОН БИВЭР

БУРХАН МИНЬ, ТА ХААНА БАЙНА?!
СУРГАЛТЫН DVD



Эрхэм анд минь,

Хүнд бэрх үе, сорилтой тулгарахад Бурханы амлалтаас харцаа салгах амархан. Амьдралын улирал бүрт, ангамал цөл шиг амьдрал дунд ч Бурханы зорилго оршин байдгийг сануулан урамшуулах гэж энэ номыг бичлээ.

Ангамал цөл шиг улиралд л Бурхан зүрхийг зөөлөж, зан чанарыг маань шилмэл сайн болгохдоо зорьж очих ёстой Өөрийнх нь аугаа төлөвлөгөөндөө бэлтгэж байдаг юм. Бурхан чимээгүй болж, оршихуй нь хол, та бид хаягдчихсан юм шиг мэдэрдэг тэр үед ч Бурхан бидний дотор хийх ёстой ажлаа хийсээр л байдаг. Цөлийн амьдралыг амжилттай даван туулсаны дараа Бурхан хэрхэн өргөмжилдөгийг энэ номын хуудас бүрээс та уншина.

Энэ номыг танд бэлэглэж байгаа юм шүү. Номоос сурсан бүхнээ урам хэрэгтэй нэгэнтэй өгөөмрөөр хуваалцаарай. Бусад хэрэгтэй материалаа CloudLibrary.org гэсэн цахим хуудаснаас татаж авах боломжтойг сануулья.

Цөлийн амьдралыг Түүний хүч чадал, эрх мэдэлтэйгээр даван гарч, Бурханы дуу хоолойг тодорхой сонсдог, илүү нигүүлсэнгүй хүн болоосой гэж таны төлөө залбирч байна. Алтыг галаар цэвэршүүлдэгийн адил энэхүү цэвэршүүлэх цаг хугацаа та биднийг шижир алт болгох болтугай.

Түүний амлалтыг урдаа барьж, замаа сайн дуусгаарай!

Ерөөгдөгтүн!

Жон



CloudLibrary.org

Жон Бивэр
JohnBevere@gmail.com



MESSENGER
INTERNATIONAL
MessengerInternational.org



БУРХАН МИНЬ, ТА ХААНА БАЙНА?!

**ЦӨЛ ДУНД
ЗОРИЛГОТОЙ
БӨГӨӨД ХҮЧТЭЙ БАЙХ**

БУРХАН МИНЬ, ТА ХААНА БАЙНА?!

ЦӨЛ ДУНД
ЗОРИЛГОТОЙ
БӨГӨӨД ХҮЧТЭЙ БАЙХ



ЖОН БИВЭР

God, Where Are You?! Mongolian by John P. Bevere
MessengerInternational.org

Originally published in English as *God, Where Are You?!*
A previous version of this title was published in 1992 under the title:
Victory in the Wilderness.
This updated version offers new and revised content from the author.

© 2019 Messenger International

Additional resources in Mongolian by John and Lisa Bevere are available for free
download at: CloudLibrary.org

To contact the author: JohnBevere@ymail.com
This book is a gift from Messenger International and is NOT FOR SALE

Printed in Mongolia

Бурхан минь, Та хаана байна?! Жон П. Бивэр
MessengerInternational.org

Англи нэр: *God, Where Are You?!*
Анх 1992 онд: *Victory in the Wilderness* нэрээр хэвлэгдэж байсан.
Энэхүү хэвлэл нь агуулга нэмж, шинэчлэн найруулсан хувилбар болно.

© 2019 Messenger International

Жон, Лиза Бивэрийн Монгол болоод бусад хэл дээрх материалыг дараах цахим
хуудаснаас үнэ төлбөргүй татаж авах боломжтой: CloudLibrary.org

Зохиолчтой холбогдох имэйл: JohnBevere@ymail.com
Монгол хэл дээрх энэхүү номыг Мессенжер Интернэйшнэл байгууллагаас
Монголчуудад бэлэглэж байгаа бөгөөд ХУДАЛДАХЫГ ХАТУУ ХОРИГЛОНО.

Монгол улсад хэвлэв

АГУУЛГА

Өмнөх үг	9
Танилцуулга	11
1 “Та хаана байна вэ?”	15
2 Сайн хамтрагч	25
3 Цөл зайлшгүй хэрэгтэйн учир	35
4 Харилцаа	45
5 Шинэ дарс	57
6 Тэнгэрийн шагнал	71
7 Бурханы өндөр хурдны зам	81
8 Сайтар барьж байгуул	95
9 Хүчний бэлтгэл	109
10 Цөл дэх ус	121
11 Эзэний замыг бэлтгэ	133
12 Цөл дэх ялалт	147
Хэлэлцэх асуулт	163
Хавсралт	169

ӨМНӨХ ҮГ

Үнэхээр ЭЗЭН Сионыг тайвшруулж, хоосорсон газар бүхнийг нь тайтгаруулна. Зэлүүд талыг нь Еден шиг, цөлийг нь ЭЗЭНий цэцэрлэг мэт болгоно, Тэр. Тэндээс баясгалан, цэнгэл, талархал, дуу хуур олдох юм.

—Исаиа 51:3

Би Исаиа номд хайртай - Исаиа бол миний хайртай Хуучин гэрээний эш үзүүлэгч. Бурхан бидний цөлжсөн хэсгүүдийг амьдрал буцласан цэцэрлэг болгохыг хүсдэг болохыг Исаиагийн дүрслэл батлаж байна. Чухам цөлжсөн газрын хатсан хөрс л бидний өөрчлөлт, хувиралд амин үүрэг гүйцэтгэхийг Исаиагийн үгс илчилжээ. Хуучин юмсыг бүхлээр нь зайлуулсан нөхцөлд л айсуй юмсын илчлэл ирнэ. Аав маань биднийг энэ бэлтгэлийн улирлаар давуулж байж л, Амлалтын газарт оруулдаг.

Миний бие урам мохоох элсний нүүдэлд бариулангаа алдан, гутрал гунигийн цөлийг ханьтайгаа хөтлөлцөөд л туулсан. Хань минь: “Бурхан минь, Та хаана байна?” хэмээн залбирч, бодлогоширч, хашхирч байхыг нь би харсан.

Тэрбээр бид хаана алдаа гаргачихав хэмээн шөнө орой болтол гайхшран суудаг байсан сан. Буруу алхам хийчихэв үү эсвэл засч залруулж болохоор алдаа байна уу?

Өглөө бүр, нар мандахаас өмнө Жон энэ өдөр л цэлмэж, нөхцөл байдал өөрчлөгдөх байх хэмээн найдсандаа... хариулт хайн, Бурханыг сонсохоор явж, харин би түүнийг гэртээ эргэж иртэл нь босон суун хүлээдэг байсан сан. Аавыгаа эргэж ирэх үед нь хөвгүүд маань сэрчихсэн байдаг байв.

Би Жонд: “Бурхан юм хэлэв үү?” гэж шивэглэнэ.

Харин Жон толгой сэгсэрнэ. Зүрх маань гунигт автаж, найдвар маань бөхнө.

Бид галзуурчихсан байв уу? Бид ер нь Бурханыг сонссон юм болов уу? Бид яаж яваад ийм болчихов? Бурхан биднийг энэ хүртэл дагуулчихаад, яагаад ийм хоосрол дунд чив чимээгүй байна?

Тийм ээ, би цөлд зөндөө уйлсан.

Гэхдээ тэр үед би өнөөдөр мэдэж байгаа зүйлээ мэддэг байсан сан бол, тэр улирлыг хавьгүй хөнгөн зүрхээр итгэл дүүрэн туулахгүй юу. Өөрийгөө шинэчлэгдэн, бэлтгэгдэж байна гэдгээ мэдэхгүй юу.

Тиймээс би энэ номыг зүгээр нэг сайн гарын авлага гэхгүй, харин жинхэнэ бэлэг гэнэ. Цөлийн улиралдаа сайн суралц - тэгвэл дараагийн улиралдаа алзахгүй.

Чи ганцаараа биш шүү - зоригтой байгаарай.

Нью-Йорк Таймсын бестселлер зохиолч
Мессенжер Интернэйшнэл байгууллагын
үндэслэн байгуулагчдын нэг
Лиза Бивэр

ТАНИЛЦУУЛГА

Энэ ном нь миний болоод өөр олон хүний цөлийн аяллын түүх юм. Би хэрэг зоргодоо “хүрчихсэн” юмуу Бурханы надад зориулсан бүх юмыг олборлочихсон хүн биш. Тийм боловч эдгээр хуудсаас та Бурханы дотор буй хувь тавилангийнхаа төлөө давших урам зориг олж, хүчээ сэлбээсэй хэмээн залбирч байна.

Ном маань тус сэдвийг нэгт нэгэнгүй судлаад дүгнэчихсэн, төгөлдөршсөн бүтээл биш гэдгийг шууд хэлье. Энэ талаар олон зүйл бичиж болно. Гэхдээ би цөлийн улирлын хамгийн гол талуудыг хөндөн, чин зүрхнээсээ бичсэн юм шүү. Ном маань ердөө л таныг цөлтэй танилцуулж, цөл дундуур Ариун Сүнсний удирдамжийг мэдрэг дагахад сургах л зорилготой.

Түүнчлэн цөл гэж юу болох, юу биш болох - цөлийн зорилго, ач тусын талаар өгүүлнэ. Жишээ, дүрслэл, зааврын үгээр минь дамжин та цөлийн улирлыг ухаалгаар туулж сурах болтугай.

Би та бүхэнд анхныхаа хоёр үйлчлэлийн талаар олон жишээ ярьж өгнө. Хамгийн анх би Техасын Даллас хотод пастортаа болоод чуулганыхаа зочдод дөрвөн жил хагас үйлчилсэн бөгөөд сүүлийнхээ жил хагас мөнөөх цөл гэдгийг нь анх үзэж билээ. Хоёр дахь цөл маань Флоридагийн чуулганд хоёр жил хагас залуусын пастораар үйлчилж байхад тохиосон бөгөөд хамгийн хачирхалтай нь бас л үйлчлэлийн маань сүүлийн жил хагас үргэлжилсэн байдаг юм. Тэр хатуу ширүүн цөлөөр туулахдаа би, Далласын цөл бараг л элсэн тасархай руу хийсэн зугаалга байж дээ гэж бодож билээ.

Амьдралд маань дахиад цөлийн улирал ирсэн үү? Ирсэн. Гэхдээ тэр үед би энэ бүхэн нь ямар утга учиртай болохыг сайн мэддэг болсон байлаа. Тиймээс “Бурхан минь, юу болоод байна

аа?” хэмээн ахин дахин уйлдгаа больсон байлаа. Юу болоод байгааг, үүнд хэрхэн хариу үйлдэхийг би өмнөх улирлуудаасаа сайтар сураад байв.

Би яг ийм улиралдаа яваа маш олон эрчүүд, эмэгтэйчүүдтэй ярилцаж явсан. Тэд яриан дундаа эргэлзээ, гутралын талаар байнга дурьддаг. Олонх нь юу болоод байгааг ойлгодоггүй. Үнэндээ Лиза, бид хоёр саяхан яг энэ сэдвээр хоёр подкаст хийсэн бөгөөд амьдралдаа хүлээж авч үзээгүй олон тооны хариу хүлээж авсан билээ. Энэ бүхэн нь намайг хамгийн анх бичиж байсан *Цөл дэхь ялалт* гэдэг номоо эргүүлж харахад хүргэв.

Миний гучаад жилийн тэртээ бичсэн ном л доо. Тэгээд номоо анхааралтай уншихдаа, ном маань 1980 оны сүүл, 1990 оны эхэн үед тохирсон эш үзүүллийн үг болохыг ухаарав. Тиймээс манай хянан тохиолдуулагч, бид хоёр тус номоос хэзээ ч үеэ өнгөрөөхгүй үнэнийг нь шүүвэрлэж аваад, дээрээс нь өнгөрсөн гучин жил хураасан ухаарлаа нэмээд, бүгдийг нь цоо шинээр дахин бичсэн юм. Тиймээс энэ маань хянан засварлагдсан ном бус, харин цоо шинэ ном гэж хэлж болно. Таны гарт байгаа ном энэ үеийн болоод ирэх цагийн хүмүүст цөлийн улиралд зүгээ алдахгүй явахад нь туслана гэдэгт итгэж байна.

Бидэнд “Тэнгэрийн доорх бүх зүйлд тогтоогдсон цаг, бүх явдалд хугацаа буй” (Номлогчийн үгс 3:1) гэсэн. Түүнчлэн амьдралд улирлууд гэж байдаг бөгөөд улирал бүр зорилготой. Зөв зүйтэй үйлдэхийн тулд улирал тус бүрийн зорилгыг мэдэх нь чухал. Цасны хувцастай хүн сноубордын хэрэгслээ аваад, кабель бүхээгээр уулын орой дээр гарснаа зог тусав. Яагаад? Яагаад гэвэл зун болчихсон учраас, цас байхгүй! Тэр хүний зугаа нь зун ямар ч ашиггүй, гагцхүү өвөл л зугаатай юм.

Энэхүү номоороо би цөл нь тайрч, бэхжүүлдэг амин чухал улирал болохыг л тайлбарлахыг зорьлоо. Ганц үгээр хэлбэл цөл нь бэлтгэлийн улирал юм. Би цөлийн талаар гол төлөв үйлчлэл дээр л хэрэгжүүлж ярина. Бид бүгдээрээ дуудагдсан - зарим нь зах зээлийн газар, зарим нь боловсролын талбарт, зарим нь эрүүл мэндийн салбарт, зарим нь засгийн газар, төрийн албанд гэх мэт. Би таван талт үйлчлэл хийх дуудлагатай учраас, голдуу энэ талуудыг л тусгаж ярих байх. Бурхан таныг ямар ч талбарт дуудсан байж болох ч, ерөнхий зарчим нь амьдралын бүх талбарт ялгаагүй жигд хэрэгжинэ. Зах зээлийн газарт байгаа хүмүүс нь Сайн мэдээний үйлчлэлд дуудагдсан хүмүүс шиг л дуудлагадаа бэлтгэх ёстой. Амьдралын бүх талбар дээр ийм л байдаг.

Өөр нэг чухал зүйл хэлмээр байна: Би “Аян замд аминд орох арга” нэртэй тэмдэглэл хэсэг дээрээ зарим нэг тустай санааг нэмж оруулсан байгаа. Тэдгээр нь цөлд өнгөрөөх цагаа аль болох ашиг, өгөөжтэй байлгахад чинь туслах зорилготой, бие даасан, зурвас санаанууд юм. Үүний тусламжтайгаар та цөлд байхдаа, над шиг улирлаа мэдэхгүйгээсээ болоод дэмий толгойгоо ганзагалж явах бус, харин ганцаараа хангах чадвартай Бурханыг улам ч урам зоригтой дагана гэдэгт ихэд найднам.

Мэхийн хүндэтгэсэн

Жон Бивэр

2019 оны 1-ээр сар

1

“ТА ХААНА БАЙНА ВЭ?”

Гангийн халууныг амар тайвнаар даван туулахдаа, бид Бурханд хайртайгаа гэрчилдэг бол, Бурхан бидэн дээр анхилам оршихуйгаараа айлчлахдаа бидэнд хайртайгаа гэрчилдэг юм.

— **Мадам Гүён / Жан-Мари Бувэр дэ ла Моттэ-Гүён**

Үзэгтүн, би урагш явдаг боловч Тэр алга, хойш явавч би Түүнийг ажиглаж чаддаггүй. Тэрээр зүүн талд ажиллахад би үзэж чаддаггүй. Тэрээр баруун тал уруу эргэхэд би Түүнийг харж чаддаггүй.

— **Иов 23:8-9**



Дотроо багтрав ч, учрыг нь эс олно.
 Болж бүтэж байгаа юм нэг ч алга.
 Ой зургаан сартай ууган хүүдээ хүртэл тэвчээр алдарна.
 Эхнэр рүүгээ хашхична.
 Пастортаа гонсойно.
 Хамт ажилладаг хүмүүстээ дургүй хүрнэ.
 Яг үнэнээ хэлбэл, магадгүй хамгийн гол нь Бурханд гомдож,
 уурлаж, гоншигнож байсан байх. “Та юугаа хийгээд байгаа юм бэ?”

“Та яагаад амьдралд маань хөдлөхгүй байгаа юм бэ?”

“Амлаад байсан бүрэн дүүрэн байдал чинь хаана байна?”

“Яагаад бүх юм ийм муухай байгаа юм бэ?”

“Та яагаад надтай ярихгүй байгаа юм бэ?”

“Та хаана байна?” гэдэг утгагүй гомдол амны маань уншлага болсон байлаа.

Танд ч бас Эзэний нэрийг шивнэхийн *даруйд л* Эзэн хүрч ирээд, *тэр даруй хариулах* тохиолдол байсан л байх.

Гэтэл заримдаа ахин дахин мессеж явуулаад байхад ч ямар ч хариу ирдэггүй үе бий. Яг л Бурхан хаяад явчихсан гэлтэй. Магадгүй та яг одоо ийм нөхцөлд байж мэдэх. “Бурхан минь, Та хаана байна?!” гэдэг үгийг тас харанхуй руу бархирмаар байгаа байх.

Би ч бас цөлд байж үзсэн. Гэхдээ би үүнийгээ мэдээгүй юм. Тэр үед би Техасын Далласт амьдарч байсан бөгөөд өөрийгөө Есүст хаягдсан Түүний үнэнч дагалдагч л гэж бодож байв. Тэр бол шинэхэн итгэгч миний анхны цөлийн зогсоол байсан юм.

Үүнээс өмнө Эзэн рүү хашхирахын төдийд л Эзэн хариулдаг байлаа. Тэрбээр миний хамгийн өчүүхэн хүсэлтэд ч шууд л хариулна. Түүний оршихуй дэргэд бөгөөд дэндүү баталгаатай, дэндүү хүчтэй байдаг байлаа. Гэтэл одоо юу болоод байгааг би яаж ч ухаад, ойлгохгүй байв. Би өдөр бүр өвдгөө зулгарч,

тэнхээгээ тасартал: “Бурхан минь, юу болоод байна аа? Та надаас сая бээрийн газар орших шиг л” хэмээн сөгдөн хашхирна.

Би амьдралаа ахин дахин гүйлгээд: “Би ямар гээчийн аймшигтай нүгэл үйлдчихсэн юм бол?” гэж асууна.

Мэдээж би хүн шиг л үе үе нүгэлд уначихдаг боловч, тэр даруй гэмшин, Есүсийн санал болгодог уучлалыг гуйдаг байв. Миний л мэдэхийн амьдралд маань санаатайгаар хийдэг, дадал болсон нүгэл байсангүй.

Би: “Бурхан минь, Та яагаад надтай ярихаа больчив?” гэсээр, эцэсгүй үргэлжлэх гангийн халуунд хатсаар.

Мэдээж би Библийн аугаа баатар Иовын дэргэд чигчийн чинээ амьтан боловч, үг үйлдэл маань түүнийхтэй л адил байлаа. Иовын нөгөө сүрхий үгсийг одоо л ухаарах шиг. Зарим үг нь миний цөллөг мэт амьдралыг л хэлээд байх шиг:

Үзэгтүн, би урагш явдаг боловч Тэр алга, хойш явавч би Түүнийг ажиглаж чаддаггүй. Тэрээр зүүн талд ажиллахад би үзэж чаддаггүй. Тэрээр баруун тал уруу эргэхэд би Түүнийг харж чаддаггүй. (Иов 23:8-9)

Би залбирсаар байвч, тэнгэр гууль шиг л байв.

Тэгтэл Эзэн надад Христэд итгэх итгэлийн амьдрал нь зүйрлэбээс хүүхдийн бойжилт төлөвшилтэй зэрэгцээ болохыг харуулав. Би сүнсний нярай байсан бол, эдүгээ дараагийн төвшин рүүгээ дэвшиж байгаа ажээ. Тухайн үед нүдэн дээр маань амьд жишээ байж л байлаа. Аддисон маань ой зургаан сартай байв. Лиза мундаг ээж байсан тул Аддисоныг уйлагнахын төдийд л харайж очоод халамжилна. Нүд ирмэхийн зуур хүү маань ээжийнхээ тэвэрт мөөмөө идэн, аюулгүй байдалд баясан тайтгарна.

Аддисон бусад жаалуудын л нэгэн адил өсч бойжиж байв. Дөрвөн хүү маань дөрвүүлээ хоолоо идэж сурсныг санаж байна. Ёстой аймаар юм болно! Талыг нь аман дээрээ, талыг нь ширээ, сандал, шалан дээр нялж өгнө.

Аав, ээж нь урьдынх шигээ ам руу нь халбагадаад өгөхгүй байгаад хүүхэд бухимддаг ч гэсэн, ингэснээрээ бид хоёр хариуцлагатай аав, ээж болж байгаа юм. Хөвгүүд маань хоолоо талаар нэг тараахад нь бид хоёр хажуугаас нь үсэрч ороод, бүгдийг нь хийгээд өгчихмөөр санагдав ч, арван наймтай болтол нь хоолыг нь халбагадаж өгөх гээгүй л юм бол, ингэх нь тэдэнд тусгүй гэдгийг бид мэднэ!

Хүүхэд өсөхөд тэдний өсөлт хөгжлийг дэмжих дэргэдийн тусламжийн төвшин ч өөрчлөгдөнө. Бурхан ч биднийг хөгжүүлж, сүнсээр төлөвшүүлэхийн тулд яг ийм зүйл хийдэг. Биднийг дахин төрсөн нярай болж, Бурханы Сүнсээр дүүрэх үед Бурхан биднийг уйлагнахын даруйд л дээгүүр маань тойрон эргэлддэг. Гэтэл цаг хугацаа өнгөрч, бид сүүнээс гарах ёстой (Еврей 5:12). Бурхан биднийг сүнсээр өсгөж төлөвшүүлэхийн тулд уйлаан болгонд маань хариулалгүй, бэрх цагаар туулж гарахыг зөвшөөрнө.

Хүүхэд болгон том хүн болдог үйл явц шиг сүнсээр өсч төлөвших нь байх л ёстой үйл явц гэдгийг Эзэн надад ойлгуулсны дараа би элдвийг эргэцүүлдэг болов: *“Би буруу байв уу? Миний туулж байгаа энэ зам Эзэнээс ирсэн шийтгэл юм болов уу? Намайг Есүсийг дагаж, үйлчлэх дайтай болгож өсгөн боловсруулах гэж цөлөөр дагуулж байгаа юм болов уу?”*

Тэгтэл гэнэт Есүст яг ийм явдал тохиосныг санав. Есүс Иохан Баптистаар баптисм хийлгүүлж, Аавдаа магтуулсныхаа дараа шууд Ариун Сүнсээр хөтлүүлэн цөл рүү явсан байдаг. Есүс ял зэмлэл хүлээгээгүй - мэдээж ямар ч гэм нүгэл үйлдээгүй.

Тэгтэл нэг удаа ээлжит уур цухал, гомдлын “үзэгдлийн” үеэр надад: *“Магадгүй, энэ цөл миний бодоод байгаа шиг аймшиг биш ч юм билүү?”* гэсэн бодол орж ирэв.

Цөлийн талаарх үзэл бодол

Хэрэв бид Есүс шиг байх гэвэл, зан чанар маань хөгжих ёстой. Гэтэл Бурхан энэ сургалтыг чухам цөлд хийхээр шийджээ. Цөлд байхад ер нь Бурхан Өөрөө алс хол, амлалт нь хоосон санагддаг. Гэхдээ энэ нь бодит байдал бус, зөвхөн мэдрэмж юм. Үнэндээ “Тэр Өөрөө “Би чамайг хэзээ ч орхихгүй мөн чамайг хаяхгүй” гэж айлдсан” (Еврей 13:5) билээ.

Цөлд бид нэгэнтээ багтай санагдаж байсан Бурханы амлалт үг, мөрөөдлөөс эсрэг зүг яваад байгаа юм шиг санагддаг. Цөлд сүнслэг өсөлт хөгжлийг нэг ч мэдрэхгүй. Үнэндээ бүр ухарч буураад байх шиг л санагдана. Бурханы оршихуй тодорч томрох бус, харин ч бүр бүдгэрч жижгэрнэ. Үүгээр тогтохгүй танд хэн ч хайргүй, таныг хэн ч тоохгүй байгаа юм шиг санагдана. Гэхдээ тийм биш юм.

Үнэндээ цөл нь Христийн жинхэнэ дагалдагч нарын тогтмол зогсоол билээ. Мэдээж та цөлөөр урт, богино хугацаанд дайраад гарахдаа маш их ганцаардана. Гэтэл Есүсийн эрүүл саруул өсөлт

хөгжилтэй дагалдагч болохын тулд та цөлөөр хэдэн ч удаа туулах боломжтой.

Тэр хувхай газар Гүүгл газрын зургийг ашиглан товч зам, дөт арга хэрэглээрэй гэж зөвлөмөөр байв ч, харамсалтай нь тийм юм байдаггүй юм. Байхгүй нь ч сайн. Учир нь амлагдсан газартаа очмоор байгаа л бол, цөлийн аяллыг - энэ цаг, улирлыг хүлээн авахаас өөр аргагүй.

Цөл гэж яг юу вэ?

Гэхдээ л ихэнх хүмүүс ус ч үгүй, нөмөр ч үгүй жинхэнэ хатмал, хувхай цөлд биеэр очиж тарчлах шаардлагагүй нь сайхан юм даа. Цөлд өдрийн халуунд хатаж, шөнийн хүйтэнд хөхөрч, өлсөж цангаж, ганцаардана. Дээрээс нь төөрөөд, аврагдах замаа олохгүй. Бид ийм байдлыг биеэр үзээгүй байж болох ч, сүнсний цөл нь яг л ийм мэдрэмж төрүүлдэг юм. Энэ номоороо би өөрийнхөө цөлд өнгөрөөсөн амьдралын гол, гол түүхээс хуваалцана - ийм түүх надад цөөнгүй бөгөөд аль нь ч зугаа цэнгэл шиг байгаагүй!

Тийм боловч цөл нь Бурханыг чин үнэнээр дагах гэж байгаа хүнд заавал ч үгүй сөрөг муухай цаг хугацаа байх албагүй. Энэ бол сайхан мэдээ. Хэт халилтай сонсогдож байж болох. Гэхдээ цөл нь биднийг сургаж, цэвэрлэж, хүчжүүлж, илүү их үр жимстэй болгодог Ариун Сүнсний шинэ хөдөлгөөнд бэлтгэх туйлаас эерэг зорилготой газар юм.

Олон хүн цөлд нэвтрэхдээ, цочирдож, буруу зөрүү юм хийж эхлэдэг. Учрыг нь мэдээгүй байж буруу хайгуул, буруу үйлдэл хийнэ. Жишээлбэл урьдын адил амьдралд нь аз жаргал авчирч, хуучны сайхан юмсыг нь сэргээх байх гэж найдсандаа ажлаа юмуу чуулганаа солих гэх мэт огцом өөрчлөлт хийж болох. Ганц бие хүмүүсийн хувьд зовиуртай салалтын дараа дахин шинэ харилцаа эхлүүлж болох.

Та Бурхан яагаад таныг тэр хуурай ангамал нөхцөлд оруулсныг ойлгохоосоо өмнө зугтах зам хайж байгаа бол, цөлийнхөө хугацааг санаандгүйгээр уртасгана л гэсэн үг. Үүнээсээ болоод өөртөө бүр их зовлон, гутрал, тэгээд магадгүй ялагдал авчирч болзошгүй. Учир нь та Бурхан танд ямар нэгэн шалтгаанаар зориуд энэ улирал, газрыг зөвшөөрснийг ойлгохгүй байна.

Израилийн хүүхдүүд дөчин жил цөлд байхдаа яг ийм алдаа гаргасан билээ. Үүнийг ойлгоогүйгээсээ болоод бүхэл бүтэн нэг

үеийнхэн Амлагдсан газарт орж чадаагүй юм. Юутай гашуун түүх! Бурхан тэднийг тэнгэрийн амлалтад хүргэж, шинэ гэрээг эзлэх хүчирхэг дайчид болгохын төлөө шалгаж, сургаж, бэлтгэх зорилгоор л цөлд авчиржээ. Гэтэл Израилийн хүүхдүүд цөлийг шийтгэл хэмээн андуу ойлгоод, зогсоо зайгүй гоншигнож, гомдоллож, тачаадсан юм.

Хожим цөлөөс гарч, Амлагдсан газрыг байлдан дагуулах цаг нь болоход, хүмүүс арван туршуулын авчирсан муу мэдээнд итгэн гонгинолдон гомдоллосон. Нэг бол Бурханы амлалт, чадварт итгэх, нөгөө бол хүний үзэл бодол, мөхөс чанарт итгэхийн аль нэгийг нь сонгох ёстой болоход, тэд Бурханд бус, хүмүүст итгэхийг сонгожээ. Тэд сүү балаар халгисан нутгаа эзлэж чадахгүй гэдэг худалд итгэн, ялагдал хүлээжээ. Тэд Бурханы мөн чанар, зан чанарыг хайхраагүй учраас, өөдгүй муугаар үйлджээ.

Тиймээс Бурхан олон ч удаа: “За за, дураараа л бол!” хэмээхэд хүрсэн билээ. Уг нь тэд цөлөөр дөнгөж дайраад л гарах ёстой байсан ч, үүнээсээ болоод насаараа үлджээ.

Аймшигтай! Та, бид хоёр ийм шийдвэр гаргаж, ингэж төгсөхийг хэзээ ч хүсэхгүй! Тийм боловч элч Паул: “Энэ бүхэн жишээ болон тэдэнд тохиолдсон бөгөөд үүнийг үеийн төгсгөл тохиож буй бидэнд сануулга болгон бичжээ” (1Коринт 10:11) гэж хэлсэнчлэн, бид Израилийн алдаанаас суралцах ёстой.

Цөлийн сургууль эхэлснийг таниад сурчихбал, шүдээ хавиран, гомдоллож суухын оронд энэ цөлийн цаана шинэ төлөвшил, хүч, ерөөл, боломж, амлалт биелдэг “Амлагдсан газар” хүлээж байгаад талархах болно. Ийм хандлага л бэрх цагийг хөнгөлөх бус уу? Тэр цагт л бид Иаков шиг:

“Ах дүү нар минь, элдвийн сорилтод орохдоо үүнийг бүрэн баяр хөөр гэж үз. ...Хатуужил нь төгс үйл байг. Тэгвэл та нар төгс, бүтэн юугаар ч дутахгүй байна. (Иаков 1:2,4) гэж хэлж чадна.

Цөлийн сургууль нь “би буруу хэрэг хийчихжээ” гэсэн үг үү?

Сайн асуулт байна!

Ихэнх хүн цөлд байхдаа: “Би ямар буруу хэрэг хийсэн бэ? Би

Бурханы дургүйг хүргэчихэв үү?” гэж асуудаг. Гэтэл энэ нь цөлийн зорилгыг төөрөгдүүлсэн асуулт юм.

Цөл нь Бурхан доторх хувь тавиландаа бэлтгэх цаг гэдгийг ойлгосон эрчүүд, эмэгтэйчүүд Библид ч, түүхэнд ч олон бий. Тиймээс цөл нь Бурханы няцаалтын бус, бэлтгэлийн газар юм.

Аян замд аминд орох арга

#1 Цагаа мэдэр

Дийлэнх хүмүүс цөлийг гайхдаг. Бурхан дэндүү сайн бөгөөд бид ч Бурханы ерөөл, оршихуй, амлалтуудыг дагаж өсдөг. Бид энэ сайхан үе өнгөрч, өөр цаг ирнэ гэдгийг огт хүлээдэггүй. Гэтэл нэг л өдөр юмс нэг л биш болоод явчихдаг. Тиймээс цочирдож балмагдахын оронд гэдрэг ухраад, эрүүл ухаанаар эргэцүүлэх хэрэгтэй. Юун дундуур туулж яваагаа ойлгох нь маш чухал. Яагаад гэвэл ямар улиралд байгаагаа мэдэхгүй бол, буруу хариу үйлдэл үзүүлнэ.

Яг л Флоридагийн өмнөд нутгаас Канадын умард нутаг руу нүүхтэй л адил. Өвөл болж, термометр хасах хэмийг заах үед хаана байгаагаа мэдэхгүй бол, тэсгим хүйтэнд дулаан хувцасгүй гараад явчихаж мэдэх!

Тэгвэл цөлийн хувьд ч ялгаагүй юм. „Цөл эхэллээ!” гэсэн замын тэмдгийг анзаарахгүй бол, сэтгэлээр навсайтлаа унаж, магадгүй бүр өндөр өртөгтэй алдаа ч гаргаж болох. Хуучин гэрээнд Иссахарын хөвгүүд: „цаг үеэ мэдэрч, Израиль юу хийх ёстойг мэдсэн тэдний хоёр зуун тэргүүн нь өөрсдийн бүх ах дүү нараа удирдан ирсэн байлаа” (1Шастир 12:32) гэсэн байдаг.

Цөлд яваагаа мэдбэл, юу хийхээ мэдэх л болно.

Тийм ээ, муу сонголтынхоо гороор хуурай цөл шиг амьдрал үзэх үе байдаг л даа. Үнэндээ бид Есүстэй усны дусал шиг адилхан болсон ч, зарим нүглээ нэг үйлдсээр л, алдаа гаргасаар л байдаг. Тиймээс ганц удаагийн маш муу шийдвэр юмуу эсвэл олон удаагийн онцгүй сонголт нь биднийг нүхэнд унагах боломжтой.

Гэхдээ хамгийн чухал нь: Бурхан бөгөөд Тэргүүн тахилч маань

хүн бидний мөхөс чанарыг ойлгодог, өршөөлт Нэгэн. Тиймээс өөрөө яваад орчихсон нүхнээсээ буюу цөлөөсөө гарахын тулд эхлээд хайрт Аав дээрээ очоод: “Аав аа, би ийм нүгэл хийчихлээ (нүглээ нэрлэ). Намайг өршөө. Би нүглээ гэмшиж, Таны нигүүлсээр өөрөөр амьдрах болно” гэж хэлэх хэрэгтэй.

Би юу хэлэх гээд байна вэ гэхээр - та өөрийнхөө муугаас болж цөлд гацсан байж болох ч, Эзэнтэйгээ эвлэрч, Түүний сургамжийг үг дуугүй хүлээн аваад, удахгүй цөлөөс гарна гэсэн найдвар тээн урагшаа яв. Магтаалч: “Цаг хугацаа минь Таны гарт байна” (Дуулал 31:15) гэсэн болохоор цаг хугацаа гагцхүү Бурханаас л хамаарах ажээ. Та цөлд байгаа бол, Бурхан хүссэн учраас л тэр. Гэтэл цөлөгдөөд байх буруу хэрэг хийгээгүй хүнд энэ бүхэн дэндүү гомдолтой санагддаг. Тэгвэл Бурхан цөлийг шийтгэл гэж үзддэггүй бас биднийг шийтгэх гэсэндээ бус, харин Есүстэй адилхан болгох гэсэндээ л цөлөөр явуулдгийг хэлж өгөхийн тулд л энэхүү номоо бичин суугаа маань энэ билээ.

Түүнчлэн Бурхан таныг Сатаны гарт тушаагаад, нэг мөр хаях гэсэндээ цөлд авчирдаггүй. Гэтлэлийн хоёрдугаар үеийн хүүхдүүд Амлагдсан газарт орох зөвшөөрлийг хүлээж авахаас өмнө Бурхан тэдэнд:

ЭЗЭН Бурхан чинь чамайг энэ дөчин жилийн турш цөлд удирдсан бүх л зам мөрийг дурсан сана. Энэ нь чиний зүрхэнд юу байсныг, тухайлбал тушаалыг нь дагах эсэхийг чинь мэдэхийн тулд мөн чамайг номхтгож, шалгаж сорихын тулд байсан юм (Дэд хууль 8:2) хэмээн сануулсан байдаг.

Тэгэхээр хэдийгээр Израильчууд талархалгүй, мунхаг авир, тэрслүү зангаараа холион бантан хутгаад, цөлд байх хугацаагаа сунгачихсан боловч, Бурхан энэ бүгдийг нь сайнаар эргүүлэхийг хүссэн! Бурхан дандаа л ингэдэг. Тиймээс ч би баясдаг! Та баясахгүй байна уу?

Буруу ойлгов оо - биднийг цөлд байлаа гээд Эзэн ажлаа зогсоохгүй. Эзэн Өөрөө л биднийг цөлөөр дагуулан гаргадаг шүү дээ. Түүнгүйгээр бид туулж гарч чадах ч үгүй. Цаашилбал цөл нь Бурхан биднийг дахин ашиглахыг хүсэх хүртлээ хадгалж байдаг агуулах биш юм. Халуун сэтгэлт Абу маань ингэж ажилладаггүй. Харин ч эсрэгээрээ - цөл нь Бурханы хүч чадлаа гайхуулан ажилладаг газар, цаг болой.

Та “Модыг ширтвэл, ойг олж харахгүй” гэдэг үгийг мэдэх байх.

Тэгвэл цөл ч бас тийм л байдаг. Цөлд байгаа хүн Бурханы ажил үйлсийг олж хардаггүй.

Цөл нь - ямар ч байсан Бурханыг дуулгавартай дагаж байгаа хүмүүсийн хувьд ялагдах газар яав ч биш! Энэ амин чухал үнэнийг чанга мэдэгдэх хэрэгтэй. Цөлд дөч хоног амралт ч үгүй, ер бусын илрэл ч үгүй, тайтгаруулж, урамшуулчих хань ч үгүй, өлсөж сульдсан Есүсийг Диавол дайрчээ. Есүс харин Диаволыг Эзнийг Үгээр ялсан! Цөл нь Бурханы хүүхдүүдийн ялагддаг цаг хугацаа бус, харин “Биднийг Христ дотор ямагт ялуулдаг бөгөөд Түүний тухай мэдлэгийн анхилуун үнэрийг хаа сайгүй биднээр түгээдэг Бурханд харин талархал нь байдаг” цаг (2Коринт 2:14).

Израильчууд цөлөөр нэвтрэхдээ, тус нутгийн улс үндэстнүүдийн эсэргүүцэлтэй тулсан. Эзэн Израильд өөдөөс нь тулалд гэсэн. Израилийн хүүхдүүд Аморичуудыг (Тооллого 21:21-25), Мидианчуудыг (Тооллого 31:33-35) ялсан. Хэрэв Бурхан Израилийг ялагдалд хүргэхийг хүссэн бол, юу гэж өөдөөс нь тулалд гэх билээ. Бурхан Израилийг ялагдуулах гэж цөлд авчраагүй ч, харамсалтай нь Израильчуудын дийлэнх хувь нь өөрсдөөсөө болоод Амлагдсан газартаа орж чадалгүй, үхэцгээсэн билээ. Бурхан үүнийг хүсээгүй. Израильчууд өөрсдөө л дуулгаваргүй зангийнхаа золгүй үр хөврөлийг үзжээ.

Энэ түүх танд цөл нь Бурханы дургүйцэл, шийтгэлийн газар биш гэдгийг ойлгуулна байх аа. Цөл нь Бурханд мартагдаж, хаягдсан хүмүүсийн очдог газар ч биш. Цөл нь бидний амаараа шороо үмхэж, ялагдлаа хүлээдэг газар ч биш!

Бурхан сайныг сэдсэн л байгаа!

Цөл нь тэмдэг, ерөөл, элбэг дүүрэл юмуу гайхамшгийг хайх цаг бус, харин таны дотор зан чанар, хүчийг бий болгодог Бурханы зурхийг хайх цаг.

Амьдралынхаа байр суурийг ойлгосон бол, амьдрал чинь үзэл бодлоор хэлбэршинэ. Тэр цагт та Бурханы хүрэлтийг нь мэдрэхгүй ч, мутрыг нь харна. Энэ үед таны Бурханыг хайрлах хайр “Бурхан надад юу өгөх вэ?” гэдэг хандлагаас “Бурхан надаас юу хүсч байна?” гэдэг хандлага руу дэвшин төлөвшинө.

Эртний ариунтан Иов гуньж гутарсандаа Бурхан чухам юу хийгээд байгааг мэдэх юм алга хэмээн халагласан талаар би өмнө ярьсан. Иов хаашаа ч харсан - Бурхан байсангүй! Иовын амьдрал

ийм дүгнэлтээр төгссөн бол, үнэхээр золгүй төгсөх байж. Гэтэл Иов долоон голтой байж, бууж өгөөгүй бөгөөд итгэл, найдварын үг хэлжээ:

Гэвч Тэр миний замыг мэддэг. Тэр намайг шалгасан бөгөөд би алт мэт урагш гарч ирнэ (Иов 23:10).

Гайхамшигтай ухаарал! Бурхан биднийг юунд хүргэх гээд байгааг бид ухаж ойлгож чадахгүй ч, Бурхан замаа мэднэ. Зүгээр л Бурханд итгэ. Учир нь элч Паул: “Та нарт сайн үйлийг эхлүүлсэн Тэрээр үүнийгээ Христ Есүсийн өдрийг хүртэл төгс болгоно гэдэгт би бат итгэж байна” (Филиппой 1:6) хэмээн бичсэн болой.

Энэ үнэн цөлд ч үнэн гэдгийг бид мэднэ.

2

САЙН ХАМТРАГЧ

Христэд итгэдэг хүмүүс дайсагналын хар хуйтай тулахдаа, дайснаас ч сүр хүчтэй босч ирж чадна. Тэд шуурганд нүдүүлэх тусам нуруулдан дүнхийх хүчирхэг бүдүүн мододтой адил юм.

—Билли Грахам

Есүс Ариун Сүнсээр дүүрч Иорданаас буцаж цөлд Сүнсээр хөтлөгдөн...

—Лук 4:1



За, цөлд тавтай морил! Юу нь ч баяртайгаар мэндчилдэг юм гэж үү? Хэдийгээр бид сүнсний цөлийг сайн сайхан гэж үздэггүй ч, хайрт Аав маань цөлийг ихэд чухалчилдаг бөгөөд та Түүний найдвартай гарт байна.

Та цөлийг итгэлийн аяллаар очиж үзээд байх газар биш гэж бодож байгаа бол, дахин нэг бодож үзэхийг хичээнгүйлэн захъя! Учир нь цөлд тэнд очиж, үнэ цэнэтэй цагийг өнгөрөөсөн үй олон ариунтны мөр бий - тэр бүү хэл Бурханы Хүүгийн Өөрийнх нь ч мөр буй.

Өөрөөр хэлбэл бид цөлд ганцаараа биш, харин сайн хамтрагч нарын дунд байна гэсэн үг.

Сайн хүний нэрийг худалдлаа гэх бий. Гэхдээ цөлийг давсан баатруудаар бахархахгүй байхын аргагүй.

Мэдээж би Библийн “дорнын бүх хүний дундаас тэрээр хамгийн агуу” (Иов 1:3) нь хэмээн сайшаасан Иовыг хэдийнээ дурьдсан. Иов хамаг юмаа алдсан - өмч хөрөнгө, үр хүүхэд, эрүүл мэнд, ханийхаа дэмжлэгийг. Цогт, зөвт Иовыг нөхөд нь битүү нүгэл үйлдэв хэмээн ялласан. Амьдралынхаа цөлд шар махтайгаа хатсан Иов адагтаа би хэзээ ч төрөөгүй байсан бол дээр байж гэхээс өөр үггүй болжээ.

Бурхан Ур нутгийн Абрахам гэдэг чинээлэг эрийг хамаг байдгаа орхиод, амлагдсан шинэ газрын эрэлд гарахыг дуудсан тэр л мөрөөр та алхална. Сарак ч хоцролгүй, мөр зэрэгцээд л алхсан! Тэдний амьдрал - аяллын дийлэнх хэсэг нь цөлд л өнгөрсөн.

Мосе ч цөлийг дотор гадаргүй мэддэг байсан. Тэрбээр Фараоны ордонд ханхүү шиг өссөн ч, Египет хүнийг алсныхаа дараа цөлд орогнон, дөчин жил хонь хариулсан бөгөөд чухам тэнд л Бурхан түүнд галт бутан дотор Өөрийгөө илчилсэн билээ:

Мосе хадам эцэг Мидианы тахилч Иетрогийнхоо хонин сүргийг хариулж байв. Тэрээр сүргийг цөлийн араар

тууж, Бурханы уул Хоробт хүрчээ. ЭЗЭНий тэнгэрэлч өргөст бутан дундаас галын дөлөн дунд түүнд үзэгдэв. Харэгтун, бутанд гал дүрэлзэж байсан боловч бут шатахгүй байгааг Мосе харлаа. Тэгээд Мосе —Бут яагаад шатахгүй байгаа энэ гайхамшигт үзэгдлийг очиж харъя байз гэлээ. Тэрээр харахаар эргэснийг ЭЗЭН үзсэн агаад бутан дундаас түүнийг Бурхан дуудан —Мосе! Мосе! гэсэнд тэрээр —Би энд байна гэж хэлэв. (Гэтлэл 3:1-4)

Дараа нь Мосе буцаж Египетэд очоод, хүмүүсээ Египетээс жолоодон, цөлийн зүг хөдлөв өө!

Цөлд та аавын амины ганц хүү байгаад, ах нарынхаа хорт явуулгаар нүхэнд хаягдаад, дараа нь Египетийг зорио хүмүүст боол болж зарагдсан Иосефтой учирна. Үүгээр барахгүй тэрбээр хожим хилс хэргээр шоронд орсон. Фараоны гянданд Бурхан Өөрийгөө Иосефт илчлэхэд, Иосеф талхчин, ордны хэрэг хамаарагч хоёрын зүүдийг тайлан хөрвүүлэхдээ, энэ нь хожим Фараонтны өөрийнх нь зүүдийг хөрвүүлэх үйл явдалд бэлтгэх үйл явц байсныг мэдээгүй.

Тэгээд мэдээж Давид хаантан байна. Самуел түүнийг дараагийн хаанаар зөгнөв үү үгүй юу Давид хээрээр гэр, хэцээр дэр хийж, агуйд хоног төөрүүлж, цөлд амь залгуулах маягаар л хааны сэнтийд бэлтгэгдэж эхлэсэн юм. Тэнд л Бурхан Давидад Өөрийгөө түүний Хоньчин, Хүч хат, Бамбай, Бат цайз нь болохоо илчилсэн бүлгээ.

Иохан Баптист бол аугаа эш үзүүлэгч гэдэг алдар нэрийг хүртсэн хүн - аав нь түүний талаар илчлэл - үзэгдэл үзсэнээ Иоханд хэлсэн. Гэтэл Бурхан Иоханд Өөрийгөө Библийн сургуулийн танхимд бус, чухам цөлд л илчилсэн бөгөөд эцэстээ Иохан Иүдеагийн цөлд амьтны арьсаар хувцаслан, шавьжаар хооллож амьдарсан билээ. Лук 3:2-3 дээр “Аннас болон Каиаф нар тэргүүн тахилч байх үед цөлд буй Захариагийн хүү Иоханд Бурханы үг ирэв. Тэрээр нүгэл уучлагдах гэмшлийн баптисмыг тунхаглан Иордан хавийн бүх нутгаар явлаа” гэдэг.

Арабын цөлд л Бурхан элч Паулд хожим Шинэ гэрээний ихэнхийг бүрдүүлсэн нууцуудаа илчилсэн бөгөөд элч маань

“Хүүгээ миний дотор илчилснээр Түүнийг би харийнхны дунд тунхагладаг юм. Тэр даруй би мах цустай хэнтэй ч зөвлөсөнгүй, Иерусалим уруу, надаас өмнө элч байсан тэр хүмүүс уруу ч

явсангүй, харин Арабт очоод, Дамаскт дахин нэг эргэж ирсэн” (Галат 1:16-17) хэмээн бичсэн билээ.

Элч Иохан *Есүс Христийн илчлэлийг* хүлээж авахдаа, хаана байлаа?

Есүс доторх зовлон зүдүүр, хаанчлал, тэвчээрийг хамтран хуваалцагч ба ах дүү чинь болох Иохан би Бурханы үг болон Есүсийн гэрчлэлээс болж Патм хэмээх арал дээр байлаа. (Илчлэл 1:9)

Патм арал нь цөлийн амьдралд яг тохирсон зэлүүд арал байжээ.

Тэгээд мэдээж хамгаас чухал нь олны өмнө Аавынхаа бөгөөд Ариун Сүнсний соёрхлыг хүлээн авсныхаа дараа тэнгэрийн удирдамжаар Сатаны шалгууртай нүүр тулахаар цөл рүү илгээгдсэн Есүс Эзэнтэн маань бидэнтэй хамт цөлд байна.

Бурхан дараах загвараар олонтаа ажиллахыг би ажигласан билээ: Бурхан бидэнд ирээдүйд биднээр дамжуулан хийх аугаа юмсаа харуулчихаад, дараа нь биднийг бэлтгэхээр шууд цөл рүү дагуулдаг.

Эзэн Есүс тэргүүтэй аугаа ариунтнуудад цөл хэрэгтэй байсан бол, өчүүхэн миний бие амар дөт замыг хичнээн хүсэв ч, надад цөл хэрэгтэй гэдэг санаанаас зайлахгүй юм даа. Цөл нь Бурхан биднийг

Аян замд аминд орох арга

#2 Ганцаардаж байв ч, Бурхан тантай хамт

Цөлд Бурхан ерөөсөө байхгүй юм шиг санагддаг. Түүгээр хамгийн их дутаж байхад, Тэр сая бээрийн газар байх шиг л.

Бурхан хоёр янзаар бидэнтэй хамт байдгийг ойлгох хэрэгтэй. Эхнийх нь „Би чамайг хэзээ ч орхихгүй мөн чамайг хаяхгүй” (Еврей 13:5) гэдэг Бичээс дээр суурилна. Энэ үг нь Бурханы газар сайгүй оршигч чанарыг илэрхийлнэ. Энэ талаар Давид хаан „Хэрэв би тэнгэр өөд очвол, Та тэнд, Хэрэв би Үхэгсдийн оронд ор дэрээ засвал, Харагтун, Та тэнд” (Дуулал 139:8) гэж хэлсэн байдаг. Та Бичээсийн үгд итгээд, Бурханд найдбал - юу ч мэдрэгдэж, юу ч болж байсан - Бурхан тантай хамт байна. Бурхан хамт байдгийн нөгөө нэг илрэл нь бидний итгэлийн амьдралын хамгийн

шалгадаг, номхруулдаг, хүчжүүлдэг, шинэтгэдэг газар юм. Тэнд л Бурхан бидний дотор бурханлаг зан чанарыг хэлбэршүүлдэг. Энэ нь ирээдүйн Бурханы хаанчлал доторх үр жимстэй ажлын бэлтгэл хөрс болдог.

Цөлийн хамгийн сайхан тал нь цөлд Бурхан Өөрийгөө цоо шинэ арга замаар илчилнэ! Эш үзүүлэгч Исаиа:

Үнэхээр ЭЗЭН Сионыг тайвшруулж, Хоосорсон газар бүхнийг нь тайтгаруулна. Зэлүүд талыг нь Еден шиг, Цөлийг нь ЭЗЭНий цэцэрлэг мэт болгоно, Тэр. Тэндээ баясгалан, цэнгэл, талархал, дуу хуур олох юм (Исаиа 51:3) хэмээн бичжээ.

Бурхан Еден цэцэрлэг дотор Адам, Ева хоёрт Өөрийгөө илчилж, тэдэнтэй нөхөрлөсөн.

Цөлд хүн Эзэнээр өлсөж цангадаг. Тиймээс Бурхан ухаан санаа нь цэгцэрсэн, өлөн хүнд Өөрийгөө илчлэхэд, тэрбээр амьдралын аахар шаахар юмсаас Бурхан руу эргэхдээ амархан байдаг. Тэгээд бидэнд хандсан Бурханы дуудлагад хариулахдаа, бид дээрх баатрууд шиг л болно. Цөлд л Эзэн Өөрийгөө цоо шинэ арга замаар илчилдэг. Исаиа 45:15 дээр “Израилийн Бурхан, Аврагч минь, Үнэхээр Та Өөрийгөө нууцалдаг Бурхан юм” (Исаиа 45:15)

дуртай хэсэг билээ. „Илчлэн харуулах” гэдэг нь үл харагдахаас харагдах руу, үл сонсогдохоос сонсогдох руу, үл мэдэгдэхээс мэдэгдэх рүү гаргаж ирнэ гэсэн үг юм. Энэ нь Бурхан Өөрийгөө бидний махан биеийн мэдэрхүйд бодитой болгох явдал юм. Бидний магтаал хүндэтгэл, хувийн залбирал, ууланд гарах зэрэг өдөр тутмын амьдралын үй олон үйл явдлаар дамжин өрнөж болох энэ учрал гайхалтай.

Тиймээс таныг цөлд сүнсээр өлсөж, цангаж байхад, Бурхан хүрч ирээд, Өөрийнхөө үзэсгэлэнтэй сайхан, хөвсөлзүүлэм оршихуйгаараа ерөөхгүй байгаа бол, тайвшраад, Бурханы „Би чамайг хэзээ ч орхихгүй мөн чамайг хаяхгүй” гэсэн амин чухал амлалтыг нь түшээрэй. Бурханы оршихуй мэдрэгдэхгүй үед Түүнийг алдаршуулан хүндэтгэж чадаж байгаа чинь л Бурханыг хайрлах жинхэнэ хайрыг чинь хамгаас чанга харуулна.

гэдэг. Бурхан Өөрөөр нь өлсөж цангадаг хүмүүст Өөртэй нь дотносохын жаргалыг эдлэх хүслийг нэмж өгдөг бол, Өөрөөр нь өлсөж цангаагүй хүмүүсээс Өөрийгөө нуудаг. Өөрт нь хэв нэг хандахыг хэнд ч Бурхан зөвшөөрөхгүй.

Бурханаар өлсөж цангах

Бурханыг үнэн голоосоо эрэн хайдаг хүмүүст Бурхан Өөрийгөө илчилнэ.

Бурхан Израилийн хүүхдүүдийг даруусгаж, өлсгөж цангаах гэсэндээ л цөлд аваачсан гэснийг санаж байна уу? Гэтэл тэд Иошуа шиг Эзэнээр өлсөхийн оронд Эзний тэднээс тайлж хаясан бохир юмсаар өлсөж эхлэсэн. Тиймээс ч Бурхан Өөрийгөө Мосед илчилсэн шигээ Израильчуудад илчлэхээр иртэл, Израильчууд Бурханаар огт өлсөөгүй байв. Өлсөх нь бүү хэл, үнэндээ бүр эсэргүүцсэн. Дэд хууль ном дээр:

Уул галаар дүрэлзэн шатаж байхад та нар харанхуйн дундаас гарах дуу хоолойг сонсон танай овгийн тэргүүнүүд, ахмадууд бүгдээрээ над уруу хүрч ирээд, “Бидний Бурхан ЭЗЭН бидэнд Өөрийнхөө сүр жавхлан, аугаа чадалаа үзүүллээ. Бид гал дотроос гарч байгаа Түүний дууг сонсоцгоолоо. Бурхан хүнтэй ярьж, тэр хүн нь амьд байгааг бид энэ өдөр үзлээ. Тэгэхээр бид одоо юунд үхэх ёстой юм бэ? Энэ их гал биднийг залгина. Хэрэв бид ЭЗЭН Бурханыхаа дууг цааш нь сонвол үхнэ. Галын дундаас амьд Бурханы айлдах дуу хоолойг сонсоод, бидэн шиг амьд үлдсэн махбодтой хүн хэн байна вэ? Та өөрөө очиж, манай Бурхан ЭЗЭНий айлдах бүхнийг сонсоод, ЭЗЭН Бурханыхаа танд айлдсан бүгдийг бидэнд хэлж өг. Бид үүнийг сонсоод даган мөрдье” гэжээ. (Дэд хууль 5:23-27)

Бурхан Өөрийгөө Мосед илчилсэн шигээ Израильчуудад дахин Өөрийгөө илчлэхийг хүстэл Израильчууд ухраад, Мосегоос: “Та өөрөө очиж, манай Бурхан ЭЗЭНий айлдах бүхнийг сонсоод, ЭЗЭН Бурханыхаа танд айлдсан бүгдийг бидэнд хэлж өг. Бид үүнийг сонсоод даган мөрдье” хэмээцгээжээ.

Хүмүүс Бурхантай биечлэн танилцалгүй, Түүний тухай л мэддэг байсан нь даанч харамсалтай. Тиймээс ч тэд Бурханы тушаасныг хэзээ ч хийж чадаагүй юм. Израильчууд Бурханыг мэдэхгүйгээсээ болоод өөрсдөд нь амласан тэр газрыг хэзээ ч үзэлгүй, цөлд эцэслэсэн билээ.

Бурхан биднийг Мосе, Давид, Иосеф, Паул нарын адил цөлд оруулахдаа, сорьж шалгаж, Түүгээр цангах нь уу эсвэл биднийг урвуулан авч одох тав тух, таашаалаар цангах нь уу гэдгийг л хардаг. Иаков:

Та нар гуйгаад хүлээн авдаггүй. Учир нь та нар өөрсдийн тааламжид зарцуулья хэмээн буруугаар гуйдаг байна. Завхай эмс ээ, ертөнцтэй найзлах нь Бурханы эсрэг дайсагнал гэдгийг та нар мэдэхгүй гэж үү? Тэгэхлээр хорвоотой ходий хэн боловч өөрийгөө Бурханы дайсан болгож байгаа юм. Эсвэл Бичвэр дэмий хоосноор “Бидний дотор Түүний нутаглуулсан сүнс нь атаархан хүсдэг” хэмээсэн гэж та нар бодож байна уу? Гэвч Тэр илүү их нигүүлсэл өгдөг. Тиймээс “Бурхан бардмыг эсэргүүцэж харин дарууд нигүүлсэл өгдөг” гэдэг. Тиймээс Бурханд захирагдагтун. Дьяволыг эсэргүүц. Тэгвэл тэр та нараас зайлна. Бурханд ойртогтун. Тэгвэл Тэр та нарт ойртоно. Нүгэлт та нар гараа цэвэрлэ. Хоёр санаат та нар зүрхээ ариусга (Иаков 4:3-8) гэжээ.

Бид Бурханыг чин зүрхээрээ хайж, Түүн рүү ойртбол Бурхан бидэнд ойртоно. Израилийн хүүхдүүд Бурханы гэхээсээ илүү өөрсдийнхөө дур хүслийг (татаалыг) л эрж байсан. Тэд эр, эмгүй дэлхийн хангаж өгдөг тав тух, аюулгүй байдалтай хөөцөлдсөн, завхай амьтад байсан. Энэ бүх тансаглал, хангамж нь тэднийг Египет улс, тэдний их цэргээс авраагүйг тэд дороо мартжээ.

Бурхан биднийг Өөртэй нь дотносохын тулд хоёр зүйл хийх ёстой гэсэн. Нэгдүгээрт - гараа цэвэрлэх. 2Коринт 7:1 дээр “Хайртууд минь, эдгээр амлалт байгаа тул бид өөрсдийгөө махбодын ба сүнсний бүх л бохиросоос цэвэрлэе. Ингэхдээ Бурханаас эмээж, ариун чанарыг төгс болгоё” гэжээ. Нүгэл биднийг Бурханаас тусгаарладаг: “Харин хилэнц чинь та нарыг Бурханаас хагацуулан Нүглүүд чинь Түүний нүүрийг Та нараас далдалжээ. Тиймээс Тэр сонсдоггүй” (Исаиа 59:2).

Хоёрдугаарт - зүрхээ цэвэрлэх. Үүнийг Иаков хэлжээ: “Хоёр санаат та нар зүрхээ ариусга” (Иаков 4:8). Давхар санаатай хүмүүс Сүнс - махан биеийн хооронд наашаа цаашаа гуйвдаг. Тэд Бурханы юмс дээр оюун санаагаа төвлөрүүлэн анхаардаггүй. Колоссай 3:1-2 дээр “Тиймээс хэрэв та нар Христтэй хамт амилуулагдсан л юм бол дээгүүрхийг хай. Тэнд Бурханы баруун талд Христ заларч байгаа. Газар дээрхийг бус дээгүүрх зүйлсийг эрмэлз” гэдэг.

Та хайраа юун дээр тогтоосон байна - тэр зүйлээ л амь тавин хайна. Түлхүүр үг нь *тогтоох* юм. Эмэгтэй хүн үсэндээ хими хийлгэхэд, үснийх нь ширхэг бүр химийн аргаар буржийдаг. Туг үсийг нь тэнийлгэж байгаад буцаагаад тавихад, эргээд л нөгөө тогтсон хэлбэртээ орж, буржийна.

Хүмүүс цуглаанд явж, магтаалын багт дуулж, Христэч үйл ажиллагаанд оролцдог. Гэхдээ “Христэч” юм хийгээгүй үед нь ухаан санаа нь хаана байдаг бол? Тэд ухаан санаагаа юун дээр тогтоосон байна - тэр газарт нь л байна. Хүн цуглааны байрнаас юмуу Христэч орчноос гарч явах үед ухаан санаа нь яг л мөнөөх химитэй үс шиг эргээд нөгөө тогтсон зүйл рүүгээ явна.

Би Америкийг хөндлөн гулд туулахдаа, магтаалын дуу дуулдаг, номлолыг утсан дээрээ тэмдэглэж авдаг, тэр бүү цаг заваа зориулан үйлчилдэг олон хүнтэй уулзаж, ярьж явсан. Мэдээж эдгээр нь муу зүйл биш. Тийм боловч тэд үйлчлэх хоорондуураа юу ярьдаг гээч - дандаа л мөнгө, мэргэжлийн спорт, хувцас, медиа дээрх шинэ мэдээ, хобби, эсрэг хүйсийн хүн, дэлгүүр хэсэх, дуртай апп зэрэг дэлхийн юмсын талаар ярьдаг. Үүнийгээ ярихаараа нүд нь гэрэлтээд л явчихна. Гэтэл Библи унших, залбирах, үйлчлэлийн талаар ярих юмуу цуглаанд явах нь тэдний хувьд алба мэт байдаг.

Дурлалт бүсгүйтэйгээ гэрлэх гэж байгаа эр хүн бүсгүйнхээ талаар яаж бодож, яаж ярихаа заалгахгүй. Бүсгүй нь угаасаа тэр залуугийн өдөр нь бодолд нь, шөнө нь зүүдэнд нь уяатай явах бөгөөд нэрийг нь хэлүүтээ л дуу хоолой нь цангинаж, жингэнээд л явчихна. Учир нь залуу дуу хоолой, зүрхээ бүсгүй дээрээ тогтоожээ. Түүнд давхар санаа байхгүй. Тэр өөр эмэгтэйчүүдийн талаар бодохгүй. Тэр дурлажээ.

Дуулал 16:8 дээр Давид “ЭЗЭН өмнө минь үргэлж байсан. Тэр миний баруун талд байдаг учраас Би ганхахгүй” хэмээн өгүүлсэн. Тэрбээр хоёрдмол санаагүй, цэвэр зүрхтэй байжээ. Тэрбээр Эзэнийг хайрлахаас өөр зүйлийг хүсээгүй. Давид энэ дэлхийн юунаас ч илүү Бурханд л хайртай байжээ. Есүсээс илүү хайрлаж, дурлаж, итгэж байгаа юмыг шүтээн гэдэг юм шүү. Давид:

“ЭЗЭНий уул өөд хэн авирч болох вэ? Ариун газарт нь хэн зогсож болох вэ? Цэвэр гартай, ариун зүрхтэй, Хуурмаг хоосонд сэтгэлээ өргөөгүй, Худал тангараг тавиагүй нь буюу” гэсэн (Дуулал 24:3-4).

Юуг ч Есүсээс илүү хайрладаггүй, дурладаггүй, итгэдэггүй хүн нь цэвэр зүрхтэн болой. Матай 10:37 дээр Есүс “Эцгээ юмуу эхээ Надаас илүү хайрлагч нь Миний хувьд зохистой нэгэн биш. Хүүгээ эсвэл охиноо Надаас илүү хайрлагч ч Миний хувьд зохистой нэгэн биш ээ” гэсэн.

Цөлд Бурханыг таньж мэдэх боломжоо алдталаа дэлхийг хайрласан Израилийн хүүхдүүд шиг байв!

Исаиа 35:1-2:

Цөл хийгээд хагсмал газар баярлан Эзгүй тал ч баясан замар цэцэг мэт дэлгэрнэ. Цэцэглэнхэн дэлгэрээд, цэнгэнхэн баясаад, баяр хөөртэйе уухайлна. Ливаны алдар, Кармел ба Шароны цог жавхлан түүнд соёрхогдоно. Тэд ЭЗЭНий алдар, Бурханы маань сүр жавхланг харна.

Цөлд Эзэний алдар илчлэгддэг!

Бидний өмнө алхлаж явсан аугаа ариунтнуудтай мөр зэрэгцье! Давид, Мосе, Паул, Иосеф тэргүүтэй Бурханы аугаа эрчүүд, эмэгтэйчүүд шиг цэвэр гар, цэвэр зүрхээр Бурханд ойртноу.

3

ЦӨЛ ЗАЙЛШГҮЙ ХЭРЭГТЭЙН УЧИР

Болдоггүй юм болчихсон байгаа биш, зовлон дунд чангахан шиг архир. Эзэн чамайг цөл дундуур хэрхэн хөтлөж, өдөр бүр хооллож, хувцаслаж байсныг сана. Бурхан чиний адгийн аашийг тэвчиж, “Египетийн дур булаам таашаалын” төлөөх санаашрал, гонгинол бүхнийг чинь дуугүй өнгөрөөсөн! Энэ бэрхшээл дунд Эзэний нигүүлсэл хангалттай байгаагүй юу?

—Чарльс Эйч. Спержен

ЭЗЭН Бурхан чинь чамайг... цөлд удирдсан... нь чиний зүрхэнд юу байсныг, тухайлбал тушаалыг нь дагах эсэхийг чинь мэдэхийн тулд мөн чамайг номхтгож, шалгаж сорихын тулд байсан юм.

—Дэд хууль 8:2



Миний хувьд цөл нь ёстой гэнэтийн цохилт байж билээ. Үнэндээ Христийг дагасан эхний хэдэн жил маань яг л төгсгөлгүй бал сар байв. Лиза, бид хоёр Техасын Далласт суурьшиж, би нэг хэсэг инженерээр ажиллаад, дараа нь чуулганд үйлчлэх болов. Би пастор, пасторынхаа гэргийд бас манай том чуулганд зочилж байгаа хүмүүсийг угтаж үйлчлэх “ажилд” ороод бөөн баяр! Наддаа л тэнгэрийн улс шиг байлаа. Манай чуулган Америкийн хамгийн алдартай чуулганы нэг байсан болохоор би энэ дэлхийн хамгийн нэртэй алдартай Сайн мэдээний үйлчлэгч нарт үйлчлээд л...

Тэдгээр томчуудыг онгоцны буудлаас тосч аваад л, манай чуулганд зочлох хугацаанд нь чуулган, зочид буудал зэрэг хүрэх ёстой газарт нь хүргэж өгөөд л, хамт хооллоод л... эрин цагийнхаа хамгийн аугаа хүмүүстэй л цагийг өнгөрөөсөн дөө. Ажлын маань эхний хэдэн жил ёстой л зүүд мэт оргилуун байлаа.

Гэтэл гэнэт нэг л бишдэж эхлэв. Бишдэхээр барахгүй, хэцүүдэв. Тухайн үед Бурхан надад юу ч илчилж өгөөгүй учраас, би цөлд нэвтэрч байгаагаа ер мэдээгүй юм. Цөлд Бурхан биднийг сургадаг. Цөлд л бидний зан чанар хөгжиж, итгэл маань бэхэждэг. *Цөл зайлшгүй хэрэгтэй.*

Жишээлбэл, та насаараа боол яваад чөлөөлөгдсөн Израиль хүн гэж бодъё. Та дөнгөж сая догшрон хуйлрах усан ханан дундуур явсаар, нөгөө эрэг дээр нь ямар ч осолгүй, хув хуурай гарах аймаар бас гайхмаар үйл явдлыг биеэр үзжээ. Тэгсэн таныг нөмөрлөн хамгаалсан мөнөөх усан хана чинь таны дайснуудыг харин хөмрөн сөнөөж, дарангуйлагч чинь мөнхөд сүйрэв! Та Бурханы энэ ялгуусан чөлөөлөлтийг баярлан хөөрөн, бүжин тэмдэглэв! Бурхан таны талд гэдгийг мэдсэн болохоор та юунаас ч айхаа больж, Бурханы хүч чадал, итгэмжтэй чанарт цаашид хэзээ ч эргэлзэхгүй!

Тэгтэл тэс өөр тайз засагдав: хэдэн өдрийн дараа - та ядарч,

цангаж, халууцжээ. Нөгөө “амлагдсан газар” маань сураг бараагүй, оронд нь та баахан могой, хилэнцэт хорхойтой цөлөөр зорилгогүй тэнүүчилнэ. Нөгөө морьдтойгоо далайд живсэн цэргүүдийн талаарх дуу хуур дуусч, оронд нь: “Та яах санаатай биднийг Египетээс гаргаав? Биднийг, үр хүүхэд, мал сүргийг маань цангааж алах гээ юү?” гэсэн гомдлоор удирдагчаа булсан дуу л дуулдана.

Тэгэхээр бодоцгооё. Бурхан таныг энэ их аниргүй цөлөөр зүгээр л хэрэн хэсүүлэх гэж хүчирхэг дайснаас тийм сүр хүчтэй чөлөөлсөн болж таарч байна уу? Ердөө л энэ үү? Мэдээж үгүй. Цөл нь амлагдсан газартаа хүрэхийн тулд заавал дайрдаг дамжин өнгөрөх билээ.

Эзэн Израилийн хүүхдүүдийг Египетээс цөл рүү дагуулсан шигээ таныг ч дагуулна. Диавол биш, Бурхан таныг тийш нь дагуулжээ. Цөл нь өөрийн гэсэн зорилго - тэнгэрлэг төлөвлөгөөтэй. Нэгдүгээрт - Бурхан биднийг даруу чанарт сургаад, дараа нь шалгадаг. Энэ нь бидэнд зүрхний маань үнэн чанарыг мэдүүлэхийн төлөө юм.

Бурхан биднийг яаж даруусгадаг вэ? “Тэрээр чамайг номхтгон, чамайг өлсгөж... маннагаар чамайг хооллож байсан” (Дэд хууль 8:3). Бурхан Израильчуудыг өлсгөж даруу занд сургажээ. Гэхдээ Бурхан тэднийг маннагаар хооллосныг дараагийн хэсэг нь хэлжээ. Жаахан зөрчилтэй үг бус уу? Маннагаар хооллоод байгаа юм чинь тэд яаж өлсөх билээ?

Тэгэхээр манна нь тэнгэрэлч нарын хоол - хүний хүртэж болох хамгийн дээд хоол болой! Елиа үүнээс хоёр зүсэм идээд л дөч хоног аялах тамир тэнхээтэй болсон байдаг. Гэтэл Израильчууд маннагаар цатгалдаж байсан. Тэд долоо хоногийн зургаан өдөрт нь өглөө бүр шинэхэн манна хүлээн авдаг бөгөөд зургаа дахь өдрийн манна нь долоо дахь өдөрт нь хүрэлцдэг байсан нь бас л нэг гайхамшиг байв. Израильчууд Бурханаас анх манна хүлээж авсан өдрөөсөө Амлагдсан газрынхаа босгон дээр хуарагнах өдөр хүртлээ *нэг ч хоосон хоноогүй*.

Тэгэхээр Бурхан яагаад “Би та нарыг өлсөхөд хүргэсэн” гэж хэлэв? Бурхан ямар өлсгөлөнгийн талаар яриав? Ингэж бодъё: та өглөөний цайндаа ч, оройн хоолондоо ч дан талх иддэг бол яах уу? Цөцгийн тос, хайлмаг, жимсний нухаш, махны нөөш, загас - ер нь ямар ч холцгүй, хоосон талх. Би хэдхэн өдөр, долоо хоногийн талаар яриагүй, харин *дөчин жилийн* хоолны дэглэмийн талаар ярьж байна!

Би залуусын пастор байхдаа, тавин зургаан залуугаа дагуулаад найм хоног Тринадад арал руу илгээлтээр явсан юм. Тринададын чуулган биднийг хоол ундаар дайлж, найрсаг сайхан хүлээн авсан ч, өдөр бүр тахиа өгөв. Тэд тахиагаа янз бүрээр амтлаж, будаа, ногоотой өгч байсан ч, мөнөөх л тахиа!

Найман өдөр тахиа идсэний дараа бид өөр хоол санагалзаж эхлэв. Гэртээ ирээд, манай бүлгийн нэг залуу ээжээсээ оройн хоолонд юу хийсэн бэ гэж асуутал ээж нь: “Тахиа!” гэж хариулжээ. Манай залуу дуу алдаад, надад бургер аваад өгөөч гэж гуйсан юм даг.

Тринададад бид наймхан өдөр тахиа идээд л уйлагнаж эхлэсэн бол, дөчин жил ямар байхыг төсөөлж байна уу? Дөрвөн жил бус, *дөчин жил* нэг л хоол шүү дээ! Тэгэхээр Бурхан тэднийг ингэж л өлсгөсөн байх нь. Бурхан тэдний идмээр байсан зүйлийг нь өгөөгүй, харин амьд бөгөөд эрүүл байхад хангалттай зүйлийг нь л өгчээ.

Үүнээс гадна өөр юу тэднийг өлсгөж, байхгүй зүйлээ үгүйлэхэд хүргэсэн бэ? Бид энэ түүхийг уншихдаа, тэр хүмүүсийн гутал, хувцас нь урагдаж салбараагүйд гайхах байх - гэр бүлийнх нь төсвийг үнэхээр сайн хэмнэж өгчээ. Тэгэхээр дөчин жил нэг л

Аян замд аминд орох арга

#3 Байдлыг өөрийн гараар шийдэхээс татгалз

Бие даасан, өөрөө бүхнийг мэддэг, чаддаг Америкчууд бидэнд цөлд ирдэг хамгийн том едөөлт нь ямар нэг юм хийх гэж оролдох явдал юм. Эзэн байрнаас маань нүүгээд, хэдэн сая бээр газар байх мэт санагдах үед, хаанчлалын төлөө хамгийн өчүүхэн хичээл зүтгэл маань бүтэлгүйтэх үед, залбирлын цаг маань дэмий л өвдгөө өвтгөсөн цаг болох үед бид цөхөрсөндөө юу ч хамаагүй хийх гэж оролддог. Тэгвэл энэ тун тааруу санаа шүү. Цөлд угаасаа нэг их юм болдоггүй - аяга ус, залхмаар хоолноос өөр юм байхгүй. Энэ хувхай хоосон газар бид амьдрал гэдэг чинь бидний хийдэг юмуу байдаг зүйлээс хавьгүй том болохыг ойлгоно. Бурханыг дотно таньж мэдэж, өдөр бүр Түүний хүслийг биелүүлэхээс илүү чухал зүйл амьдралд үгүйг ойлгоно.

Би цөлд байхдаа алсын хараа, халуун сэтгэл, хүсэл

ижил хувцастайгаа амьдрах ямар байдаг бол? Юутай уйтай! Дэлгүүр хэснэ, онлайнгаар шинэ загвартай танилцана гэсэн ойлголт байхгүй. Дөчин жил нөгөө л бор углааштайгаа!

Тийм ээ, тэдний үндсэн хэрэгцээ хангагдсан байсан - халуун, хүйтнээс хамгаалагдсан байсан - гэхдээ амьдралд амт нэмэх зүйлс юу ч байгаагүй.

Яг л ийм дүнсгэр амьдрал хэдэн долоо хоног бус, дөчин жил үргэлжилсэн гээд бод! Нөгөө л өргөст ургамал, зэгс, хатсан хөрс - ямар ч долгиолсон ус, саглагар ой, анхилам усан үзмийн талбай, үзэсгэлэнт нуур байхгүй - өдөр бүр зүгээр л шар цөл!

Тэдэнд хэрэгтэй юмс нь л байснаас бус, хүссэн юмс нь байгаагүй. Энэ ойлголтоор дараах ишлэлийг дахин шалгана уу:

Хүн зөвхөн талхаар бус, харин ЭЗЭНий амнаас гарах үг бүрээр амьдардаг гэдгийг чамд ойлгуулахын тулд Тэрээр чамайг номхтгон, чамайг өлсгөж, чиний мэддэггүй, чиний эцэг өвгөд ч мэддэггүй байсан маннагаар чамайг хооллож байсан. (Дэд хууль 8:3)

жолоо гэх юмгүй болчихсон байсан учраас, ганц өдөр нь долоо хоног шиг, долоо хоног нь сар шиг л уртуу санагддаг байж билээ. Тийм боловч надад урагшлаад байхаас өөр зам байгаагүй. Зүгээр л хөлөө чирээд, зүрхэнд минь буй Бурханы Үгийг атгасаар, чадахаараа үйлчилсээр, явсаар, тэвчээр алдсандаа түргэдсэн юм хийхээс биеэ татсаар байх ёстой байлаа. Надад зориулсан газар Бурханд байгаа гэдгийг би өдөр бүр өөртөө сануулсаар явах ёстой байв. Бурхан цагийг гарздаагүй, Бурхан амлалтаа биелүүлэхдээ л биелүүлнэ.

Тэгээд мэдээж цөл нь өөрийгөө дөвийлгөж, өргөх цаг биш! Та цэвэрлэгдэж, бэлтгэгдэж байгаа болохоор тогтуун байж, нүгэл үйлдэх өдөөлтийг няцаах ёстойгоо санаарай.

Эзэний барьж байгаа цөлийн уртын замаар Эзэнтэй л хамт гүйх ёстой юм шүү. Түүнийг дэндүү удаан байна хэмээн түрүүлж явах шийдвэр гаргав аа!

Бурхан тэдний махан биеийнх нь хүсэх юмсыг зайлуулаад, үндсэн хэрэгцээг нь л хангах байдлаар өлсгөхөд хүргэжээ. Тэгээд тэднийг өлсгөснөөрөө: Өөрийг нь хүсэх нь үү эсвэл орхиод явсан зүйлээ хүсэх нь үү? Бурханыг хайх нь уу эсвэл махан биеийнхээ тачаалыг хайх нь уу? Зөвт байдлаар өлсөж цангах нь уу эсвэл тайтгарал, таашаалаар өлсөх нь үү? гэдгийг харахыг хүсчээ. Харамсалтай нь Израильчуудын зүрх өөрсдийг нь бүрэн хангаж чадах цорын ганц Бурхан дээр тогтоогүй байсан учраас, шалгалтдаа унажээ:

Тэдний дундах холилдсон хүмүүс шунахай хүсэлд автаж мөн Израилийн хөвгүүд ч дахин уйлж —Хэн бидэнд идэх мах өгөх вэ? Бид Египет нутагт үнэгүйгээр идэж дассан загас, өргөст хэмх, тарвас, ногоон сонгино, сонгино, сармисыг санагалзаж байна. Харин одоо ой гутаж гүйцлээ. Энд маннагаас ондоо харах юм юу ч алга гэцгээв. (Тооллого 11:4-6)

Израильчууд урьдын боолын амьдрал нь эдүгээ Бурханы дагуулж авчирсан хуурай цөлөөс илүү сайхан гэж санатлаа Египетэд хорогджээ. Тэд гомдоллож, гоншигнож, махны төлөө бархиралдсан бөгөөд Бурхан ч тэдний уйлаан майлааныг сонсов:

Иймээс Тэр хүсэж шаардсаныг нь өгсөн боловч Тэдний аманд эцээх өвчнийг илгээсэн. ...Тэр тэдэнд шунан хүссэнийг нь өгсөн тул Ийнхүү тэд идэж, сайн цадацгаасан. Харин шунал хүсэл нь эс хангагдсан. Хоол нь тэдний аманд байх зуур (сүнсний тураал иржээ). (Дуулал 106:15, 78:29-30)

Израильчууд хүссэнээ авсан - гэхдээ өндөр төлөөс төлсөн. Тэр махтай нь хамт сүнсний тураал иржээ. Тэр тураал нь тэдний тэвчээрийг сорон, шалгалтыг давах чадваргүй болгоод, эцэстээ Амлагдсан газарт орохоос нь хорив! Мах хүссэн явдал нь нүгэл байгаагүй боловч, тэр хүсэл нь юуг төлөөлж байсанд л гол нүгэл нь оршиж байв. Энэ нь тэдний Бурханд, Түүний удирдаж, хангах арга замд ханахгүй байгаа зүрхийг нь илчилсэн юм. Мөн тэдний боолын боол явснаа умартаад, богд шиг жаргаж байсан мэт эргэн санагалзах болсон Египет дэхь хуучин амьдралаа санагалзах дур хүслийг нь илчилсэн юм.

Энэ бол хүн бүрийн санаж сэрж явбал зохилтой сургамж болой: Бид Амлагчийг Өөрийг нь бус, зөвхөн амлалтын ашгийг эрээд байвал, цөлд хүчтэй байж чадахгүй. Тэгээд нөгөө “хуучны сайхан өдрүүдээ” санагалзаж эхлэнэ. Гэхдээ яг үнэнээсээ ярьбал, тэдгээр нь сайхан өдрүүд бус, зүгээр л боолын амьдрал байсан билээ.

Надад юу *өгч*, миний төлөө юу *хийж* чадах бол гэдэг сэдлээр Эзний араас явах нь нэг хэрэг бол, Эзнийг Өөрийг нь хайх нь тэс өөр хэрэг юм. Эхний сонголт нь таны ашиг, хувийн сэдлийн төлөө бөгөөд сайндаа л Бурхантай нэг их төлөвшилгүй харилцааг тогтооно. Харин Эзнийг Өөрийг нь хүсэн хайх явдал нь бидний хүсдэг хүчирхэг, дотно харилцааг бий болгоно.

Ариун гачаал

Хувхай цөлд амьдрах нь мэдээж олон талын гачигдлыг үүсгэнэ. Энэ нь сэтгэл санаа, бие махбод юмуу материаллаг тал дээрээ хүссэн зүйлээ бус, харин шаардлагатай зүйлээ л хүртдэг цаг. Бурхан бидний үндсэн хэрэгцээг хангахаа амладаг. Тиймээс хүссэн бүхнээр маань цатгалдуулаад байлгүй, харин өдөр тутмын маань үндсэн хүнсээр л хангана.

“Үрээгээ танихгүй баян” гэдэг нь сайн цагийг илтгэсэн үг. Гэтэл цөлд үрээ байтугай, үр ч олдохгүй! Үүгээр барахгүй, маш олон төрлийн гачигдал нүүрлэнэ. Энэ бол таны санасан хүссэнээ бус, харин үндсэн шаардлагаа мэдрэх цаг. Цөлд таны сүнсэнд юу хэрэгтэйг Бурхан мэднэ. Энэ нь таны бодож байсан зүйл биш байж болно! Цөлд Бурхан бидний хүслийг бус, хэрэгцээг хүлээн авдаг.

Биднийг цэвэрлэж бэхжүүлэх нь цөлийн үндсэн зорилго. Бид Бурханы *хангамжийг* бус, *зүрхийг* дагах ёстой. Тэр цагт бид сайн сайхан явахдаа, Эзэн Бурхан минь л гэрээгээ байгуулахын төлөө биднийг элбэг баян болгосныг мартахгүй болно (Дэд хууль 8:2-18).

Гэхдээ *бидний* хэрэгцээ, хүслийн талаарх тодорхойлолт, бодит байдал хоёр маань тэнгэр газар шиг ялгаатай байдаг нь хамгийн гол асуудал болдог. Бид хүслээ “хэрэгцээ” гэдэг ч, үнэндээ бол үгүй юм! Магадгүй олонх маань Паулын дараах үгийг бас л сураагүй яваа байх:

Би үүнийг дутагдсаны улмаас ярьж байгаа юм биш.
Учир нь би байгаадаа сэтгэл хангалуун байж сурсан юм.
Би тарчигхан байхыг ч мэднэ, элбэг дэлбэг байхыг ч мэднэ. Ямар ч, аливаа нөхцөл байдалд цатгалан болон

өлсгөлөн байх, элбэг байх, дутагдахын аль алины нууцад би суралцсан. Намайг хүчирхэгжүүлэгч Түүгээр би бүгдийг хийж чадна. (Филиппой 4:11-13)

Гачигдахдаа ч, элбэг байхдаа ч Христийн хүчээр сэтгэл хангалуун байхад Паул суралцжээ. Гэтэл харамсалтай нь манай Барууны чуулганд хүмүүс сэтгэл хангалуун байхыг огт сураагүй мэт - элбэг дэлбэг амьдралтай олон хүн ядуу зүдүүсээс ялгарах юмгүй сэтгэл дундуур амьдардаг. Бид өмчлөх эрхтэй гэж бодсон бүхнээ өөрийн болгохоос нааш, өөрийгөө бас л дутуу байна гэж үздэг. Бид хүний зан чанар, итгэлийг нь үнэлэх ёстой байтал итгэл, сүнсний амьдралыг нь хичнээн хөрөнгөтэй, хэр амжилттай, олон нийтийн сүлжээнд хэдэн дагагчтайгаар нь шүүж, хэмждэг.

Израилийн хүүхдүүд Египетээс алт, мөнгө, тансаг хувцас тэргүүтэй асар их хэмжээний эд агуурсыг нь хамаад гарсан. Тийм боловч тэр үнэт төмөрлөгөөрөө цөлд шүтээн урлаж, тэр шүтээндээ нөгөө тансаг хувцсаа өмсөж байгаад бүжиглэн мөргөсөн байдаг. Тэдгээр эд агуурс нь бурханлаг чанарыг бус, харин ч яах аргагүй дэлхийн чанарыг илтгэж байна. Египетээс гарсан анхны хүмүүсээс хоёрхон хүн л Амлагдсан газарт тэнцэж орсон билээ. “Харин Миний зарц Калев өөр сүнстэй байж, Намайг бүрэн дагасан тул түүний орсон тэр нутагт нь Би түүнийг аваачих бөгөөд үр удам нь тэр газрыг эзэмших болно” (Тооллого 14:24).

Бид бие биеэ хэн гэдгээрээ бус, харин юутай гэдгээрээ хэмжиж эхлэх үед бидний үнэлэмжийн систем гажигтдаг.

Нөгөөтэйгүүр санхүүгээр ерөөгдөх юмуу удирдлага, нөлөөллийн байр сууринд очингуугаа үүнийгээ дураараа дургих Бурханы зөвшөөрөл гэж үздэг хүн байна! Тэд хүссэнээ худалдан авч, мөнгөө хүслээрээ зарцуулж, өөрийнхөө ашгийн төлөө нэр нөлөөгөө хэрэглэдэг. Цөлд бүтэлгүйтсэн хүмүүс л голдуу ингэж авирладаг. Үнэндээ санхүүгийн ерөөл, өндөр эрх мэдэл нь харин ч Бурханы зорилго, удирдамжийн төлөө Түүнд улам найдахад л хүргэх ёстой юм.

Есүс ямар хандлагаар үйлчилснийг үз. Тэр амиа бодоогүй. Тэр бидний нүгэл, өвчин, үхлийн ялыг Өөр дээрээ авсан. Есүс хэдийгээр ширхэг ч нүгэлгүй байсан ч, бидний сайн сайхныг Өөрийнхөө сайн сайхнаас дээгүүр тавьсан юм. Тэрбээр Өөртөө наахын тулд бус, харин өгөхийн төлөө л амьдарч, үйлчилж байв! Есүс Өөрийгөө няцааж чадсан учраас л, бидэнд хамгийн аугаа бэлэгийг буюу мөнх амийг хүртээсэн билээ.

Ийм төлөвшилтэй зан чанарыг Бурхан цөлд л бидний дотор бүтээдэг юм. Цөл нь Сүнсний үр жимс боловсордог газар. Бурханыг таньж мэдэх бадрангуй хүслээр услаад өгбөл, бид Түүн шиг л амьдрахыг сурна.

4

ХАРИЛЦАА

*Дотоод амьдрал цэгцрэх үед бэрхшээл аяндаа
арилдаг нь гайхмаар шүү.*

—Эй. Даблью. Тозер

*Та нар Намайг хайрладаг бол тушаалуудыг
минь сахь.*

—Иохан 14:15



Бурхан Өөртөө чухам юуг эрсэндээ, бидэнд цөлийн аяллыг бэлтгэнэ вэ? Бид бидэнд хэрэгтэй хэд хэдэн ашгийн талаар үзсэн бөгөөд цаашдаа ч өөр олныг үзнэ. Тэгвэл Бурханд ашиг байна уу? Байна аа. Бурхан бидэнтэй харилцаагаа ахиулан бэхжүүлэхийг хүсдэг. Бурхан бидэнтэй дотносохын хүслэн болдог. Харамсалтай нь олон хүн Эзэнтэй тогтоосон харилцаагаа хайрлан хамгаалж явахын оронд ашгийн төлөөх хэрэгсэл болгочих санаатай.

Би Лизатай сүй тавиад байхдаа, толгой түрүүгүй дурлаад байлаа. Байнга л Лизагаа бодно. Болж л өгвөл, хамт байна. Лизад ямар ч хамаагүй хэрэгцээ гарбал, хийж байсан ажлаа хаяад, машиндаа харайж ороод, авчраад л өгнө.

Нэг удаа бид хоёр Лизагийн гэрт таван цаг өнгөрөөснөө санадаг юм. Тэгээд дуртай дургүй харьж билээ. Гэртээ оров уу үгүй юу утас дуугарав. Утсаа автал, Лизагийн маань ялдамхан дуу: “Хонгор минь, чи манайд хүрмээ орхичихож” хэмээн уянгалав.

Тэр үг чихний чимэг шиг л сонсдож, би ч гуяа алгадаад: “Тэгвэл, очоод авахаас!” гэж билээ.

Тэгээд очоод дахиад гурван цаг хамтдаа байсан сан. Ямар сайхан өдөр байсан гэж санана.

Тэр үед Лиза над руу харанхуй шөнөөр утасдаад: “Хонгор минь, би зайрмаг идмээр байна” гэсэн бол, би өөдөөс нь: “Аравхан минут! Ямар амттайг авчрах уу?” гэж хэлдэг байлаа. Лизагийн дэргэд байхын төлөө бүх боломж, бүх далимыг бүрэн ашиглана. Би Лизад жолоогүй хайртай учраас, түүний хүслийг биелүүлэх нь надад жаргал байв. Би Лизад хайртайгаа *батлах* гэж тийм юм хийгээгүй, харин *хайртайдаа* хийдэг байсан юм.

Лизагийн талаар хүмүүст дуртай дургүй, хүчээр ярьдаг байсан гэж бодож байна уу? Үгүй шүү. Би намайг сонсож байгаа хүн болгонд Лизаг магтан дуулдаг байв. Хүнтэй ярьж байгаад далим л гарбал, Лизагийн талаар, айсуй гэрлэлтийнхээ талаар ярина. Би дурласан байв!

Гэтэл гэрлээд хэдхэн жилийн дараа би спорт, найз нөхөд тэгээд ялангуяа үйлчлэлдээ илүүтэй анхаарах болов. Одоо надад Лизатай цаг өнгөрөөх, түүнд юм хийж өгөх нь төвөгтэй болж эхлэв. Лиза миний өдрийн бодол, шөнийн зүүд байхаа больжээ. Гагцхүү Христмас баяр, тэмдэглэлт өдөр, төрсөн өдрөөр нь л бэлэг өгдөг болсон ч, тэр нь ч хүртэл төвөгтэй санагдана. Нэг удаа Валентины баяраар бэлэг авч өгөхөө мартаад, ханийгаа дэндүү гомдоож билээ. Би уучлалт гуйхаас өөр яаж ч чадаагүй юм. Хамгийн харамсалтай нь би төлөвшилгүй зангаасаа болоод гэрлэлтийн амьдрал маань ямар улирлаар явж байгааг таньж хараагүй юм. Бидний нэгдэл ганхаж, анхны хайр маань хагдарч байв!

Тийм боловч Бурхан эцэстээ миний анхаарлыг олзлож, зүрхийг минь эргүүлсэнд талархдаг. Бурхан надад миний хар амиа хоохойлсон байдлыг харуулав. Бурханы нигүүлслээр бидний анхны хайрын гал дахин бадарч, гэрлэлт маань эдгэрсэн юм.

Яг ийм явдал Бурхантай тогтоосон харилцаанд маань тохиодог. Христийн олон үнэнч эрэлчин - дагалдагч нар тав тухын бүсэд хүрэхээрээ хайгуулын ажлаа зогсоож, тухлаж аваад, хурааж эхлэдэг. Тэд Бурханы араас гүйхээ больдог. Тэд өөрсдийгөө бусадтай харьцуулах аргаар юмуу эсвэл өөрийнхөө төгс гэж үзсэн сүнслэг жишгийг тогтоож, Бурханыг хувьчлан таньж мэдэхээ зогсооно. Өдөр тутмын даалгавар, амжилтын төлөөх улайрал, амьдралын аахар шаахар юмс нь тэдний гол зорилго болж хувирна. Тэд одоо Бурханыг таньж мэдэх гэсэндээ бус, зүгээр л адислуулж, ерөөлгөх журмаар л хайж ирнэ. Хараа нь Бурханаас өөр рүүгээ эргэн, зүрх нь ээдэнгэтжээ. Тэд “Христэч” нөхөрлөлөө байгуулсаар, чуулгандаа байр суурь, статусаа тогтоосоор явах боловч, чухам өөрсдөд нь амь хайрлагч Нэгэнийг сонирхохоо больжээ.

Бид Бурхантай дотно харилцааг хүсэлгүй, харин ашиг, ерөөлд нь улайрч эхлэхдээ тун амархан төөрөлддөг. Шударгаар ярьцгаа. Бид залбирах цаг гаргасан хэмээн цээжээ дэлдэв ч, Бурхан үүнийг маань зүгээр л Түүнийг ашиглах гэсэн оролдлого гэж үзэж болно. Бид Бурханыг хэрэгцээтэй цагт тусламж авдаг эх үүсвэрээ болготлоо доош хийжээ. Гэхдээ Бурхан бидэнд дэндүү хайртай болохоороо мэхлэгдсэн чигээр маань хаячихдаггүй юм. Бурхан Есүсийг хайсан үй түмэн хүмүүст хийж өгсөн зүйлээ бидний ч төлөө хийнэ:

Нуурын нөгөө эрэг дээр зогсож байсан хурсан олон дараа өдөр нь энд ганцаас өөр завь байгаагүйг харжээ.

Тэд мөн Есүсийг шавь нарынхаа хамт завинд суугаагүйг, харин шавь нар нь явсныг харав. Эзэн талархал өргөсний дараа хүмүүс талх идэж байсан тэр газрын ойролцоо өөр завинууд Тиберээс ирлээ. Тэгээд Есүс ч, шавь нар нь ч тэнд байхгүйг хараад, хурсан олон өөрсдөө завинуудад сууж, Есүсийг хайн Капернаумд ирэв. Тэд Түүнийг нуурын нөгөө талд олоод, Түүнд —Рабби, Та хэзээ энд ирсэн бэ? гэв. Есүс тэдэнд — Үнэнээр үнэнээр Би та нарт хэлье. Та нар тэмдгүүдийг үзсэндээ Намайг хайгаагүй, харин талх идэж цадсан учраас хайж байна. (Иохан 6:22-26)

Есүс бидний үйлдлийн далд сэдлийг мэднэ. Өөрийг нь хайж ирсэн үй түмэн хүмүүс үнэндээ тэмдгийг харж, ойлгохын оронд ерөөлд (үнэгүй хоолд) татагдсаныг Есүс мэдсэн. Тэмдэг нь чиглэл юмуу мэдээлэл өгөх зориулалттай болохоос биш, өөрийгөө гайхуулдаггүй. Тэр олон хүн Өөрийг нь илчилсэн тэмдгээс нь болж биш, харин гэдсээ цагтах гэсэндээ л дагаж байгааг Есүс мэдсэн.

Ямар нэг юм хэрэгтэй болохоороо эсвэл ямар нэг юм авах гэхээрээ л холбогддог - нэг тийм хүн байдаг даа? Эсвэл бүр таны нэр нөлөө, мөнгө, материаллаг эд юмсыг чинь ашиглах гэсэндээ л тантай нөхөрлөсөн хүн байдаг уу? Тэдэнд та огтхон ч сонин биш, тэд таныг огтхон ч хайрлаагүй, зүгээр л та тухайн үед тэдний зорилгод ашигтай байжээ. Ингэж ашиглуулах *аймшигтай!*

Ийм амиа бодсон хандлага нийгэмд ч, чуулганд ч газар авч байна. Чуулганы олон хүн сэтгэл дундуур байдаг. Тэдний Есүсийг хайрлах хайр нь хөрчээ. Тэд Эзэнд ашиг тооцож үйлчилдгээс биш, Түүнийг халуунаар хайрласандаа үйлчилдэггүй. Тиймээс Бурхан тэдний хүссэнийг нь өгч байгаа цагт тэд Бурханд баярлаж, аз жаргалтай байна. Харин асуудал үүсч, амьдрал хэцүүдэх үед зүрхнийх нь сэдэл ил болно.

Хүн өөр дээрээ төвлөрч байгаа цагтаа заавал гомдоллоно. Яагаад? Яагаад гэвэл асуудал юмуу бэрхшээл ирэхдээ л ирнэ. Тэр цагт хар амиа хоохойлсон чанараар дүүрэн гомдол сад тавина. Бэрхшээл үргэлжилсээр байгаа цагт гомдол үргэлжилсээр байна. Энэ загварыг Израилийн хүүхдүүд дүрслэн харуулсан юм. Эзэн тэднийг Египетийн дарлалаас чөлөөлөх үед хүмүүс бөөн баяр болсон:

Аароны эгч, эш үзүүлэгч Мириам гартаа хэнгэрэг авахад эмэгтэйчүүд бүгд түүнийг даган хэнгэрэг авч бүжиглэв. Мириам тэдэнд дуулан —ЭЗЭНд дуулъя! Тэр өндөрт өргөмжлөгдлөө. Хүлэг морийг унаачтай нь далайд Тэр хаялаа гэв. (Гэтлэл 15:20-21)

Үүнээс том жаргал байсангүй. Тэд өөрсдийг нь дарангуйлагчаас чөлөөлсөн Бурханы аугаа байдал, гайхамшигт хүч, сайн сайхнаар бахдав. Гэтэл гуравхан өдрийн дараа тэр хүмүүс Шурын цөлийн гашуун усыг үзээд: “Бид юу уух вэ?” (Гэтлэл 15:24) хэмээн гоншигносон. Утгагүй юм. Улаан тэнгисийг хага ярсан тэр Бурхан уух ус өгч чадахгүй гэж үү? Гурван хоногийн өмнө Мосег эгээтэй л ардын баатар болгочихоогүй хүмүүс шүү дээ.

Бурхан үнэхээр “гашуун усыг амтлаг” болгосон. Тийм боловч энэ гайхамшиг ч дороо мартагдаж. Хэдэн өдрийн дараа хүмүүс хоолны асуудлаар дахиад л бөөн гомдол гаргасан: “Бурхан биднийг чөлөөлөхөөс өмнө хавьгүй дээр байж!” Тийм гэж үү? Харгалзагч нарын хараан дор, хатуу шилбүүрийн ормон дор тоосго цохих дээр байв гэж үү?

Тэр цөлд Израилийн хөвгүүдийн даяар хотол түмэн Мосе Аарон нарын эсрэг гонгинолдов. Израилийн хөвгүүд тэдэнд —Бид Египетийн нутагт махтай тогооны хажууд сууж, цадталаа талх иддэг байхдаа ЭЗЭНий мутарт алагдсан бол дээр байж. Та нар чуулганыг бүхэлд нь өлсгөлөнгөөр алах гэж биднийг энэ цөлд авчирлаа гэв. (Гэтлэл 16:2-3)

Бэрх, хуурай цагт дэгдсэн гомдол нь ихэвчлэн удирдагч, гэр бүл, найз нөхөд, дайснууд, тэр бүү хэл төр засгийг чиглэдэг. Дийлэнх хүмүүс (айсандаа) энэ их зовлондоо хэзээ ч Бурханыг нээр заан буруутгахгүй. Тиймээс Израильчууд Мосе, Аарон руу дайрсан ч, үнэндээ “Эзэн л биднийг хөсөрдүүллээ!” гэж боджээ. Мосе ч үүнийг нь мэдээд: “Гонгиноон чинь бидний эсрэг биш, харин ЭЗЭНий эсрэг юм” (Гэтлэл 16:8) хэмээн тэдэнд шууд тулгасан байна.

Аян замд аминд орох арга

#4 Санаагаа тодорхой болгох

Би цөлийн амьдралтай дөнгөж танилцаж байхдаа, өөдрөг хандлагатай байх гэж их зүдэрдэг байлаа. Учир нь хэзээ ч, юу ч өөрчлөгдөхгүй юм шиг л харагддаг байв. Үнэндээ хүлээхийн зовлонгоос гадна хүлээлтийн зовиур гэж нэг хэцүү юм бий. Бурханаас хайрласан аялан номлох мөрөөдөлд маань нэвтрэн ороход саад хийж байгаа тэр тээртэй нөхцлөөс би үнэхээр залхаж байлаа. Эзэн намайг цөлөөр дамжуулан шинэтгэж байгаагаа ойлгуулав. Гэхдээ нэг өдөр би бас л Эзэнээс „цөл чинь яагаад ийм өргөн уудам, удаан юм бэ” хэмээн шалгааж байтал Эзэн надад: „Би чамайг Надад үйлчлээд байна уу, мөрөөдөлдөө үйлчлээд байна уу гэдгийг чинь хармаар байна” хэмээн сануулсан юм.

Энэ үг миний анхаарлыг олзлов! Би зүгээр л дэлхийгээр Сайн мэдээ тараах мөрөөдлөө хөөж байна уу эсвэл Бурханд дуулгавартай найдаж, Үгийг нь хүлээж байна уу? Ингэсэн цагт л би Бурханы хүсэлтэй эгнэнэ.

Тиймээс би ингэж зөвлөө: Бурхан танд гайхамшигтай мөрөөдөл өгсөн байлаа ч, мөрөөдөл чинь Бурханы оршихуй, хүслээс давах ёсгүй шүү.

Цөл амиа бодсон байна уу амиа бодоогүй байна уу гэдэг зүрхний маань сэдлийг илчилдэг. Таны зүрхэнд юу болж байгааг, таныг юу жолоодож байгааг Ариун Сүнснээс асуу. Таныг “Египетэд” дөнгөлсөөр, цөлд гомдоллуулсаар байгаа зан чанар танд байна уу? Шударга байх нь таны цаашдын эрүүл мэндэд бас Бурханы хайрынхаа үндсэн дээр таны дотор хийдэг засварын ажилд амин чухал шүү.

Тийм боловч хүн бүр гэмшиж, зүрхнийхээ нөхцлийг өөрчлөх боломжтой! Энэ бол маш сайхан мэдээ. Бид Бурханыг ашиглах санаагаа хаяж, үтэр түргэн гомдлоо зогсоож, Бурхантай нөхөрлөхийг хүсэн хайж болно.

Тэр цагт Бурхан биднийг хайрласандаа цөл рүү илгээж болно.

Бурхан томъёо биш

Бурхан Өөрөө Израилийн хүүхдүүдийн араас яваагүй учраас, тэд Бурханы замыг мэдэх аргагүй байжээ. Тэд Бурханы хүчирхэг үйлсэд баярласан боловч, Бурханы ер бусын хүч татрах тоолонд тэд будилсан. Мосег уулан дээр байхад, тэд замаасаа гажин тоглоцгоосон. Тэд авралын ашиг тусад л баяссан. Тэд Бурханаар ч цангаагүй, Бурханыг таньж мэдэхийн төлөө ч цангаагүй.

Нэгэн өдөр цөлд Бурхан Мосед: “Би өмнө чамтай ярьсан шиг Өөрийн биеэр Синай уулнаа бууж ирээд, хүмүүстэй ярих гэж байгаа тул бууж очоод өөрсдийгөө ариусгахыг тэдэнд дуулга” гэжээ. Гэтэл товлосон өдөр болж, Эзэн цог жавхлангаа бадраан, алдар сүрээ гайхуулан үзэгдсэнд, хүмүүс үүнийг нь тэсвэрлээгүй:

Бүх ард түмэн тэнгэрийн дуу, аянгын гялбаа, эвэр
бүрээн дууг мэдрэн, утаа нүүгэлтсэн уулыг харангуутаа
айн дагжиж, алсад зогсоор байв. Мосед тэд —Та
бидэнтэй яриач. Бид сонсьё. Харин Бурхан бидэнтэй
бүү яриг. Эс тэгвэл бид үхнэ гэв. (Гэтлэл 20:18-19)

Хүмүүс Мосед: “Та л бидний өмнөөс Бурхантай яриад, юу хэлснийг нь бидэнд дамжуулж өг - тэгээд бид түүнийг нь хийе” гэсэн утгатай үг хэлэхдээ, Бурхантай *харилцаа* тогтоолгүй, ашиг олох гэсэн аминч хүслээ л харуулжээ. Тэд магадгүй Бурханы үгийг сахих гэсэн сайн санаагаар хэлсэн байх. Гэхдээ Бурхантай *дотно харилцаа тогтоолгүйгээр* Бурханы үгийг сахих боломжгүй байв.

Израильчууд харилцааг бус, зүгээр л асуудлаа шийдүүлэхийг хүссэн учраас, Бурхан тэдэнд Арван тушаал өгсөн! Гэхдээ Арван тушаал ч асуудлыг нь засч чадаагүй. Үе өнгөрөх тусам хүмүүс эдгээр тушаалыг дагаж чадахгүй гэдгээ улам л батлан харуулжээ.

Тэгвэл манай үеийнхэн ямархуу байна? Бурханы замаар өөрийнхөө хүчээр явах гэж оролддог сайн санаатан, сайхан сэтгэлтэн олон бий.

Бид биелүүлж чадахгүй баахан амлалт, андгай тангараг өргөчихөөд, эцэстээ залбирч ч чадахгүй болтлоо дарамтанд ордог. Сүүлдээ Бурхантай харилцаагаа сайжруулах гэсэндээ пастор, хань ижил, найз юмуу аль нэг алдартай блоггерийн Бурхантай харилцах харилцааг нь хуулбарлан дууриах гэж оролддог. Бид Бурхантай амь амьдралаа зориулсан, дотно харилцаа тогтоолгүйгээр, Израильчууд шиг зүгээр л Үг - Тушаалыг нь сахих гэж оролддог.

Иохан 14:21 дээр Есүс “Миний тушаалуудыг хүлээн авч сахигч нь Намайг хайрлагч мөн. Намайг хайрлагч нь Эцэгт минь хайрлагдана. Би ч түүнийг хайрлаж, Өөрийгөө түүнд илчилнэ” хэмээн айлдсан.

Би энэ хэсгийг уншихдаа, Эзэн надад: “Жон, чи Миний тушаалуудыг сахих юм бол, Надад хайртай батлана” гэж хэлж байгаагаар төсөөлдөг байлаа. Тэгтэл нэг өдөр Эзэн надад энэ ишлэлийг ахин дахин унш гэсэн юм. Би ч ахин дахин унштал, Эзэн: “Чи Миний хэлснийг ойлгосонгүй - дахин унш!” гэлээ. За, Эзэн! Ийм маягаар би уг ишлэлийг найм, есэн удаа уншив.

Тэгээд сүүлдээ: “Эзэн минь, миний ухаангүй байдлыг өршөө, Та надад хэлэх гэснээ харуулаач!” гэж хашхирлаа.

-“Жон, Би “Чи Миний тушаалуудыг сахих юм бол, Надад хайртайгаа батлана” гэж хэлээгүй. Чиний Надад хайртай үгүйг Би мэднэ шүү дээ! Би зүгээр л “Хүн Надад үнэн голоосоо хайртай бол, тушаалуудыг маань сахих л болно!” гэж л хэлсэн юм.”

Би ойлгов! Энэ чинь хууль биш, *харилцаа* юм байна. Би үүнийг нь тушаал - хууль гэж хардаг байж. Тэгтэл Эзэн харилцааны амин чанарыг илчилжээ.

- Бурханыг дүрэм, журмаар таньж мэдэхгүй.
- Бурханд арга барилаар хүрэхгүй.
- Аугаа хүчирхэг, ариун Бурханыг томъёо болгодоггүй юм!

Гэтэл бидний олонх маань Эзэний талаар ийм л эндүү үзэл бодолтой явдаг. Бурхантай харилцахын оронд аз жаргалтай амьдралын долоон алхам, авралын дөрвөн алхам бүхий төлөвлөгөө, амжилттай харилцааны таван тал, баталгаатай хариулт авчирдаг залбирлын арга барил гэх мэт “хууль, томъёог” баримталдаг. Бид Бурханыг дуртай цагтаа дуудаж авчраад, хүслээ гүйцэтгүүлдэг шидэт гүцэн доторх савдаг шиг л санадаг. Бурханд ингэж ханддаг хүмүүс чинь нүглийг барахгүй байх нь аргагүй шүү дээ.

Бурхан бол хамгийн сүүлийн үеийн бие дааж ашигладаг, томъёо биш! Бурхан бол хүүхдүүдийнхээ - та, бид хоёрын дотор амьдардаг амьд Бурхан! Тэр биднийг мэдэж, бидний хийж байгаа бүхэнд оролцохыг хүсдэг. Энэ бол зүрхнээс зүрхэнд урсах харилцаа юм. Хайрыг хайхардаггүй байдлаас маань болоод л Есүс ингэж айлджээ:

Гэвч Надад чиний эсрэг зүйл байна. Чи анхны хайраа орхижээ. Тиймээс чи хаанаас унаснаа сана бас гэмш. Анхны үйлсээ үйлд. Чи эс гэмшвээс, Би чам дээр очиж, дэнг чинь байрнаас нь зайлуулах болно. (Илчлэл 2:4-5)

Тэгвэл Израильчуудаас ялгаатай нь Мосе Бурханыг холоос хүндэтгэж байгаадаа сэтгэл ханаагүй. Тэрбээр Бурханы оршихуйн дүрийг харахдаа, гэдрэг ухралгүй, харин ч ойртож очжээ. Гэтлэл 20:21 дээр “Бурханы байгаа түнэр харанхуйд Мосег ойртон очих үед ард түмэн хол зогсож байв” гэдэг. Мосе хэдий гурван сая хүний удирдагч, Хуучин гэрээний хамгийн том тэмдэг, гайхамшгуудад гар бие оролцсон нөлөө бүхий, хүчирхэг хүн байсан ч, иймэрхүү юмст ханаагүй юм. Энэ их тэмдэг, гайхамшгийг үзсэнийхээ дараа Мосе хэрхэн залбирсныг үзнэ үү:

Одоо тэгэхлээр гуйж байна, хэрэв би Таны мэлмийд тааллыг олсон бол замуудаа надад мэдүүлээч. Тэгвэл би Таныг мэдэж, Таны мэлмийд тааллыг олох юм. Энэ үндэстэн Таны ард түмэн гэдгийг ч харгалзан үзээч гэв. Тэгтэл Тэр —Миний оршихуй хамт явж, Би чамд амралтыг өгнө гэв. Дараа нь Мосе Түүнд —Хэрэв Таны оршихуй явахгүй бол биднийг эндээс бүү явуулаач. Эс тэгвэл би болон Таны ард түмэн мэлмийд тань тааллыг олсон нь юугаар мэдэгдэх вэ? Та бидэнтэй хамт явж байгаагаар бус уу? Тэгвэл би болон Таны ард түмэн бид газрын хөрсөн дээр буй бүх ард түмнээс ялгагдах юм гэв. ЭЗЭН, Мосед —Чиний хэлсэн энэ зүйлийг Би бас хийнэ. Учир нь чи Миний мэлмийд тааллыг олсон. Би чамайг нэрээр чинь мэддэг гэж айлдав. Тэгэхэд Мосе — Алдраа надад үзүүлээч, гуйж байна гэжээ. (Гэтлэл 33:13-18)

Бурхан Мосед том санал тавьжээ. Цөлд зовж яваа Мосед Бурхан хүмүүсээ дагуулж яваад, Амлагдсан газартаа ор гэжээ. Тэр байтугай тэнгэрэлч нараараа аян замыг нь аюул, саадгүй болгохоо ч амлаж. Тэр газар нь цэцэрлэг жимсээр дүүрэн, сүү балаар халгисан үзэсгэлэнтэй сайхан нутаг болохыг ч сануулж. Гэхдээ нэгэн зүйл нь - Бурхан Өөрөө тэдэнтэй хамт явахгүй гэжээ. Мосе үүнийг дуулмагцаа, татгалзахын аргагүй тэр саналаас нь татгалзжээ. Мосе үндсэндээ: “Надад амлалтаас илүү Тал хэрэгтэй” гэж хэлжээ. Энэ үг Бурханы сэтгэлийг хичнээн баясгасан бол.

Үүгээр ч зогсохгүй Мосе бүр: “...замуудаа надад мэдүүлээч. Тэгвэл би Таныг мэднэ...” (Гэтлэл 33:13) гэжээ. Бурханыг таньж мэдэхийн тулд Түүний замыг мэдэх хэрэгтэй! Бурхан хүч, хангамжийг нь төдийгүй, зүрхийг нь хайдаг хүмүүст замаа

мэдүүлдэг юм. Харин Бурханы зүрхийг мэддэг хүмүүс хүч дотор явна: “Харин Бурханаа мэдэгч ард түмэн хүчирхэг болж, үйлдэл хийнэ” (Даниел 11:32).

Би дөнгөж үйлчилж эхлэж байхдаа, өглөө болгон шахуу 1-2 цаг залбирдаг байлаа. Тэгээд нэг иймэрхүү залбирал хэлнэ: “Бурхан минь, намайг хүмүүсийн сүнсийг аврахад, өвчтэйг эдгээхэд, чөтгөрүүдийг хөөхөд ашиглаач.” Би энэ л залбирлыг янз бүрээр давтан залбирсаар байна. Би тийм холын хүрээтэй үйлчлэлийн төлөө Бурхан руу хашхирч байхдаа, өөрөө өөртөө амиа бодохыг мэддэггүй хүн шиг л санагддаг байлаа.

Тэгтэл нэг өдөр Эзэн надтай ярив: “Хүү минь, залбирал чинь ямар ч байгүй, амиа бодсон залбирал байна.” Энэ үг намайг цочроов.

-“Чи ямар сэдлээр энэ бүхнийг хийх нь вэ? “Намайг ашиглаач” л гэх... *чи өөрөө* л өөрийнхөө залбирлын төвд байгаа бус уу? Би чамайг сүнсийг авруулж, чөтгөрүүдийг зайлуулж, өвчтэйг эдгээлгэх гэж бүтээгээгүй. Би чамтай дотно нөхөрлөх гэж л бүтээсэн.”

Энэ үг намайг бүр ч их цочроов. Дараа нь Бурхан надад хэзээ ч мартахааргүй нэгэн зүйлийг харуулав: *Иудас Есүсийн нэрээр л хүмүүсийг чөлөөлж, өвчтэйг эдгээсэн!* Тийм ээ, Есүс арван хоёроо илгээхдээ, бүгдийг нь илгээсэн - тэр дунд хожим Есүсээс урвах Иудас ч явсан. Миний бай буруу байжээ. Бидэнд хандсан Бурханы зорилго - Түүний тэнгэрийн шагнал болбоос *Есүс Христийг таньж мэдэх* явдал болой (Филиппой 3:10).

Хэдэн жилийн дараа Лиза цуглаандаа бэлтгэн бас л нэг иймэрхүү залбирал хэлжээ. Тэгээд Эзэн, Лиза хоёрын дунд дараах яриа өрнөсөн байна. Эзэн Лизад: “Лиза, Би хүмүүсийг *ашигладаггүй*. Би хүмүүсийг тослодог, эдгээдэг, өөрчилдөг, Өөртэйгээ адилхан болгож баталгаажуулдаг болохоос, хүмүүсийг *ашигладаггүй*.” Тэгээд цааш нь: “Лиза, чи найздаа ашиглуулж үзсэн үү?” гэж асууж.

- “Үзсэн.”

- “Ямар байсан?”

- “Ашиглуулчихсан юм шиг л!”

Эзэн цааш нь: “Олон үйлчлэгч нар Над руу “Намайг ашиглаач!” гэж хашхирдаг: “Эдгээхэд ашиглаач, нөлөөлөхөд ашиглаач, аврахад ашиглаач.” Тэгэхээр нь Би тэдний сэтгэл зүрхийг нь олох байх гэсэндээ, хүссэнийг нь ёсоор нь болгож өгсөн ч, тэд

үйлчлэлдээ автаад, таг болсон. Тэд Миний арга замд суралцахад нэг ч анхааралгүй, *хувийнхаа* гүрэнг байгуулах гэж Миний тэдэнд өгсөн бэлэгийг хэрэглэдэг. Зовлон тохиоход тэд Над руу хашхирдаг ч, хүссэн цагт нь, хүссэн аргаар нь залбирлынх нь хариуг өгсөнгүй гэж гомдоллодог. Тэд ашиглуулсан мэдрэмждээ уурлан, Надад хорсдог. Тэд Намайг мэдэхгүй учраас, явдаг” гэж хэлжээ.

Жишээлбэл эр нөхрөө таньж мэдэх ямар ч сонирхолгүй, зүгээр л тэр хүнээс хүүхдүүд төрүүлэх цор хүсэлтэй эмэгтэй байвал яах уу? Тэр эмэгтэй нөхрийнхөө хөлд унаад: “Эр нөхөр минь, үр удмаа залгуулахдаа *намайг ашиглаач!* Гуйя, надад хүүхэд хайрлаач. Эс бөгөөс би үхье!” гэж уйлан хайлбал яах уу? Жаахан гажигтай сонсогдож байгаа ч, энэ нь Бурхантай ямар ч харилцаагүй атлаа “Хүмүүсийг аврахад намайг ашиглаач!” гэж Бурхан руу хашхирч байгаагаас маань ялгаа юун. Бид Бурхантай дотно бол, хүүхдүүд аяндаа л төрнө - эр, эм хоёр дотно байхад хүүхэд төрдөгтэй л адил.

Тэгэхээр Израильчууд зөв зүйлээ хайж, мөшгөөгүй. Тэд *Бүтээгчийг бус, бүтээлийг* хайсан. Тэгээд яаж дууссаныг нь бид мэднэ. Цөл нь угтах бэрхшээлд бэлтгэх цэц ухаан, хүчээр хангах бэлтгэл сургуулийн газар болохын оронд гарз хохирлын газар болж, эцэстээ тэр үеийнхэн цугаараа мөхсөн. Дэндүү хайран! Амлагдсан газар хаяанд нь байсан шүү дээ.

Энэ бол том сургамж! Энэхүү сүр жавхлантай дотно харилцааныхаа аян замд бид цөлд нааштай хандах ёстой юм.

5

ШИНЭ ДАРС

*“Таны шинэ дарс тэргүүтнийг шинэтгэдэг
савууд байх болтугай бид”*

—Ефрем де Сириан

*Урьдын юмыг бүү дурсагтун. Эртний юмыг
бүү бодогтун. Үзэгтүн, Би шинэ зүйл хийх
бөгөөд Тэр нь одоо соёолж гарна. Та нар үүнийг
мэдэхгүй гэж үү? Би хээр талд зам тавьж, цөлд
гол урсгана.*

—Исаиа 43:18-19



Бурханыг дотно таньж мэдэхийн тулд бид өөрчлөлтөд нааштай хандах ёстой. Харин үүнийг хийх шилдэг газар нь цөл юм.

Хувхай, хөсөр энэ газар бид Ариун Сүнсний шинэ хөдөлгөөнийг гэрчлэн харна.

Бидний хамгийн их зөрчилддөг асуулт болбоос: *Заавал яахаараа хуурай, бэрх цагаар туулж байж өөрчлөлт өрнөдөг юм бэ?* Тэгвэл бүгдээрээ энэ бүлгээрээ зарим нэг гаргалгааг харна.

Арван найман сарын цөлийн аяллынхаа дараа би залуусын цуглааны удирдагчаар сонгогдов (тийм ээ, их эртний түүх шүү!) Би залуусын чуулганд ажиллаж явсан туршлагагүй учраас, Америкийн хамгийн хурдан өсч яваа Флоридагийн тус чуулганд үйлчлэхээс нилээд сүрдэж байлаа. Гэхдээ Бурхан намайг илгээсэн гэдгийг мэдэж байсан болохоор, Түүнийг хичээнгүй хайх аваас, бүх зүйл сайн болох л ёстой байв.

Тэр залуусын чуулган нь хүүхдүүдийг янз бүрийн, хөгжөөнтэй үйл ажиллагаагаар бөмбөгдөх маягаар явдаг, уламжлалт загвар дээр л тогтсон чуулган байлаа. Харамсалтай нь тэдгээр өсвөр насныханы дийлэнх нь сүнсээр олигтой өсөөгүй байв. Олонх нь хамаа намаагүй амьдралтай. Тиймээс намайг удирдаж эхлэх үед Ариун Сүнс: “Гэмшил, ариун байдал, дуулгавартай байдал, удирдлагадаа захирагдах талаар сурга” хэмээн айлдахыг сонсов. Тиймээс би энэ тухай л зааж, номлосон бөгөөд тодорхой хугацааны дараа бүлгийнхэний уур амьсгал орвонгоороо өөрчлөгдлөө.

Үр дүн нь ч гайхмаар байв. Хэдхэн сарын дотор залуусын бүлэг маань гурав дахин өсөв. Бурханаас хол явсан гэмт хэргийн бүлэглэлийнхэн, гаж бүлэглэлийнхэн, хориод настнууд юу юугүй л Есүсийг мэдэх болов. Өмнөх бүлэгт явдаг байхдаа итгэлээсээ няцсан олон залуусын итгэл дахин дүрэлзэв. Бид Бурханы цул оршихуйд дурлаж, Бурханыг хайрлах хайр маань өсч байлаа. Бурхан биднийг, бидний хүчин зүтгэлийг ер бусаар ерөөв.

Би Далласын цөлөөс гараад удаагүй байсан болохоороо амьдралынхаа бүх цөлийг дуусгачихсан гэдэгтээ итгэл дүүрэн байлаа. Эдүгээ би Сайн мэдээг номлох дуудлагадаа нэг мөр хөл тавин оржээ. Би “Есүс нэг л удаа цөлд очсон болохоор, би ч бас нэг л удаа очно” гэж бодож байлаа. Гэтэл дэндүү буруу байв. Ариусгал, хүчийн тал дээр надад засах зүйл бас л их, цөлийн талаар сурах зүйл бас л их байв. Хожим миний үзсэн цөл өмнөх арван найман сарын цөлийн аяллыг маань хүүхдийн наадгай шиг л санагдуулж билээ.

Ариун Сүнс манай удирдлагын багт маш олон шинэ санаа өгч байлаа. Цөлийн бэлтгэлийн дараа тэнгэрээс шинэ дарс асгарч, бид “Бурханаар илгээгдэх” үед ийм л зүйл болдог. Бурхан бидэнд яаж Мосе, Давид, Иосеф шиг үр нөлөөтэй, үр жимстэй байхыг харуулж байгаа нь тэр.

Залуус маань үнэхээр ер бусаар өсч байв. Тэгтэл энэ бүх амжилтын дунд сэтгэл маань цуглааны гадна байгаа хүмүүсийн төлөө энэлэн шаналах болов. Төв Флорида даяар байгаа бүх залууст хүрэх хэрэгтэй хэмээн бодогдоно. Тэгээд залбирч байтал, *Залуусынхаа цуглааныг зурагтаар дамжуулбал ямар вэ?* гэсэн санаа төрлөө. Энэ нь 1980-аад онд Сайн мэдээг дэлгэрүүлэх шилдэг арга байв. Тэр үед чинь интернет, олон нийтийн сүлжээ, Ютүб, ухаалаг утас - юу ч байгаагүй шүү дээ. Гэтэл манай хотын хамгийн том телевиз дөрвөн сая хүнд хүрэх хүчин чадалтай болохыг олж мэдэв. Хамгийн догь нь тэр телевизийн Хагас сайны 22 цаг нь боломжтой байж таарав. Энэ нь өсвөр насныханыг “олзлох” сайхан цаг байлаа.

Би энэ санаагаа тэргүүн пастортаа хэлтэл, тэрбээр манайд ийм том юм хийх төсөв байхгүй гэсэн болохоор, би пастораасаа энэ телевизийн хөтөлбөрийг санхүүжүүлэх ажилд залуусыг уриалж болох эсэхийг асуув. Пастор ч зөвшөөрсөн тул би хүүхдүүддээ төв Флорида даяар хар тамхи, архинд донтох гэх мэт элдэв асуудалд баригдсан залууст хүрэх алсын хараагаа танилцууллаа. Залуусын бүлгийн хүүхдүүд алсын харааг минь дэмжиж, бид сонин түгээх, түргэн хоолны газар ажиллах, жижиглэнгийн худалдаа хийх зэрэг төрөл бүрийн хагас цагийн ажлын орлогоороо дамжуулан Хагас сайны орой бүр мөнөөх телевизийн байранд нэвтрүүлэг хийх хангалттай хэмжээний барьцааны мөнгө хуримтлуулав.

Манай тэргүүн пастор гайхаж, үүнийг Бурханы үйлс хэмээв. Энэ бол шинэ дарсны үр дүн байв - чуулганы залуусын бүлэг Хагас сайны 22 цагт телевиз дээр очиж нэвтрүүлэг хийх нь тэр бүр

тохиолдоод байдаг үйл явдал биш шүү. Гэхдээ энэ ажил бүтсэн юм. Төдөлгүй бид тэр “шинэ дарсыг” хүлээж аваагүй байсан бол, Сайн мэдээг хэзээ ч сонсохгүй байсан сүнснүүдийн арвин ургацыг хурааж гарав. Намайг залуусын пасторын үйлчлэлээ орхисноос олон жилийн дараа ч манай “Галтай залуус” зурагтын нэвтрүүлгээр дамжин амьдрал нь өөрчлөгдсөн тухайгаа гэрчилсэн олон хүн таарч билээ.

Өөрчлөлт сайн зүйл

Залуусын бүлгийнхээ талаар удахгүй үргэлжлүүлэн ярина. Харин одоо шинэ дарс гэж юу болох, энэ яагаад чухал болох талаар тодорхойлон ярилцъя.

Бурханы бидэнд хүсдэг өөрчлөлт нь ер нь бол амаргүй боловч, хэзээд үр жимстэй, сайн зүйл байдаг. Өөрчлөлт нь бидний тав тухын төвшинг хөнддөг учраас, бид өөрчлөлтөд дургүйцдэг. Хүн ер нь дадал хэвшлийн амьтан. Шинээр тогтоогдсон хэв маягт дасах гэж наян юм болно. Гэхдээ Бурханы хаанчлал дотор үр нөлөөтэй байхын тулд бид өөрчлөлтөд нээлттэй хандахаас өөр аргагүй.

Бурханлаг гэр бүлд өссөн хүний итгэлийн үйлдэл, арга барил, уламжлал эртнээс хэлбэршсэн, гүн суурьтай байдаг. Мэдээж уламжлал бүхэн буруу биш боловч, хүмүүс зүрхнээсээ бус, дан уламжлалаар хандаад байвал, итгэлийн илэрхийлэл нь амьгүй дэглэм болно.

Үнэндээ иймэрхүү дэглэм нь шашны бат цайз болох нигууртай. Бурханлаг дүртэй шашинжсан хүн нь Бурханы эрт урьд үйлдсэн юмсаар түрүү барин, одоо үйлдэж буй үйлсийг нь эсэргүүцдэг.

Есүсийн цагт амьдарч байсан Фарисайчууд тэргүүтэй шашны удирдагч нар яг ийм байдлаар үйлддэг байсан. Тэд Абрахамын хүүхдүүд, гэрээний хөвгүүд, Мосегийн хүүхдүүд гэдгээрээ сайрхсан. Тэд Бурханы үйлдсэн зүйлсээр түрүү барихдаа, яг өмнө нь зогсож буй Бурханы Хүүг эсэргүүцсэн юм. Есүс ирээд тэдний тав тух, тогтвортой амьдралын тал бүрийг нь хөндсөн учраас, мөргөлийн уламжлал, хэв маягтаа улайрсан тэр хүмүүс тавгүйтэн зөрчилдөж эхлэжээ. “Тэд Бурханыг хайрцаглахгүй, харин өөрсдөө Бурханы хайрцагт багтах ёстойг” Есүс маш тодорхой айлдсан юм. Гэтэл тэд энэ өөрчлөлтийг эсэргүүцэн, уламжлалаасаа чаргууцалджээ.

Шашинжсан хүн зүгээр л “Бурхан гагцхүү бидний параметр

дотор гагцхүү биднээр дамжуулан ажиллана” гэдэг элит хандлагыг хөгжүүлэн бий болгодог бөгөөд үүнийг дураар нь орхибол, эцэстээ худлаа шүүх тэгээд үзэн ядалт, урвалтыг авчирна. Есүсийн цаг үед ч ийм зүйл болсон, чуулганы түүхэнд ч ийм зүйл байсан.

Үүнийг өөрчилж, итгэл, алдрын нэг төвшнөөс нөгөө рүү дэвшихийн тулд бид тав тухын бүсээсээ гарч, Бурханы Сүнсний удирдамжийг мөшгих ёстой. Энэ зам нь Бурханы биднээс шинэ амьдралыг төрүүлдэг цөлөөр дайрч гарах нь олонтаа.

Энэ үлгэр загварыг Иохан баптистын амьдралаас бэлээхэн харж болно. Түүний аав нь тахилч - нэг үе бүр тэргүүн тахилч явсан хүн. Иохан явсаар, явсаар эцэстээ аав шигээ тахилч болох замналтай байв. Тэрбээр Иерусалим дахь сургуульд сурч, Гамалиел хэмээх алдарт багшийн дор тахилч болохоор сургагдах байв. Гэтэл нэг өдөр Эзэний Сүнс Иоханыг цөл рүү дуудсан. Иохан залбирах тусам, цөлд татагдах дотоод ятгалга нь бэхэжсээр байв. Түүний дотор иймэрхүү маягийн бодлын тэмцэл зөрчил өрнөж байсан гэдэгт би эргэлздэггүй:

Хар багаасаа хамт өссөн нөхөд маань бүгдээрээ л “Библийн сургуульд” сурлаа. Тэд албан ёсны диплом хүлээн авч, удирдагч нар болчихлоо.

Тэд томилогдож, улсынхаа дурын синагогт заах эрхтэй болно. Тэд намайг юу гэж бодох бол? Би “Библийн сургуульд” сурахгүй бол, хувь тавилангаа хэрхэн биелүүлэх билээ?

Амьдралд маань дуудлага байгааг би мэднэ. Намайг мэндлэхэд өндөр зэрэгтэй тэнгэрлч намайг үйлчлэгч болно гэж аавд маань хэлсэн гэдэг. Гэтэл би цөл рүү явбал, хүмүүс намайг хэн байсныг хэзээ ч мэдэхгүй өнгөрнө. Надаар хэн ч номлуулахгүй.

Тийм боловч Иохан цөлд дуудагдсан халуун дуудлагаараа тархи толгойг нь бөмбөгдөх энэ олон эргэлзээг ялаад, Сүнсийг даган цөл рүү явахаар шийдсэн юм. Түүний талаар “Хүүхэд өсөж, сүнсээр хүчирхэг болсон бөгөөд Израилийн өмнө гарч ирэх өдрөө хүртэл цөлд амьдрал (Лук 1:80) гэдэг. Иохан зургаахан сар үйлчлэхийн төлөө хүүхэд байхаасаа л цөлд бэлтгэгдэж эхлэсэн нь сонин байгаа биз. Тийм атал Есүс Иоханыг “эмэгтэйгээс төрсөн” хамгийн аугаа эш үзүүлэгч гэсэн билээ.

Бичээс Иоханд ямар, ямар хатуу хөтүү нөхцөл тулгарсан, тэрбээр ямар ямар цөлийг туулсан, цөлд хичнээн хугацаа өнгөрөөсөн талаар юм хэлээгүй. Лук 3:2 дээр “Аннас болон Каиаф нар тэргүүн тахилч байх үед цөлд буй Захариагийн хүү Иоханд Бурханы үг ирэв” гэдэг. Аннас, Каиаф хоёрыг утгаа алдсан шашны

систем дор үйлчилж байхад хатуу, ширүүн хуурай цөлд цоо шинэ сав хэлбэршиж байсан нь сонирхолтой.

Аян замд аминд орох арга

#5 Байшин барилгүй, майханд амьдар

Цөл нь цаг зуурын - зүгээр л дамжин өнгөрөх гэдгийг бүү март. Тиймээс цөлд байхдаа байшин барилгүй, майханд амьдар!

Израильчууд хэдийгээр олон арван жил цөлөөр тэнэсэн ч, Бурхан үүнийг төлөвлөөгүй юм. Бурхан тэдэнд боломжийн газраа олоод байшин барьж суурьшаад, үзэгдэх бодит байдалтайгаа эвлэр гэж хэлээгүй. Израильчууд майханд амьдарч байсан бөгөөд хэзээ хэзээгүй хамаг юмаа хамж аваад, хөдлөхөд бэлэн байсан. Цөл нь хэзээ ч эцсийн зорилго байгаагүй, харин түр зуурын нөхцөл байв. Бурхан: „Хөөе, цөл чинь гайгүй юм байна. Амлагдсан газар хэнд хэрэгтэй юм? Бүгдээрээ суурь ухаад, боломжийн сууц барьцаа” гэж хэлээгүй. Тийм ээ, Бурхан Өөрөө ч цөлд байхдаа майханд амьдарсан юм шүү.

Хуарагнах нь богино хугацаанд зугаатай, сайхан байж болох ч, ихэнх хүмүүс гадаа байснаас жинхэнэ байшинд аж төрөхийг илүүд үзнэ. Тиймээс төөрөлдөөд, цөлд суурь тавьчих бий. Юу юугүй хуучин майхнаа хураагаад, хамаг юмаа хамж аваад нүүхэд бэлэн байгаарай.

Бурхан Иоханыг тухайн үеийн “Библийн сургуульд” бус, харин цөлд бэлтгэсэн! Гэтэл цөлд Иоханаар дамжуулан хэлсэн Эзэний Үгийг Иүдеа, Самарийнхан сонсохоор оволзон ирсэн. *Шашны газруудад бус, чухам цөлд л Сүнсний шинэхэн хөдөлгөөн сэвэлзэж - шинэ дарс асгарч эхлэсэн. Шашны хуурамч байдал, уламжлалыг жигшсэн хүмүүс Бурханы Хүүгийн айлчлалд бэлтгэн, өөрчлөгдөхөд бэлэн зүрхээр Иоханыг сонсохоор очжээ.*

Үүнээс хойш нэг их удалгүй Есүс Иоханаар баптисм хийлгэхээр Иордан гол дээр ирэв. Иохан өөрийгөө Есүст баптисм хийгээд байх зохистой хүн биш гэж үзсэн ч, Есүс үүнийг хүсчээ. Есүсийн хувьд,

тухайн цаг үед Бурханы Сүнсний газар дээр үйлдэж буй ажлаас тодрон гарч ирэх нь Түүний үйлчлэлд зайлшгүй чухал байлаа. Тэгээд Есүс Сүнсээр дүүрээд, тэр даруй цөл рүү хөтлөгджээ.

Есүс цөл рүү хөтлөгдөхдөө, Сүнсээр *дүүрэн* байсан бол, дөч хоногийн шалгуур, сорилын дараа Сүнсний *хүч дотор* цөлөөс гарч ирснийг нь Библи маш тодорхой хэлдэг. Есүс газар дээр биелүүлэхээр ирсэн тэр л үйлчлэлдээ бүрэн бэлтгэгджээ. Иохан Баптистын үйлчлэлээс хэдхэн сарын дараа цөлөөс өөр шинэ зүйл ундарсан нь Есүс Христийн үйлчлэл байв.

Шинэ дарсны тулам

Есүсийн үйлчлэл эхлэснээс хойш удалгүй ийм нэгэн явдал болжээ: “Тэд Түүнд —Иоханы шавь нар ба фарисайчуудын шавь нар байнга мацаг барьж залбиралаа өргөдөг. Харин Таных идэж, ууцгаах юм гэсэн” (Лук 5:33). Хамгийн түрүүнд ““тэд” гэдэг нь хэн бэ?” гэж асуух хэрэгтэй. Хариултыг нь Матайн Сайн мэдээнээс олж болно: “Дараа нь Иоханы шавь нар Түүн дээр ирж...” (Матай 9:14). Олон жил би энэ хүмүүсийг Фарисайчууд байсан гэж бодож явсан ч, нэг өдөр Иохан Баптистын дагалдагч нар байсныг нь олж мэдээд, Бичээсийн энэ хэсгийг цоо шинэ гэрлээр харах болов! Тэдгээр эрчүүд, эмэгтэйчүүд байнга мацаг барьж, олон цагаар залбирч байхад, Есүсийн дагалдагч нар огт тэгэхгүй байгаад дургүйцжээ. Иоханы дагалдагч нар хамаг л золиосыг гаргаж байхад, Есүсийн дагалдагч нар хамаг л анхаарлыг хүртэж байв.

Иоханы үед Бурханы Сүнс мацгаар дамжуулан маш их хөдлөдөг байж. Гэтэл Иоханы дагалдагч нар Иоханы үйлчлэлийн загвараас Бурханы Сүнсний *одоогийн* үйлс рүү шилжээгүй буюу өөрчлөгдөөгүй байв. Өөрсдийнх нь үйлчлэлийн *арга барил*, хүндэтгэл л үр жимс авчирсан гэдэгт тэд итгэлтэй байжээ. Тэд Иохан Баптистыг дагах гэж өндөр төлөөс төлж, ар гэрээ орхиод, цөлд шавьжаар хооллосон ч, эдүгээ удирдагч нь шоронд оржээ. Гэтэл Тэр шинэ Хүний дагалдагч нар тэдний дүрмээр тоглохгүй байв. Иоханы багийнхан шаралхсандаа шашны сүнсийг хөгжүүлэх аюулд оржээ.

Шашны сүнс хэзээд Бурханы одоо *үйлдэж буй* зүйлийг эсэргүүцэж, Бурханы урьд өмнө *үйлдсэн* зүйлээр түрүү барьдаг гэдгийг бүү мартаарай. Иоханы дагалдагч нар Бурхан *одоо* юу хэлж, хийж байгааг анхаарахаасаа илүүтэй, удирдагчдаа үнэнч

байх тал дээр, дагалдагч нарын биеэ авч явах тал дээр л анхаарч байв. Тэдний хараа Бурханы зүрх дээр тогтохоо байжээ. Нэгэнтээ Бурханы зүрх рүү хөтлөж байсан *арга барил* нь эдүгээ тэдний гол төвлөрөл болжээ.

Тэгээд бардамнал, гомдол дарангуйлж эхлэв. Иохантай хамт байгсад нь үйлчлэлд цагаа - магадгүй бүр мөнгөө зориулсан байх. Гэтэл тэдний тэмцэн хамгаалсан, хийсэн, олж авсан бүхэн нь аюулд тулаад байв. Тиймээс хэдийгээр удирдагч нь өөрөө Есүсийн талаар “Тэр өсөж, харин би буурах ёстой” (Иохан 3:30) хэмээн мэдэгдэж байсан ч, тэд шашны лаг шавартаа улам шигдээд, өөрчлөлтийг эсэргүүцжээ.

Тэгвэл Есүс тэдэнд хэрхэн хариулсныг үзнэ үү: “Шинэ хүргэнийг байхад та нар бараа бологчдоор нь мацаг бариулж болохгүй биз дээ?” (Лук 5:34) Есүс: “Бурханы Хүү Өөрөө тэдний дунд зогсож байхад, яагаад мацаг барих ёстой гэж? Бурханаас ямар нэг юм хүсч байгаа бол, Над руу ирэхэд л болно” гэсэн утгатай үг хэлснээрээ, тэдний шашинлаг арга замыг илчилжээ. Шашинлаг сэтгэхүй нь тэднийг Бурханы тааллыг мацаг тэргүүтэй шашны зан үйлээр олж авах ёстой гэдэгт итгүүлжээ. Тэд мацгийг Бурханд хүрэх арга гэж үзсэн учраас л, энэ асуудлаа мацаг барьдаггүй (юмуу эсвэл тэдний арга арга барилыг хэрэглэдэггүй) хүмүүсээс дээр тавьжээ. Ийнхүү бардамналд суудал засч өгсөн байна. Арга барил нь жинхэнэ үр жимсээсээ чухал болжээ.

Хоолноос мацаг барих тустай ч, энэ нь Бурханыг шахаанд оруулах бус, харин таныг Бурханы үгийг илүү сайн сонсох байр сууринд хүргэх зорилготой юм. Тэгэхээр Бурхан Өөрөө яг дэргэд нь байсаар байхад, яахаараа дагалдагч нар Бурханы дуу хоолойг сонсохоор мацаг барих ёстой гэж? Лук 5:34-35-ыг дахиад харна уу: “Есүс тэдэнд —Шинэ хүргэнийг байхад та нар бараа бологчдоор нь мацаг бариулж болохгүй биз дээ? Харин хүргэн тэднээс аваачигдах өдрүүд ирнэ. Тэр өдрүүдэд тэд мацаг барина гэв.”

Есүс дагалдагч нараа хожим мацаг барих хэрэгтэй болж магадгүй гэж хэлээгүй, харин заавал мацаг барина гэжээ. Иоханы дагалдагч нар гагцхүү хоолноос мацаг барих талаар ярьсан бол, Есүс тэс өөр мацгийн талаар ярьжээ. Тэр мацаг нь Сүйт хархүү аваачигдсан өдрүүдэд өрнөнө гэдгийг тэмдэглэнэ үү. Есүс хоолоор төдийгүй, Түүний бодит оршихуйгаар дутах талаар өгүүлжээ. Есүсийн сургаалт үлгэрийнх нь тайлбараас үүнийг мэдэж болно. Цөл нь нэг талаараа Бурханы бодит оршихуй байхгүй байх нөхцөл гэдгийг бүү мартаарай.

Одоо Есүс сургаалт үлгэрээ хэрхэн тайлбарласныг үзнэ үү:

Хэн ч шинэ дарсыг хуучин туламд хийдэггүй. Тэгвэл шинэ дарс тулмыг зад татна. Дарс асгарч, тулам ч сүйднэ. (Лук 5:37)

Библи дээр дарс нь Бурханы оршихуйн билэгдэл болно. Ефес 5:18 дээр Паул “Дарсанд бүү согтуур. Эс бөгөөс хэт самуурал буй. Харин Сүнсээр дүүр” гэсэн.

Бид Бурханы оршихуйн дарсаар дүүрэх боломжтой болсон! Шинэ дарс нь Бурханы Сүнсний шинэ хөдөлгөөн юм.

Би энэхүү чухал асуудлыг дахин товч дурьдъя. Сүнсээр дүүрэх нь ямар гайхамшигтай байдгийг санаж байна уу? Бурханы оршихуй маш амттай бөгөөд хүчтэй байдаг. Та залбирах бүрий, Түүний оршихуй шууд үзэгдэж, Бурхан дэргэд байгааг өдөржин мэдэрнэ. Заримдаа чуулганд Бурхан тантай дэндүү дотно байх учраас, та зүгээр л суугаад, уйлдаг.

Тэгтэл нэг л өдөр Бурханы оршихуй мэдрэгдэхгүй байгааг анзаарна. Урьдынх шигээ л залбирсаар байв ч, Бурхан минь, Та хаана байна? гэмээр оргүй хоосон санагдана. Та цөлд иржээ!

Бурханы оршихуйгаас мацаг барих цаг буюу цөл нь өөрийн гэсэн шалтгаантай байдаг. Бурхан таныг шинэ тулам болгохоор бэлтгэж байгаа ажээ. Та Бурханы Сүнсний шинэ хөдөлгөөн болох шинэ дарсыг хуучин туламд хийж болохгүй.

Есүсийн үед хонины арьсаар хийсэн савыг дарсны тулам болгон хэрэглэдэг байжээ. Анх дарсыг хийж байхад, арьс нь уян зөөлөн байв. Дарсныхаа хэмжээгээр амархан сунаж, хаашаа л бол хаашаа тэлнэ. Гэтэл цаг хугацааны явцад дарсны тулам маань Ойрх Дорнодын уур амьсгалын эрхээр хатаж агшаад, хатуурч хэврэгшдэг байна. Одоо тэр туламд дарс юүлбэл хатаж, хорчийсон арьс шинэ дарсны жинг ч, хүчин чадлыг ч дийлэлгүй, амархан цуурч урагдаж мэдэх. Энэ асуудлыг засахын тулд хуучин тулмыг хэдэн өдрийн турш усанд дэвтээгээд, дараа нь чидуны тосоор сайтар элдэнэ. Ингэж дарсны туламны уян хатан чанар, сунах чадвар сэргэнэ.

Энэ нь бидэнд тохиох явдлын билэгдэл юм. Учир нь бид сүнсний шинэ дарсны тулам билээ. Бид Бурханы оршихуйг тээхээр дуудагдсан. Хүрээлэн буй уур амьсгал маань бидний эмзэг мэдрэг талыг Бурханд нээж өгдөг. Бид тэнгэрт бус, харин дэлхий хэмээгдэх завхарсан орчинд аж төрж байна. Тиймээс ухаан санаа маань шинэчлэгдэх ёстой. Дарсны тулмаа уян зөөлнөөр нь хадгалж - ямагт шинэ дарсанд бэлэн байхын тулд бид Бурханы Үг дотор дэвтээгдэх ёстой. Ефес

5:26 дээр Паул “Тэр (Есүс) чуулганыг үгээр дамжуулан усанд угааж цэвэрлэн, ариусгаад” гэж бичжээ. Тулмыг чидуны тосоор зөөллөж элдэх нь Бурханыг залбирлаар эрэн хайх явдал юм. Бид Бурхантай Үгээр болоод залбирлаар уулзахад, ухаан санаа маань шинэчлэгдэж, цаашид арга барил, замдаа хатуу болхи загнахгүй.

Гэхдээ дарсны хуучин тулмыг сэргээхийн тулд эхлээд хуучин дарсыг нь асгах хэрэгтэй! Сав хоосорно - өөрөөр хэлбэл Бурханы бодит оршихуй байхгүй болно! Энэ нь Бурханы бодит оршихуйгаас “мацаг барих” цаг буюу цөлийн хуурай цаг болой! Энэ улирал таныг *өөрчлөлтөд* бэлтгэнэ!

Бурхан яагаад Өөрийнхөө бодитой оршихуйг татчихдаг вэ? Таныг гонсойлгох гэсэндээ тэр үү? Үгүй юм аа. Мэдээж амьдралд гонсойх явдал зөндөө гарна. Тэгвэл таныг хэрэгтэй цаг болтол нь шүүгээндээ хадгалж байх гэж тэр үү? Үгүй юм аа. Үнэндээ Бурхан таныг Өөрийг нь улам ихээр хичээнгүйлэн хайгаасай гэсэндээ л оршихуйгаа татдаг юм. Хайгуул нь таныг улам л уян хатан болгоно. Бурханыг хайхаа больчихсон хүмүүс л хатуурч, дагдаршдаг. Тэд арга барил дээрээ суурьшдаг. Тэд хуучин бодит туршлагаасаа тунгаан гаргасан томъёон дээрээ суурьшдаг.

Иохан Баптистыг дагадаг хүмүүс яг л ийм байсан. Эзэн Иохан Баптистаар дамжин хүчтэй ажиллаж байгааг харсан учраас л тэд Иоханд наалджээ. Гэтэл сүүлдээ тэд Бурханыг дотно таньж мэдэх тэнгэрийн шагналын төлөө үргэлжлүүлэн давшаар байхын оронд итгэл, арга барилдаа зангирчээ.

Бурханы хөдөлгөөн бүртэй хамт шинэ сургаал ирдэг. Сургаал, эрүүл доктрин нь бидэнд Бурханы зүрхийг л хүртээх зорилготой зүйлс юм. Гэтэл хэрэв бид хараагаа сургаал, доктрин дээр гацаачихбал, шашинлаг хүлээс, хуульчлал, алдааны аль нэгд юмуу эсвэл бүгдэд нь унана.

Бурханыг хүндэтгэлийн хатуу хөшүүн арга барилаар таньж мэдэхгүй. Гэтэл Христэд итгэдэг олон хүн өөрөө ч мэдэлгүй ийм амьдралын хэв маягт шигдчихдэг. Тэд “яг л ийм маягаар хүндэтгэх ёстой” гэсэн үлгэр загвар, үе шат, дэглэмийг тогтоодог. Тэгээд яваандаа “элит” Христэд итгэгч болмогцоо, эрэл хайгуулаа зогсоогоод, нөгөө хөгжүүлэн боловсруулсан үлгэр загвар, уламжлал дээрээ суурьшаад авна. Тэд хэдийгээр Сайн мэдээгээр бүрэн аж төрөөд байгаа боловч, дотроо хоос оргисоор л байна.

Иеремиа 29:12-13:

“Та нар Намайг дуудаж, ирж, Над уруу залбирахад Би та нарыг сонсоно. Та нар Намайг хайх бөгөөд бүхий л зүрхээрээ Намайг хайвал олно.”

Хоосон залбирлаар Бурханыг олохгүй. Шашны томъёонд хүлэгдсэн, маш итгэмжтэй залбирдаг хүмүүс олноороо бий. Залбиралд маань *Түүнийг* хичээнгүйлэн хайсан сэтгэл оршоосой гэж Бурхан хүсдэг. Залбирал нь зүгээр нэг дэглэм бус, харин эрэл хайгуул байх ёстойг Бурхан энд тодорхой айлджээ. Бурханы зүрхийг мэдэх гэсэн халуун хүсэл, хичээнгүй хайгуул. Тиймээс л Еврей 11:6 дээр Бурхан: “Бурханд ойртон буй нь Тэр байдаг гэдэгт болон Өөрийг нь хайгчдад Тэр Шагнагч нь болдог гэдэгт итгэх ёстой” гэжээ.

Тэгэхээр Есүсийн хэлсэн үгийг дахин харцгаая:

Хэн ч шинэ дарсыг хуучин туламд хийдэггүй. Тэгвэл шинэ дарс тулмыг зад татна. Дарс асгарч, тулам ч сүйднэ. Харин шинэ дарсыг шинэ туламд л хийх ёстой. Хуучин дарс уусан хэн ч (тэр даруй) шинийг нь хүсдэггүй агаад “Хуучин нь аятайхан” гэх бус уу гэж тэдэнд айлдав. (Лук 5:37-39)

Хуучин дарс хэрэглэж байсан ямар ч хүн тэр даруй шинэ дарс хүсэхгүй. “Тэр даруй” гэдэг нь түлхүүр үг юм. Учир нь хүн дадал хэвшил, үлгэр загварын амьтан. Бурхан тэр тав тухын бүсийг эвдэн, хуучин дарсыг асгаад, биднийг шинэ дарсаар цангаахын тулд бэлтгэлийн хуурай цагаар дарсгүй, хоосон явуулдаг. Уух юмгүй ангаж хатсан хүн: “Би наад шинэ дарсыг чинь уумааргүй байна, би тэдэн оны хуучин дарсаа л ууна” гэж гомдоллож маяглахгүй. Бурханы оршихуй, хүчийг үгүйлж байгаа хүн Бурханы шинэ хөдөлгөөнд амьдралаа дэлгээтэй байлгана. Та цөлд байхдаа:

“Бурхан, Та миний Бурхан Би Таныг эртлэн хайх болой. Усгүй, хуурай, ангамал газарт Сэтгэл минь Танаар цангаж, Бие махбод минь Таныг Хүсэн тэмүүлж байна. Таныг би ариун газарт хайсан. Таны хүч, Таны алдрыг харсан” (Дуулал 63:1-2) гэж хэлсэн Давид шиг л байна.

Давид Бурханы оршихуй, хүчээр цангасан. Тиймээс ч тэрбээр дуудагдсан ажилдаа орохдоо, Эзэний хүссэн зүйлд зохицсон бол, Саул хаан Бурханы арга замаар бус, өөрийнхөө арга замаар үйлдсэн байдаг.

Цөлийн удаах аялал

Энэ үед би залуусын пастораар үйлчилж эхлээд байснаа бүлгийнхээ эхэнд дурьдсан билээ. Телевизийн цуглаан маань маш амжилттай болсноос гадна бид бүс нутгийнхаа хоёр дахь том радиогоор Сайн мэдээ түгээдэг байлаа. Ер нь бүх ажил үйлс маань төгс өрнөж байв.

Тэгтэл нэг өдөр намайг залбирч байтал Бурханы Сүнс айсуу өөрчлөлтийн талаар хэлэв: “Би чамайг залуусын пасторын үйлчлэлээс чинь авч, Америкийн баруун эргээс зүүн эрэг, Канадын хилээс Мексикийн хил, Аляскаас Хавай... хүртэлх хотуудын чуулган, конференцууд руу илгээнэ.”

Би Сүнсний энэ үгийг Лиза, өөр мужид амьдардаг нэгэн найз хоёроосоо өөр хүнд хэлэлгүй, зүрхэндээ хадгалав. Энэ үгийг үнэхээр Бурхан айлдсаныг би бат мэдэж байлаа. Тэр үүнийг Өөрөө л хийнэ, миний тусламж Түүнд хэрэггүй.

Гэтэл нэг жил өнгөрлөө - юу ч болсонгүй. Хүлээх хугацаандаа надад Бурханы оршихуйд нэвтрэх улам л хэцүү болсоор, сүүлдээ бараг боломжгүй болов. Би урьд урьдынхаасаа ч ихээр залбирч байсан ч, ямар ч нэмэргүй байлаа. Үүнээс гадна залуусын бүлгийнхээ талаар тээж явсан алсын хараа маань ч хагдарсаар (хуучин дарс асгагдаж) байв. Залбирах тусам, алсын хараа маань улам л замхарсаар. Гаднаа ямар ч өөрчлөлт байхгүй, дотроо хүсэл маань аньсаар.

Би залуусын цуглаан эхлэхээс өмнө олон цаг залбирч, заримдаа бүр “өөр хүнээр номлуулаач” гэж Бурханаас гуйдаг байлаа. Би цуглаанд хов хоосон очив ч, яг үйлчлэх үеэр маань Бурханы оршихуй намайг хучаад л авна. Гэхдээ үйлчлэлээ дуусгаад, гэртээ харих замд маань Бурханы оршихуй дахиад л дээшээ өргөгдөөд, долоо хоног чимээгүй болчихно!

Энэ бүхнээс гадна манай гэр бүл урьд хожид үзээгүй “дотоод”, “гадаадын” зөрчил дундуур туулж байлаа. Би “хамаг хэрэг надаас л болж байна” гэж үзсэн болохоороо өөрийнхөө урьд хожид хийсэн байж болзошгүй бүх нүглийг мэдэгдсэн ч, хуурай байдлаас чөлөөлөгдсөнгүй.

Нэг өдөр бас л ийм бодолд дарагдаж суутал Эзэн надад: “Чи нүгэл үйлдсэн учраас, цөлд байгаа юм биш! Би чамайг айсуу өөрчлөлтөд бэлтгэж байгаа юм” гэж айлдав.

Бурхан намайг айсуу үйлчлэлийн дарамтын жинг даах хүчин чадалтай болгон хөгжүүлж байжээ. Исаиа 43:18-19-ийг үзнэ үү:

Урьдын юмыг бүү дурсагтун. Эртний юмыг бүү бодогтун. Үзэгтүн, Би шинэ зүйл хийх бөгөөд Тэр нь одоо соёолж гарна. Та нар үүнийг мэдэхгүй гэж үү? Би хээр талд зам тавьж, цөлд гол урсгана.

Тогтоосон цаг нь ирэхэд, Эзэн мөнөөх “айсуй өөрчлөлтөө” хэрхэн нарийн ширийн болгосон талаар би номынхоо адгаар ярина. Цөлд учраа олохгүй, голоо тасартал хичээж байхад минь Эзэн эхлээд Америкт, эцэстээ олон үндэстэнд хүрэх үйлчлэлийг минь төрүүлэхээр бэлтгэж байжээ.

Найз минь, Бурхан *шинэ* дарсыг хийхийн тулд чиний *хуучин* дарсыг хатаах бөгөөд чи *хуучин руугаа* буцахыг хүсэхгүй.

6

ТЭНГЭРИЙН ШАГНАЛ

Хуучин руугаа буцаж очоод, хамаг асуудлаа хамж үүрчихээд, ирээдүй рүү бүр ч их асуудал горилсон нүдээр ширтэн, бүдэрч гэлдэрсээр хайран амьдралаа барах хүмүүс байх юм.

—Ди. Эль. Мүүди

Ах дүү нар аа, би өөрөө барьж авсан гэж боддоггүй, харин хийдэг ганц юм маань ардхаа мартаж, урдах өөдөө тэмүүлж, Христ Есүс дотор Бурханы дээш чиглэсэн дуудлагын шагналын төлөө бариа өөд урагшилдаг.

—Филиппой 3:13-14



Элч Паул Шинэ гэрээний захидлын гуравны хоёрыг бичиж, харь үндэстний дунд олон чуулган эхлүүлсэн хүн. Түүний үйлчлэл даян дэлхийд хүрсэн ч, тэрбээр амьдралынхаа төгсгөлд “*Би хүрээгүй*” гэж хэлжээ. Паулын сэтгэл ханаагүй бөгөөд уралдааныхаа бариандаа орж, тэнгэрийн шагналаа гардаж авах хүртлээ ханах ч үгүй.

Бидний хувьд уралдаанаа дуусгаж, шагналаа хүлээж авахын тулд нэн тэргүүнд “хараахан хүрээгүй, хараахан олоогүй” гэдэг бодлыг зүрхэндээ тогтоох хэрэгтэй.

Бид төгс болоогүй, өөрчлөгдсөөр, өссөөр байх ёстой.

Мосе ч гурван сая хүнтэй үндэстнийг удирдах ер бусын хувь дуудлагатай, Хуучин гэрээнд хэзээ ч, хэний ч үзээгүй ер бусын тэмдэг, гайхамшигт гар бие оролцсон хүн.

Гэтэл Бурхан Мосег дэлхий дээрх хамгийн номхон (суралцахад бэлэн) хүн гэсэн. Мосе өөрийгөө зорилгодоо хүрсэн гэж үзэлгүй, уралдаанаа дуусгахын төлөө давшсаар яваад, тэнгэрийн шагналаа хүлээн авсан юм. Өсч, өөрчлөгдөхийн тулд бид суралцахад бэлэн байх ёстой.

Бурханы төлөөх уралдаанаа дуусгахын төлөө хийх ёстой хоёр дахь зүйл нь *тэдгээр юмсыг (ялалт, ялагдлаа) мартаад, ардаа орхих хэрэгтэй!* Энэ талаар ч Бурхан мөн л Исаиа 43:18-19 дээр хэлжээ:

Урьдын юмыг бүү дурсагтун.

Эртний юмыг бүү бодогтун.

Үзэгтүн, Би шинэ зүйл хийх бөгөөд

Тэр нь одоо соёолж гарна.

Та нар үүнийг мэдэхгүй гэж үү?

Би хээр талд зам тавьж, цөлд гол урсгана.

Паул хэрвээ ахин дахин тунгаагаад л байсан бол, Түүнийг Христийн дотор урагш явахад нь урьдын алдаа, гадуурхагдал, нүглүүд нь тушаа болох байв. Гэтэл бас хуучны ялалт ч биднийг тушиж чадна. Бид өөртөө итгэл дүүрэн, багтай байж, биднийг үнэтэй болгож, тээж байсан ололт амжилтдаа найдаад эхэлбэл, яг одоо Бурханы бидэнд өгөх гэж байгаа зүйлсийг алдана. Исаиа 43 дээр чухам үүнийг л хэлжээ. Урьдын юмс ч ялгаагүй Бурханаас л ирсэн. Гэхдээ цаашид Бурханы өгөх зүйлсийг гүйцэтгэсээр байхын тулд бид Бурханы урьд өмнийн арга замыг хойш тавихад бэлэн байх хэрэгтэй. Эс бөгөөс хуучин тулам болох аюултай.

Паул ч энэ үнэнийг цохон тэмдэглэсэн:

Би хүүхэд байхдаа хүүхэд шиг ярьж, хүүхэд шиг боддог, сэтгэдэг байлаа. Би эрийн цээнд хүрээд хүүхэд зангаа орхисон юм. Тэгэхээр бид одоо толинд бүдэг бадаг хардаг ч, дараа нь нүүр нүүрээ харна. Би одоо хэсэгхэнийг мэддэг ч, би өөрөө бүрэн мэдэгдсэн шигээ дараа нь би бүрэн мэдэх болно. (1Коринт 13:11-12)

Хүүхэд байх нь буруу биш. Хүүхэд зүгээр л төлөвшилгүй байдаг. Таван настай байхад амьдрал маань Тонка, Лего (Тонка гэдэг машин, Лего гэдэг угсардаг тоглоом) хоёроос л тогтдог байлаа. Тэр үед цагаан толгойгоо цээжилсэн явдал маань миний хамгийн том амжилт байв. Надад амьдралын арай ярвигтай, арай хүндхэн талыг шийдвэрлэх төлөвшил байхгүй учраас, би амьдралыг хар шилээр л хардаг байв.

Арван найман настайд минь Тонка, Лего хоёр урьдын юмс болсон байв. Харин олон жилийн төлөвшлийн эцэст буюу өнөөдөр би амьдралыг тас хар шилээр харахаа больсон. Миний ойлголтын төвшин ч, хүчин чадал ч өсчээ. Арван наймт таван наст шиг авирлах нь гаж юм. Бид өсөхдөө цаашид хэрэгцээгүй болсон эсвэл бидэнд баяр баясал авчрахаа больсон хүүхэд зан, хуучин ойлголтоо хойш тавьж, мартдаг.

Үүнтэй адилхан бид Бурханы юмс дотор өсч, амьдралын үе шатаар өгсөн дэвшихдээ, төлөвшөөгүй хуучны юмсаа хойш тавих хэрэгтэй. Паул хэлэхдээ, эдүгээ бид Бурханы замууд, алдрыг бүрэг бараг харж байгаа ч, тэнгэрийн шагналаа хөөсөөр байх аваас, хараа маань тодорсоор тодорсоор эцэстээ Бурханыг нүүр нүүрээрээ харна гэсэн. Өөрөөр хэлбэл Бурхан биднийг мэддэг шиг, бид Түүнийг мэдэх болно!

Аян замд аминд орох арга

#6 Хийж болохгүй юмсын жагсаалт

Бичээсээс Израильчуудын эмгэнэлт түүхийг үзэхүл, цөлд түр буудалмаж байхдаа хийж болохгүй юмс гэж байдаг ажээ. Үнэндээ Христэд итгэх итгэлийн амьдралдаа хэзээ ч хийх хэрэггүй юмсын овоо хөөрхөн жагсаалт байдаг ч, цөлд эдгээрийг хийх өдөөлт маш хүчтэй байдаг. Тус жагсаалтын үндсэн зүйлсийг хэсэгчлэн тоймлон танилцуулбал:

1. Муу ёрын юмсыг тачаадан хүсэх. Бид ядарсан үедээ буруу юмс нь биднийг тайтгаруулах - магадгүй бүр аз жаргалтай болгох байх гэж горьддог.
2. Шүтээнтэй хөөцөлдөх. Бурхан хүсэхгүй гэдгийг нь мэдсээр байж, өөрийнхөө хүсэлтэй хөөцөлдөх нь шүтээн шүтэх явдал. Хэн нэгнийг, ямарваа зүйлийг Есүсээс илүү хайрлах нь шүтээн шүтээн явдал.
3. Бэлгийн харилцаатай холбоотой нүгэл, гаж явдалд оролцох.
4. Эзэнийг сорих.
5. Гомдоллох, гонгинох, гоншигнох.

Коринтынхонд хандсан эхний захидалдаа Паул биднийг цөлд байсан эцэг өвгөдөөсөө сургамж аваарай гэсэн:

Та нар үүнийг эс мэдэхийг би хүсэхгүй байна. Ах дүү нар аа, эцгүүд маань бүгд үүлэн дор байж, бүгд тэнгисийг гатлан гарч ... Гэсэн ч тэдний олонх нь Бурханы таалалд нийцээгүй тул цөлд хиарсан юм. Тэд тачаадан хүссэн шиг мүү муухай юмсын араас бид тачаадан хүсэхгүй байхын тулд энэ нь бидэнд жишээ болсон юм. (1Коринт 10:1, 5-6)

Өндөр төлөөс төлсөн Израильчуудаас сургамж ав.

Найз минь, цөлд Бурханы замуудыг - тэр бүү хэл зүрхийг нь ч олж болно. Гагцхүү мятрашгүй байж: „Бурхан минь, би Таны сайн сайхан, хайрыг мэдрэхгүй байсан ч, Таныг сайн гэдэгт, Та надад хайртай гэдэгт итгэж байна” хэмээн хатуу хэл.

Паулын дурьдсан тэнгэрийн шагнал нь юу юм бол? Тэрбээр энэ асуултын хариуг өмнөх ишлэлдээ хэлжээ. Филиппой 3:10 дээр “Ингэхдээ би үхэлд нь Түүнтэй адил болсноор Түүнийг болон амиллынх нь хүчийг бас зовлонг нь хуваалцахыг таньж мэдээд” гэжээ. Бурханы тэнгэрийн шагнал нь Бурханы Хүү - Есүс Христийн дүр төрхөөр баталгаажиж, Тэр биднийг мэддэг шиг, Түүнийг мэдэх явдал болой! Бид энэ зорилгодоо хүрэн хүртлээ санаа амралгүй, Бурханы зүрхийг эрэн хайсаар байх ёстой.

Тэнгэрийн шагналын төлөө хийх ёстой гурав дахь зүйл нь “бай руугаа давших!” Давших гэдэг нь эсэргүүцэл, дарамтыг сөрсөн утгатай үг юм. Эзэнийг таньж мэдэхэд эсэргүүцэл ирнэ.

Диаволын хамгийн том дайсан нь Есүс Христийн дүр төрхөөр баталгаажсан хүн бөгөөд харанхуйн хүч хэн хэнээс илүү энэ хүнийг л довтолно. Итгэгч хүмүүс Христийн дүр төрхөөр баталгаажихдаа, цаашид өөртөө амьд бус, харин тэдний дотор амьдарч буй Нэгэнд амьд болдог. Тэд Христ доторх амьдарлыг илүү баялгаар, илүү хүчирхэгээр ухаарч ойлгодог. Тиймээс л Паул Түүнийг мэдэхийн тулд Түүний зовлонгийн нөхөрлөлийг мэдэх ёстой гэжээ. Паулын өгүүлж буй махан биеийн зовлон нь өөрийгөө үхүүлж, амилуулагдсан амьд хүрэх явдал юм. Петр бичжээ:

Иймээс Христ нэгэнтээ махбодоороо зовсон тул та нар ч гэсэн ижил санаагаар өөрсдийгөө зэвсэглэ. Учир нь махбодоороо зовсон нь нүглийг дуусгасан. Энэ нь биеэр амьдрах үлдсэн хугацаандаа цаашид хүний хүсэл тачаалын төлөө бус, харин Бурханы хүслийн төлөө амьдрахын тулд юм. (1Петр 4:1-2)

Махан бие дотроо зовсон хүн цаашид дэлхийн нүглээр замнаж, өөрийнхөө зам дээр төвлөрч, өөрийгөө дөвийлгөхгүй. Түүний дотроос Христийн зан чанар ажилладаг! Энэ л бидний бай - зорилго болох ёстой.

Христтэй хамт зовох

Христийн зовлон гэж юу вэ? Библийн энэ ойлголтыг тодорхой төрлийн шашны сургаалаар завхруулдаг учраас, энэ талаар олон хүн буруу ойлголттой явдаг. Энэ зовлон нь зүгээр л өвдөж хавдаад үхэх юмуу эсвэл төлбөрөө хийх мөнгөгүйгээсээ болоод шаналах

явдал биш юм. Мөн Бурханаар өрөвдүүлэх гэж хэдэн долоо хоног хоол ундгүй явах явдал ч биш юм. Энэ зовлон нь золиос бус, харин дуулгавартай байдал болой! Христийн зовлон гэж юу болохыг Еврей номын бичээч маш тодорхой хэлжээ:

Тэрээр махбодынхоо өдрүүдэд Өөрийг нь үхлээс аварч чадах Нэгэнд чанга хашхиран, нулимсаараа залбирал ба гуйлтаа өргөсөн. Тэр эмээдэг байсан тул Бурхан Түүнийг сонссон билээ. Тэрээр Хүү нь байсан хэр нь зовсон зүйлсээсээ дуулгаварт суралцсан. (Еврей 5:7-8)

Есүс дэлхий дээр цаанаасаа дуулгавартай болчихоод ирээгүй, харин дуулгавартай байдалд суралцсан юм. Есүс дуулгавартай дагах бараг боломжгүй үед ч Аавынхаа үгэнд орсноороо дуулгавартай байдалд суралцжээ. Есүс хүнд бус, Бурханд таалагдахыг хүссэн. Түүний дуулгавартай байдлаар эцэстээ хүн төрөлхтөн ерөөгдөнө гэдгийг Есүс мэдэж байжээ. Жинхэнэ зовлон нь хүний хүслийг сөрөн, Бурханы хүслийн дагуу амьдрах явдал болохыг Петр тодорхойлжээ (1Петр 4:2).

Ухаан, сэтгэл мэдрэмж, биеийн мэдэрхүй маань биднийг амархан, найрааны, таашаалын замаар явахыг даллан дуудаж байхад, Бурханы замаар явах нь “Христийн зовлон” ажээ. Бурхан *биднийг* нэг зам руу дуудаж байхад, найз, гэр бүл, ажлынхан маань өөр зам руу дуудах үед бид машид зөрчилддөг. Харамсалтай нь зөрчил үүсгэдэг гол эзэд нь бидний хамгийн дотны хүмүүс болж таардаг. Тухайлбал Петр Есүсийн үхэл, оршуулгатай маргасан явдал нь үүний сонгодог жишээ болно:

Есүс тэр цагаас эхлэн Иерусалим явахаа, ахлагчид, ахлах тахилч нар болон хуулийн багш нарын зүгээс их зовлон амсах, алуулах ба гурав дахь хоног дээрээ амилах ёстойгоо шавь нартаа илэрхийлж эхлэв. Петр Түүнийг хажуу тийш аваачаад —Эзэн минь, Таныг Бурхан энэрэг. Ийм юм Танд хэзээ ч бүү тохиолдог гэж зэмлэж эхэлсэнд Тэр эргэж, Петрт —Миний араас зайл, Сатан аа! Чи Надад бүдрүүлэл болж байна. Учир нь чи Бурханы юмсыг бус, харин хүмүүний юмсыг л бодож байна гэлээ. (Матай 16:21-23)

Есүс Бурханыг дагахын тулд Иерусалимд очиж, зовлон эдлэж,

алуулж, гурав дахь өдрөө амилуулагдах тухайгаа дагалдагч нартаа хэлжээ. Петр ч Есүсийн үгээс “амилуулагдана” гэсэн хэсгийг нь сонсоогүй болтой. Үгүй аваас Есүсийн удахгүй үхнэ гэсэн үгд тэгтэл цочирдмооргүй сэн.

Петрийн дотор нэг иймэрхүү бодол эргэлдсэн байх:

Байзаарай, Та чинь Мессаиа (энэ илчлэлийг Петр дөнгөж сая хүлээн авсан). Тиймээс хаанчлалаа байгуулж, Израилийг сэргээх ёстой. Би чинь Таныг дагах гэж ажил, ар гэр, хань ижлээ хойш тавьсан. Таныг л дагах гэж найз нөхөдгүй болсон. Хамаг цаг заваа зориулсан. Одоо л нэг гайгүй нэр хүндтэй болж ирж байна. Синагогийн удирдагч нар Таныг солиотой гэж бодно, сонин хэвлэлүүд Таныг зөрчилтэй хүн гэж зогсоо зайгүй бичиж байна. Олон нийтийн сүлжээн дээр Тан ииг их яригддаг хүн алга. Гэхдээ ихэвчлэн таагүй, цуу яриа дэгдэж байна. Нэр хүндтэй олон теологич, удирдагч нар Таныг буруу номтон гэдэг. Тэгтэл Та одоо үхлийн талаар яриад уналаа. Тэгээд би яах болж байна? Таныг дагасан хайран цаг минь. Муу нэрнээс өөр юу ч үгүй хоцрох нь.

Тэгээд Петр: “Болохгүй, Эзэнтэн минь, тэгж болохгүй!” гэсэн утгаар дуу алджээ.

Петр амиа бодсон, дэлхийн бодолтой байгааг Есүс шууд цохож хэлэх ёстой байж. Петр Бурханы нүдээр хараагүй. (“Энэ дэлхийн бурхан” 2Коринт 4:4) Сатан дэлхийг хувийнхаа ашиг сонирхлыг эрэхэд л сургадаг бол, тэнгэрийн хаанчлал өөр байдаг. Бид Бурханы хүслийг биелүүлэхийн тулд соёлын урсгалыг сөрөх ёстой - хэрэгтэй бол, дэлхийн нөлөөнд хэт автсан “Эзэн доторх ах, эгч дүүсийнхээ” эсрэг ч зогсох ёстой. Петр муу хүн байгаагүй ч, бодол нь Христээр бус, дэлхийгээр баталгаажсан байжээ. Петр дэлхийн арга замаар санадаг, сэтгэдэг байдлаа өөрчлөх дургүй байв.

Бас нэгэн жишээ нь Израилийн хүүхдүүд Канааныг тандсан түүх юм. Израильчуудыг цөлд ирээд жил гаруйтай болж байтал, Бурхан Мосед: “Миний та нарт амласан газрыг тандуулахаар хэдэн хүнийг илгээ” гэсэн утгатай тушаал өгчээ. Мосе арван хоёр овгийн арван хоёр удирдагчийг сонгосны дунд Иошуа, Калев хоёр байв.

Эрчүүд тэр газрыг тагнаад буцаж ирэхдээ тун зөрчилтэй мэдээ дуулгажээ. Арван хүн нь:

Гэхдээ тэр нутагт амьдарч буй ард түмэн нь хүчирхэг, хотууд нь бэхлэгдсэн агаад маш том юм. Бид тэнд Анакийн үр удмыг үзэв. Амалекчууд Негевийн нутагт амьдарч байна. Хитчүүд, иебусчууд, аморичууд нь уулархаг нутагт амьдарч байна. Канаанчууд далайн эрэг болон Иорданы эрэг хавиар амьдарч байна гэлээ. ... Харин түүнтэй хамт явж байсан хүмүүс —Тэд биднээс хэтэрхий хүчирхэг тул бид тэр ард түмний өөдөөс өгсөж очиж чадахгүй гэсээр байв. Тийнхүү өөрсдийн тагнасан нутгийн талаар тэд Израилийн хөвгүүдэд базаахгүй мэдээ дэлгэрүүлж —Бидний тагнан туулсан тэр нутаг нь оршин суугчдаа цөлмөж иддэг нутаг бөгөөд тэнд бидний харсан бүх ард түмэн нь хэмжээгүй том хүмүүс юм. (Тооллого 13:28-29, 31-32)

Гэтэл Калев, Иошуа хоёр өөр мэдээ авчирсан:

Гэтэл Калев ард олныг Мосегийн өмнө намжаагаад —Бид гарцаагүй дийлж чадах учир өгсөж очоод түүнийг эзэлж авцгаая гэв. ...Хэрэв ЭЗЭН, биднийг таалбал Тэр биднийг тэр нутагт аваачиж, тэрхүү сүү зөгийн бал урссан нутгийг бидэнд өгөх болно. Зөвхөн ЭЗЭНий эсрэг л бүү тэрсэл. Тэр нутгийн ард олноос бүү ай. Тэд бидний хоол болно. Хамгаалалт нь тэднээс зайлуулагдсан бөгөөд ЭЗЭН бидэнтэй хамт байна. Тэднээс бүү айгун гэлээ. (Тооллого 13:30,14:8-9)

Тэр арван хоёр хүн бүгдээрээ нэг л газрыг тагнасан. Нэг л газар, хот, хүмүүсийг үзсэн. Тэгээд яагаад арав нь нэг янзаар, хоёр нь өөр янзаар мэдээллэх болов? Хамаг учир нь харах өнцөгтөө л бий!

Бурхан Өөрийг нь бүрэн дагасан Калев, Иошуа хоёрыг өөр сүнстэй хүмүүс хэмээв (Тооллого 14:24). Өөрөөр хэлбэл тэд хүний хүслээс Бурханы хүсэл рүү ахижээ. Тэд хүний үзэл санаагаар бус, Бурханы нүдээр харсан. Үүнд л Иошуа, Калев хоёр бусад арваасаа өөр мэдээ авчирсны гол оньс оршино. Аравт нь өөрийнхөө тав тух, аюулгүй байдал, гэр бүлийг Бурханы хүслээс дээгүүр тавьжээ. Тэд Бурханы хаанчлалд бус, өөрсдийнх нь амьдралд нөлөөлөх юмсаар

л амьдарч байв. Бурхан тэднийг хэзээ ч орхихгүй, тэдний өмнө ирсэн бүх зүйлийг бүтэлтэй болгоно гэдгийг тэд ойлгоогүй. Ард түмэн ч яг л ийм буруу бодолтой байв. Учир нь:

Израилийн бүх хөвгүүд Мосе Аарон нарын эсрэг гонгинолдож байв. Даяар хотол түмэн тэдэнд —Бид Египет нутагт үхэцгээсэн ч болоосой! Эсвэл бид энэ цөлд үхэцгээсэн ч болоосой! ЭЗЭН юунд биднийг энэ нутагт авчирч байна вэ? Эхнэрүүд болон бяцхан хүүхдүүдийг маань олз болгохоор, биднийг илдэнд унагаахаар уу? Египет уруу буцсан нь бидэнд дээр байх юм биш үү? гэцгээж байв. (Тооллого 14:2-3)

Израилийн хүүхдүүд ядаж л хоолтой, ядуу ч гэсэн тогтвортой амьдралтай байсан Египет дэхь “хуучны сайхан өдрүүдээ” эргэн санагалзсан. Тэд Египетэд боол байсан атлаа одоогийн нөхцлөө боолын амьдралаас ч дорд гэж үзжээ. Тэд цөмөөрөө зайлшгүй өөрчлөлтөд дургүйцсэн. Хэдийгээр нүүдлийн амьдралын хэв маяг, хоол унд нь горьгүй байсан ч, одоо тэдэнд их бага хэмжээнд танил болсон цөл нь илүү баталгаатай санагдах болжээ. Израильчууд энэ байдлаасаа болоод л Амлагдсан газрыг хэзээ ч үзээгүй, тэдэнд хандсан Бурханы хүсэл ч хэзээ ч биелээгүй юм.

Харин Иошуа, Калев хоёр давших ёстой байв. Тэднийг элэг нэгт “ахан дүүс” нь эсэргүүцэн: “Тэднийг чулуугаар шид” (Тооллого 14:10) хэмээн амыг нь барихаа дөхжээ. Иошуа, Калев хоёрыг эсэргүүцэгч нар нь дэлхийн сэтгэлгээтэй, дэлхийн хараатай, шинэчлэгдээгүй оюун ухаантай хүмүүс байв. Тиймээс ч хүнийхээ замаас ч салаагүй, цөлөөсөө ч гараагүй юм.

Иошуа, Калев хоёр шиг элч Паул ч: “Христ Есүс дотор Бурханы дээш чиглэсэн дуудлагын шагналын төлөө бариа өөд урагшилдаг (давшдаг)” (Филиппой 3:14) гэсэн билээ.

Исаиа 43:18-19 дээрх заавар бидэнд урам болох учиртай:

Урьдын юмыг бүү дурсагтун.
Эртний юмыг бүү бодогтун.
Үзэгтүн, Би шинэ зүйл хийх бөгөөд
Тэр нь одоо соёолж гарна.
Та нар үүнийг мэдэхгүй гэж үү?
Би хээр талд зам тавьж, цөлд гол урсгана.

Харамсалтай нь өнөөдөр ч олон хүн өөрт нь хандсан Бурханы хүслийг биелүүлж, эрх чөлөө рүү давшихын оронд “аюулгүй байдлаа” сахиж үлдэхийг илүүд үзсээр байна. Тэд айсуй өөрчлөлтөөс айсандаа, дарамттай ч гэсэн танил орчноо сонгоно. Гэтэл бас Бурханы хуучин үйлсэд сэтгэл ханаад, шинэ өөрчлөлт рүү давших хүсэлгүй хүмүүс байна. Бурхан тэднээр дамжуулан аугаа зүйлс хийсэн нь үнэн боловч, тэр хүмүүс урьдын амжилтынхаа талд майхнаа засаад, суурьшаад авсан нь тоогүй.

Бурханы хүслийг дагах нь амь, эрх чөлөө, жинхэнэ биелэлд хүрэх цорын ганц зам болой. Таны хувьд яг одоо тэнгэрийн шагнал руу давших боломжгүй мэт харагдаж байж болох. Бурхан шинэ зүйл үйлдэх боловч, энэ нь чухам “цөл дундаас оргилохыг” Исаиагаар дамжуулан айлдсан. Өөрөөр хэлбэл, бид Бурханы хүслийг биелүүлэхээр Сүнсийг дагах үедээ боломжгүй гэмээр хуурай цөлд явж ордог. Гэхдээ хүнд боломжгүй нь Бурханд боломжтой (Лук 18:27). Учир нь тэр цөлийн цаана баялаг амьдрал, байлдан дагуулал, биелэл хүлээж буй.

Бурханы хүслийг эсэргүүцэж, өөрсдийг нь цөлийн гачигдлаас чөлөөлөх өөрчлөлтөөс татгалзсан арван туршуул, ард түмэн шиг байлгүй, танд зориулсан Бурханы тэнгэрийн шагнал болох Амлагдсан газар руугаа итгэл дүүрэн давшаарай!

7

БУРХАНЫ ӨНДӨР ХУРДНЫ ЗАМ

Дайсагнал нь зүгээр нэг зэвсэг биш. Энэ нь бидний сүнсний амьдралыг эвшээн ахиулах Бурханы хамгийн үр дүнтэй зэвсэг. Бидний ухралт гэж хардаг нөхцөл байдал, үйл тохиолдол нь биднийг чухам сүнсээр огцом өсгөх харваа болж таарах нь олонтаа. Үүнийг ухаарч, амьдралд байх л зүйл хэмээн хүлээн авахын цагт дайсагналыг тэсч тэвчихэд хялбар болдог.

—Чарльс Стэнли

Хашхирагч нэгний дуу “Зэлүүд талд ЭЗЭНий замыг бэлтгэцгээ. Цөлд Бурханд маань Их замыг шулуун болгогтун.

—Исаиа 40:3



Жигтэй санагдаж болох ч, цөлд Бурхан өндөр хурдны замаа тавьсан байдаг! Бурханы амьдардаг өндөр буюу өргөмжлөгдсөн амьдрал, сэтгэлгээ рүү хүргэдэг өндөр хурдны зам цөлд л бий.

Өнгөрсөн түүхэнд энэ замаар явсан нь цөөхөн. Тийм боловч Бурхан өнөөдөр үүгээр зорчуулахаар хүмүүсийг олноор нь бэлтгэж байна. Энэ талаар Исаиа 35:6, 8 дээр өгүүллүүн:

Тэр үед доголон нь буга мэт дүүлж, Хэлгүй нь баяртайгаар хашхирна. Учир нь цөлөөс ус гарч, эзгүй талд урсана. ...Тэнд нэгэн тэргүүр зам буй болж, Ариун Зам хэмээн нэрлэгдэнэ.

Цөл дэхь Бурханы хурдны зам нь “Ай- 95” юмуу “66-аар” зам гэх мэт домогт нэргүй, зүгээр л *ариун* зам хэмээгдэх ажээ.

Ариун байдлыг бас “цэвэр байх нөхцөл” гэдэг. Есүс “Зүрхэндээ цэвэр ариун байгсад ерөөлтэй еэ! Тэд Бурханыг харах болно” (Матай 5:8) гэсэн. Есүс ариун бус, бохир чуулганы төлөө эргэж ирэхгүй. Тэрбээр ямар ч толбо, үрчлээгүй чуулганы төлөө эргэж ирнэ.

Олон арван жилийн өмнө дөнгөж үйлчлэлд хөл тавьж байгаа залуу байхдаа нэгэн удаа залбирч байтал минь Бурхан амьдралыг минь ариутгахаа харуулж билээ. Би ч жигтэйхэн баярласандаа Лизад: “Бурхан миний бохирыг зайлуулах гэнэ” гээд, Бурханаар зайлуулагдах ёстой, хамаг л хүсэшгүй, муу муухай юмсаа тоочин хэлж билээ. (Лиза ч бас дээрээс нь нэмэрлэв!)

Тэгтэл дараагийн гурван сар нь юу ч болсонгүй. Үнэндээ амьдрал маань улам л уруудаж, надад бүр ч их ариутгал хэрэгтэй болж байгаа мэт санагдав. Тиймээс би Эзэн дээр очоод: “Миний муу зуршлууд яагаад дээрдэх биш, дордоод байна?” гэж асуулаа.

Тэгтэл Эзэн: “Би чамд Би *Өөрөө* чамайг ариутгана гэж хэлсэн. Гэтэл чи өөрийнхөө хүчээр хийх гээд байна. Харин Би үүнийг чинь *Өөрийнхөө* аргаар хийнэ” гэв. Тэр үед би арван найман сарын цөлийн аялалд орох гэж байгаагаа огт мэдээгүй билээ.

Бидний бус, Түүний аргаар

Би шинэхэн итгэгч байхдаа Ти. Эл. Осборны үйлчлэлтэй танилцаж байлаа. Доктор Осборн бол гэргий Дэйзитэйгээ хэдэн арван жил дэлхий даяар Сайн мэдээний бөгөөд эдгэрлийн хүчирхэг, гайхамшигтай үйлчлэл хийсэн аугаа үйлчлэгч, зохиолч хүн байв. Тэд үйлчлэлээрээ хэдэн арван сая хүнийг аврал руу хөтлөсөн юм.

Тиймээс би Доктор Осборныг манай чуулганд номлохоор Далласт ирэхэд нь хөл газар хүрэхгүй баярласныг яана. Дээрээс нь би зочин номлогч нарыг угтаж, тэдэнд үйлчлэх ажилтай байсан учраас Ти. Эл. гуайтай хувьчлан танилцав. Түүнтэй хамт байх нь яг л Есүстэй хамт байх шиг санагдана.

Ти. Эл. гуай манай чуулганд хэд хэдэн удаа ирж, бид хоёр ихэд дотносов. Тэрбээр надад дөнгөж үйлчлэлд бэлтгэгдэж буй залуу байхдаа хэрэглэж байсан бүх номоо өгснөөс гадна хоёр удаа өөрийнхөө өмсдөг байсан олон хувцсыг өгч билээ (бид хоёрын хэмжээ дамжаа яг адилхан байв). Тэр үед Лиза, бид хоёрт хувцас авах мөнгө байхгүй байсан болохоор, би тэр эрхэм хүний өгсөн хувцсаар маш их гоёсон доо. Тэдгээр айлчлалын дараа Дэйзи, тэр хоёр Лиза, бид хоёрт яг л аав, ээж шиг минь дотно хүмүүс болж билээ.

Үүнээс хэдэн жилийн өмнө намайг Америкийн корпорацд ажиллаж байхад, Ти. Эл. гуайн номлож байсан нэгэн цуглаан дээр Ариун Сүнс надад: “*Чи түүнд үйлчлэх болно. Чи Доктор Осборнд үйлчлэх болно*” хэмээн шивэгнэв. Тиймээс би дотроо үүнийг нь тэр хүний багт орж, ирээдүйд адилхан Сайн мэдээний үйлчлэл эхлүүлэхийн баталгаа гэж итгэв.

Гэтэл цаг хугацаа өнгөрсөн ч, юу ч болсонгүй - би цөлдөө байсаар л байлаа. Осборны гэр бүл үйлчлэлийнхээ баазыг Тулсад байршуулсан боловч, өөрсдөө Орландод амьдардаг байв. Цаг хугацаа өнгөрөх тусам миний үйлчлэлээ эхлүүлэх дотоод дарамт туйлдаа хүрч, би Осборны гэр бүлд ойртохын тулд Орландо руу нүүхээр шийдсэн юм. Энэ маань давхар санаатай байлаа. Нэгдүгээрт - энэ нүүдлээрээ чуулгандаа үйлчлэхээ больсноо Ти. Эл. гуайд илэрхий болгох. Ти. Эл. гуай төгс журмын хүн байсан

болохоороо намайг хэзээ ч чуулганаас маань “хулгайлахгүй” байв. Хоёрдугаарт - Лиза, бид хоёр Орландод амьдрах учраас, тэдний үйлчлэлд амархан нэгдэх боломжтой. Бид Флорида руу нүүх юм бол, Ти. Эл. гуай, бид хоёр амархан харилцаа холбоо тогтоож болохоор байв.

Тийм ээ - энэ маань үнэхээрийн ядсан арга байлаа. Гэхдээ би байж сууж ядсандаа, намайг жинхэнэ дуудлага руу минь чиглүүлэх Бурханы ажилд “туслахаар” шийдсэн маань энэ.

Тиймээс би Далласын чуулганы пастортаа ажлаасаа гарч, Орландо руу нүүх болсноо дуулгахаар уулзах цаг авав. Тэгтэл тэр уулзалтын өмнөх орой нь гурван өөр хотын гурван пастор надтай утсаар ярих нь тэр. Тэд миний маргааш хийх гэж байгаа алхмын талаар дуулаад, бүгдээрээ яг адилхан зүйл асуусан юм: “Лиза чамтай бүрэн санал нийлж байгаа юу?”

Лиза надтай бүрэн санал нийлээгүй байлаа. Лиза надад хэд хэдэн ч удаа: “Жон, би чамайг дагана аа. Гэхдээ энэ санаа чинь нэг л зөв санагдахгүй байна” гэж хэлсэн ч, би түүний үгийг үг гэж тоогоогүй юм. Би *Лиза зүгээр л харахгүй байна. Би энэ гэрийн тэргүүн учраас, гэргий минь миний чиглүүлэгт зүгээр л захирагдах ёстой* л гэж бодож байлаа. Даанч төлөвшилгүй, мунхаг байж дээ, би.

Тэр орой гурав дахь пастортай утсаар ярьж, мөнөөх асуултыг сонссоны дараа дотор минь нэг юм хага үсэрчих шиг л болов. Нүд маань нээгдэж, би Бурханы ажлыг булааж хийх гээд байгаагаа харав.

Маргааш нь Лиза, бид хоёр пастор, пасторынхаа гэргий хоёртой уулзаад, яагаад тэдэнтэй уулзахыг хүссэн талаараа бас урьд оройн гурван дуудлагын дараа санаагаа өөрчилсөн тухайгаа үнэнээр нь л хэлэв. Тэд хоёр надад үнэхээрийн нигүүлсэнгүй хандаж, биднийг цаашид ч үлдэж, хуучин орон тоон дээрээ ажиллаасай гэж хүсч байгаагаа хэлэв.

Мөрөн дээрээс минь бул хар чулуу аваад хаячих шиг л болж, би Бурханы ажлыг Өөрөөр нь хийлгэхэд бэлэн болов. Тийм боловч ариутгалын үйл явц дуусаагүй гэдгийг бас л мэдсэнгүй. Гэтэл яг тэр өдөр удаах түрлэг орж ирсэн юм.

Пастор, пасторын гэргий хоёртой уулзсанаас зургаан цагийн дараа би чуулганыхаа ажилчидтай хамт сагс тоглохоор бэлтгэлийн хувцсаа өмсөж байтал утас дуугарлаа. Харилцуурын цаана Ти. Эл. Осборн гуай байв! Би зүгээр л хөшчихөв.

Тэрбээр надтай арван есөн минут ярихдаа Лиза, бид хоёрт хамт үйлчлэх санал тавиад, бид хоёрыг өөрийнхөө болоод Дэйзигийн туслахаар авч, тэдэнтэй хамт дэлхий даяар аялах санал тавилаа.

Түүнчлэн бид алсдаа шинээр тариалагдах чуулгануудад үлгэр загвар болохуйц чуулганыг Тулсад эхлүүлэх ажээ. Эцсийн зорилго нь - тэдний томоохон аянаа зохион байгуулдаг дэлхийн өнцөг булан бүрт нэг ижил загварын чуулганууд байгуулах явдал ажээ.

Би тэр дуудлагын үеэр зогсоо зайгүй *“Аав аа, би Таныг ажлаа хийнэ гэдэгт итгэж байсан. Гэхдээ ийм хурдан гэж санасангүй!”* хэмээн бувтнасаар байлаа. Ти. Эл. гуайтай ярьж байхдаа, миний нэгэн зэрэг цочирдож бас баярласныг яана! Би цөлийн гарц дээр ирчихлээ гэдэгтээ бат итгэлтэй байлаа. Баярласандаа таазанд тулгал үсэрмээр ч юм шиг. Утсаа тавьсныхаа дараа би Бурханд талархахаар гадаа гарсан ч, сүнсэнд маань дохио асч, түдгэлзээ мэдрэгдэв. Нэг л тавгүй, хавирсан мэдрэмж.

Би *“Үгүй ээ Бурхан минь, гү, гү, гү, гү Та ингэж болохгүй! Та Өөрөө олон жилийн тэртээ намайг Ти. Эл. Осборнд үйлчилнэ гэж амласан! Та ингэж болохгүй!”* гэж бодлоо.

Дохио унтарсангүй. Энэ дохионоос салж, тавгүй мэдрэмжээсээ салах гэж бүтэн гурван өдөр залбирлаа. “Бурхан минь, надад баяр хөөр өгөөч!” гэж хашхирлаа. Лиза ч Осборны хостой ажиллахыг үнэн голоосоо хүсч байсан ч, бас л тэр дохиог мэдрэчээ.

Эцэстээ би энэ эргэлзээ нь Бурханаас байж магадгүй гэдэгт итгэхээс шууд татгалзав. (Миний зүгээс гаргасан бас л нэг төлөвшилгүй, аюултай нүүдэл) Тиймээс ажлын ярилцлага өгөхөөр Лизатай хамт Оклахома руу нисч очив. Бүх юм сайхан л бүтэж байх шиг харагдаж байлаа. Ти. Эл. гуай, Дэйзи хоёр ч бидэнд албан ёсоор тэр байр суурийг санал болгож, Христмасын үдэшлэг дээрээ бид хоёрыг багийнхаа хамт олонд албан ёсоор танилцуулав.

Дараа нь бид хоёр Далласт эргэж ирээд, би чуулганыхаа ажлаас гарлаа. Нөгөө дохио унтрахгүй л байв. Олон цагаар залбирсан ч, дотор тавгүй хэвээрээ л. Би урт удаан залбирлаараа таагүй мэдрэмжээ албадан зайлуулах гэж оролдож байлаа. Даанч юу ч өөрчлөгдсөнгүй.

Эцэстээ би Лизад: “Юу болоод байгааг мэдэх юм алга. Гэхдээ нэг л биш байна” гэтэл, тэрбээр санал нийлэв.

Би Ти. Эл. гуайтай яриад, мэдрэмжийнхээ талаар учирлан хэлтэл, тэрбээр: “Бүгдээрээ уулзаж байгаад ярилцбал яаж байна?” гэсэн тул би Тулса руу нисч очоод, бид хоёр бүтэн цаг ярилцсаны эцэст Ти. Эл. гуай: “Бид чамд үнэхээр хайртай учраас бас чи бидэнд хайртайг чинь мэддэг учраас л энэ байр суурийг санал болгосон. Гэхдээ энэ бүхэн Бурханаас биш болтой” гэсэн юм.

Би ч өөдөөс нь: “Би ч бас ойлгохгүй л байна. Гэхдээ таны зөв

болтой” гэлээ. Миний амнаас ийм үг гарна гэдэгт би өөрөө ч итгэсэнгүй. Үнэн голоос маань л гарсан үг байх. Ти. Эл. Осборн гуайтай ажиллана гэдэг чинь миний нэг насны мөрөөдөл байсан шүү дээ.

Тэр үед би өдөр бүр өглөө эрт гадагшаа гараад, цаг хагас юмуу хоёр цаг залбирдаг хэвшилтэй байв. Гэтэл миний баатар - Доктор Осборнтой тохиолдсон дээрх явдлаас хойш би дор хаяж арван дөрвөн хоног өглөө дэмий л уйлахаас өөр юу ч залбирч чадсангүй. Сүүлийн хэдэн сард болж өнгөрсөн үйл явдалд би итгэж чадахгүй байлаа. Яг л хайртай хүнээ алдчихсан мэт үгээр дүрслэшгүй ихээр гуниглаж байв. Ийнхүү хоёр долоо хоногийн “гашуудлын” дараа би эзгүй хээр очоод: “*Яагаад?! Та яагаад надад хориглож байгаа юм? Та Өөрөө л намайг тэр хүнд үйлчилнэ гэж зургаан жилийн өмнө хэлсэн. Тэгээд яагаад?!*” хэмээн тэнхээ мэдэн хашхирлаа.

Тэгтэл Эзэн надад хэзээ ч мартагдашгүй үг хэлсэн юм даа: “Яагаад гэвэл Би чамайг Надад үйлчлэх нь үү эсвэл мөрөөдөлдөө үйлчлэх нь үү гэдгийг чинь харахыг хүсэв!”

Би ч нам болов.

Аян замд аминд орох арга

#7 Найз нөхдөө зөв сонго

Энэ тийм сонин содон зүйл биш л дээ. Гэхдээ явж явж манай талынхан л бидний хамгийн аюултай, хорон шүүмжлэгч, эсэргүүцэгч нар болж таарах нь цөөнгүй. Найзаа гэж бодож явсан хүнээс хавчлага ирэх нь цөөнгүй.

Цөлд бид жинхэнэ хавчлагатай тулгарч болзошгүй учраас, Христийг дагадаг хүнд хавчлага зайлшгүй гэдгийг мэдэх хэрэгтэй. Элч Паул: „Үнэндээ, Христ Есүс дотор сүсэг бишрэлтэй амьдрахыг хүсэгч бүх хүн хавчигдах болно” (2Тимот 3:12) хэмээгсэн. Хавчлага нь шинэтгэх үйл явцсын нэгээхэн хэсэг юм. Тэгвэл хавчлага хэнээс ирэх вэ? Нэгдүгээрт - хуурамч амьтаас - Бурханыг гэх өчүүхэн ч сэтгэлгүй атлаа итгэгч царайлан Бурханы хүмүүсийг шүүлтүүргүй болгодог этгээдүүд. Тиймээс л Паул Мосег эсэргүүцсэн Ианне, Иамбре нарын талаар ярьсан юм. Тэд бол гадныхан бус, Эзэний чуулган дунд байсан хүмүүс.

Тэгтэл Бурхан: “Тиймээс л Би Абрахамд Исаакийг тахилын ширээн дээр тавь гэж хэлсэн. Тэр Намайг түүнд амлан байж өгсөн ерөөлөөс минь илүү хайрлах нь уу үгүй юу гэдгийг Би харахыг хүсэв. Абрахам мөрөөдөлдөө хүрэхийн тулд Надад үйлчилж байна уу эсвэл чухам Надад үйлчилж, тэр мөрөөдлийг биелүүлэх журамт чанарт минь найдаж байна уу гэдгээ харуулах байлаа.”

Энэ мэдэгдлээрээ Бурхан миний сүүлийн хоёр долоо хоног амь тэмцэн зөрчилдсөн хамаг асуултыг таг болгосон юм. Тэгтэл сүүлийн арван найман сарын хугацаанд анх удаа сүнс дотор минь баяр хөөр дэгдэв. Тэрхэн мөчид амьдрал маань дахин нээгдэж, би гэдэг хүн хичнээн ерөөгдсөн хүн болохоо харж билээ. Би өөрийгөө үзэсгэлэнт гэргийтэй, хөөрхөн үртэй болохоо ухаарч, гэргий, хүү хоёртоо дахин дурлав. Би өөрийгөө жилийн дөрвөн улирлын дийлэнх өдрүүдэд нар шардаг газар маш сайхан усан сангаас гучаадхан алхмын зайтай байршдаг, цоо шинэ орон сууцанд амьдарч байгаагаа ухаарав. Би Бурханд таалагдахын тулд хийх ёстой гэж бодсон үйлчлэлдээ үхэн хатан улайрсандаа, энэ бүхнийг харах нүдгүй болсон байжээ.

Паул өөрийнхөө үзсэн хавчлага, аюулаас дүрслээд зарим зовлон нь „хуурамч ахан дүүсээс” нь ирсэн тухай хэлжээ (2Коринт 11:26).

Цөлд таныг хайрлаж, халамжилдаг, амьдралд чинь Бурханы хүслийг өгүүлдэг хүмүүс л тустай. Шүүмжлэгч нар юмуу Бурханд дуулгаваргүй загнахыг ятгадаг хүмүүс хэрэггүй. Тухайлбал Иовын гэргий, найзууд шиг хүмүүс. Бас танд бурханлаг засвар хэрэгтэй байхад, худлаа бялдуучилдаг хүмүүс ч хэрэггүй. Танд таныг хайрладаг, Бурханы цэц ухааныг өгүүлдэг хүмүүс л хэрэгтэй.

Мэдээтэй байгаарай: Цөлд орсонд чинь таныг шүүмжилж, тэр бүү хэл ялаж байгаа хүн таны жинхэнэ найз биш байж болох шүү. Ариун Сүнс бидний нүглийг ухааруулдаг бөгөөд голдуу хэн нэг хүнээр дамжуулж бидний алдааг харуулж, гэмшүүлдэг. Тийм боловч ямар ч найдвар авчрахгүй, эцэс төгсгөлгүй ял нь дайснаас үүдэлтэй. Тиймээс болгоомжлоорой!

Одоо эргээд бодоход, Бурхан намайг Ти. Эл. Осборнд үйлчилнэ хэмээн айлдахад үед би тэр эрхэм хүнд угаасаа л үйлчилж байсан юм билээ. Би түүнийг Далласт ирэх бүрийд нь үйлчилж, түүнтэй нөхөрлөх завшааныг хэдийнээ эдлэж байжээ.

За ингээд би ажилгүй болов оо. Тэгээд хуучин ажилдаа эргээд орж болох эсэхийг асуухаар чуулган дээрээ ширэн нүүрлэсээр очлоо. Би туслах пастораар үйлчилдэг нэгэн нөхрөө хараад: “Найз нь тэр хаалган доогуур шургачихмаар, хариугүй амьтан болчихоод явж байна” - яг ингэж хэлснээ санаж байна. Би чинь Ти. Эл. Осборн, Дэйзи хоёртой ажиллах гэж байгаагаа хүн болгонд зарлачихсан. Тэр бүү хэл пастор маань хүртэл тайзан дээрээс зарлачихсан. Тэгсэн тийм юм болоогүй байдаг.

Чуулган маань надад нигүүлсэнгүй хандан, хагас цагийн ажил олгож, би тэнд найман сар ажиллав. Тэгтэл нөгөө Бурханы намайг бэлтгээд байсан үйлчлэлийн дараагийн үе маань тохиож, надад Америкийн хамгийн хурдан өсч яваа чуулганд ажиллах урилга ирэв. Би тэдний залуусын пастор болох ажээ. Энэ явдал гайхмаар өрнөв. Энэ бол Бурханы үүд гэдгийг Лиза, бид хоёр хоёулаа мэдэж байлаа. Эдүгээ би энэ шинэ байр сууринд бэлтгэгдсэн, шинэхэн дарсыг тээх, шинэ тулам болсон байв.

Цэвэрлэгдэх зам

Есүсийг дэлхийгээс явснаас хойш олон зууны турш дагалдагч нар нь өөрийнхөө хүчээр ариун байдалд хүрэх гэж үзжээ. Үнэндээ ариун байх гэсэн энэ тусгүй оролдлогын үр дүнд бүхэл бүтэн чуулганы урсгал чиглэлүүд бий болсон юм. Ариун байдал нь махан биеийн гадаад хориг бус, харин Бурханы нигүүлслийн ажил учраас, хийсэн бүхэн маань биднийг хуульчлалын хүлээсэнд оруулжээ.

Бурхан бардамд бус, дарууд нигүүлслээ өгдөг. Бардам хүн ариун байдалд Бурханы тусламжгүйгээр, зүгээр л бичмэл гарын авлага, дүрэм, журам дагаснаар хүрч болно гэж боддог. Тэгвэл даруу хүн энэ нь аюултай гэдгийг мэддэг бөгөөд Эзэний нигүүлсэлд (хүчинд) л найддаг. Бурхантай тогтоох дотно харилцаа нь цэвэр юм. Учир нь хүн ийм харилцаагаар дамжиж байж л зүрхнээ бичигдсэн хуулийг сахих хүчтэй байна.

Олонх маань Шинэ гэрээний бичвэрийг дагаснаараа юмуу бичээсийн бус итгэл үнэмшлээр ариун байдалд хүрэх гэж оролдоод, гутамшигтайгаар бүтэлгүйтсэн байдаг. Хуулийн үсгийг

сахиснаараа аврагдах гэж оролдоод бүтэлгүйтсэн Еврейчүүд шиг, бид ч энэ дүрмийг дагаснаараа ариун байдал дотор алхаж чадахгүй. Олон хүн тодорхой зан авир, үйлдлийн тал дээр өөрөө өөртөө хуульчлалыг дэрлэсэн санаагаар хориг тогтоодог. Эдгээр нь бүгд дотоод цэвэршилд хүрэх гэсэн зорилготой гадаад хориг юм.

Гэтэл Бурхан гадна талын ариун байдлыг тоодоггүй. Цэвэр зүрх нь цэвэр зан авирыг үйлдвэрлэдэг учраас, Бурхан таныг зүрх сэтгэл дотроо өөрчлөгдөөсэй гэж хүсдэг. Матай 23:26 дээр Есүс “Эхлээд аяга, савныхаа дотор талыг цэвэрлэ. Тэгвэл гадна тал нь ч цэвэрхэн болно” гэж хэлсэн.

Зүрх чинь цэвэр бол, та Есүсийг үл хүндэтгэсэн үйлдэл хийхгүй. Та интернэт дээрх порно хуудсаас хол байж, ил задгай хувцаслахгүй. Эр хүн юмуу эмэгтэй хүн салж сарниагүй гэдгээрээ сайрхах атлаа хамт ажилладаг хүнээ зүрхэндээ хүсэн тачаадах юмуу эсвэл үе үе интернэтээр порно үзэх нь ариун явдал уу?

Зүрх чинь цэвэр бол компьютер, утсан дээрээ зохисгүй материал эрж хайхгүй. Технологи чинь таныг бохирлоод байгаа юм биш, зүрх чинь л бүхнийг шийдэж байгаа хэрэг. Зүрх чинь цэвэр бол, та гагцхүү Бурханы хүсдгийг л хүснэ.

Цөл нь Бурхан бидний санаа, сэдлийг цэвэрлэхдээ хэрэглэдэг чигчлүүр юм. Бурхан бидний зүрхийг Чуулганыхаа төлөө эргэж ирэх айлчлалдаа бэлтгэж байна. Бурхан Өөрийнх нь дүр төрхийг хуулсан, Өөрийнх нь зан чанар дотор алхдаг, өөрийнхөө бус, *Түүний* алдрыг гийгүүлэх үеийнхэнийг босгож ирж байна:

Том байшинд зөвхөн алт, мөнгөн төдийгүй мөн мод, шавар сав суулга ч байдаг. Зарим нь хүндэтгэлийн, зарим нь жирийн хэрэглээнийх. Иймд хэн өөрийгөө эдгээр зүйлээс цэвэрлэнэ, тэр хүндэтгэлд зориулагдан ариусгагдсан, Эзэнтэнд хэрэгтэй бөгөөд алив сайн үйлд бэлтгэгдсэн байх болно. (2Тимот 2:20-21)

Хүндэтгэлийн, жирийн гэсэн хоёр төрлийн сав байгааг тэмдэглээрэй. Жирийн гэдгийг Грекээр атимиа гэх бөгөөд энэ нь “үл хүндэтгэл, гутамшиг, ичгүүр, жигшүүр” гэсэн утгатай үг ажээ. Бурхан “Хэрэв чи үнэгүйгээс үнэтэйг гаргаж авбал, Чи Миний төлөө яригч болно” (Иеремиа 15:19) гэж байна. Үнэтэй нь цэвэрлэгээгээр дамжин бохиросоо чөлөөлөгдөх замаар жигшүүрээс авагджээ.

Малахи бол Шинэ гэрээний талаар маш их зөгнөсөн Хуучин гэрээний эш үзүүлэгч. Гэхдээ тэрбээр Шинэ гэрээний үг хэллэгийг

мэддэггүй байсан болохоороо, Ариун Сүнсээр дамжуулан Шинэ гэрээний Христэд итгэгч хүмүүсийн талаар харж, сонссон зүйлээ өгүүлэхдээ “Левит”, “тахилч” зэрэг нэр томъёог хэрэглэжээ.

Малахи Эзэн сүмийнхээ төлөө ирэхээсээ өмнө эхлээд сүм дээрээ (*Чуулган дээрээ*) ирэхийг зөгнөн хэлжээ. Зорилго нь: цэвэршүүлэх. Тэрбээр:

Тэр мөнгийг хайлуулагч ба цэвэршүүлэгч мэт сууж,
Левийн хөвгүүдийг цэвэршүүлэх болно. Зөвт байдал
дотор ЭЗЭНд өргөл өргөдөг болтол нь тэднийг Тэр алт
ба мөнгө адил цэвэршүүлнэ (Малахи 3:3) гэжээ.

Левитүүд нь чуулган доторх Христийн дагалдагч нар болох “хааны тахилч нарыг” (1Петр 2:9) сүүдэрлэн харуулсан болно. Бурхан энэ тахилчийн ажлын шинэтгэлийг алт, мөнгийг цэвэршүүлэх үйл явцтай жишсэн болохоор эхлээд алт, мөнгөний шинж, эдгээрийг хэрхэн цэвэршүүлдэг талаар ойлгож авах хэрэгтэй. Энэ хоёр төмөрлөгийн цэвэршүүлэх үйл явц нь төстэй учраас, би алтны талаар л ярья.

Алт нь боронзон туяатай, сайхан шаргал өнгөтэй төмөр. Байгальд хаа сайгүй байдаг ч, маш багаар олддог бөгөөд цэвэр хэлбэрээрээ олдох нь ховор. Цэвэршүүлсэн алт нь цэвэнд идэгддэггүй, уян хатан, зөөлөн чанартай байна. Алт нь бусад төмөрлөгтэй (зэс, төмөр, никел) холилдохоороо уян хатан чанараа алдаж, хатуурч бас зэврэмтгий болдог. Энэ хольцыг хайлш гэнэ. Бусад төмөрлөгийн орц нь өндөр байх тусам алт хатуурдаг бол, хайлшийн хувь бага байх тусам, алт уян хатан, зөөлөн байна.

Тэгэхээр зүйрлэл нь тодорхой байна: Бурханы өмнөх цэвэр зүрх нь шижир алттай л адил. Цэвэр зүрх нь зөөлөн, булбарай, уян байна. Тиймээс л Ариун Сүнсний хэлснээр:

“Өнөөдөр та нар Түүний дууг сонвол, Цөл дэх сорилтын өдрийн тэрслэл дэх шиг Та нар зүрхээ бүү хатууруул.” ... Харин “өнөөдөр” гэгдэж л байгаа бол бие биенээ өдөр бүр зоригжуулагтун. Эс бөгөөс та нараас хэн нэгэн чинь нүглийн мэхлэлээр хатуурах вий.
(Еврей 3:7-8,13)

Нүгэл нь *цэвэр* алтыг хайлш болгон, зүрхийг маань хатууруулдаг нэмэлт бодис ажээ. Хатуурхал нь мэдрэмжийг алдагдуулдаг

бөгөөд энэ нь эргээд Эзэний дуу хоолойг сонсох чадварт маань саад болно.

Харамсалтай нь өнөөдөр бурханлаг дүртэй атлаа Есүсийн төлөө дүрэлзсэн өр зөөлөн зүрхгүй, ийм хүмүүс олон байна. Бурханы төлөөх сүүн цагаан, дүрэлзсэн хайрыг амин хувийнхаа таашаал, тав тух, ашгийг эрэлхийлдэг аминч, цэвдэг хайр орложээ. Тэд бурханлаг байдлыг ашигтай гэж үзэхдээ (1Тимот 6:5), зүгээр л Амлагчийг нь хасаад, санаандгүйгээр юмуу эсвэл амраар нь амлалттай хөөцөлдөх болжээ. Тэдгээр мэхлэгдэгсэд хожим тэнгэрийг хүлээн авна гэсэн найдлагаар өнөөдөр дэлхийгээр зугаацна! Гэтэл Бурхан ийм юм хүсдэггүй:

Бурхан ба Эцэгийн өмнө цэвэр бөгөөд бузартаагүй
сүсэглэл бол ... өөрийгөө ертөнцөөс бохирдуулалгүй
хамгаалах нь ажгуу. (Иаков 1:27)

Есүс ямар ч толбо, үрчлээсгүй эсвэл алив ийм юмгүй, ариун чуулганы төлөө - энэ дэлхийн юмсаар бузартаагүй хүмүүсийн төлөө эргэж ирнэ.

Алтны өөр нэгэн шинж нь зэв, зэврэлийг эсэргүүцдэг. Бусад төмөрлөгүүд уур амьсгалын эрхшээл дор ганддаг бол, цэвэр алт гандахгүй. Гууль (зэс, цинкийн шаргал хайлш) нь алттай төстэй харагддаг боловч, алтны чанарыг агуулдаггүй. Гууль нь амархан ганддаг. Гууль нь алтны чанарыг бус, гадаад төрхийг л тээдэг. Чуулганд алт шиг төрхтэй боловч, алт шиг чанаргүй гуулин сав олон бий. Энэ хоёрыг гагцхүү цэвэршүүлэгч гал л ангилна. Цэвэршүүллийн дараа Малахи ингэж хэлжээ:

Иймд зөвт ба буруут, Бурханд үйлчилдэг нэгэн ба Түүнд
үйлчилдэггүй нэгний ялгааг та нар дахин нэг харах
болно. (Малахи 3:18)

Эргээд алтыг цэвэршүүлэх яриандаа орьё. Алтны доторх их хэмжээний гадны бодис нь алтыг хатууруулаад зогсохгүй, зэврэл, ялзралд мэдрэг, дэлхийн уур амьсгалын нөлөөнд автамхай болгодог.

Яг одоо дэлхийн арга замууд чуулган руу хальж байна. Бидэнд дэлхийн соёл нэвчсэн болохоор бид гандаж байна. Америкийн чуулганы үнэ цэнэ дэлхийн чанараар бохирдсон. Олон хүмүүс мэдрэмжээ алдаж, цэвэрших шаардлагатай гэдгээ ч ухаардаггүй.

Тэгвэл алтыг цэвэршүүлдэг шиг Есүс ч чуулганаа дэлхийн нөлөөнөөс цэвэрлэхээ Малахи 3:3 дээр хэлжээ. Алтыг цэвэршүүлэхдээ нунтаг дотор давтаад, дараа нь флюс гэдэг бодистой холиод, хоёуланг нь өндөр хэмийн галтай зууханд хийнэ. Тэр үед хайлш, бохирдол нь флюстэй нийлэн, дээшээ хөвж гарч ирдэг бол, жинхэнэ хүнд алт нь гүндээ тунадаг байна. Дараа нь бохирдол, хогийг (флюстэй нийлсэн зэс, төмөр, цинк зэргийг) салгаж авна.

Тэгвэл одоо Бурхан хэрхэн цэвэрлэдгийг харна уу:

Өөдөөс чинь Би мутраа эргүүлж, Хог шаарыг чинь шүлтээр мэт цэвэршүүлж Хольц бүхнийг чинь арилгана. Шүүгчдийг чинь Би анхных шиг нь Зөвлөхүүдийг чинь эхнийх шиг нь сэргээнэ. Ингэсний дараа чи зөвт хот, Итгэмжит хот гэж нэрлэгдэнэ. (Исаиа 1:25-26)

Биднийг цэвэршүүлдэг Бурханы гал нь юу вэ? Хариултыг нь дараах хэсгээс олж болно:

Хэдийгээр та нар эдүгээ түр зуур, шаардлагатай бол элдвийн сорилтод зовсон ч үүндээ үлэмж баярладаг. Ингэснээр итгэлийн чинь шалгуур галаар шалгагдах, мөхөх алтнаас ч илүү үнэтэй байж, Есүс Христийн илчлэл дээр магтаал, алдар, хүндэтгэлд хүрэх юм. (1Петр 1:6-7)

Бурханы цэвэршүүлэгч гал нь цөлийн үндсэн сэдэв болох *сорил, зовлон* ажээ. Энэ өндөр хэмийн халуун нь бидний амьдрал дахь бохирыг Бурханы зан чанараас салгадаг байна. Энэ үйл явц нь ариун байдалд хүргэх магадлалтай. (Яагаад “магадлалтай” гэж хэлснээ удахгүй тайлбарлана)

Алтын өөр нэгэн шинж нь шижир байдлаараа маш тунгалаг чанартай байдаг (шил шиг тунгалаг). “Арван хоёр хаалга нь арван хоёр сувд ажээ. Хаалга нэгбүр нь нэг цул сувд байсан бөгөөд хотын гудамж нь шил мэт тунгалаг шижир алт байв” (Илчлэл 21:21). Та нэгэнт галт сорилоор цэвэршсэн бол, тунгалаг болно! Тунгалаг агуулахуун нь өөрийгөө бус, доторх зүйлээ алдаршуулдаг. Тунгалаг зүйл нь саадгүй бөгөөд анзаарагддаггүй.

Бид нэгэнт цэвэршсэн бол, дэлхий дахин Есүсийг харах болно. Бид хий худлаа биш, үнэнийг хэлдэг, үгээ сахидаг, шударга

журамтай, нууж хаах зүйлгүй тунгалаг амьдарч байвал, дэлхийн хүмүүс анхаарч харах болно.

Исаиа дээр энэ тухай өндрөөр өгүүлдүүн:

Үзэгтүн, мөнгө шиг биш ч Би чамайг цэвэршүүлсэн.
 Чамайг зовлон зүдүүрийн зуухан дотор Би сонгосон.
 Би Өөртөө, Өөртөө л үйлдэнэ. Учир нь Миний нэр яаж
 бузарлагдаж чадах юм бэ? Би алдраа бусдад өгөхгүй.
 (Исаиа 48:10-11)

Энэ зуухан дахь гал нь алт, мөнгийг цэвэршүүлдэг бодит гал биш, харин зовлон учраас Бурхан “*мөнгө шиг ч биш*” хэмээжээ. Бидэнд ирдэг сорил нь үнэ цэнэтэйг бузраас ангилдаг халуун гал билээ.

Бурхан үүнийг биднээс албадан зайлуулахгүй. Тиймээс л 2Тимот 2:21 дээр Паул: “Иймд хэн өөрийгөө эдгээр зүйлээс цэвэрлэнэ...” гэжээ. Та өөрийгөө зөвтгөж, шалтаглаад, бохироороо хойш суугаад байх юм бол, Бурханыг таныг бохироос чинь албадан салгахгүй. Зовлон чинь ч ямар ч үр ашиггүй гарз болно. (Тиймээс л би өмнө “магадлалтай” гэж хэлсэн юм) Ариун байдлын хурдны зам дээр явагддаг цэвэрлэгээний үйл явц нь дуусашгүй, тууштай бас их зовиуртай үйл явц. Тийм боловч ургацыг нь бодоод уриалгахнаар хүлээн авах хэрэгтэй.

Еврей номын бичээч: “... ариуслыг мөшгөгтүн. Үүнгүйгээр хэн ч Эзэнийг үзэхгүй” (12:14) гэсэн. Есүс “Зүрхэндээ цэвэр ариун байгсад ерөөлтэй ээ! Тэд Бурханыг харах болно” гэсэн. Бурханы зүрхийг хөөдөг Давид “Хэн буруугаа ухаарч чадах вэ? Намайг нууцлагдсан буруунуудаас ангижруулаач” (Дуулал 19:12) хэмээн орь дуу тавьсан байдаг.

Бид ч бас ингэж хашхирмаар сан. Бурханаас зүрхийг маань цэвэрлээч гэж гуйбал, Бурхан нүднээс далд байх тэр бүх бохирыг цэвэрлэж хаяна. Галт сорил ирэх үед уурлалгүй, бусдыг буруутгалгүй, зорилгыг нь олж хар. Зүрхээ нягтлаж, үнэ цэнэтэйг бузраас цэвэрлэхийг Бурханд зөвшөөр. Бурхан “Би ариун учраас та нар ариун байгтун” (1Петр 1:16) хэмээн тушаасан.

Цэвэршүүлэл нь угийн сайн сайхан зүйлийг улам бататгаж, харин бохирлон дордуулагч зүйлийг зайлуулж хаядаг. Хүндэтгэлийн сав болж, Бурханы сайхан алдрыг нэвт шувт гайхуулан гийгүүлэхийн тулд Түүний цэвэрлэгээг таатай хүлээн ав.

8

САЙТАР БАРЬЖ БАЙГУУЛ

Туйлын тэнгэрт гялалзах одод шиг тод од байдаггүй юм. Цөлд ундрах ус шиг амтлаг ус байдаггүй юм. Дайн дунд амьд байж, ялан дийлдэг итгэл шиг үнэтэй итгэл байдаггүй юм. Шалгагдсан итгэл туршлагыг бий болгодог. Сорил шалгуураар гараагүй бол, мөхөс гэдэгтээ хүн итгэхгүй. Сорил шалгуураас аваад гарсан Бурханы хүч байгаагүй бол, та тэр хүчийг хэзээ ч мэдэхгүй.

—Чарльс Эйч. Спержен

*Учир нь махбодын дагуух нь махбодынхыг,
Сүнсний дагуух нь Сүнсний юмсыг боддог.*

—Ром 8:5



Тосолгоо бус, зан чанар л хүнийг Бурханы хөвгүүд, охид болгодог. Тэгээд цөлд дарамт ирж, гутрал бөөгнөж, мөрөөдөл алсрах үед л мөнөөх шаардлагатай зан чанарын хэлбэршил чинь өрнөнө.

Цөлд би дэлбэртлээ уурладаг байлаа. Энэ тухайгаа 1-ээр бүлэгт дурьдсан. Тиймээс би Бурханаас: “Би яагаад хүн болгонд уурлаад байгаа юм бэ? Би энэ их уураас салахын тулд юу хийх хэрэгтэй вэ?” гэж асуув.

Гэтэл Бурхан: “Махан биеийг хүлж, зайлуулж болохгүй, цовдлох ёстой” гэлээ.

Тэгэхээр нь бүр их цухалдаад: “Тэгвэл энэ уур хаанаас ирнэ вэ? Би аврагдахаасаа ч өмнө ийм ууртай байгаагүй!” гэж хэлэв.

Гэтэл Бурхан: “Уур чинь чиний дотор байж л байсан. Гэхдээ чиний алтан бөгжин доторх бохирдол зууханд шатаагдахаасаа өмнө далд байсантай адил дотор чинь далд байж байгаад, халуун зууханд орохоороо ил гарч байгаа нь энэ. Би чамайг зовлонгийн зууханд хийснээрээ уурыг чинь ил гаргасан юм” гэж хариулав.

Би Бурхан чухам юу яриад байгааг ойлгосонгүй. Тиймээс Бурхан надад илүү нарийн тайлбарлаж өгөв: “Чи гэргий, хамтран зүтгэгсэд, найз нөхөд, хүүхдээ нөхцөл байдал, дарамтдаа буруутгаж болно. Гэхдээ буруутгах юм бол, уур чинь үлдээд, халуун багасах үед буцаад гүнд чинь орчих учраас, энэ үйл явцыг дахиад л эхлүүлэх хэрэгтэй болно. Үүний оронд чи: “Бурхан минь, намайг уучлаарай. Энэ уурыг надаас аваач” хэмээн гэмшиж болно. Ингэбэл Би ковшоороо уурыг чинь ухаад гаргана.”

Тиймээс би яг ингэв. Халуун цөлийн дарамт дор уур илчлэхэд, би нүглээ илчилж, гэмшиж, үүнийг зайлуулж өгөхийг Бурханаас гуйсан юм.

Иймээс л цөл хэдий хатуу ширүүн боловч, үнэ цэнэтэй байсан бөгөөд эцэстээ намайг үлэмжийн баяр хөөрд аваачсан билээ:

Хэдийгээр та нар эдүгээ түр зуур, шаардлагатай бол элдвийн сорилтод зовсон ч үүндээ үлэмж баярладаг. Ингэснээр итгэлийн чинь шалгуур галаар шалгагдах, мөхөх алтнаас ч илүү үнэтэй байж, Есүс Христийн илчлэл дээр магтаал, алдар, хүндэтгэлд хүрэх юм. (1Петр 1:6-7)

Цөл нь биднийг цэвэршүүлдэг бөгөөд бидний дотоод зан чанарыг хөгжүүлдэг газар. Зовлон, хавчлагын зууханд л жинхэнэ бурханлаг хүн төрдөг юм. Ром 5:3-4 дээр “Түүгээр ч барахгүй мөн зовлонтойдоо баярладаг. Учир нь зовлон нь тэвчээрийг, тэвчээр нь батжилыг, батжил нь найдварыг төрүүлдгийг мэднэ” гэдэг.

Давид хаанчлалтай хөөцөлддөг бус, Бурханы зүрхийг хөөдөг хүн байсан учраас, Бурхан түүнийг таалсан! Гэтэл Саул хаан хэзээ ч цөлд цэвэршүүлэгдээгүй учраас, хэзээ ч цэвэршилгүй, айдастай чигээрээ дууссан юм. Харин Давид цөлд цэвэршүүлэгдсэн бөгөөд Бурхан түүнийг мөнөөх Саулаар дамжуулан цөл рүү илгээсэн байдаг!

Бурханы арга зам нууцлаг байж болох ч, төлөвлөгөөнүүд нь хэзээд сайн байна!

Мөрөөдөл хойшлогдов уу?

Цэвэрлэгдэх ч зовиуртай шүү. Би танд худлаа ярихгүй - цөл бол Диснейлэндийн аялал биш. Цөл бол зовлон. Тэгээд заримдаа маш зовиуртай замаар ирдэг.

Бурхан танаар юу хийлгэхээр дуудсанаа зүүд, алсын хараагаар харуулсан байж болох. Танд хандсан төлөвлөгөөгөө хэлсэн байж болох. Гэтэл цөлд Эзэнийг хайх тусам, Үгийг нь дагах тусам, таны зүрхэнд тавьсан тэр мөрөөдлөөс улам л алсраад байх шиг санагдана.

Иосефыг л аваад үз: Тэрбээр ах нар, гэр бүлээ захирах удирдагч болох мөрөөдөлтэй байв. Тэгээд яасан? Хамгаалж явах ёстой ах нар нь түүнийг нүхэнд хаяад, төдөлгүй гадаад руу боол болгоод худалдчихсан. Иосефын цочрол, гутрал, зовиурыг төсөөлж байна уу?

Тэрбээр мэдээж Бурхан шууд оролцож, түүнийг чөлөөлөх ёстой гэж бодсон байх. Гэтэл тэрбээр хэдэн сар юмуу жил боолчлогдоогүй, харин арав гаруй жил боолчлогдсон болохоор найдвар нь тэгс хийгээд замхраа байх. Урт хугацаа шүү! Энэ хооронд түүнд гай тарьсан хүмүүс нь эрх чөлөөтэй амьдарч, баян аавынхаа баялгийг эдлэж байгааг Иосеф мэдэж л байсан.

Иосеф яасан? Тэр цөлд яаж хандсан? Тэрбээр Бурханы амлалтыг марталгүй, итгэлээ сахиад л, үйлчлээд л явсан. Тэр итгэмжтэй байсан, хичээнгүй байсан, тэгээд эцэстээ ерөөлтэй амжилтыг үзсэн.

Гэтэл түүний нөхцөл байдал дахин өөрчлөгдөх гэж байв - гэхдээ энэ удаа бүр шал дордсон. Түүний даргын авгай Иосефыг хараандаа авчээ. Авгай Иосефыг нэг бус удаа хоргоосон ч, Иосеф тухай бүр Бурханаас эмээн, бэлгийн ёс бус явдлаас зугтжээ. Эцэстээ тэр авгай Иосефыг год харайн зугтахаас өөр аргагүй байдалд ортол нь түрэмгийлэв. Дараа нь шаралхсандаа Иосефыг хилс хэрэгт гүтгэн, шударга бусаар яллуулж, гянданд хориулжээ. (Ер нь бол хааны албатын гэргийг хүчирхийлэх гэж оролдсон гадаад боол дахиж хэзээ ч нарны гэрэл үздэггүй байв)

Шоронд байгаа хүндэлдвийг эргэцүүлэхээс өөр хийх юм байхгүй. Иосеф ямар бодлын сүрэгтэй тэмцэлдсэнийг төсөөлөшгүй. *Би насаараа л Бурханд үнэнчээр зүтгэлээ. Тэгээд яав? Буруугүй атлаа гянданд ялзарч үхэж байна. Амьдрал ингээд л дуусаа! Бодбол, хорон санаат ах нар маань жаргаж яваа биз. Би ямар буруу юм хийсэн юм бэ? Зүгээр л “Бурханаас ирсэн” гэж бодсон зүүдээ л ярьсан - тэгээд хар! Бурханд үйлчлэх ямар хэрэгтэй? Түүнийг дагах тусам, амьдрал маань доройтсоор байх шиг.*

Иосефын ийм бодлыг буруутгах аргагүй. Ойлгомжтой шүү дээ?

Тэгтэл нэг өдөр Иосеф цөлийн хамгийн том сорил - шалгалтаа өгчээ. Бурхан түүнийг ордны хэрэг хамаарагч, талхчин хоёртой учруулсан бөгөөд тэр хоёр нь дор бүрнээ жигтэй зүүд зүүдлээд, тайллыг нь хайж гарав. Иосеф Бурханд болоод Түүний амлалтад итгэхээ больчихсон байсан бол, зүгээр л өөрийгөө хараад, тэднийг хөөчих байв. Тэрбээр: “Та хоёр урьд шөнө зүүдлээ юу? Хээц... би ч бас зүүдлэж л явлаа. Бас л Бурханаас ирсэн зүүд гэж бодсон. Гэхдээ байна шүү - зүүд биелдэггүй юм. Зүүд бол дэмий, хоосон, худлаа зүйл. Тиймээс намайг тайван байлга!” гэж хэлэх байсан.

Ингэсэн бол Иосеф цөлдөө илүү олон жил - магадгүй үхэн үхтэлээ үлдэх байсан биз. Тэрбээр эрх чөлөөнд хүрэх тасалбараа алдах байсан. (Хожим ордны албат нь хаандаа Иосефын чадварын талаар дуулгасан нь Иосефыг эрх чөлөө, өндөр албан тушаалд хүргэсэн юм) Иосеф өөрийгөө өрөвдсөөр хоцорсон бол “Бурхан амлалтаа сахидаггүй, итгэмжгүй!” гэдгийг янз бүрийн байдлаар илэрхийлсээр, итгэлгүй, найдваргүй, хорссон чигээрээ гяндандаа талийх байсан байх.

Гэтэл Иосеф тэгээгүй. Тэрбээр Бурханы өөрт нь хувьчлан өгсөн амлалттай зөрчилдсөн бодлуудыг сөрөөд, ордны хэрэг хамаарагч,

талхчин хоёрт үйлчилсэн юм. Иосеф Бурханд дуулгавартай хэвээрээ л үлджээ. Үр дүн нь? Эцэстээ Иосеф ганц л өдрийн дотор суллагдаж, Фараоны дараагийн хүн болтлоо тушаал дэвшсэн!

Иосефыг удирдагч болсноос есөн жилийн дараа байгалийн гай гамшгаас болж ах нар нь Египетэд ирээд, дүүгийнхээ өмнө зогсож байв. Иосеф ихэнх хүмүүс шиг өшөө хорслын шинжтэй арга хэмжээ аваагүй. Тэрбээр одоо удирдагч шиг удирдагч болжээ. Иосеф өөрт нь хорон мууг үйлдсэн хүмүүст сайнаар хандсан. Тэрбээр урвагч нарт хорсдог бус, харин итгэл, хайр, уучлал үзүүлдэг хүн болжээ. Иосефын талаар магтаалч өгүүллүүн:

Үүнээс өмнө Тэрээр нэг хүнийг буюу Боол болон худалдагдсан Иосефыг илгээсэн. Хөлийг нь тэд дөнгөнд оруулж, Өөрийг нь төмрөөр гинжилсэн. Түүний үгс биелэгдэх хүртэл тийм байсан. ЭЗЭНий үг түүнийг шалгасан. (Дуулал 105:17-19)

Иосефт хандсан амлалтаа хэзээ биелүүлэхээ Бурхан л мэдэж байв. (Тэр зүүд нь хориод жилийн дараа л биелжээ) Цөл нь Иосефын дотор амьдрал, гэр бүл, удирдагчийн байр суурийг нь байгуулах зан чанарыг хэлбэршүүлжээ. Иосефын Эзэнээс эмээх сэтгэл нь түүний хамаг амжилтын оньс байв. Нөхцөл байдлаасаа үл хамааран, Иосеф Бурханы Үгийг ярьсаар, үйлдсээр, дагасаар байжээ.

Тэгвэл таны хувьд? Бурхан танд зүүд юмуу үгээрээ дуудлага, алсын хараа өгч, төлөвлөгөөгөө задласан байж болох. Гэтэл та Иосефтай адил цөлд суусаар, Эзэнийг хайж, Үгийг нь дагах тусам зүрхэнд чинь суусан мөрөөдөл улам л алсарсаар байгаа ажээ.

Бусад хүмүүс - тэр бүү хэл тантай дайсагнадаг хүмүүс ч үйлчлэлдээ (юмуу амьдралынхаа талбарууд дээр) өсч дэвшсээр. Гэтэл та Бурханаас хүлээж авсан мөрөөдлөөсөө улам л зөрсөөр. Та чадах бүхнээ хийсээр байгаа ч, мөрөөдөл чинь биелж байгаа юм алга.

Эргэн тойрны чинь Эзэнийг хайдаггүй, завхарсан хүмүүс өсч дэвшиж, хөгжин цэцэглэсээр. Тэд санхүүгийн болоод нийгмийн “ерөөлүүдийг” хамж байх шиг л харагдана. Бялдуучлал, дарангуйллаар ахидаг хүмүүс бий, бий. Хүмүүс шударга бус зүйл үйлдэн, худлаа ярьж, хулгай хийснээрээ амжилтанд хүрч, “ерөөгдөөд” байгаа юм шиг харагдах. Гэтэл та Иосеф шиг л Фараоны гянданд дөнгөтэй сууна.

Ийм байдлын эсрэг та юу хийж байна? Гомдоллож байна уу? Бурхан юу гэж хэлснийг харна уу:

“Та нарын үгс Миний эсрэг хатуу байв” гэж ЭЗЭН айлдаж байна. “Гэсэн ч та нар «Бид Таны эсрэг юу ярьсан юм бэ?» гэдэг. Та нар хэлэхдээ «Бурханд үйлчлэх нь ашиггүй. Бид Түүний тушаалыг сахиж, түг түмдийн ЭЗЭНий өмнө гашуудан явах нь ямар ашиг өгөх вэ? Өдгөө бид ихэмсгийг ерөөгдсөн гэж дууддаг. Гэм буруутнууд өөдлөөд зогсохгүй тэд бас Бурханыг сорьж, зугтан гардаг» гэдэг” (Малахи 3:13-15)

Гомдоллогсод энд юу хэлнэ вэ? Тэд “Бидэнд ямар ч ахиц дэвшил алга. Тэгэхээр Бурханыг дагасны ашиг юун? Бид биш, завхарсан, дүр эсгэгч нар л дэвжээд, ерөөгдөөд, цэцэглээд байна” гэсэн утгатай үг хэлжээ. Гэтэл үүнийг нь Бурхан Өөрийг нь сөрсөн, аймшигтай, хатуу үг хэмээв. Товчхондоо тэд гомдол гарган, гоншигножээ.

Израилийн хүүхдүүд гомдол гаргаснаасаа болоод л Амлагдсан газартаа хүрээгүй. Гомдоллох нь яагаад Бурхантай сөргөлдөх явдал вэ? Бурхан яагаад үүнийг хатуу шүүдэг вэ? Энэ нь дам маягаар Бурханд: “Миний амьдралд хийж байгаа зүйл чинь надад таалагдахгүй байна. Би Таны оронд байсан бол, өөрөөр хийх байсан юм” гэж хэлж байгаа явдал юм. Энэ нь Бурханыг доромжилсон хэрэг билээ.

Бурхан хэн Өөрийг нь дагах нь уу, хэн ашиг хөөх нь үү гэдгийг олж мэднэ. Эхнийх нь хүмүүс юу ч болж байсан Бурханыг дагахаар шийдчихсэн бол, сүүлийнх нь хүмүүс дургүйгээ хүрэхээр гомдол гаргадаг. *Жинхэнэ* ерөөл нь зарим хүний “ерөөл” гэж үздэг зүйлээс ялгаатай юм. Хандлага (зүрх) чинь буруу байвал, зарим ерөөл удаан үргэлжлэхгүй. Эзэн амиа бодсон гомдоллогч хүмүүсийг ерөөлтэй нь хамт яана гэснийг үзнэ үү:

Тахилчид аа, одоо энэ бол та нарт өгөх тушаал юм. Түг түмдийн ЭЗЭН айлдаж байна. “Та нар сонсохгүй аваас, зүрхээ Миний нэрийг хүндэтгэхийн төлөө дэлгэхгүй аваас та нар дээр Би хараал буулган, та нарын ерөөлүүдийг ч хараах болно. Үнэхээр Би тэднийг хараасан. Учир нь та нар үүнийг зүрхэндээ хүлээн авахгүй байна. (Малахи 2:1-2)

Бидний шагнал, өв нь эд юмс бус, харин Эзэн болой! Езекиел 44:28 дээр “Би өв нь юм” гэдэг.

Христэд итгэдэг олон хүн хараагаа жинхэнэ өвөөсөө салгаад, эд юмс дээр тавих болжээ - тэдгээр нь Бурханаас ирсэн сайн сайхан зүйлс ч байж болно. Гэхдээ энэ нь аавтайгаа харилцаатай байхын оронд аавынхаа гарыг л хараад байдаг хүүтэй адил юм. Би дөрвөн хүүтэй бөгөөд тэдэндээ өгөх дуртай. Гэтэл хөвгүүд маань надтай юм салгах гэж л харилцдаг бол, үнэхээрийн элэг эмтэрмээр. Малахи цааш нь юу гэснийг үзнэ үү:

Харин ЭЗЭНээс эмээдэг хүмүүс бие биентэйгээ ярихад ЭЗЭН анхаарал тавин сонсдог. ЭЗЭНээс эмээдэг болон Түүний нэрийг болгоодог хүмүүсийн төлөө дурсгалын ном Түүний өмнө бичигдсэн билээ. (Малахи 3:16)

Эд бол “гомдоллогч” нартай л адил цөлөөр яваа хүмүүс боловч, тэдний эрхэм зорилго нь байр суурь, алдар нэр, эд юмс биш ажээ. Ийм хүмүүс нийгэм, бизнесийн талаар ярьж чаддаг ч, Эзэний талаар юмуу Эзэний Үгийн талаар ярихаараа зүрх нь оволзоод л ирдэг.

Тэд бол Лукийн “Тэд нэг нэгэндээ —Замд Тэр бидэнтэй ярилцаж, Бичвэрийг бидэнд тайлбарлаж байхад нь зүрх маань [бидний дотор] шатаж байсан бус уу? гээд...” (Лук 24:32) хэмээн бичсэн хүмүүс юм. Тэдний хүсэл нь Сүнсний юмс дээр тогтдог. Тэд: “Би Бурханыг л мэдмээр байна, Түүнд л таалагдмаар байна, би Эзэний Үгээр өлсөж цангаж байна, Бурхан миний баяр баяслын ундарга учраас, миний баяр хөөр Түүнд л очих болтугай” гэдэг. Энэ л хамгийн чухал. Тэдний анхны хайр нь байр суурь, статус, эзэмшил бус, харин Есүс ажээ.

Тэдний авир үйлдэл цөлд байна уу эсвэл хэдэн сая хүний өмнө номлож байна уу гэдгээс шалтгаалахгүй.

Учир нь бид Бурханы хамтран зүтгэгчид бөгөөд та нар Бурханы тариан талбай, Бурханы барилга мөн. Надад өгөгдсөн Бурханы нигүүлслийн дагуу би мэргэн барилгачин мэт суурь тавьсан бөгөөд өөр нэгэн түүн дээр барьж байна. Гэхдээ түүн дээр яаж барихаа хүн бүр анхаарагтун. (1Коринт 3-9-10)

Бид амьдралаа хэрхэн байгуулж байгаа дээрээ анхаарах ёстой! Бичээс хүний амьдрал, хаанчлалыг байшин барихтай зүйрлэдэг. Бид Бурханы барилга учраас, Бурханд хамаатай:

Тиймд тэнгэрлэг дуудлагыг хуваалцагч ариун ах дүү нар аа, бидний хүлээн зөвшөөрдөг Элч ба Тэргүүн Тахилч болох Есүсийг ажицгаа. Түүний [бүх] гэрт Мосе итгэмжит байсны адил Тэр Өөрийг нь томилсон Нэгэнд итгэмжит байсан юм. Учир нь барилгачин барилгаасаа илүү хүндэтгэл хүлээдгийн адил Мосегээс илүү их алдрыг Тэр хүртэх зохистойд тооцогдсон юм. Учир нь аливаа барилга хэн нэгнээр баригддаг. Харин бүх юмсыг барьсан нь Бурхан мөн. (Еврей 3:1-4)

Байшинг Хэн барьж байгааг харж байна уу? Эзэн. Хүний хүч биш. Бурханы байгуулсан бүхэн үлдэж, бидний байгуулсан бүхэн нурна. “ЭЗЭН гэрийг барьж байгуулахаас нааш Түүнийг байгуулагчид дэмий хөдөлмөрлөнө” (Дуулал 127:1). Хүний Бурхангүйгээр барьж байгуулсан зүйлс - амьдрал, гэр бүл эсвэл үйлчлэл - тэсэхгүй.

Үүнийг Эхлэл 11:4-өөс харж болно: “За хөдөлцгөөе, бүгдээрээ хот болон тэнгэрт тулам оройтой өндөр цамхаг барьж байгуулан нэрээ алдаршуулцгаая.”

Бабел цамхагийг барьж байгуулсан хүмүүс ямар сэдэлтэй байв? Тэд амин хувийнхаа мөрөөдөлд хүрч, өөрсдийгөө мандуулахыг хүсчээ. Тэд Бурхан шиг хүчирхэг атлаа Бурханаас бүрэн тусгаар байхыг хүссэн. Тэр замнал нь Бурханы бус, тэдний хүслийг л биелүүлсэн. Бурханаас тусдаа юм хийнэ гэдэг хэзээ ч бүтэхгүй хэрэг. Учир нь санаа маань хичнээн сайхан байсан ч, Бурхан байхгүй бол, ямагт гарз болно. Тиймээс л бидэнд:

Надад өгөгдсөн Бурханы нигүүлслийн дагуу би мэргэн барилгачин мэт суурь тавьсан бөгөөд өөр нэгэн түүн дээр барьж байна. Гэхдээ түүн дээр яаж барихаа хүн бүр анхаарагтун. Учир нь тавигдсан суурь болох Есүс Христээс өөр суурийг хэн ч тавьж чадахгүй. Хэрэв хэн нэгэн энэ суурин дээр алт, мөнгө, эрдэнийн чулуу, мод, өвс болон сүрлээр баривал ажил болгон нь илэрхий болно. Учир нь мөнөөх өдөр үүнийг харуулна. Юу гэвээс энэ нь галаар илчлэгдэх ба гал нь хүн бүрийн ажлын чанарыг шалгах болно (1Коринт 3:10-13) хэмээн сэрэмжлүүлжээ.

Бурханы байгууламжийг алт, мөнгө, үнэт чулуугаар, хүний байгууламжийг мод, өвс, сүрлээр төлөөлнө. Энэ нь гагцхүү тэнгэрийн шүүхэд хамаатай ишлэл үү? Үгүй! Эдгээр ишлэл нь

Есүсийн сүм дээрээ ирэх үйл явдлыг (Малахи 3:16-4:1, 1Коринт 3:16-17) дүрслэж байгаа юм. Тэрбээр мод, өвс, сүрлийг *залгигч* юмуу алт, мөнгийг *цэвэршүүлэгч* гал шиг ирнэ. Тиймээс л Тэрбээр: “Хэрэв хэн нэгний ажил шатвал тэрээр хохирол амсана. Тэр өөрөө гал дундуур гарсан мэт боловч аврагдана” (1Коринт 3:15) гэжээ.

Хэрэв та амьдрал, бизнес, үйлчлэлээ өөрийнхөө хийсэн тоосгоор буюу бяр тэнхээгээрээ юмуу дэлхийн хөтөлбөр техникээр барьбал, ... хүмүүсийг айлган сүрдүүлж, дарангуйлж, захиргаадах аргаар барьбал, ... бялдуучилж, байр суурь олохын төлөө бусдын цүнхийг зөөх аргаар барьбал, ... бусдыг шүүмжилж, хов жив тараан, амьдралыг нь сүйрүүлэх аргаар барьбал - барьсан бүхэн чинь шатаж, үгүйрэх болно.

Олон хүн өөрийгөө дөвийлгөж, санасандаа хүрэх гэсэндээ залилж, худлаа ярьдаг. Тэгвэл энэ арга ч шатна! “Хэн ч өөрийгөө бүү мэхлэг. Хэрэв та нарын дунд хэн нэг нь энэ үед өөрийгөө мэргэн гэж боддог бол тэр нь мэргэн болохын тулд мунхаг болог. Учир нь энэ ертөнцийн мэргэн ухаан бол Бурханы өмнөх мунхаглал ажээ. Энэ нь “Тэрээр цэцдийг баширлал дээр нь барьж авдаг” гэж бичигджээ” (1Коринт 3:18-19).

Амин хувиа эрсэн амьдралын чинь аль ч тал Бурханы мэлмийд мод, өвс, сүрэл шиг л үзэгдэнэ. Эзний нэрээр зүтгэж, бусдад таалагдаж, хамаг цаг заваа золиослосон байсан ч, энэ бүхэн чинь шатна.

Дэлхийн цэц ухаан хүн дээр л төвлөрдөг. “Хэрэв зүрхэнд чинь гашуун атаархал ба хувиа хичээсэн зорилго байх аваас бүү бардамна, үнэний эсрэг худал бүү ярь. Энэ мэргэн ухаан бол дээрээс бууж ирдэг нь биш харин газрынх, төрөлхийнх бөгөөд чөтгөрийнх юм” (Иаков 3:14-15). Атаархал нь өрсөлдөөн, хар сэрийг төрүүлдэг. Өөрийнхөө нутаг дэвсгэрийг баталгаатай байлгахын тулд бид найз нөхөд, журамт чанараа гаргуунд нь гаргахаас гадна хамгийн гол нь Бурхантай тогтоосон харилцаагаа золионд явуулах эрх мэдлийн тоглоом эхлүүлж мэдэх. Пастор, үйлчлэгч нар ч Бурхантай зүрх - зүрхээрээ хослон амьдрахын оронд байр суурь, хэргэм зэрэг юмуу цалингийн төлөө сэдлээр жолоодуулж болох.

Гэтэл Бурханы зүрхийг үнэн голоосоо хайдаг хүмүүст Бурханыг хайх тусам, улам л холдоод байх шиг санагддаг учраас, тэд гутарсандаа:

“Бурхан минь, Би Таныг хайв ч, дээшээ бус, доошоо л ороод байх юм” гэж хашхирахад нь Бурхан “Илүү гүн

ух!” гэж хэлдэг. Над уруу ирж, үгийг минь сонсоод үүний дагуу үйлдэгч нь хэнтэй адил болохыг та нарт Би харуулъя. Тийм хүн нь барьж буй байшингийнхаа суурийг, газраа гүн ухаад хадан дээр суурилуулсан хүнтэй адил юм... (Лук 6:47-48)

Би Далласт амьдардаг байхдаа, тэнгэр баганадсан цамхаг босгож байгаа барилгачдыг их хардаг байж билээ. Байгууламж нь том байх тусам гүн ухах бөгөөд барилгынх нь суурь ч тэр хэмжээгээрээ үнэтэй тусна. Дээрээс нь харахад, барилгачид хөдлөж ядаад, ямар ч ахицгүй байна гэмээр. Тэгтэл сууриа тавиа л бол, асар богино хугацаанд өндрөөс өндөр байшин сүндэрлээд л босоод ирнэ. Бэлтгэлийн хугацаатай нь харьцуулахад, бараг л ганц шөнийн дотор босчихов уу гэлтэй санагдана.

Дээшээ сүндэрлэх үйл явц нь доошоо малтах үйл явцсын дэргэд юу ч биш ажээ.

Христийн бие дотор олон хүн доошоо малтуулах бэлтгэл үе шатдаа яваа гэдэгт би итгэдэг - онцгойлон олон тооны залуус. Үүнд Бурханыг магтъя! Тэд үйлчлэлд юмуу Эзэний өгсөн аль нэг мөрөөдөлд дуудагдсан байж болох ч, одоо зүгээр л үйлчилсээр яваа ажээ. Амьдрал нь онц ахицгүй харагдаж болох ч, Бурхан тэднийг цөлд нарийн бэлтгэж байгаа гэдэгт би итгэж байна. Суурь цутгагдаж, Христийн зан чанар хэлбэршиж байна. Ийм зан чанартай хүмүүс л айсуй жилүүдэд Христэд болоод Түүний хаанчлалд халуунаар үйлчлэх хүмүүсийн тоонд баталгаатай орно.

Цөлөөр дамжаагүй хүмүүс тухайлбал улс төрийн тавцан дээр өөрийгөө өргөмжилсөөр, дардан замаар урагшилсаар байх мэт харагдана. Үүнийг үзсэн цөлийн хэд маань жаахан атаархаж, өөрсдөө ч бас замаа товчлох арга чарга хайж гарна. Тийм боловч эцэстээ тэр зам нь тогтвортой зан чанарыг авчрахгүй бөгөөд хэдийнээ бий болгосон зан чанарыг маань ч үгүй хийдгийг ойлгоод, ийм хулхи зүйлийн төлөө өөрт байгаагаа тавьж туухгүй гэж шийднэ. Тэд Бурханыг хүлээж, гагцхүү Мастер Барилгачнаараа л Хадан дээр тогтсон суурь тавиулна.

Өнөөдөр зарим пасторууд Бурханыг хичээнгүй хайсаар байв ч, ямар ч урамгүй байж болох. Тэд хуурай цөлд байгаа ажээ. Хүмүүс дэлхийн маркетингийн аргаар үйлчлэлээ амжилтанд хүргэж, өөрсдөө алдар нэрд хүрч байгааг тэд харсаар. Олон нийтийн сүлжээ тэдэнд аз жаргал, амжилтын хийсвэр төсөөллийг өгнө. Тийм боловч ийм арга техникээр барьж байгуулахыг

Бурхан цөлийнхөнд зөвшөөрөхгүй. Учир нь Бурхан тэдний насан туршийн, бат бэх суурийг бэлтгэж байна.

Үүнээс гадна зарим хүмүүс Бурханаас ямар ч нарийн ширийн тодруулгагүй, зүгээр л дан мөрөөдөл хүлээгээд авчихсан байдаг. Тиймээс тэд энэ бүхэн яаж биелэх талаар зогсоо зайгүй гайхширч, хамаг боломжоо нэг нэгээр нь алдаад байх шиг л санадаг.

Аян замд аминд орох арга

#8 Иошуа яг зөв хийсэн

Цөл нь сайн зорилготой юм бол, бид яаж саараас нь зайлсхийгээд, сайныг нь хүртэх вэ?

Иошуа бол цөлд яг зөв зүрхтэй байж чадсан хүний онц жишээ билээ. Мосег Синай ууланд гарахад, Иошуа бэлд нь үлдээд, хүлээсэн. Тэрбээр Эзэний оршихуйтай аль болох ойр байхыг хүссэн. Мосег майхан сүм дотор Бурхантай уулзахад, Иошуа ч Эзэний оршихуйтай ойр байх гэж тэнд байжээ. Мосег дууссаны дараа ч Иошуа Уулзалтын майханд үлдсэн (Гэтлэл 33:11).

Иошуа номыг үзбэл, тэдний эцэг өвгөдийг (өмнөх үеийнхэнийг) сүйрүүлсэн таван нүгэл нь шинэ үеийнхнээс нь (Иошуагийн үеийнхэнээс) харагддаггүй. Гагцхүү Ахан гэдэг ганц хүн л эндсэн. Аханыг нүгэл үйлдэхэд, удирдагч нар нь түүний асуудлыг газар дээр нь шууд шийдсэн байдаг. Өмнөх үеийнхэн нь буюу эцэг, эх нь алдаа завхралаасаа болоод Бурханы амлалтын биеллийг үзэлгүй, цөлд үхэхийг харсан шинэ үеийнхэн нь яг зөв юм хийжээ.

Иошуа болоод түүний үеийнхэн Бүтээгч дээрээ төвлөрсөөр, Амлагдсан газарт орж чаджээ. Тэд Бурханы Үгийг бат сахиж, урам алдахаас сэргийлсэн. Тэд гомдол гаргахаас татгалзаж, Бурханд шуурхай итгэсэн.

Цөлөөр Бурхан Өөрийг нь дуулгавартай хүлээх хүмүүсийг өөрийгөө өргөмжилдөг, дарангуй, зальжин хүмүүсээс салгана.

Бурханыг дахин ирэхийг харуулдан хүлээж буй хүмүүс л Бурханаас цөлөөс гарах гарц, жинхэнэ өргөмжлөлийг хүлээж авна. Бурхан:

“Би тогтоосон цагийг сонгохдоо Чигч шударгаар шүүх билээ. Дэлхий болон тэнд оршин суугч Бүгд ганхана. Баганануудыг нь Би Бат тогтоожээ. Села. Бардамнагчдад Би “Бүү бардамна” Буруутуудад “Эврээ бүү өргө. Эврээ өндөрт бүү өргө. Бүдүүн хүзүүгээр бүү ярь” гэв. Учир нь өргөмжлөл Дорноос ч үгүй, өрнөөс ч үгүй, Цөлөөс ч үл ирнэ. Харин Бурхан Шүүгч бөгөөд Нэгийг бууруулж, нөгөөг өргөмжилнө” (Дуулал 75:2-7) гэдэг.

Махан бие ашиггүй

Махан бие - Сүнсний тэмцлийн талаарх үнэн нь зөвхөн үйлчлэлийн талбарт бус, амьдралын бүх талбар дээр хэрэгжинэ! Махан биеийнхээ хүчээр үр дүнд хүрсэн бол, баяр хүргэе! Гэхдээ та энэ үр дүнгээ цаашид махан биеийнхээ хүчээр л хадгалах ёстой болно. Харин Сүнсний хүчээр төрсөн үр дүнг Бурхан Өөрөө цааш нь аваад явна.

Махан биеийн үйл явдал нь ер нь бол дарангуйлал, хяналтын орчин руу л хөтлөнө. Удирдагч нар үр дүнд хүрэхийн тулд эрх хүчээрээ далайлгах юмуу сэтгэл мэдрэмж дээр л тоглолт хийнэ. Хэрэв та тийм хүмүүсийг дагадаг бол, тэдний удирдамжинд хэрхэн хариу үйлдсэнээрээ л *амжилт юмуу бүтэлгүйтлийнх нь* хариуцлагатан болно. Тэр орчинд маш их дарамт, хуульчлал, ноёрхол, дарангуйлал оршино.

Би үйлчлэлийн талбар дээр л төвлөрч ярьж байгаа боловч, дан үйлчлэл бус, харин махан биеийн хүчээр төрсөн *бүхэн* ийм байдгийг хэлмээр байна. Тиймээс энэ зарчим зах зээл, боловсрол, эрүүл мэнд, төрийн алба, цэрэг арми, мэргэжлийн спорт зэрэг Бурханы хүмүүсээ дуудсан бүх талбар дээр хэрэгжинэ.

Тонгоруулбал - Сүнсээр төрсөн нь өөрийнхөө гавьяагаар төрөөгүй гэдгээ ойлгодог учраас, өөрийнхөө хүчээр өсч чадахгүй гэдгээ ч мэддэг. Бурхан Өөрийнхөө бүтээсэн (барьж байгуулсан) зүйлийг цааш нь Өөрөө хариуцлагатайгаар авч явна.

Исаакийг төрөхөд, Ишмаел хэдийнээ бие даагаад байжээ (Эхлэл 16:21). Миний харснаар, мөрөөдлийн Исаакийг мэндлэхээс өмнө Ишмаелыг бүтээх хүчин зүтгэл хэзээд дэргэд байдаг. Тиймээс

Бурханы амлалтыг хүний хүчээр бүтээх өдөөлтийг эсэргүүц. “Энэ зарц бүсгүйг хүүтэй нь зайлуул. Зарц бүсгүйн хүү миний хүү Исаактай хамт өв залгамжлахгүй.” (Эхлэл 21:10)

Эзэн хүмүүстээ “Ишмаелын хүчин зүтгэлийг зайлуул. Учир нь махан биеийн үр амлалтын үртэй хамтарч өв залгамжлахгүй” хэмээн айлдах өдөр айсуй. Хэдийгээр тэр нь үр дүнтэй харагдаж болох ч, Бурхан “Зайлуул!” гэнэ. Тийнхүү Бурханы оршихуйд ямар ч махан бие алдаршихгүй!

Бурханы шүүх болоход, өөрийнхөө хүчээр барьж байгуулсан амьдралын чинь бүх хэсэг цэвэршүүлэгч галыг тэсч үлдэхгүй. Хэрэв та амьдралаа амиа хичээсэн, өөрийгөө өргөмжилсөн хүчин зүтгэлээр байгуулсан бол, энэ бүхэн чинь шатна. Гэхдээ “Тэр өөрөө гал дундуур гарсан мэт боловч аврагдана” (1Коринт 3:15).

Тэгээд гагцхүү Бурханы Сүнсээр бөгөөд нигүүлслээр олдож, мэндэлж, амлалтаар хүлээн авагдсан нь л тогтож үлдэнэ.

9

ХҮЧНИЙ БЭЛТГЭЛ

*Зовлонгийн өндөрлөг дээр л Эзэний шилдэг
дайчид төрдөг.*

—Чарльс Эйч. Спержен

*Хүүхэд өсөж, сүнсээр хүчирхэг болсон бөгөөд
Израилийн өмнө гарч ирэх өдрөө хүртэл цөлд
амьдрал.*

—Лук 1:80



Олон жилийн өмнө амьдралд минь тохиолдсон бэрхшээл надад Христийн дагалдагч бидэнд итгэлээ бэхжүүлж, сунгах бэлтгэлийн цаг хэрэгтэй байдгийг дүрслэн ойлгуулсан юм. Итгэх эсэхийг чинь мэдэхгүй - гэхдээ энэ сорил маань аль нэг хуурай, хувхай газар бус, харин эрүүл мэндийн клуб, спорт зааланд өрнөж билээ.

Би гучин таван настай байхдаа Жоржиагийн Атлантагийн чуулган дээр тэнхээ тасартал номлоод, индрийн ард шургачиж унах дөхөв. Өөрийгөө бие физиологийн хувьд тааруухан байгааг мэдмэгцээ, цаашдаа итгэмжтэй үйлчилмээр байвал, хүчтэй байх хэрэгтэй гэдгээ ухаарав.

Харьж ирээд, Лизад болсон явдлыг яриад: “Би спортоор хичээллэлээ!” хэмээн мэдэгдэв.

Хамгийн гайхмаар нь Лизагаас: “Ашгүй дээ, би чамайг спортоор хичээллээсэй гэж залбирч байсан!” гэдэг хариу сонсов. Нөхрийнхөө яг юуных нь төлөө залбирахыг мэддэг эхнэртэй байна гэдэг бөөн ерөөл!

Тэр үед манайх Флоридад аж төрж байсан бөгөөд манайхаас хоёр байшингийн зайтай Кип гэдэг мэргэжлийн тулаанч найз маань амьдардаг байв. Кипийн хүүхдүүд манай залуучуудтай үе тэнгийнхэн байсан бөгөөд бид гэр бүлийн сайхан найзууд байлаа. Кип надад хэд хэдэн удаа хамт бэлтгэл хийе гэсэн санал тавьсан боловч, би дандаа: “Үгүй чшш... найз нь завгүй, цаг байхгүй” гэдэг байсан юм. Би ч завгүй нь завгүй л байсан л даа. Гэхдээ гол шалтгаан нь мэргэжлийн тулаанчтай бэлтгэл хийхээс сүрдэнэ биз дээ.

Манай Кип 118 кг жинтэй атлаа дөрөвхөн хувийн өөхтэй, булиа эр байв. Цээж нь төгс гурвалжин, хэвлий нь нидрүүлэг. Кип, бид хоёр үе үе хөвгүүдтэйгээ гадаа сагс юмуу хоккей тоглоно. Түүнтэй мөргөлдөх үед тэр газар дээрээ ганхалгүй үлдээд, харин би хэдэн алхмын зайд шидэгдэнэ!

Атлантагийн аяллын дараа би Кипийнд очоод: “Кип, би

жиимд явах хэрэгтэй байна. Чи намайг дасгалжуулна гэсэн - одоо дасгалжуулж болох уу?” гэлээ.

Кип ч шууд л: “Тэгье л дээ. Би чамайг жиим авч явъя!” л гэлээ. Тухайн үед би түүний зэвүүнээр мушилзахыг анзаараагүй бөгөөд намайг юу хүлээж байгааг гадарласан ч үгүй!

Маргааш нь бид хоёр жиимийн зааланд орлоо. Тэгээд тэнд “томчууд” л бэлтгэл хийдэг болохыг шууд ойлгов. Агаарт тестостерон давалгаалж, хөлсний үнэр хамар цоргино. Эхний өдрөө би хөнгөн жингээр олон удаа шахсанаар бус, харин хүнд жингээр цөөхөн шахаж байж булчин хөгждөгийг сурав. Гурав, дөрөв шахахад л болно.

Тэгээд гурав дахиа явуулаад, дөрөв дэхээ өргөхөд л жинхэнэ адал явдал өрнөнө. Энэ үед таны бүх эд эс чинь “Больё оо!!” гэж чарлана. Гэхдээ таныг бүслээд зогсчихсон, хангай шиг нөхөд чинь: “Явуул, явуул, явуул!” гэж доргиоход, та нэг л мэдэхнээ тэр жинг дөрөв, тав өргөчихсөн байдаг. Энэ төвөгтэй асуудлыг энгийнээр булчингийн хөгжил гэдэг ажээ.

Тэгэхээр жаахан ичмээр боловч, би эхний өдрөө 43 кг-ыг л шахав. Кип ч намайг ямар хол байгааг ойлгосон байх! Ийнхүү хэдэн долоо хоног жиимд итгэмжтэй явсны үр дүнд 47 кг руу ахилаа. Дахиад хэдэн долоо хоногийн дараа 56 кг. Тэгээд эцэстээ 61 кг-д хүрэхдээ, төмрийнхөө хоёр талд тус бүр 20,5 кг - ын стандарт туухай хийх болсондоо нүүр бардам байв.

Энэ түүхээ би бүлгийнхээ сүүлээр үргэлжлүүлнэ. Харин миний бяр орсон түүх маань Эзэн хэрхэн биднийг цөлийн “жиимд” аваачаад, сүнсний булчинтай болгодог үйл явцсыг яруу тодоор дүрслэн харуулах сайн жишээ болно.

Цөл нь биднийг “Бурхан минь, Та хаана байна?!” гэж хашхируулан, хатаах зорилготой газар бус, харин хүнд сорил, өдөөлтийн газар учраас, тэнд сүнс маань бяр ордог. Цөл нь хахир хатуу газар мөн боловч, биднийг сүнсний хүчний бэлтгэл хийж байхад, Хэн бидний өмнөөс шахаж байдгийг марташгүй:

“Хэрэв Бурхан бидний талд юм бол, хэн биднийг эсэргүүцэх вэ?” (Ром 8:31)

Бурхан бидний төлөө бас бидний өмнөөс шахаад зогсохгүй, дээрээс нь баттай амлалтаа өгчээ:

Бурхан итгэмжтэй, Тэр та нарыг хэр чинь хэтэртэл

соригдохыг зөвшөөрдөггүй, харин дааж гарахын
тань тулд сорилттой хамт мөн гарцыг ч буй болгоно.
(1Коринт 10:13)

Тиймээс та ямар ч шалгуураар орсон, ямар ч гутарч сөхөрмөөр
хуурай газраар явсан - Бурхан хэзээ ч бидэнд дааж давшгүй зүйлийг
зөвшөөрөхгүй гэдгийг мэдээрэй. Энэ үнэхээр гайхамшигтай.

Сорил дунд өөрийгөө хэн болохыг бүү март. Бурханы
хайрт хүүхдүүд бидэнд Есүс: “Харагтун, могой ба хилэнцэт
хорхойнуудад халдах, дайсны хамаг хүчээс дээгүүрх эрх мэдлийг
Би та нарт өгсөн. Та нарт юу ч хор учруулахгүй” (Лук 10:19) гэсэн.
Тиймээс дайсан биднийг юугаар ч нүүлгэсэн бай - бид ялна.
Ялахгүй байсан бол, Бурхан зөвшөөрөхгүй байсан!

Гэтэл олон хүн яг үүн дээр л бууж өгдөг. Тэд илүү том асуудлыг
шийдвэрлэх хүчин чадлаа ахиулдаггүй. Тэгээд жиимээс зугтана
эсвэл жиимд очлоо ч гомдол гаргаад суучихна. Тэгвэл Паул тэс
өөр хандлагын талаар өгүүллрүүн:

Учир нь Христийн төлөө Түүнд зөвхөн итгэх бус,
Түүний төлөө бас зовох нь та нарт соёрхогджээ.
(Филиппой 1:29)

Зовлон “соёрхогдсон” гэхээр жаахан ойлгомжгүй байна уу?
Энэ чинь одоо юу гэсэн үг вэ? “Соёрхол” гэдэг чинь ерөөлийг
илтгэсэн үг болохоор би л хувьдаа ямар нэгэн ерөөл ирэх нь гэж
ойлгож байна.

“Зовлон”, “соёрхол” гэдэг хоёр үг яахаараа нэг өгүүлбэрт
багтдаг билээ? Яг л: “Төрсөн өдрөөр чинь шүдийг чинь мэдээ
алдуулахгүй ломбодох эрх соёрхлоо” гэж хэлэхтэй л адил. “Юу?
Баярлалаа, гэхдээ хэрэггүй.” Өнөөдөр дэлхий дээр Америк шиг
тав тухтай улс байхгүй. Тиймээс бид бүр ч ойлгохгүй. Толгой
эргэмээр. Ихэнх хүмүүс жаахан зовоод ирэхээрээ:

“Надад ийм юм тохиолдох гэж, арай ч дээ.”

“Яахаараа би байдаг юм?”

“Яахаараа би ингэж зовдог юм?”

“Шал дургүй хүрчихлээ!”

“Намайг юу туулж байгааг хэн ч мэдэхгүй!”

“Би яагаад зүгээр амьдарч болдоггүй юм?”

“Бурхан минь, надаас үүнийг зайлуулаач!”

“Яахаараа заавал тэмцэх ёстой юм. Буугаад өгчихье” гэдэг.

Бид бүгдээрээ л нэг иймэрхүү янзаар бодож, авирлах үе бий. Бид

сорил, зовлонгийн (цөлийн) зорилгыг ойлгодоггүй нь тун харамсалтай.

Гэтэл Бурхан Түүний хаанчлалыг үр дүнтэй байгуулахад шаардлагатай хүчин чадлыг бидний дотор бий болгоход юу хэрэгтэйг, хичнээн хэмжээний хүч шаардлагатайг мэднэ. Тиймээс л Паул бидэнд итгэлийн булчинг маань өсгөхийн тулд стратегийн ач холбогдолтой зовлон “соёрхогдсон” гэдэг Бурханы амлалтыг сануулсан буюу.

ӨДӨӨЛТИЙН ҮҮРЭГ

Цөлийн хүчний бэлтгэлд өдөөлтийг таньж, эсэргүүцэх чадварын өсөлт багтана. Бурхан Аав нь Хүүгээ сорих зөвшөөрлийг Диаволд олгох үед Есүс яг ийм замаар туулсан билээ: Есүс Ариун Сүнсээр дүүрч Иорданаас буцаж цөлд Сүнсээр хөтлөгдөн, дөчин өдрийн турш диаволд соригджээ. Тэр өдрүүдэд юу ч идээгүй ба тэдгээрийг гүйцэхэд Тэрээр ихэд өлсжээ. (Лук 4:1-2)

“Зөвшөөрөх” гэдэг үгийг би тун болгоомжтой сонгосон. Учир нь Бурхан хэзээ ч өдөөлтийг зохиогоогүй. “Хэн нь ч уруу татагдахдаа “Бурхан намайг уруу татаж байна” гэж бүү яриг. Учир нь Бурхан муу муухайд уруу татагддаггүй бас Өөрөө хэнийг ч уруу татдаггүй” (Иаков 1:13).

Өдөөлт ирэх үед бидэнд юу тохиолддог вэ? Сатан бидний Бурхантай тогтоох аз жаргалтай, дуулгавартай харилцааг таслах ганц л сэдлээр биднийг нүгэл унагадаг. Сатан ийм зорилготой байсаар байтал, Бурхан яах гэж өдөөлтийг зөвшөөрнө вэ? Элч Петр бидэнд ингэж ойлгуулжээ: “Иймээс Христ нэгэнтээ махбодоороо зовсон тул та нар ч гэсэн ижил санаагаар өөрсдийгөө зэвсэглэ. Учир нь махбодоороо зовсон нь нүглийг дуусгасан” (1Петр 4:1).

Өөрөөр хэлбэл өдөөлтөөр ирдэг шалгалт нь - цөлд нүглийг болоод бусад бэрхшээлийг дийлэх ялалт нь бүгд бидэнд сүнсний булчингаа хөгжүүлж, төлөвшихөд маань туслах үүрэгтэй. Дээрх ишлэлд “зэвсэглэ” гэдэг чухал үг гарч байна.

Тулаанд зэвсэггүй орж байгаа салааг харсан уу? Буу, танк, винтов, ямар ч зэр зэвсэггүй? Аймшиг! Тэгвэл зовлон, сорилд зэвсэглээгүй Христийн дагалдагч нар яг л ийм гамшигт өртөнө.

Арилжааны нисэх онгоцны нисгэгч нар бол болзошгүй шалгалтад хэзээд бэлтгэлтэй явдаг хүмүүс. Нислэгийн компаниуд зургаан сар тутамд нисгэгчдээ бэлтгэл сургуульд хамруулдаг. Нисгэгч симулятор дотор суугаад болзошгүй бүхий л төрлийн

аюул осолд хариу үйлдэнэ. Юуны төлөө, яах гэж? Шуурхай нөхцөл байдлыг шийдвэрлэх чадвараа батжуулахын төлөө. Онгоцны осол болоход *зэвсэглээгүй* зорчигч нар байдаг бүхий л мэдрэмжээ гаргадаг бол, нисгэгч хүн хариу үйлддэг. Яагаад? Яагаад гэвэл тэд *зэвсэглэжээ*.

Дуулгавартай Христэд итгэдэг хүн цөлд ийм л эрдэмд суралцдаг. Цөл нь биднийг дайсагналтай тулгаруулж, хэтийн байлдан дагуулалд зэвсэглэдэг. Бэрхшээл - цөл бидэнд ирэхдээ л ирнэ. Энэ дэлхий дээр бид зовлон, бэрхшээлтэй тулгарах боловч, эдгээрийг ялахад маань туслана гэдгээ Есүс амласан. Энэ дунд бид бэхэждэг юм.

Боломжийг бүтээ

Бид цөлийг сүнслэг булчингаа томруулж, Эзэний өгөх гэж байгаа зүйлд хүчирхэгжих сайхан боломж гэж харах хэрэгтэй.

Ах дүү нар минь, элдвийн сорилтод орохдоо үүнийг бүрэн баяр хөөр гэж үз. (Иаков 1:2)

Аян замд аминд орох арга

#9 Ишмаелыг төрүүлэх бий

Бид цөлд ороод „яасан ч их уддаг юм” гэж бодох үед хаалганы цаана зогсож байсан өдөөлт гуй: „Тийм аа, мөрөөдлөө биелэл болгохын төлөө ямар нэг юм хий” гэдэг. Би үүнийг Ишмаелын төрөлт гэж нэрлэдэг юм. Бид Бурханы хийнэ гэж амласан зүйлийг хүнийхээ хүчин зүтгэлээр хийх гэж оролдох үед Ишмаел төрдөг. Ишмаелууд голдуу хууль ёсны байдаг боловч, махан биеэс төрдөг юм.

Энэ санаа маань мэдээж Бурхан „хүүтэй болгож өгнө” хэмээн амласан Абрахам, Сарах хоёрын түүхээс эхтэй. Тэд арван нэгэн жил хүлээгээд, хөөрхий Абрахам 86-тай золгож, Сарах ч хүүхэд төрүүлэхэд хэтэрхий оройтжээ. Тиймээс тэд „Б” төлөвлөгөөндөө орж, Сарах нөхөртөө „Хагараар дамжуулан амлагдсан хүүгээ гаргаж ав” гэдэг санал дэвшүүлжээ. Энэ маш тааруу санаа байв. Тийнхүү

Америкчууд бид интерпренерүүдийг дэмждэг улс учраас, боломж гэдэг ойлголтыг мэдэж байх ёстой. Жишээлбэл, бизнесийн боломж гэдэг нь өсөх, амжилтанд хүрэх, хөгжин цэцэглэх боломж юм. Энэ нь бидний үзэл бодлоо тэлэх завшаан болой. Тиймээс бэрхшээлийг ч бас ингэж л хар. Учир нь Иаков “Итгэлийн чинь шалгуур хатуужилд хүргэдгийг та нар мэдэх билээ. Хатуужил нь төгс үйл байг. Тэгвэл та нар төгс, бүтэн юугаар ч дутахгүй байна” гэсэн буюу.

Цөлд хатуужлаа өсгөх боломж баталгаатай бий. Өнөөгийн ертөнцөд “хатуужлыг” юу гэж ойлгодог билээ? Ерөнхийдөө бидний даацыг нэмэгдүүлэх зориулалттай дасгал болох хатуужлын бэлтгэл сургуультай холбож ойлгодог. Товчхондоо хатуужлын бэлтгэл сургууль нь бидний хэтийн бэрхшээлийг даах *хүчин чадлыг* өсгөдөг.

Тэгэхээр ийм байна: Бидэнд ямар ч бэрхшээл тулгарсан бай - Бурхан үүнийг зорилготойгоор зөвшөөрсөн бөгөөд тэр зорилго нь *хүчин чадлыг* төрүүлдэг. Бурхан маргааш бидэнд зайлшгүй ирэх дарамтын төвшинг загварчилсан (нисгэгчийн бэлтгэлээ хийдэг загвар онгоцыг санаж байна уу) бэрхшээлийг өнөөдөр бидэнд

Ишмаелууд хэдийгээр сайн сайхан харагддаг ч, үнэндээ тун тааруу санаа байдаг. Махан биеийнхээ хүчээр төрүүлсэн бүхнээ та махан биеийнхээ хүчээр л авч явна гэдгийг санаарай!

Би ч бас заримдаа „Б” төлөвлөгөөгөөр оролдож үзсэн. Бурхан надад нэг л өдөр дэлхий даяар номлодог үйлчлэлтэй болно гэж амласан боловч, юу ч болохгүй байв. Би нутгийнхаа чуулганд үйлчилсээр л, үйлчилсээр л байлаа. Тиймээс би хэд хэдэн удаа сайн эр болж, цөлөөс оргох гэж үзсэн боловч, хүчин зүтгэл маань асар өндөр өртөгтэй тусч, бүтэлгүйтсэн юм. Тэгээд гараа өргөн бууж өгөх үед минь Бурхан нүүдлээ хийж, бүхнийг эргүүлдэг байв.

Нэг насны зовлонд унах гээгүй л юм бол, Ишмаелыг бүү төрүүл! Танд амласан зүйлээ Бурхан Өөрөө л хийг.

зөвшөөрнө (би дахиад л зөвшөөрөх гэдэг үгийг онцлон тэмдэглэж байна). Тиймээс л сорил нь ямагт бидний өнөөдрийн бэлэн байдал, үүрэг хариуцлагын төвшнөөс өндөр санагддаг юм. Үндсэндээ Бурхан өнөөдрийн бэрхшээлийг ашиглан, биднийг хэтийн том, том байлдан дагуулалд бэхжүүлдэг.

Харин одоо миний булчинтай болсон түүх рүү эргэж орцгооё. Кипийн дасгалжууллын ачаар би 61 кг өргөдөг болсон тухайгаа ярьсан. Энэ нь миний хувьд том ололт байсан боловч, би үүнээс илүүг өргөж чадах эсэхээ гайхаж байлаа. Тухайлбал, сүнсний амьдрал дээр авч үзбэл, Эзэн надад 61- ээс хүнд жинтэй сорил бэлтгэсэн байвал яах уу?

Тиймээс би жиймдээ явсаар байлаа. Тэгээд 92 кг өргөдөг болсон ч, хэдэн жил тэр жингээсээ дээшилсэнгүй. Нэг удаа Калифорнийн конференц дээр номлотол, хэдэн эрчүүд надад: “Жон, чи 100 кг өргөж үзээгүй, тээ?” гэлээ.

Би ч: “Үгүй ээ, хэдэн жил оролдоод бараагүй” гэж ирээд л гонсгор царайлан хариуллаа.

Гэтэл: “Бид туслая” гэдэг юм. Тэгээд мэдээж тэр өдөр би 100 кг өргөөд, хөл газар хүрэхгүй баярлав!

Үүний дараа манай Мессенжер Интернэйшнэл үйлчлэлд нэг хүн шинээр орж ирсэн нь хүндийг өргөлтийн тамирчин байж таарсан бөгөөд би түүнтэй хамт бэлтгэл хийж эхлэлээ. Түүний ачаар би 106 кг, нэг удаа бүр 111 кг - ыг ч шахав. Гэхдээ би үүнээс дээшээ явж чадах болов уу?

Жилийн дараа Детроитод номлов. Бүтэн сайны цуглааны дараа тэр чуулганы пастор: “Жон, манайд нэг дасгалжуулагч бий. Манай цуглаанд явдаг, олон улсад алдартай хүндийн дасгалжуулагч. Маргааш өглөө би түүн дээр цагтай. Хамт явах уу?” гэлээ.

Би ч хөөрөөд: “Тэгье л даа!” л гэлээ.

Маргааш нь яваад очлоо. Дасгалжуулагч намайг хэмжиж үзээд: “Чи дээд талдаа 111-ийг шахсан юм биз дээ?” л гэлээ.

-“Тийм ээ, гэхдээ ганц л удаа.”

-“Тэгвэл өнөөдөр хоёулаа тэрнээс ч хүндийг өргөнө өө.”

Юу? Би ингэж хэлээгүй боловч, дотроо “Энэ хүн галзуурчихаж. Энэ боломжгүй!” гэж бодож байлаа. Гэтэл хэсэг дасгалжуулалт, бэлтгэлийн дараа итгэмээргүй зүйл болж, түүний ачаар би 120 кг өргөчихөв.

Миний баярласан гэж. Манай багийн гишүүн, бид хоёрыг Колорадо руу буцсаны дараа дасгалжуулагч маань биднийг долоо хоног тутам и-мэйлээр дасгалжуулж байлаа. Бид ч бэлтгэлээ хичээнгүй хийсээр, дараагийн жил нь Детроитын нөгөө цуглаандаа дахин зочлов. Тэр үед би 42-той байлаа.

Бүтэн сайн өдөр Ариун Сүнсний гайхамшигт мөн чанарын талаар номлов. Нэг дэхь өдөр нь цуглаан дээр ирээд, бидний хэсэг нөхөд жиим рүү явлаа. Дасгалжуулагч: “Жон, өнгөрсөн шөнө би чамайг 136 кг өргөж байна гэж зүүдэллээ” гэв.

Би: “Пөөх!” хэмээн дуу алдсан ч, дотроо бол “*Та тэгж зүүдлэж болно оо. Харин би зүүдлээгүй шүү!*” гэж л бодлоо.

- “Жон, чи өчигдөр Ариун Сүнсний хүчний талаар номлосон. Тэр зүүдийг надад Ариун Сүнс өгсөн! Тиймээс энэ сандал дээр гар. Хоёулаа өргөнө өө!”

Тэгээд биеэ халаагаад, төмөртөө туухайгаа углаад, нэг сүрхий уухилж аваад, 136 кг-ыг өргөчихөв!

Баярласандаа Детроитны онгоцны буудал дээрээс Лиза руу залгаад: “Би ч бараг онгоцгүй, өөрөө л хөөрчих гээд байна шүү!” гэж хэлж билээ.

Би 136 кг-ыг өргөх үедээ ер нь бол 100-ыг л өргөдөг байсан шүү дээ. Үнэндээ зуугаар арав шахдаг болсон байлаа. Гэтэл долоон жилийн өмнө дөнгөж эхлэж байхдаа ямар байсныг минь санаж байна уу? Хэрэв 35 насанд минь Кип над дээр 43 кг-ыг бус, шууд 136 кг-ыг тавьчихсан бол, юу болох байсан бол? Би газар дээрээ нам болох байв! Туухайтай төмөр нурж орж ирээд, намайг налчийлгах байсан! Би ийм чадалд хүрэх гэж олон жил тууштай хөдөлмөрлөсөн билээ. Тиймээс өнөөдөр надад хэвийн санагдаж байгааг 100 кг долоон жилийн өмнө амьдралыг маань дуусгах байв!

Тиймээс өнөөдөр бидэнд төвөг болдог, эцэс төгсгөлгүй сорилууд нь хэтийн том, том шалгалтанд бэлтгэж буй сүнсний хүчний бэлтгэл ажээ. Бид Эзний дотор хүчтэй байвал, хаанчлалыг байгуулах үйлсэд хүчтэй л ажиллана.

Харамсалтай нь, шүүх сэнтийн өмнө нулимс асгаруулан зогсоод, Есүсээс: “Би чамаар ихийг хийлгэх гэсэн боловч, чамд үүнийг дагаж ирэх бэрхшээлийг даах хүчин чадал нь байсангүй” гэдэг үгийг дуулах хүмүүс гарах болно. Бурхан бидэнд хэрээс минь хэтэрсэн зүйлийг зөвшөөрөхгүй гэж хэлсэн учраас, бүр ч харамсалтай. Тэрбээр бүр амласан шүү дээ!

Тэгэхээр миний хүндийн жингийн түүхээр зүйрлэн ярья. Та 61 кг-ын сүнсний даацтай ажээ. Гэтэл Бурхан танд 83 кг дарамт, хавчлага, өдөөлт, сорилыг даах хүчин чадал шаардсан төлөвлөгөө, байр суурь бэлтгээд байсан ч, танд хангалттай хүч байхгүй учраас, Бурхан үүнийг зөвшөөрөхгүй. Оронд нь Бурхан биднийг бэлтгэлд гаргана. Бурхан өдөөлт, сорилын зохиогч биш. Гэхдээ алсдаа таныг шалгах боловч, сүйрүүлэхгүй хэмжээний ачааг буюу магадгүй 70 кг-ын сорилыг зөвшөөрнө.

Жишээлбэл, нэг хүн таны талаар цуу яриа тараажээ. Харин та биеэ өмөөрөн, тэр хүн рүү хариу дайрч, ялгаагүй цуурхал тараахын оронд Бурханы Үгэнд орон, дуугүй байж, нөгөө хүнийг ерөөжээ. Мундаг байна. Та 70 кг-ын хүндийн шалгалтыг давчихлаа! Тэгсэн дараагийн шалгалт нь 74 кг. Энэ бэрхшээл дунд ч та Бурханы Үгийг үргэлжлүүлэн дагасаар байвал, танд зэхсэн Бурханы хаанчлалын өндөр төлөвлөгөө, шинэ байр сууринд бэлэн болжээ.

Харин нөгөө хов живд гоморхон, нөгөө хүн рүүгээ эргэж дайрбал - тийм ээ, та зөв таалаа - Эзэн гашуудаад: “Буцаж очоод 65 кг-аа дахиад өргөөрэй” гэж хэлнэ. Та “жиимд” явсаар байгаа ч, үр дүнд хүрэхгүй байна.

Бэлтгэлээ хийсээр байгаа боловч, төвшин чинь ахихгүй байна. Дараа нь Бурхан санхүүгийн бэрхшээл зөвшөөрнө - дахиад л 70 кг-ын шалгалт. Гэтэл та Бурханы хангамжийг хайхын оронд шууд л: “Асуудалгүй! Кредит картаа шавхаж хэрэглэе!” гэж хэлнэ. Тэр үед Бурхан нэмэлт жинг чинь аваад: “Буцаад 65 кг руугаа!” гэж хэлнэ.

Хожмын нэг өдөр та хаанчлалын 84 кг бүхий жинтэй даалгавар, байр суурийн төлөө Бурханд хэрэгтэй болно. Та цөлийн шалгалт - хүчний бэлтгэлдээ дандаа бүтэлгүйтсэн бол, танд тэр нөхцөл, байр суурийн жинг даах сүнсний булчин байхгүй учраас, Бурхан таныг тухайн ажилд урьж чадахгүй. Тиймээс Бурхан тэр даалгавар, байр суурийг даачих өөр хүний эрэлд гарна.

Илүү том эрх мэдэл хийгээд хүч

Иймээс л цөл чухал байдаг: *Цөл бидний хүчийг байгуулдаг.*

Цөлд Иохан Баптист сүнс дотор хүчтэй болсон.

Цөлд Есүс сүнс дотор хүчтэй болсон.

Тайван цагт бус, харин сорил нүүрлэж, итгэл нь шалгагдах үед л тэдний сүнсний булчин хөгжсөн.

Иаков бидэнд тун сонсголонтой мэдээ дуулгаж байна. Сорил дундуур гарахдаа, хэрэв Бурханы замаар үйлдбэл, та хүчтэй бөгөөд бэлэн болно. Учир нь Бурхан айлдруун:

Итгэлийн чинь шалгуур хатуужилд хүргэдгийг та нар мэдэх билээ. Хатуужил нь төгс үйл байг. Тэгвэл та нар төгс, бүтэн юугаар ч дутахгүй байна. (Иаков 1:3-4)

Иаковын хэлсэн “Хатуужил” гэдэг үг нь бидний тэвчээр, хүчин чадал юм. Түүнчлэн Иаков цөлийг талархан хүлээж авсан хүнд: “Сорилтыг тэсвэрлэдэг хүн ерөөлтэй еэ! Учир нь тэр шалгуулчихаад, Өөрийг нь хайрлагсдад Эзэний амласан амийн титмийг хүлээн авна” (Иаков 1:12) хэмээн амлажээ.

“Титэм” гэдэг үг нь эрх мэдлийг илэрхийлэх бөгөөд харин эрх мэдэлтэй хамт хүч ирдэг. Есүс Диаволд соригдохоор цөлд очоод, дуулгавартай байдал, тууштай зангаараа илүү том эрх мэдэл, хүчийг олоод гарч ирсэн болохоор (Лук 4:1,14-ийг үзнэ үү), бид ч цөлийн улирлаас илүү том эрх мэдэл, хүчийг олоод гарч ирж чадна.

Та яахыг мэдэхгүй. Харин би Эзэний надад бэлтгэсэн зүйлийг даах сүнсний булчинтай байхыг хүснэ.

“Жиим явцгаах уу?”

10

ЦӨЛ ДЭХЬ УС

*Сөрөг нөхцөлд Бурханд итгэхгүй байгаа бол,
Бурханд ерөөсөө итгэдэггүй ажээ.*

—Чарльс Эйч. Спержен

*Энэ уснаас уух хүн бүр дахин цангана.
Харин Миний өгөх уснаас уух хэн ч хэзээ ч
цангахгүй. Харин Миний өгөх ус тэр хүний
дотор мөнх амь өөд оргилох булгийн ус болно.*

—Иохан 4:13-14



Цөлийн бороо - нүдний гэм. Цөлд устай золгох амаргүй, золголоо ч худаг юмуу булгийн ус л бий. Цөл нь хуурай, ангамал газар (Дуулал 63:1). Тиймээс л Есүс биднийг урихдаа ингэж хэлжээ:

Баярын их өдөр болох сүүлчийн өдөр Есүс зогсоод хашхиран —Цангасан хүн байвал Над уруу ирж, уугтун. Бичвэр хэлсэнчлэн Надад итгэгчийн дотроос амийн усны гол урсах болно гэв. Есүст итгэгсдийн хүлээн авах Сүнсний тухай Тэр үүнийг хэлжээ. Есүс хараахан алдаршуулагдаагүй тул Сүнс тэнд өгөгдөөгүй байлаа. (Иохан 7:37-39)

Би цөлд байхдаа, залбирах гэж оролдовч амьд усны сэнгэнэсэн ундааг олох гэж зүдэрч байсан хэд хэдэн тохиолдлоо санаж байна. Нэг удаа Эзэнийг хайхаар оройхон тийшээ улсын хамгаалалттай хүрээлэнд очиж майхнаа засав. Тэндээ хоноод өглөөгүүр харих санаатай байв. Тэгээд оройжин залбираад, дараа нь Библиэ уншаад, дараа нь магтаалын дуу дуулах маягаар бараг гурван цаг болсон ч, ямар ч үр дүнгүй байлаа. Сэргэх янзгүй, хув хуурай. Гонсойсондоо аяны хөнжилдөө шургаад, унтах гэж оролдлоо.

Тэр шөнө чөтгөрүүд ялалтын баяраа тэмдэглэж байх шиг л. Би олигтой ч унтаж чадсангүй. Бурхан яагаад надад Өөрийгөө илчлэхгүй байгааг гайхсаар, дэмий л эргэлдэж хөрвөөсөөр. Маргааш өглөө нь гадаа гараад, цэцэрлэгт хүрээлэнгээр алхангаа Сүнс дотор залбирсаар байсан ч бас л хув хуурай байлаа. Ийм маягаар дахиад цаг хагас болов. Сүүлдээ би дээшээ хараад: “Эзэн минь, би цөлд байх шиг байна” гэж хэллээ. Би “Бурханыг хайхаа болиод, гэртээ харихаас. Бурхан л намайг цөлд авчирсан болохоор, Бурхан л намайг цөлөөс гаргана. Би юу ч хийгээд нэмэргүй!” гэж бодож байлаа.

Гэхдээ энэ маань буруу бодол байсан юм. Бурхан биднийг баахан гонсойлгож, буулт хийлгэх гэж цөлд аваачдаггүй. Цөл нь бүтэлгүйтлийн бус, харин ялалтын цаг байх учиртай! Ийнхүү боджээ явтал, гэнэт дотроос минь нэгэн намуун дуу: “Тулалд!” гэх нь сонсдов. Тэр ганц намуун үг надад шаардлагатай байсан очийг асааж, амьдралыг ноцоов. Би тэр даруй: “Дотор минь буй Бурханы бэлэг бадар! Амьд усны голууд урстугай! Сэтгэлд минь байгаа худгууд хальтугай!” гэж хэлэв. Тэгээд Израильчуудыг цөлд байх үед юу болсныг саналаа:

Тэндээс тэд Беер уруу явав. Мосед “Ард олныг цуглуулагтун. Би тэдэнд ус өгье” гэж ЭЗЭНий айлдсан худаг нь энэ юм. Израиль энэхүү дууг дуулан Оргилон дүүрэгтүн, худаг аа! Түүнд дуулагтун. (Тооллого 21:16-17)

Бичээсийн эдгээр үгийг давтах тоолонд залбирал маань улам эрчимжиж, нэг мэдэхнээ би замаар дээшээ доошоо алхлан, Эзэний Үгийг хүч чадал, галаар залбиран тунхаглаж байв. Бүх зүйл сэргэж, би тэс өөр хүн болжээ! Надтай Бурханы хүчирхэг оршихуй хамт байлаа. Хэдэн минутын өмнө би дарамтаа даахгүй, сульдаж явсан бол, эдүгээ ямар ч дайсантай Эзэний Үгээр мөргөлдөхөд бэлэн, тулаанд гарахаар оворлож байв!

Энэ байдал хорин таван минут үргэлжилсэн ч, таван минут болсон мэт л санагдав. Эдүгээ би сэргэхээр барахгүй, дэлхийг байлдан дагуулахад бэлэн болжээ!

Есүсээс ундаалсан хүний зүрхнээс амьд усны голууд юмуу булгууд урсана гэсэн. Цөлд бид Бурханы Сүнсний хүрхрээг (бороог) үзэхгүй. Цөлд сэргээх усыг Бурханы оргилуур юмуу худгаас буюу зүрхнийхээ цөмөөс татаж авдаг юм.

Иохан 7:39 дээр Есүс Өөрийнх нь өгүүлээд буй усны эх үүсвэр - худаг нь Эзэний Сүнс бөгөөд итгэгч хүний зүрхнээс ганц гол бус, харин голууд урсан гарна хэмээн тэмдэглэн хэлснийг анхаарна уу.

Эзэний Сүнс яаж бидний зүрхнээс голууд мэт урсдаг вэ? Эш үзүүлэгч Исаиа Сүнсний ажлын мөн чанарыг ийнхүү тайлбарлажээ: “ЭЗЭНий Сүнс, Мэргэн ухааны ба ухаарлын сүнс, Зөвлөгөөний ба хүч чадлын сүнс, Мэдлэгийн хийгээд ЭЗЭНээс эмээхүйн сүнс Түүн дээр оршино.” (Исаиа 11:2)

Ариун Сүнсийг Цэц ухааны Сүнс, Ойлголтын Сүнс, Зөвлөх Сүнс, Чадлын Сүнс, Эзэнээс эмээхүйн Сүнс гэжээ. Есүс Сүнс голууд шиг урсана гэсэн болохоор, Цэц ухааны гол, Ойлголтын

гол, Зөвлөгөөний гол, Чадлын гол, Мэдлэгийн гол, Эзэнээс эмээхүйн гол байдаг байх нь. Тиймээс хүрээлэн дотор зүрхэнд минь гал авалцсанд ч гайхах явдалгүй.

Үүнийг дэмжих ишлэлээс дурьдбал:

- Хүмүүний амны үгс гүн ус мэт. Мэргэн ухааны ундарга урсах горхин лугаа адил. (Сургаалт үгс 18:4)
- Мэргэн ухаан хэнд байна Түүнд амийн ундарга юм. Мунхаглал, мунхаг хүндээ шийтгэл. (Сургаалт үгс 16:22)
- Хүний зүрхэн дэх зорилгууд гүний ус Ухаан бодролт хүн үүнийг гадагш гаргах. (Сургаалт үгс 20:5)

Сүнс итгэгч хүний зүрхэнд оршдог учраас, энэ худгууд нь мөн л итгэгч хүний зүрхэнд орших аж. Гэхдээ Эзэний замуудыг ойлгодог хүн л тэр худгаас ус татаж гаргана. “Татаж гаргах.” Энэ бол түлхүүр үг нь. Би дахин хэлье: цөлийн цангааг Сүнсний борооны усаар тайлахгүй, харин зүрхнээс татаж гаргасан усаар л тайлна.

- Сургаалт үгс 10:11 дээр “Зөвтийн ам нь амийн ундарга” гэдэг.
- Сургаалт үгс 15:23 дээр “Онож хэлсэн хариултад хүн бүр баярладаг” гэдэг.

Би: *“Бурхан л намайг цөлд авчирсан болохоор, Бурхан л намайг цөлөөс гаргана. Би юу ч хийгээд нэмэргүй!”* гэж хэлээд, майхнаа хураагаад яваад өгсөн бол, дарамтаа аваад л явах байжээ. Гэтэл зүрхэнд минь Бурханы өгсөн зүйлийг гаргаж хэлэхэд, энэ үг надад зүрхнийхээ гүн худгаас ус татах чадал хайрлажээ. Би газар доорх авралын усан сандаа хүрээд, цангаа тайлах усыг татаж гаргажээ. Цөл дунд булгийн хүйтэн ус залгилахтай л адил байв!

Олон хүн хуурай цөлд бууж өгдөг бол, Бурхан “Бүү зогс, давсаар бай!” гэсээр байдаг. Дотор минь Бурханы хүслийг гүйцэт биелэн биелтэл бууж өгөхийг мэддэггүй, гүргэр жолоо орших ёстой.

Олон хүн хуурайшаад ирэхээрээ залбирахаа больчихдог. Худгаас нь ус гарахаа больчихоор бас ус татах дэндүү хэцүү гэж бодсондоо зогсчихдог. Тэд үлбийж эхлэдэг бол, Бурхан тэднийг айсуй тулаанд шаардлагатай хүчээ базаагаасай гэж хүсдэг.

Ус татах хүчийг хаанаас олох вэ? Баяр хөөрөөс! Исаиа 12:3 “Та нар авралын худгаас баяртайгаар ус татна” гэдэг. Учир нь “Эзэний баяр баясал та нарын хүч чадал” болой (Нехемиа 8:10). Баяр баясал нь биднийг хүчжүүлдэг сүнсний хүч юм.

Эзэний баяр баясал гэж юу вэ? Би олон жил Эзэний баяр баясал гэдэг нь “Бурханы баяр баяслыг өөртөө байлгах” гэж ойлгодог байлаа. Үүнийгээ ч амьдрал дээрээ хэрэгжүүлэх гэж овоо зүдэрсэн. Гэтэл Бурхан ингэж хэлээгүй ажээ. Жишээлбэл, “хоол хийх дуртай, хоол хийхдээ жаргалтай” хүмүүс бий. Хоол хийх нь өөрөө баясал агуулдаггүй, харин хоол хийх ажлаасаа баяр жаргал авдаг гэсэн үг. “Эзэний баяр баясал” нь Бурхантай тогтоох харилцаанаас эдлэдэг баяр хөөр юм. Тэр бидэнд баяр хөөр авчирдаг!

Залбирч байхдаа Бурханы оршихуйг мэдрэхгүй байгаа нь Бурхан биднийг хаячихсан гэсэн үг биш. Тиймээс бид мэдрэмжээсээ шалтгаалж баярладаггүй, ямар Бурхантайдаа, тэр Бурхантай тогтоох харилцааныхаа сайн сайханд баярладаг юм. Тиймээс Бурхан биднийг тоодоггүй гэдэг худлаас даваад, харин ч Бурхан биднийг гүн худаг руу ойртуулж байгааг хар!

Худгийг таглахгүй байх

Гайхамшгаар мэндэлсэн Абрахамын хүү Исаак нэгэнтээ ган гачгаар дайрчээ:

Абрахамын үед анх ган гачиг болсон тэр газарт дахин ган гачиг болсонд Исаак Герар уруу одож, Филистийн хаан Абимелех дээр хүрч очжээ. ЭЗЭН, Исаакт үзэгдэж —Чи Египет уруу бүү яв! Миний зааж өгөх газарт суурьш. Тэр газарт суу. Би чамтай хамт байж, чамайг ерөөн, энэ бүх газрыг чамд болон чиний үр удамд өгнө. Би чиний эцэг Абрахамд андгайлсан тангаргаа биелүүлнэ. (Эхлэл 26:1-3)

Бурхан Исаакт тав тухтай Египет рүү явалгүй, харин Өөрийнх нь зааж өгсөн газарт очиж суурьшихыг онцгойлон захижээ. Бид цөлд орохоороо хамгийн түрүүнд “Эндээс бушуухан гарах минь!” л гэж боддог. Өглөө залбирах үед Бурханы оршихуй мэдрэгдэхгүй бол, бодлууд маань уугин, тухайн өдөр амжуулах ёстой юмсаа тоочиж эхлэдэг. Тэгээд залбирлаа гялс дуусгачихаад, амжуулах ажлаа тунгааж гарна.

Чуулгандаа сэтгэл дундуур болбол, бид Бурханаас ч асуулгүйгээр, шууд л “Сүнсний баяр хөөртэй, мундаг номлолтой газар руу явах минь!” гэж шийддэг.

Эсвэл нийгмийн юмуу бизнесийн амьдрал маань хуурай санагдбал, бид бушуухан шиг эдийн засаг нь цэцэглэж буй хотод очиж суурьшихыг боддог. “Эндээ үлдбэл, амьдралд маань зориулсан Бурханы төлөвлөгөөг биелэхийг үзэлгүй, хатаж үхэх юм байна” гэж бодно.

Ийм бодолтой Христэд итгэдэг Америкчууд зөндөө. Тэд ган гачиггүй газар олох гэж нэг олон нийтийн сүлжээний платформоос нөгөө рүү, нэг үйл ажлаас нөгөө рүү, нэг чуулганаас нөгөө рүү, нэг хотоос нөгөө рүү гүйсээр. Тэд одоо байгаа газарт нь худаг гаргаж, ангаж цангасан хүмүүст цэнгэг ус авчрах гэсэн Бурханы үйлсэд өөрсдийгөө бэлэн байлгаж, зориулагдахын оронд хувийн тайтгарал, амар амгаланг хайн, “Египет рүү дүүрвээд” ор сураггүй болно. Бурхан тэдэнд өгсөн алсын хараагаа энэ хуурай цаг үед л биелүүлэхээр ажиллаж байгааг тэд ойлгодог ч үгүй. Бас Бурхан биднийг шинэ газарт бэлтгэн, хуучныг маань хатахыг зөвшөөрдөг цаг ч байна. Хамгийн чухал нь Бурханы Сүнсээр удирдуулах! Сүнс юу ч хэлэхгүй байвал, зүгээр үлдээд л тулалд!

Исаак Бурханыг дуулгавартай дагаж, тэр гамшгийн газар үлдсэний ачаар юу болсныг үз:

Тэгээд Исаак тэр газарт тариа тарьж, тэр жилдээ зуу дахин их ургац авав. ЭЗЭН түүнийг ерөөжээ.
Тэрээр агуу их болж, маш агуу нэгэн болтлоо өслөө.
Тэр хонин сүрэг, үхэр сүрэг, асар олон хамжлагатай байсан бөгөөд филистчүүд түүнд атаархаж,
түүний эцэг Абрахамын өдрүүдэд зарц нарынх нь ухаж гаргасан бүх худгийг шороогоор дүүргэн битүүлэв. ...
Эцэг Абрахамынх нь өдрүүдэд ухаж гаргасан худгуудыг Исаак дахин ухжээ. Учир нь Абрахамыг өөд болсны дараа тэдгээрийг нь филистчүүд булж битүүлсэн байв.
Исаак тэдгээрийг эцгийнхээ өгсөн нэрээр нэрийдэв.
(Эхлэл 26:12-15,18)

Аян замд аминд орох арга

#10 Миний баяр баяслын нууц эм

Цөлд нөхцөл байдлаа л хараад байх амархан. Тэгвэл намайг цөлөөс амьд авч гарсан бяцхан нууцаа би тантай аминчлан хувалцамаар байна. Би үүнийг миний баяр баяслын нууц эм гэдэг юм.

Гаднаа баярлах юмгүй үед, юу ч өөрчлөгдөхгүй үед, залбираад, залбираад үр дүн гараагүй үед би „Есүс миний төлөө юу хийлээ?” гэж боддог. Тэгээд Есүс намайг хэзээ ч унтаршгүй, хэзээ ч татаршгүй хүхэрт галтай тамаас аварсныг санадаг. Тамын тарчлаан хэзээ ч төгсөхгүй. Там нь надад бус, Дяволд зориулагдсан газар. Тийм боловч Дявол хүн төрөлхтнийг мэхлээд, тийшээгээ хүмүүсийг зөөдөг болжээ. Тийм байтал Есүс амиа өгсөн - Миний Бүтээгч *намайг* тэр аймшгаас аврахын төлөө *Өөрийгөө* өгсөн.

Ийнхүү хараагаа Есүс дээр тавьж, талархалтай хандлага руу шилжиж, амьдралаа өнө мөнхийн хараагаар хармагц, одоогийн нөхцөл байдал маань өчүүхэн санагдаж эхлэдэг.

Талархууштай бүхнээ эргэн санаж, Есүс дээр хараагаа тавих нь миний баяр баяслын нууц эм.

Исаак аавынхаа анх ухаж гаргасан худгийг дахиж ухаж байж л (түүнийг нь Филистинчүүд булсан байв), үр тариагаа услах усанд хүрчээ. Исаакийн нэгэн адил бид ч бас булаатай худгийг дахиж ухаж байж, зүрхийг маань төлөвшүүлдэг Бурханы ялзрашгүй үрийг ургуулах усанд хүрэх үе олонтаа. Филистинчүүд энэ дэлхийг, дэлхийн системийг төлөөлнө. Бид энэ дэлхийн системтэй хэт наалдахдаа, өөрөө ч мэдэлгүй худгаа битүүлдэг. Гэтэл худгаа ажиллагаатай байлгаж байж л сэтгэлээ сэргэг байлгана шүү дээ.

Христийн бие рүү халдах нийгмийн соёлын довтолгоогоор олон худаг “битүүрсэн” гэдэгт би итгэдэг. Урсгал усны ундарга байх үүрэгтэй чуулган худгийг маань битүүлэх санаатай дайснаа хүлээн авснаараа цөл болон хувирсан уу?

“Бурхан чуулганаа цэнгэг усаар сэргээх үү, үгүй юу?” гэж бид асуух ёстой? Хариулт нь: Сэргээнэ ээ! Энэ зураглалыг Исаиа яруу сайхнаар илчилжээ:

ЭЗЭН чамайг ямагт удирдан Ган гачигийн үед сэтгэлийг чинь хангалуун болгож, Ясыг чинь тэнхрүүлнэ. Чи усалсан цэцэрлэг мэт, Ширгэшгүй устай урсгал мэт байх болно. Танайхнаас эрт цагийн балгасуудыг дахин сэргээж Олон үеийн сууриудыг босгоно. Чамайг «Цөмөрхийг сэргээн босгогч, Оршин суух гудамжийг засагч» гэж нэрлэнэ. (Исаиа 58:11-12)

Исаак биеийнхээ амрыг хайн, тав тухтай газар руу яваагүй шиг бид ч (хувийнхаа юмсыг хийлгүй, хувийнхаа таашаалыг эрэлгүй, хувийнхаа үгээр амьдралгүй Бурханыг хүндэтгэсэнээрээ) усалгаатай цэцэрлэг шиг байж, ширгэшгүй устай амьд усны булаг болно! Бид Бурханы замаар үйлдэх юм бол, Бурхан ангаж ундаассан хүмүүст биднээр дамжуулан амьд усаа хайрлана.

Энэ дэлхийн булсан худгуудыг Бурхан биднээр дахин ухуулах гэж байна. Энэ нь ганц, хоёр цагийн ажил бус, харин олон өдөр, хоног, сар, жилийн ажил учраас, нилээд гүргэр чанарыг шаардана.

Сэтгэл хөрөх

Цөлөөр амьдралын хүнд хэцүү улирлыг дүрслэн хэлэх гэснийг маань та ойлгосон байх аа. Цөлийг маш их цангаа, гарзын мэдрэмжээр таньж болно. Дуудлагадаа, тэр бүү хэл Бурхантай харилцахдаа ямар ч баяр хөөр мэдрэхгүй, сэтгэл хөрч, хоос оргих нь цөлд нэвтэрсний дохио байж мэдэх.

Тэгэхээр, залуусын пастораар үйлчилж байхдаа дайрч гарсан хоёр дахь том цөлийнхөө аяны талаар товч ярьмаар байна.

Флоридагийн чуулганд үйлчилсэн эхний есөн сар ер бусын байв. Үйлчлэл тэлж, бүлгүүд ч өсөв. Би ч хөлгүй баярлаж, эрч хүчээр буцлаж байлаа. Тэгтэл юу болов гэлтэй, гэнэт залгуур салж, нөгөө их халуун сэтгэл, жолоо маань унтрав.

Би урьд урьдынхаасаа ч илүү залбирсаар байсан ч, нэмэр болсонгүй. Үүнээс гадна залуусын чуулганы талаар тээж явсан анхны алсын хараа маань ч унтарч байлаа. (хуучин дарс гадагшаа юүлэгдэж байжээ) Залбирах тусам, алсын хараа маань замхарсаар. Гаднаа бахь байдгаараа байвч, дотор минь ямар нэг юм болоод байх шиг л.

Үүнээс гадна хамгийн гол нь би урьд өмнө хэзээ ч үзэж байгаагүй, гаднаас чигтэй том довтолгоонд өртөв. Яасан гэж үү?

Манай дарга намайг ажлаас халуулах гэж, над дээр хавтаст хэрэг нээсэн байв. Даргын маань хүү манай залуусын бүлэгт явдаг байсан бөгөөд нэг орой залуусын цуглааны дараа гэргийтэй маань уулзаад: “Лиза эгч ээ, аав, ээж хоёр гэртээ тийм, тийм юм хийж байхад, би яаж Жоны номлоод байгаа шиг амьдрах юм бэ?” гэж хэлжээ (Тэр хүмүүсийн үйлдлийг тоочих шаардлагагүй ч, ямар ч байсан маш муу зүйлс гэдгийг л хэлье)

Лиза цочирдсон боловч: “Аав, ээжийгээ Бурханд даатгаад, харин чи өөрөө Бурханы Үгд үнэнч бай” хэмээн мэргэн зөвлөжээ. Тэр өдрөөс хойш дарга маань миний нэр хүндийг сүйрүүлж, намайг зайлуулах төлөвлөгөө боловсруулан, хамаг хүчээ дайчилсан, уран нарийн довтолгоо эхлүүлжээ. Тэгээд овсгоо самбаа гарган тэргүүн пастор, бид хоёрын дунд яс хаяж амжив. Тийнхүү би 4 сар тэргүүн пастортайгаа уулзалдаж чадсангүй.

Тэр хүний схем амжилттай хэрэгжиж, хэдэн сарын дараа тэргүүн пастор намайг ажлаас халах шийдвэр гаргав. Залуусын бүлэгт томоохон өөрчлөлт гарах талаар пастор Бүтэн сайны өглөөний цуглаан дээр зарласан бөгөөд намайг Нэг дэхь өдөр халах гэж байгааг би пасторынхаа дүүгээс олж мэдэв.

Гэтэл Бурхан ер бусаар оролцон, тэргүүн пастор маань санаагаа өөрчилсөн юм. Бүтэн сайны өглөөний зарлал, Нэг дэхь өдрийн бидний уулзалт хоёрын дундуур Бурхан пастортай ярьсан болтой. Пастор надтай уулзах үедээ: “Жон, Бурхан чамайг бидэн рүү илгээсэн, Бурхан чамайг явах боллоо гэж хэлэх хүртэл чи эндээс явахгүй” гэж хэлж билээ.

Үүнээс зургаан сарын дараа даргын маань үйлдэл илэрч, түүнийг тэр даруй чуулганы ажлаас чөлөөлсөн юм. Тэрбээр бидний төсөөлснөөс ч ноцтой хэрэг үйлдсэн байлаа.

Цөлд би энэ мэт гадаад тулаанд ороод зогсохгүй мөн хэзээ ч үзэж байгаагүй дотоодын зөрчилд ороод байлаа. Би өөрийгөө буруу хэрэг хийчихлээ хэмээн санаж, үйлдсэн байж болзошгүй, санаанд орсон бүх нүглээ улайсан ч, дайралт ч зогссонгүй, цангаа ч арилсангүй.

Нэг өдөр бас л ямар гээчийн нүгэл үйлдсэн болоод энэ вэ хэмээн толгойгоо гашилгаж байтал, Эзэн надад: “Чи нүгэл үйлдсэндээ энэ цөлд байгаа юм биш. Би чамайг айсуу өөрчлөлтөд бэлтгэж байна” хэмээв. Энэ бол миний 5-аар бүлэгт өгүүлсэн шинэ дарс байлаа.

Энэ цөлөөр жил гаруй бэдэрсний эцэст Эзэн надад мацаг барь гэж айлдах шиг болов. Тэгээд хэдэн өдөр мацаг барьсны дараа амнаас минь өөрийн мэдэлгүй, уруулаар маань давсан хойноо

сонорт минь хүрсэн, нэгэн залбирал урсан гарсан юм. Зүрхнээс минь олгойдох хашхираа оюун санаанаас минь цойлон, би үнэн голоосоо: “Эзэн минь, би эзгүй цөлд байна уу, сая, сая хүнд номлоно уу хамаагүй - хаа ч байсан ганцхан Таны зүрхийг л хөөе!” хэмээн оргилон хашхирч билээ.

Тэгтэл гэнэт дотор минь хонх жингэнэж, би Бурханы үйлсийг харж эхлэв! “Бурхан минь, Та миний дотор үүнийг л хийж байжээ! Та намайг үйлчлэл тэргүүтэй юмсыг бус, гагцхүү Таныг л өөрийнхөө өв болгон, хамгаас хайрлан дурлах газарт аваачжээ. Тиймээс юу ч болж байсан - би юуг ч шүтэхгүй. Би үйлчлэлдээ дурлаж, Таныг умартахгүй. Зүрх минь цэх бөгөөд цэвэр байна.”

Тэгээд би Бурхан Давидын талаар юу хэлснийг санав:

Тэгээд Бурхан түүнийг зайлуулан, тэдэнд Давидыг хаан болгож өгсөн. Түүний тухай Тэрээр гэрчилж, “Бүх хүслийг минь биелүүлэх зүрх сэтгэлийн минь дагуух хүн, Иессийн хүү Давидыг Би олсон” (Үйлс 13:22) гэжээ.

Би нэгэн чухал үнэнийг давтан хэлье: Саул хаан хэзээ ч цөлд бэлтгэгдээгүй. Анх эш үзүүлэгч Самуел Саулыг хаанаар зарлах үед тэрбээр овоолгоотой тээшин дунд нуугдсан, бүрэг даруу залуу шиг л харагдаж байв. Гэтэл хэдэн удаагийн амжилтын дараа, тэр хүний бохир толион дээрээ хөвөн гарч иржээ. Саул том тулаанд ялсан ч, Бурханы зарлигийг дагалгүй, өөрийнхөө санааг гүйцэлдүүлжээ. Үүндээ ч бас ханалгүй, өөртөө зориулж хөшөө босгосон. Энэ нь Саулын сүүл сүүлээрээ илэрсэн, бөөн бөөн бурханлаг бус авирынх нь эхлэл нь л байсан юм. Тэрбээр хэзээ ч шийдвэрлээгүй бохиросоо болоод эцэстээ сүйрсэн билээ.

Таны доторхыг ил гаргадаг хоёр нөхцөл бий. Эхнийх нь бидний өмнө ярьсан, цэвэршүүлэгч гал. Нөгөөх нь амжилт. Гэхдээ амжилт таны бохирыг эргэн тойрны чинь хүмүүст ил болгосон ч, та өөрөө бохиросоо харахгүй, сохор хэвээрээ үлдэж болох. Бурханы олон зарц эхэн үедээ цэвэршүүлэгч галаар ордоггүй. Гэхдээ Саулаас ялгаатай нь тэд дуудагдаж, үйлчлэлийн байр сууриндаа очдог. Харамсалтай нь зохих ёсоор бэлтгэгдээгүй учраас, тэд амжилтанд хүрсэн ч, ил бохиртоо баригдсаар харамсалтайгаар төгсдөг.

Саул “үйлчлэлээ” хадгалж үлдэхийн тулд хүн алахаас ч буцаагүй. Харин Давид “үйлчлэлтэй” хөөцөлддөг бус, Бурханы зүрхийг хөөдөг хүн байсан. Давид цөлд байхдаа жинхэнэ “аз жаргалаа” олсон бөгөөд тэр нь мэдээж Бурхан байв. Давидад

Саулыг цааш нь харуулж хаячихаад, хаан ширээнд залрах хоёр ч удаагийн боломж олдсон. Албатууд нь ч алчих хэмээн ятгасан. Давид Саултай адил сэдэлтэй хүн байсан бол, Самуелээр ирсэн Бурханы амлалтыг бодоод, алж л орхих байсан.

Өнөөдөр Бурханы амлалтыг л авч байвал, гүтгэж, цуурч, худал ярихаас буцахгүй эрчүүд, эмэгтэйчүүд байх! Тэд өв гэдэг зүйлийн төлөө Саул шиг л авирлах. Гэтэл Бурхан байр суурь, нэр нөлөө, мөнгө юмуу алдартай хөөцөлддөг бус, харин Өөрийнх нь зүрхийг хөөдөг “Давидыг” хүсдэг. Хуучин тулмыг дахин боловсруулах үйл явц нь та, бид хоёрын дотор Бурханы зан чанарыг гүнзгийлдэг. Сүнсний шинэ дарсны даралтыг (Бурханы тосолгоо, оршихуйг) Бурханы зан чанар л даана. Бурханыг эрэн хайхад, зан чанар хөгжинө.

“Тэгээд энэ бүхэн чинь хэр удах юм?” гэж үү?

Энэ асуултанд би ингэж хариуль: “Хэдий хэр хугацаа авахад анхааралгүй, ус хальж гарч иртэл ухсаар бай.” Ер нь бол нэг удаа залбираад, хариулт ирэхгүй. Дахиад л залбирах ёстой бас дахиад л залбирах ёстой болно.

Би Далласт тэргүүн пастор, түүний гэргий хоёрт үйлчилдэг байхдаа, манай чуулганд туслах пастораар үйлчилдэг нэгэн дотны нөхөртэйгээ өглөө болгон хамт залбирдаг байлаа. Бид хоёр өглөөний 7.00 цагт өрөөндөө орж ирээд залбирахдаа, олон удаа Бурханы оршихуйг бас Түүний үйлсийг мэдэрдэг байлаа. Гэтэл ажил эхлэх цаг болж, бид 8.30-д өрөө, өрөө рүүгээ явахдаа, малтлагаа амжилттай хийж, цэнгэг усанд хүрч чадаагүйдээ сэтгэл гонсгор гарцгаадаг байв. Бас л худгаа нээж чадсангүй!

Маргааш өглөө нь дахиад л өчигдөр зогссон газраасаа эхлүүлнэ! Ийм янзаар заримдаа хоёр өдөр, заримдаа гурван өдөр явна - нэг удаа устай золгох гэж бүтэн долоо хоног залбирсныг санаж байна! Тийм боловч ингэсээр, ингэсээр усанд хүрэх үед ямар их сэргэлт, хүчийг олдог гэж санана.

Америкийн чуулгануудад амийн эх ундарга болсон худгаа булчихаад, тоосон шинжгүй амьдарч яваа итгэгч олон бий. Хамгийн аймаар нь цөөнх нь бус, олонх нь ийм байгаа байх. Гэтэл тэр хүмүүс тэнгэрлэг бэлэгээ бадраагаад, гадагш нь чөлөөлөөд өгбөл, юу болох бол? Амьдрал өөрчлөгдөж, гэр бүлүүд өөрчлөгдөж, чуулганууд өөрчлөгдөж - Америк өөрчлөгдөнө!

Олон хүний дотор Бурханы бэлэг боодолтой чигээрээ л хэвтэж байна. Худаг чинь битүү байгаа ч, Сүнс хүлээж байна. Ухаад бай! Цөлд ч цэнгэг устай золгоно!

11

ЭЗЭНИЙ ЗАМЫГ БЭЛТГЭ

*Бэрхшээл хэзээд урилгагүй, гэнэт ирдэг.
Бэрхшээл нь халдагч, хулгайч боловч, Бурханы
мутарт орохоороо Түүний ер бусын хүчийг
гайхуулах зэвсэг болдог.*

—Чарльс Стэнли

*Үнэнээр үнэнээр Би та нарт хэлье. Эцэгээс
хийж харуулсныг нь л Хүү хийхээс Хүү юуг ч
Өөрөөсөө хийдэггүй. Учир нь Эцэг юу хийнэ,
Хүү нь бас эдгээрийг түүнчлэн хийдэг.*

—Иохан 5:19



Говь, цөл нь уул намсаж, хотгор өргөгдөж- Эзэний зам бэлтгэгддэг газар. Исаиа үүнийг бидний сайн мэдэх хэсэгтээ сэтгэлд хоногштол дүрслэн өгүүлрүүн:

Хашхирагч нэгний дуу
 “Зэлүүд талд ЭЗЭНий замыг бэлтгэцгээ.
 Цөлд Бурханд маань Их замыг шулуун болгогтун.
 Хотгор бүр өргөгдөж,
 Уул толгод бүр намсаж,
 Тахир нь шулуун,
 Энхэл донхол газар нь тэгш тал бологтун.
 Ингээд ЭЗЭНий цог жавхлан илэрч,
 Махбодтой бүхэн хамтдаа үзэх болно.
 Учир нь ЭЗЭНий ам айлдлаа” гэв.
 Нэгэн дуу “Тунхаглагтун” гэсэнд
 Би “Би юуг тунхаглах вэ?” гэв.
 Махтай бодтой бүхэн нь өвс мэт,
 Гоо үзэсгэлэн нь хээрийн цэцэг мэт юм.
 ЭЗЭНий амьсгал дээрээс нь үлээвээс
 Өвс хатдаг, цэцэг ганддаг.
 Өргөн түмэн гэгч өвс л юм.
 Өвс хатдаг, цэцэг ганддаг.
 Харин бидний Бурханы үг мөнхөд байна.
 (Исаиа 40:3-8)

Энэ үгийг чухам цөлд яваа хүмүүст хэлсэн юм биш үү?

Христийн бие доторх хүн бүр Эзэнээс даалгавар хүлээн авдаг. Тийм боловч Эзэн биднийг томилон илгээх хүртэл бид бүгдээрээ махан биеийг маань цовдолдог газар болох цөлд бэлтгэгдэн, шалгуулдаг. Бас цөлд л Эзэний дуу хоолойг сонсож, үйлсийг нь ойлгох хүртлээ нам гүм байхад суралцдаг. Тэгж байж л Бурханы хүслийг дуулгавартай биелүүлж сурна.

Цөлийн аялал нь гараанаас бариа хүрсэн дардан зам бус, харин учир нь олодохгүй тойруу замууд, төлөвлөгөөнд байгаагүй зогсоолуудаас бүрддэг. Үүнийг бас л амьдралаараа жишээлэн тайлбарлая.

Би Пердюгийн Их сургуулийн оюутан байхдаа буюу 1979 онд дахин төрсөн билээ. Дөрвөн сарын дараа Ариун Сүнсээр дүүрч, Бурхан надад үйлчлэлийн талаар цухалзуулж эхлэв. Үйлчлэл нь миний амьдралын радарт огт байхгүй, миний огт сонирхдоггүй зүйл байлаа. Миний багаасаа мэдэх үйлчлэгч нар бүгд шал сонин хүмүүс байсан учраас, би тэдэн шиг болохыг хүссэнгүй. Хүнийг шүүж болохгүй л дээ. Гэхдээ тэд нэг л тийм хачин хүүхдүүдтэй, навсгар байшинтай, “нэг л бишээ” гэмээр хүмүүс байсан гэх үү дээ. Мэдээж миний энэ сэтгэлгээ буруу байсныг би хожим ойлгосон л доо. Үнэндээ мундаг, мундаг хүүхдүүдтэй, сайхан, сайхан байшинтай, гялалзаж яваа үйлчлэгч нар олон байв. Гэтэл нялх итгэгч би, Бурханд үйлчлэхийг үлэмж их зовж амьдрах юмуу эсвэл алс холын Африкт урцанд амьдарч, уранхай шаахайтай явахыг л хэлнэ гэж боддог байлаа.

Би чинь 3,000 хүнтэй, жижигхэн хотод өссөн хүн. Миний мэддэг үйлчлэгч нар гэвэл Католикийн лам нар (Тэд чинь гэрлэдэггүй учраас, надад ёстой тохирохгүй) тэгээд нэг жижиг чуулганы пастор л байлаа. Тэднийх миний үеийн хоёр сонин хүүхэдтэй бас гэр нь аймаар муухай үнэртэй! Нэг удаа гэрт нь ортол тэсэхийн аргагүй өмхий байсан учраас, би амьсгаагаа түгжиж байгаад, худлаа шалтаг хэлээд гарчихаж билээ. Тэгэхээр намайг яагаад үйлчлэлд дургүй байсныг минь ойлгосон байх аа. Би Католикийн лам болохыг бас сонин хүүхдүүдтэй, өмхий гэртэй пастор байхыг хүсээгүй юм. Би бас Африкт илгээлтийн эзэн болж очоод, урцанд хөл нүцгэн гүйхийг хүсээгүй юм.

Тухайн үед би Пердю их сургуулийн механикийн инженерийн ангиа төгсөөд, Харвардын Магистр болох төлөвлөгөөтэй байв. Үүнийхээ дараа Америкийн корпорацд орж ажиллаад, албан тушаалын шатаар ахисаар яваад, маш их мөнгөтэй болоод чуулгандаа их мөнгө өргөж, үйлчлэлийг дэмжинэ. Би ийм л төлөвлөгөөтэй байсан учраас, үйлчлэлийн талаарх Бурханы санаанаас дөлж байлаа. (Миний энэ төлөвлөгөөнд буруу юм огт байхгүй. Зүгээр л Бурхан надад ийм зам төлөвлөөгүй байв)

Дөрвөн сарын дараа Бүтэн сайны өглөө чуулган дээрээ пасторынхаа номлолыг сонсож байтал, Бурханы Сүнс надад: “Би чамайг номлолд дуудсан! Чи энэ талаар яая гэж бодож байна?” хэмээн хатуу хэлэв.

Энэ удаа би Бурханыг маш тодорхой сонссон болохоороо: “Эзэн минь, би Африкийн шугуйд өвсөн урцанд хөл нүцгэн амьдарсан ч хамаагүй - Таныг л дагая!” гэж хариулсан юм. (Бурхан бидний анхаарлыг татах аргатай. Урьд урьдын саруудад Бурханыг санаагаа цухуйлгах үед би бас зүгээр суулгүй, Бурханд үйлчлэх амьдралын өртгийг тодорхой хэмжээнд тооцож амжсан байлаа) Би юунд “За!” гэж хэлж байгаагаа ухамсарлаж байсан болохоор, надад ямар ч өртгөөр хамаагүй Бурханд л таалагдаж байвал боллоо гэдэг бодол суугаад байв!

Ингээд Эзэн намайг бэлтгэж эхлэв. Миний дотор гал дүрэлзэж, би хуурай ахан дүүсдээ Есүсийн талаар ярьж эхлэсэн бөгөөд олон ч хүн аврагдав. Жил хагасын дараа би сургуулийнхаа байранд Библи судлалын хичээл эхлүүлсэн бөгөөд хичээлд маань оюутны хотхоны өнцөг булан бүрээс оюутнууд ирж оролцоно. Долоо хоног бүр олон хүн амьдралаа Христэд өргөж, эдгэрч, эрх чөлөөнд хүрч байв.

Миний амьдралын эрэмбэ орвонгоороо эргэв! Эдүгээ би Библийн сургуульд суран, номлохын хүслэн болж, Пердюгийн механикийн инженерийн сургуулиа хаяхын түүс болов. Шалтаг нь? “Наана чинь хүмүүс үхэж, там руу явж байхад бас би номлохоор дуудагдчихаад байхад, калкулус, физик хэнд хэрэгтэй юм? Цаана чинь Есүс юу, юугүй ирэх гэж байна. Тиймээс би нэн даруй ургацын талбай руу явах хэрэгтэй!”

Нэгэн орой гэрийн даалгавраа дурамжхан шиг хийж сууснаа, инженерийн номуудаа гүйлгэн хараад, дараа нь тавиур дээр байгаа Библиэ харлаа. Гүйцээ! Би дулааны динамикийн сурах бичгээ хана руу шидэв. Тэгээд цаашид хүлээхгүй гэж шийдлээ. “Сургуулиасаа гараад, Библийн сургуульд сурах минь!”

Дараа нь намайг дагалдуулдаг байсан хүн рүүгээ залгаад: “Дон, би сургуулиа хаяад, Библийн сургуульд сурлаа!” хэмээн хатуу хэлэв.

Гэтэл Пердюгийн судлаач, тэр дотны нөхөр маань: “Өнөөдөр орой хоёулаа жаал алхаад, энэ талаар чинь залбирбал яасан юм?” хэмээн маш мэргэн хариулав. Тэгээд бид хоёр алхаад бас залбирав. Тэгсэн Бурхан надад: “Чи Миний тогтоосон цагт үйлчлэх болно. Инженерийн сургуулиа дүүргэ” гэсэн юм.

Хожим намайг “Эзэн яаж над шиг жижиг хотын хүүг дэлхий даяар илгээх гэж байгаа юм бол?” хэмээн толгойгоо гашилгаж байтал, Бурхан надад: “Чиний дуудагдсан тэр үйлчлэлийг хэн бүтээж, томилсон бэ? Чи юу, Би юу?” гэв.

-“Та!”

-“Тэгвэл үйлчлэл чинь хэрхэн биелэх талаар чи биш, Би бодох ёстой бус уу?” Энэ үг миний орой руу оров.

Тиймээс би уужраад, инженерийнхээ зэргийг хамгаалав. Төгсмөгцөө Роквел Интернэйшнэлд Америкийн Усан цэргийн төсөл дээр механикийн инженерээр ажилд орлоо. Би шинэ ажилдаа суурьшаад, сайн цуглаан олж, жилийн дараа Лиза, бид хоёр гэрлэв.

Би гэрлээгүй байхдаа цуглаанд явж эхлэсэн болохоор, хаана л хэрэгцээ гарна - тэнд үйлчилж байлаа. Гэрлэснийхээ дараа ч ялгаагүй энэ эрчээрээ л үйлчлэв. Угтагчаар үйлчилж, шоронгийн үйлчлэлд оролцож, пасторынхаа хүүхдүүдэд теннис зааж, өөр олон талбарт туслаж байлаа. Бас Чуулганыхаа оройн Библийн сургуульд суралцав.

Хоёр жилийн дараа тэргүүн пастортаа болоод түүний гэр бүлд үйлчлэх ажилд оров. Гэхдээ би номлох дуудлагатай учраас, нэг л жил хийе гэсэн юм. Би тэдний машинд шатахуун хийх, хүүхдүүдийг нь зөөх, сургуульд ороогүй хоёр хүүхдэд нь усанд сэлэхийг заах, айлчилж байгаа үйлчлэгч нарыг халамжлах зэрэг олон ажил хийв. Эцэстээ тэр ажлаа нэг жил бус, дөрвөн жил хагас хийж билээ.

Бурханы дуудлагад “За!” гэж хэлснээс хойш ийнхүү долоон жил өнгөрчээ. Их сургуульд оюутнууд бөөн бөөнөөрөө аврагдаж, эдгэрч, чөлөөлөгдөхийг харахдаа, хэдхэн хоногийн дараа л бүтэн цагийн үйлчлэлдээ орох юм чинээ санаж байлаа. Бурхан намайг ямар үйл явцсаар дамжуулахыг яагаад ч тааж мэдээгүй юм.

Чуулганд үйлчилсэн энэ хугацаандаа би гурван удаа бүтэн цагийн үйлчлэлд орох гэж үзээд, бүтэлгүйтэв. Азиас Даллас руу буцаж нисэх замдаа (Гурав дахь бүтэлгүйтлийнхээ эцэст Бурхан намайг үнэхээр тэнд байлгахыг хүсч байгаа эсэхийг харахын тулд) Иоханы Сайн мэдээг уншиж байтал “Бурханаас илгээгдсэн Иохан гэгч хүн байжээ” (Иохан 1:6) гэдэг үг хуудсаасаа ховхроод гараад ирэв. Тэгээд Бурхан надад: “Жон чи, Жон Бивэрээр илгээгдмээр байна уу, Надаар илгээгдмээр байна уу?” гэж хэллээ.

-“Танаар илгээгдмээр байна.”

Тэгтэл Эзэн надад: “Сайн байна. Учир нь хэрэв чи Жон Бивэрээр илгээгдбэл, Жоны л эрх мэдэл дотор явна. Харин Надаар илгээгдбэл, Миний эрх мэдэл дотор явна!” гэсэн юм.

Үүний дараа би тайвшраад, Бурханы суулгасан газар дээр төвлөрөх болов. Тийм боловч хэсэг хугацааны дараа тавгүйтэл маань эргээд сэдэрлээ. Цөлийн сургалт ганц улиралд багтаад дуусчихдаг зүйл бус, харин үргэлжилсэн үйл явц ажээ.

Тэр долоон жилийн хугацаанд Бурхан намайг чөлөөтэй байр суурь гартал шүүгээнд хийгээд хойш нь тавьчихсан уу? Үгүй! Хэзээ ч үгүй! Би бурханлаг зан чанараа хөгжүүлж... *Түүний* замыг *бэлтгэхийн* тулд тэр цөлд хүргэгджээ. Дуудлагынхаа байр суурин дээр сайн ажиллаж чадахын тулд надад зан чанарын төлөвшил хэрэгтэй байжээ. Сүнсний дэвшил болгоны өмнө тэр төвшинд тэнцэх бэлтгэл ордог ажээ.

Хүнийхээ хүчээр үйлчлэхгүй

Сэдэл маань хичнээн сайхан байсан ч, бид Бурханы оролцоогүйгээр мөнхийн үнэ цэнэтэй юм бүтээхгүй - бүр Есүсийн нэрээр үйлдсэн байлаа ч! Эзэн Өөрөө ч “Үнэнээр үнэнээр Би та нарт хэлье. Эцэгээс хийж харуулсныг нь л Хүү хийхээс Хүү юуг ч Өөрөөсөө хийдэггүй. Учир нь Эцэг юу хийнэ, Хүү нь бас эдгээрийг түүнчлэн хийдэг” (Иохан 5:19) гэсэн. Айхтар мэдэгдэл байна! Бурханы тослогдсон Хүү Есүс ч “Өөрөө ганцаараа туйлын үнэ цэнэтэй юу ч хийж чадахгүй” гэдгээ хэлжээ. Юун тухай хэлснийг нь хэд хэдэн жишээгээр тайлбарлая:

Есүс Бетаны Лазарыг болоод түүний Марта, Мариа гэдэг хоёр охин дүүг хайрладаг байжээ. Тэгтэл Лазар хүнд өвчөөд тусаад, дараа нь ийм явдал болов:

Тиймээс эгч дүүс Есүст хүн илгээж, —Эзэн минь, хараач, хайрладаг хүн тань өвдөв гэж хэлүүлэв. Үүнийг сонсоод Есүс —Энэ өвчин үхэлд бус харин үүгээр Бурханы Хүү алдаршуулагдахын тулд, Бурханы алдрын төлөө юм гэлээ. Марта, түүний охин дүү болон Лазарыг Есүс хайрладаг байлаа. Лазарын өвдсөнийг сонсоод, Есүс байсан газраа дахин хоёр хонов. (Иохан 11:3-6)

Есүс хэдийгээр Мессаиа байсан ч, дотны сайн нөхөдтэй байжээ. Есүс Лазарт хайртай бөгөөд түүний гэр бүлтэй нөхөрлөх дуртай байж. Гэтэл найз нь хүндээр өвдсөнийг дуулсан атлаа Есүс хоёр хоног юу ч хийгээгүй. Есүс яагаад үтэр түргэн Бетан руу яваагүй юм бол? Учир нь Есүс Бурханаас тушаал хүлээж аваагүй байв. Есүс Бурханы Сүнснээс тушаал хүлээж автлаа дуулгавартайгаар хүлээжээ. Тэгээд дараа нь явсан.

Би л Есүсийн оронд байсан бол Сүнснээс чиглүүлэг асуулгүй, шууд л Лазар дээр харайж очоод, гар тавих байсныг минь нэг удаа Эзэн надад ойлгуулж билээ. Харамсалтай нь олон хүн яг ийм сэтгэхүйтэй байдаг. Бид Бурхан угаасаа бидэнтэй хамт байдаг учраас, иймэрхүү юман дээр Бурханаас удирдамж аваад байх шаардлагагүй гэж үздэг. Гэтэл уг нь бид түр зогсоод, Бурханы Сүнсийг сонсох ёстой юм. *Бурхан* юу хүсч байгаагаа мэднэ. Бид Бурханаас тухайн нөхцөл байдлын талаар ямар санаатай байгааг нь асууж, заавар хүлээбэл, Тэр бидэнд яахыг маань хэлж өгнө.

Бид Сүнснээс чиглүүлэг ирээгүй байлаа ч, өвчтэй хүн дээр гараа тавих юм бол, Бурхан тэр хүнийг шууд эдгээх үүрэгтэй гэж бодож байж болох. Тийм юм бол, бид бүх эмнэлэг дээр очоод хоослочих байсан бус уу?

Библи, заримдаа Есүс “бүгдийг нь эдгээсэн” гэдэг ч, дандаа тийм байгаагүйг хэлэх хэрэгтэй. Жишээлбэл, Есүс яагаад Бетседа цөөрмийн дэргэдэх бүх өвчтэй, сохор, доголон, саажилттай хүнийг эдгээлгүй, гучин найман жил саажсан ганц л хүнийг эдгээсэн юм бэ? (Иохан 5) Бурханы Сүнс Есүсийг тэгж л удирдсан бус уу?

Түүнчлэн эхээс төрөхдөө л доголон төрөөд, өдөр бүр сүмийн хаалган дээр суудаг нэгэн хүн байжээ. Мэдээж Есүс сүмд орж, гарах бүрийдээ түүний дэргэдүүр өнгөрдөг л байсан байх. Тэгвэл Есүс яагаад түүнийг эдгээгээгүй вэ? *Учир нь Аав нь Есүст тийм заавар өгөөгүй байв.*

Хожим Есүсийг тэнгэр өөд өргөгдсөн хойно Петр, Иохан хоёр сүм рүү явж байгаад Сүнсний удирдамжаар нөгөө хүнийг эдгээсэн бөгөөд энэ явдал сэргэлт авчирсан юм (Үйлс 3).

Есүс тогтсон томъёогоор үйлчлээгүй. Заримыг нь нулимж эдгээсэн, заримыг нь гар тавьж эдгээсэн, заримд нь зүгээр л тушаасан, заримынх нь зовхин дээр зуурсан шавар наасан, заримыг нь тахилч руу илгээсэн. Есүс Аавынхаа хий гэснийг л хийсэн учраас, гайхмаар олон янзаар үйлдсэн! Хүн тус бүрийг эдгээх төгс цаг, аргыг Бурхан л мэднэ.

Бурхан зарц нараа өөрсдийнхөө бодол, хүслийг л үйлддэг бус, харин Есүст захирагдаж, Есүсийн үйлдэж байгаа зүйлийг харж, үйлддэг хэмжээнд хүрээсэй гэж хүсдэг. Иохан 20:21 дээр Есүс “Эцэг Намайг илгээсний адил Би бас та нарыг илгээнэ” гэсэн. Есүс Аавынхаа удирдамжаас гадуур юу ч хийгээгүй. Бид ч Есүсийн үлгэр жишээг дагах ёстой. Бид Түүн шиг амьдарч, Ариун Сүнсээр удирдуулж, алхах ёстой. Учир нь гагцхүү Тэр л биднийг удирдаж чадна. Үүний тулд махан бие маань Бурханы Сүнсэнд - Христийн

Сүнсэнд захирагдах ёстой. Харин Сүнсээр удирдуулдаг амьдралд сургах шилдэг газар нь цөл юм.

Бурхан Мосег дөчин жил цөлд бэлтгэснийхээ дараа:

Тиймээс одоо явагтун, Би чамайг Фараон уруу илгээж, чамаар Өөрийн ард түмэн болох Израилийн хөвгүүдийг Египетээс авчруулья гэв. Гэвч Мосе, Бурханд —Фараон уруу очиж, Израилийн хөвгүүдийг Египетээс гаргах гэдэг би хэн юм бэ? гэж хэлэв. Тэгэхэд Тэр —Би чамтай заавал хамт байна. Чи ард түмнийг Египетээс гарган авчирч, та нар энэ ууланд Бурханд мөргөх болно. Энэ нь чамд Би чамайг илгээсний тэмдэг болно гэж айлдав. (Гэтлэл 3:10-12)

Энэ үгийг одоо өөрөө өөрийгөө илгээдэг хүмүүст айлдсан Бурханы үгтэй харьцуулья:

Би эш үзүүлэгчдийг илгээгээгүй, Гэвч тэд гүйдэг. Би тэдэнд яриагүй боловч Тэд эш үзүүлэв. ... Үзэгтүн, Би хуурамч зүүдийг эш үзүүлэн хэлж, худал хуурмагаараа болон болчимгүй сайрхлаараа хүмүүсийг минь төөрүүлсэн тэдний эсрэг байна” гэж ЭЗЭН тунхаглаж байна. “Би тэднийг илгээгээгүй, тэдэнд тушаал ч өгөөгүй бөгөөд тэд энэ хүмүүст огтхон ч ашиг тус өгдөггүй” гэж ЭЗЭН тунхаглаж байна. (Иеремиа 23:21, 32)

Час хийж байна шүү. Хэн ч Эзэнээс ийм үг сонсохыг хүсэхгүй.

Мосе дөчин насандаа хүнийхээ хүчээр Израилийн хүүхдүүдийг *чөлөөлөх* гэж оролдоод бүтэлгүйтсэн. Учир нь *Бурхан түүнийг илгээгээгүй* байжээ. Тэр үед Мосед Египетийн өндөр эрдэм мэдлэг, удирдах ур чадвар, цэц ухаан байсан ч, Бурханы цаг хугацаа, дэмжлэг байгаагүй. Мосе Бурханы дуудлагыг *мэдэж байсан ч*, биелүүлж чадаагүй. Түүний хоосон оролдлого нь Египет хүний аминд л хүрсэн. Хэдийгээр Мосегийн санаа сэдэл нь зөв байсан ч, даалгавраа биелүүлэх анхны оролдлого нь сайныг гэхээсээ илүү мууг авчиржээ. Дөчин жилийн цөлийн далд бэлтгэлийн дараа Бурханы үгнээс гардаггүй, цоо шинэ Мосе гарч ирэв. Эдүгээ Бурханы тогтоосон цагт Мосегийн удирдлага дор дайсны цэргүүд тэр чигээрээ Улаан тэнгисийн ёроолд живсэн байдаг. Энэ бол хүний хүч хийгээд Бурханы хүчийн ялгаа юм: Ганц цэрэг бүхэл бүтэн армийн эсрэг.

Иохан Баптист зургаан сарын үйлчлэлийн төлөө цөлд гучин жил бэлтгэгдсэн ч, Есүс түүнийг эмэгтэйгээс төрсөн хамгийн аугаа эш үзүүлэгч гэсэн.

Ойлгож байна уу? *Бурханы илгээсэн* эрчүүд, эмэгтэйчүүдийн зургаахан сарын хөдөлмөр нь жаран жил *өөрийнхөө хүчээр* зүтгэсэн хүнээс ч ихийг гүйцэлдүүлнэ.

Есүс үүнийг л тайлбарлажээ: “Үнэнээр үнэнээр Би та нарт хэлье. Эцэгээс хийж харуулсныг нь л Хүү хийхээс Хүү юуг ч Өөрөөсөө хийдэггүй. Учир нь Эцэг юу хийнэ, Хүү нь бас эдгээрийг түүнчлэн хийдэг” (Иохан 5:19).

Исаиагийн үгсийг дахин харна уу:

Хашхирагч нэгний дуу

“Зэлүүд талд ЭЗЭНий замыг бэлтгэцгээ.

Цөлд Бурханд маань Их замыг шулуун болгогтун.

Хотгор бүр өргөгдөж,

Уул толгод бүр намсаж,

Тахир нь шулуун,

Энхэл донхол газар нь тэгш тал бологтун.

Ингээд ЭЗЭНий цог жавхлан илэрч,

Махбодтой бүхэн хамтдаа үзэх болно.

Учир нь ЭЗЭНий ам айлдлаа” гэв.

Нэгэн дуу “Тунхаглагтун” гэсэнд

Би “Би юуг тунхаглах вэ?” гэв.

Махтай бодтой бүхэн нь өвс мэт,

Гоо үзэсгэлэн нь хээрийн цэцэг мэт юм.

ЭЗЭНий амьсгал дээрээс нь үлээвээс

Өвс хатдаг, цэцэг ганддаг.

Өргөн түмэн гэгч өвс л юм.

Өвс хатдаг, цэцэг ганддаг.

Харин бидний Бурханы үг мөнхөд байна.

(Исаиа 40:3-8)

Цөл нь Эзэний замыг бэлтгэдэг газар болохыг Эзэн хэлжээ. Эзэний зам нь хүний хүч биш юм. Эзэн хэлэхдээ, махан биеийн бардамдал буурч, даруу (Эзэнийг хүлээж чаддаг) нь өргөмжлөгдөж, хазгай (шударга бус, бүрхэг, мэхлэгдсэн) газрууд нь тэгширч, бартаат (хайр байхгүй, хатуу, харгис) газрууд нь толигор болно гэжээ.

Би оюутан байхдаа Есүст итгэхдээ, олон талаараа ерөөгдөж, бусдад “амжилттай” үйлчилсэн ч, амьдралд маань намсах ёстой уулс, шулуун, толигор болох ёстой хазгай, хатуу газрууд олон байлаа. Зарим өө сэвээ арилгахын тулд надад цөлийн бэлтгэл хэрэгтэйг Бурхан мэдэж байжээ.

Бурханд Өөрийнхөө аргаар ажиллах боломжийг нь олгох нь цөлийн улиралд чухал байдаг. Намайг Далласт пастортаа үйлчилж байхад, нэг удаа Эзэн надад: “Жон, чи маргаашийнхаа үйлчлэлийн алсын хараанд автаад, өнөөдөр чиний дотор хийж буй үйлсийг минь алдуузай” гэж билээ. Үнэндээ ч номлохын хүслэн болсон надад тухайн үе цагийн гарз юм шиг л санагддаг байсан юм.

Та ийм урхинд орох бий! Бурхан *цагийг гарздахгүй!*

Аян замд аминд орох арга

#Ачаа тээшээ бэлэн байлга

Би үүнийг хэзээ ч зөвлөхгүй. Гэхдээ цөлийн улирал хэзээ ч дуусахгүй, мөнхөд үргэлжлэх юм шиг сунах үед танд ачаа тээшээ задлаад, суурин амьдрах санаа төрнө. Гэхдээ надад итгээрэй - Бурхан хөдлөхөөр шийдэх үедээ бүхнийг нүд ирмэхийн зуур эргүүлдэг юм шүү. Тухайлбал Иосеф гянданд насаараа хоригдох юм шиг л харагдаж байсан ч, Бурханаас ирсэн нөгөө зүүд нь нүд ирмэхийн зуур л биелчихсэн! Тийм ээ, зөв - ганцхан өдрийн дотор!

Би ч бас цөлд байхдаа дечин жил болчих шиг л санагдаж билээ. Тэгтэл гэнэт л Эзэн надад одоогийн ажлаа орхиод, аялан номлож эхлэ гэсэн юм. Өөрчлөлт тэр даруй ирээгүй ч, ирэх үедээ яг л хүй салхи шиг ирсэн. Тэгээд би ч хэдийнээ ачаа тээшээ бэлдчихсэн, дуудлагынхаа дараагийн улиралд өнхөрөөд ороход бэлэн сууж байв.

Бурхан л цаг хугацааг *авардаг!* Одоогийн байгаа газар чинь очих зүг чигт чинь чухал үүрэг гүйцэтгэдгийг ойлгоорой. Энэ бол таны бэлтгэлийн талбай. Энэ бол амлалтаас биелэл хүрэх үйл явц. Энэ бүхэн ямар маягаар яаж угсрагдаж биелэхийг Бурханд даатгаад,

өөрөө зүгээр л Түүнийг дагаад хөв! Тэр бол Бурхан, Зохиогч бөгөөд Төгсгөгч. Бид зүгээр л Түүнд итгээд, *өнөөдөр* харуулсан зүйлийг нь дагахад болно!

Бурхан намайг яг яаж номлолын үйлчлэлд гаргахыг ойлгочихлоо гэж бодох бүрийд маань Бурхан зөөлнөөр: “Жон, чи бас нэг бүтэхгүй арга боловсруулчихлаа!” гэж хэлдэг байж билээ. Энэ үнэн байв. Бурхан намайг энэ үйлчлэлд санаанд оромгүй арга замаар хөтлөсөн юм. Бурхан биднийг өнөөдөр бүрэн дүүрэн амьдруулахын тулд хохсон сэтгэлийг бус, харин хангалуун сэтгэлийг зааж өгдөг.

Бурханы арга замаар үйлд

Хүн Бурханаас том эрх мэдэл, том хүчийг хүлээн авах тусмаа, Эзэний Сүнснийг дагахгүй бол, хожим тэр хэрээрээ хагуу шүүгдэнэ. Бурхан Мосег дөчтэй байхад нь дураараа авирлалаа хэмээн хатуурхаагүй. Гэтэл хожим ийм нэгэн явдал болжээ. Биднийг ийм газарт авчирлаа хэмээн хүмүүс Зин цөлд Мосегийн өөдөөс эсэргүүцэн боссон. Тэд цангаж, ундаасчээ. Тиймээс Бурхан Мосед юу хийхийг нь зааж өгөв:

Таягаа ав. Чи өөрийн ах Ааронтай хамт даяар хотол түмнийг цуглуулаад, ус гаргуулахаар тэдний нүдний өмнө хадтай яригтун. Ингэж чи тэдэнд хаднаас ус гаргаж, даяар хотол түмэн ба тэдний мал амьтныг услагтун. (Тооллого 20:7-8)

Бурхан Мосед хаданд тушаабал ус гарна гэсээр байтал, Мосе юу хийснийг үзнэ үү:

Мосе гараа өргөөд, таягаараа хадыг хоёр удаа цохив. Ус арвин ихээр оргилон гарч, хотол түмэн бас тэдний мал амьтад ууцгаав. Харин ЭЗЭН, Мосе Аарон нарт айлдахдаа —Израилийн хөвгүүдийн нүдний өмнө Намайг ариун хэмээн харагдуулахаар та нар Надад итгээгүй учраас Миний тэдэнд өгсөн нутагт энэ чуулганыг та нар аваачихгүй гэв. (Тооллого 20:11-12)

Бурхан сая сая үзэгчийг усаар хангажээ. Гайхамшигтай! Хаднаас ус гарсан гайхамшиг хорин нэгдүгээр зуунд л лав сонсогдоогүй. Хэдийгээр Мосе усыг хаднаас гаргах тал дээрээ Бурханы зааврыг зөрчсөн ч, гайхамшиг болдгоороо болж, ус гардгаараа гарчээ. Бурхан хүмүүсийн хэрэгцээнд хариулсан. Бурхан Мосед уурласандаа, хүмүүсээс усаа харамлаж болох байсан ч, тэгээгүй. Гэхдээ энэ явдал дараах үр дагаварт хүргэжээ: Бурхан Мосед Амлагдсан газар руу хүмүүсийг удирдахыг хоригложээ.

Эндээс бид Бурхан ер бусын тосолгоогоо хүнийг алдаршуулахын төлөө бус, хүмүүсийн хэрэгцээнд хүрэхийн төлөө өгдгийг харж болно! Магадгүй Мосе хүмүүст тэгээд бас ийм хүмүүсийг удирдуулахаар тавилаа гэж Бурханд бухимдсан байх. Тэгээд өмнө Синий цөлд үйлдсэн шигээ хад руу дэлсжээ (Гэтлэл 17:1-7). Эсвэл магадгүй Мосе удирдах чадвартаа хэт дасчихаад, түүнийг юу ч хийж байсан Бурхан зүгээр өнгөрөөнө гэж бодсон байх. Тэр энэ удаа ч бас дураараа үйлдсэн боловч, үр дагавар нь хавьгүй хүнд тусав. Мосе Бурханы хүч, чадал дотор явж байсан. Түүний бүх хүч нь Бурханд найдах найдвараас нь л төрж байв. Гэтэл энэ удаа Мосе хүмүүсийн нүдэн дээр Бурханаас хамааралгүй үйлдэл гаргасан нь хатуу шийтгэл авчиржээ.

Тиймээс л Иаков 3:1 дээр “Ах дүүс минь, багш нар бид үлэмж хүнд шүүлтэд орно гэдгийг мэдэн, та нараас олноороо багш бүү бол” гэсэн юм. Хүлээсэн алдар нь том байх тусам, ирэх шүүх нь том л байна.

Цөл биднийг шүүхэд очилгүйгээр, Эзэний хүч, алдрыг дааж амьдрахад сургадаг. Цөлд бардам нь буурч, даруу нь өргөмжлөгддөг. Жинхэнэ даруу хүн Есүс шиг: “Эзэний Сүнс хийхийг нь харахаас нааш би юу ч хийхгүй. Миний хүч, чадвар юу ч биш” гэсээр явдаг.

Магадгүй Бурхан чуулганы олон хүнийг хожмын том шүүхээс хамгаалсандаа, өнөөдөр алдар, хүчээ харуулахгүй байгаа байж болох. Цөлд л Бурхан сүнснээс махан биеийг шувтлаж хаяад, биднийг Түүн рүү хашхирч, Түүнд чих тавихад хүргэдэг. Харин Бурханы алдар илэрхийлэгдэх үед бид гагцхүү Түүний арга замаар үйлдсэнээрээ л Түүний нэрэнд алдрыг өргөнө!

Сүнсний дуу хоолойг сонсоно уу. Танд хандсан ажлыг хэрхэн хийхийг Бурхан л Өөрөө харуулаг. Эзэний үйлдэж, айлдаж байгаад л анхаар.

Би манааныхаа байранд зогсож, Бэхлэлт дээр байрлан суух болно. Тэрээр надад юу айлдахыг Миний гомдлолд

Тэр хэрхэн хариулахыг Би харуулдан харсаар л байх болно. Тэгтэл ЭЗЭН надад хариу айлдруун “Үзэгдлийг бичээд, хавтангууд дээр сийл. Уншсан нэг нь ухасхийг. Үзэгдэл нь тогтоогдсон цагийн төлөө юм. Төгсгөл уруугаа энэ нь яарах агаад эс хөсөрдөнө. Хоцорч байгаа боловч үүнийг хүлээгтүн. Хойшлолгүй заавал биелэгдэх болно. Харагтун, бардам нэгний сэтгэл нь зөв бус байдаг юм. Харин зөвт хүн итгэлээрээ амьдарна. (Хабаккук 2:1-4)

Эш үзүүлэгч “Бурхан юу айлдахыг нь би харуулдан хүлээнэ” гэжээ. Бурханы Сүнсний ярьдаг нэгэн арга зам нь үзэгдэл юм. Есүс Аавынхаа үйлдлийг *хараад* үйлддэг гэсэн. Хабаккук харснаа бичиж, тогтоосон цагт харсан зүйлээрээ гүйнэ гэсэн. Дараа нь “бардам (ихэрхүү) сэтгэл нь зөв бус” гэжээ. (Энэ бол Эзэний Үгийг хүлээдэггүй, Бурханы алсын хараагаар гүйдэггүй хүн) Харин зөвт нь хүний итгэлээр бус, өөрийнхөө итгэлээр амьдарна!

Бурханы хэлснийг сонсож, дуулгавартай дагахад итгэл ирдэг. Тиймээс л Бурхан Израилийн хүүхдүүдэд “Хүн зөвхөн талхаар бус, харин ЭЗЭНий амнаас гарах (гардаг) үг бүрээр амьдардгийг ойлгуулахын тулд” (Дэд хууль 8:3) тэднийг цөлд авчиржээ. Эзэн “гарсан” бус, “гардаг” гэж хэлсэн байгааг тэмдэглэнэ үү.

Биднийг “Айлдагчийг үл хэрэгсэхээс та нар сэрэмжил. Учир нь газар дээр тэдэнд сануулсан нэгнийг тэд үл хэрэгсэх үедээ зугтаагүй бол тэгэх тусмаа тэнгэрээс сануулагч Түүнээс бид нүүр буруулан зугтаж чадна гэж үү?” (Еврей 12:25) хэмээн урамшуулжээ. Тийм боловч Түүний айлдсан нь хэзээд Бичээстэй эгнэдгийг хэзээ ч бүү мартаарай.

Гэхдээ өөрийнхөө бодлыг бататгах гэж Бичээсийг малтах нь Бурханы арга зам биш. Есүс Өөртөө: “Надад угаасаа л өвчтэйг эдгээх тосолгоо байгаа учраас, Лазар дээр очоод гар тавьчихъя” гэж хэлж болох л байсан. Гэтэл Есүс эхлээд Сүнсийг хүлээгээд, дараа нь хөдлөжээ.

Бурхан бидэнд Түүний удирдлага, чадварыг хэрэглэлгүйгээр Түүний төлөө хийх гэж оролдсон бүхэн маань хоосон дасгал болно гэдгийг зааж өгөхийн тулд биднийг цөлд аваачдаг юм. Бид махан биеэс мөнх настай юм төрөхгүй гэдгийг яс махандаа шингэтэл ойлгосон цагтаа л Бурханы даалгасан алсын хараа, төлөвлөгөөг гүйцэлдүүлэхэд бэлэн болдог. Цөл нь тэр чигээрээ

бэлтгэл - амлалтыг биелүүлэх үйл явц юм. Есүсийн үлгэр жишээг даган, аливаа бүхнийг *өөрийнхөө* аргаар бус, *Бурханы* аргаар хийж, Сүнсээр удирдуулья.

12

ЦӨЛ ДЭХЬ ЯЛАЛТ

*Бидний уй зовлон бидэн шиг л мөнх бус юм.
Гэтэл мөнхийн сэтгэлд мөнхийн уй зовлон
байхгүй. Тэдгээр нь ирдэг, Бурханаар ерөөгддөг
тэгээд оддог. Тэнгэрийн шувууд шиг толгой
дээгүүр маань пор хийгээд л нисчихнэ. Тэдгээр
нь сэтгэлд маань суурьшихгүй. Бид өнөөдөр
зовж байгаа ч, маргааш баярлана.*

—Чарльс Эйч. Спержен

*Алсын хараа байхгүй аваас Ард түмэн
журамегүй, Харин хуулийг сахигч нь жаргалтай.*

—Сургаалт үгс 29:18



Цөл нь бидний дайраад гардаг газар болохоос, эцсийн зогсоол биш! Зохицуулж чадах аваас, цөлд ялалтыг үзэж, цөлийн дээсийг давж чадна!

Намайг залуусын пастор байхад ирсэн цөл хэзээ ч дуусашгүй мэт санагдаж, гал цогийг минь үхүүлж байлаа. Миний энэ их зовлонд төгсгөл байхгүй мэт. Гэтэл нэг өдөр - нөгөө намайг нэр нүүргүй болгож, ажлаас халуулах гэсэн даргатайгаа зөрчилдөж эхлэхээс өмнө Бурханы Сүнс надад айсуу өөрчлөлтийн талаар мэдүүлэв. Тэр үед л Бурхан намайг “Америкийн зүүн эргээс, баруун эрэг хүртэлх, Канадын хилээс Мексикийн хил хүртэлх, Аляскаас Хавай хүртэлх чуулганууд, хотууд руу илгээнэ...” гэж билээ.

Гэхдээ энэ бүхэн маргааш нь юмуу тэр долоо хоногтоо багтаж болоогүйг өмнө хэлсэн! Үнэндээ өөр ямар ч нэмэлт баталгаагүй, нам гүм зургаан сар өнгөрөв. Тэгтэл нэг өдөр манай тэргүүн пастор уулзалтан дээр орж ирээд, Эзэн түүнд “Чуулганы чинь нэг пастор (бид арван нэгүүлээ үйлчилдэг байлаа) удахгүй чуулганд үйлчлэхээ больж, бүтэн цагаар аялдаг болно” гэлээ. Тэр хүн бол Жон Бивэр чи!” гэж хэлсэн юм.

Гэтэл дахиад яг зургаан сар болсон боловч, би цөлөөр явсаар л байлаа. Тэгснээ гуравхан долоо хоногийн дотор би номлуулах долоон урилга хүлээн авав - нэг нь Канадын хил дээрээс, нөгөө нь Флоридагийн Зүүн эргээс, гурав дахь нь Номхон далайгаас цаг гаруй давхих газраас бас нэг нь Мексикийн хил дээрээс! Би пасторынхаа албан өрөөнд ороод, би одоо яах уу гэтэл, тэрбээр инээд алдаад: “Жон, Эзэн надад үүнийг чинь л харуулсан байхгүй юу даа. Цаг чинь болжээ” гэсэн юм.

Төдөлгүй (1990 оны 1-ээр сард) даатгах цуглааны үеэр пастор маань Лиза, бид хоёр дээр гар тавьсан бөгөөд би тэр цагаас хойш бүтэн цагаар аялж үйлчилж байна! Бид өөрсдийгөө бэлэн гэж бодоод өөрсдөө эхлүүлэхийн оронд Эзэний цагийг хүлээж чадсан учраас, амьдралдаа хавьгүй *их* (би “их” гэдэг үгийн хүчийг яаж нэмэгдүүлэхээ мэдэхгүй байна) үр жимс хураасан билээ.

Таны дуудлага ч ийм байгаасай гэж хүсч байна. Тиймээс л Бурханы хүмүүст хайртай, жартай ахмад би танаас юу ч нуулгүй, далан булчирхайгаа үнэнээр нь тоочсон билээ. Би таныг хувь заяандаа хүрээсэй гэж хүсч байна! Тиймээс би танд зарим нэг чухал бодлоо хэлмээр байна.

Зөв зорилго ба хувь тавилан

Бид хараагаа давшихад маань саад хийд хийж байгаа эсэргүүцэл дээр бус, Бурханы зорилго дээр тавих ёстой. Бид зөв газраа хүрмээр байгаа бол, зөв хараатай явах ёстой! Уралдаж уралдаж, буруу барианд орох шиг аймшиг үгүй. Буруу байг онилж буудах шиг гамшиг үгүй!

Фарисайчууд улайрсан, хичээнгүй боловч, амиа бодсон хүмүүс байв. Тэд зөв алсын хараагүй байсандаа байгаа оноогүй юм.

Хүмүүс бидэндээ Бурхан ямар хувь тавилан, зорилго зэхнэ вэ? Ефес 1:11 дээр “Бас бүх юмсыг хүсэл хийгээд шийдвэрээрээ үйлддэг Түүний зорилгын дагуу урьдаас тогтоогдсоноор бид Христэд өвлөгч болсон” гэжээ.

Олон хүн “урьдаас тогтоогдсон” гэдэг үгийг сонсохоороо бүдэрдэг. Энэ санааг ойлгохын тулд бүгдээрээ энэ үгийг язгуур, утгвараар нь задлаж үзье. “Урьдаас гэдэг утгвар үг нь” “таны дуусгах газар” юмуу “бариланы зурвас” гэсэн л утгатай юм. Нэгтгээд үзэх юм бол, зүгээр л “бариланы зурвасаа харж гараанаасаа гарах” л гэсэн утга бүрдэнэ. Тиймээс Ефес 1:11 дээр хэлснээр, Бурхан хүн төрөлхтнийг бүтээхээсээ ч өмнө Өөрийнх нь зорилго гүйцэлдэх эцсийн зогсоолыг тогтоож өгчээ.

Ром 8: 28-29:

Бурханыг хайрладаг, Түүний зорилгын дагуу дуудагдсан хүмүүсийн сайн сайхны төлөө бүх юм хамтдаа ажилладаг гэдгийг бид мэднэ. Тэр Өөрийн Хүүг олон ах дүүсийн дунд ууган нь байлгахын тулд, урьдаас мэдсэн хүмүүсээ Тэр бас Түүний дүртэй адил болгохоор урьдаас мэдэж тогтоосон юм.

Цаг хугацаанаас ч өмнө Бурханы тогтоосон бидний эцсийн зогсоол нь Бурханд хайртай биднийг Есүс Христийн дүр төрхөөр баталгаажуулах явдал байж! Бурхан таныг зүгээр нэг амжилттай

үйлчлэгч юмуу хаанчлалд сая, сая доллар өгдөг баян хүн эсвэл алдартай жүжигчин болгож, ажил карьерын зорилгод хүргэх гэж бүтээгээгүй. Тэр бүү хэл өвчтэйг эдгээж, хүмүүнлэгийн ажил хийлгэж, хүний наймааны золиос болсон хүмүүсийг аварч, хүмүүсийг элдэв донгоос чөлөөлж, төөрөгсдийг Есүс дээр авчрах гэж ч бүтээгээгүй. Мэдээж эдгээр нь бурханлаг мөртэй үйлс. Гэхдээ ийм ажил хийсэн боловч, барианыхаа зурвасыг даваагүй үй түмэн хүн байсныг мартаж болохгүй. Тэд үйлчлэл дээрээ хэт анхаараад, үйлчлэлийн цаад зорилгыг буюу амийг нь умартжээ!

Одоо тэгэхээр: “Бурхан биднийг Есүс Христийн дүр төрхөөр баталгаажуулахаар урьдаас товлосны зорилго нь юу байв?” гэсэн асуултад хариулах хэрэгтэй. Хариулт нь энгийн - Бурхан биднийг хайрладаг учраас, “Христ Есүс дотор бидэнд хандсан Түүний нигүүлслийн хэмжээлшгүй баялгийг ирэх үеүдэд үзүүлэхийн тулд” (Ефес 2:7) нөхөрлөхийг хүсдэг учраас л тэр.

Лиза, бид хоёр Лекси гэдэг охин нохойтой. Лекси маань хайр хүрмээр, зүггүй, хөгтэй амьтан. Тийм боловч бид Лекситэй хязгаартай хүрээнд л харилцана. Заримдаа түүнтэй илүү чухал яриа өрнүүлж чадахгүй байгаадаа гонсоймоор ч юм шиг. Нөгөөтэйгүүр, хөвгүүдтэйгээ харилцах харилцаа маань тэс өөр. Хөвгүүд маань төлөвших тусам, бидний харилцаа улам л сайн сайхан болсоор байна. Хөвгүүд маань бид хоёрын амьдралыг дэндүү баян болгосон. Ийм учраас л Бурхан биднийг хөгжүүлсэн юм. Бурхан бидэнтэй Лекси, бид хоёрынх шиг аар саар харилцааг хүсдэггүй. Бурхан зүрх - зүрхээрээ харилцах хөвгүүд, охидыг хүсдэг.

Бурхан анхнаасаа л бидэнтэй ингэж харилцахыг хүсчээ. Бурхан Адамыг бүтээж, Цэцэрлэгт тавихдаа хайртай байсан учраас л нөхөрлөж, хамт зугаалдаг байсан юм. Адамын удмын нэг хүн Бурханы энэ зорилгыг өөрийн болгосон бөгөөд түүний талаар “Енох Бурхантай хамт явж байсан ба түүнийг Бурхан авч явсан учир тэрээр дэлхийд байсангүй” (Эхлэл 5:24) гэдэг. Еврей номын зохиогч “Итгэлээр Енох, үхлийг үзэлгүй дээш аваачигдсан. Түүнийг Бурхан авч явсан учраас тэр олдсонгүй” (Еврей 11:5) гэдэг. Енох яагаад Бурханд таалагдав? Аугаа үйлчлэлтэй байсандаа тэр үү? Үгүй. Енох Бурхантай хамт алхаж, дотно нөхөрлөдөг байсан учраас, тэр.

Өнгөрсөнд Бурханы хийсэн бүхэн, одоо хийж буй бүхэн, ирээдүйд хийх бүхэн нь ийм л ганц зорилготой байх учиртай. Тиймээс цөлийн зорилго нь Есүс Христийн дүр төрхөөр баталгаажуулах тэр зүг рүү л заасаар байх ёстой.

Бид хэрэв бидэнд зориулсан Бурханы зорилгыг хараанаасаа алдах юм бол, журмаа алдаж, сүнсээр доройтно. Чуулган Бурханы зорилгыг хараанаасаа алдах юм бол хатангиршин, энэ дэлхийгээр жолоодуулдаг бүтэц болтлоо агшина. Бид Христтэй адилхан дагалдагч нарыг бий болгохын оронд үр дүнгээ - том, том тоо, том, том байшингаа л гайхуулдаг болно (Матай 28:19)

Сургаалт үгс 29:18-ыг дахин харцгаая: “Алсын хараа байхгүй аваас Ард түмэн журамгүй”.

Бурханы өгүүлээд буй журам л биднийг Түүний дүр төрхтэй адилхан байхаас дорд дуудлагын төлөө амьдрахаас хамгаална. Журам л биднийг Бурханы дүр төрхтэй адилхан болсоор, Түүний илэрхийлэгдсэн алдрыг үзэхээр Түүнтэй нүүр нүүрээрээ уулзахаасаа өмнө сэтгэл ханаад, буугаад өгөхөөс хамгаална. Журам л биднийг Бурханаас тавьж, дэлхийн замаар үйлдэж, махан биеийн аргаар амьдрахаас хамгаална.

Есүс алсын харааны талаар ярихдаа: “Нүд бол биеийн дэнлүү мөн. Нүд чинь саруул аваас бүтэн бие чинь гэрэлтэй байна. Харин нүд чинь ёрын муу аваас бүтэн бие чинь харанхуй болно. Хэрэв доторх гэрэл чинь харанхуй байх аваас тэрхүү харанхуй ямар их вэ!” (Матай 6:22-23) гэсэн. Тэрбээр нүд гэдэг эрхтэний талаар яриагүй, харин зүрхний нүдний талаар буюу юмсыг хүлээн авах арга замын талаар ярьжээ.

Та зүрхэндээ юмыг хэрхэн хүлээж авна - тийм л хүн болно: “Тэрээр хоолойд торох хялгас мэт агаад “Уу! Ид!” гэж тэр чамд хэлэвч Үнэндээ зүрх нь чамайг гээгүй байдаг” (Сургаалт үгс 23:7).

Та тулгарсан нөхцөлдөө хэрхэн хандана - тэгж л гарна. Арван хоёр туршуул бүгдээрээ л Канаанд нэг л ижил нөхцөл байдал, баг цайзтай хотууд, үлэмж биетэй хүмүүс, улс үндэстнүүдийн цэргүүдийг харсан. Гэтэл Иошуа, Калев хоёр бусад арваасаа тэс өөрөөр харсан. Тэр хоёр Амлагдсан газрыг Бурханы хараагаар харсан бол, бусад арав нь хүний туршлага, чадвар, нүдээр харжээ. Тэдний нүд нь муу байсан учраас, бусад зан авир нь (буюу Есүсийн хэлснээр “бүтэн бие” нь) муу байв. Тэд Бурханы хүсэлтэй сөргөлдсөн үг, үйлдлээр хариулсан бөгөөд Бурхан тэднийг мэдээг “ёрын”, “муу” гэжээ.

“Би амьд! Та нар Миний чихэнд ярьсантай адил түүнчлэн Би та нарт үйлдэх болно. Миний эсрэг гонгинсон, хорь ба түүнээс дээш насны тоолуулсан бүх хүний цогцос тооныхоо дагуу энэ цөлд унах болно. Та

нарыг суурьшуулахаар Миний тангарагласан тэр нутагт Иефуннегийн хүү Калев болон Нуны хүү Иошуа нараас өөр хэн ч орохгүй. (Тооллого 14:28-30)

Арван туршуул юунаасаа болоод Бурханыг өгсөн амлалтаа татахад хүргэв? Хараанаасаа болоод! Тэд эш үзүүллийн алсын хараагүй, зүгээр л махан хараатай байсан. Тэд харсан зүйлээ л ярьжээ.

Цөлөөр ялаад гарахын тулд бид юмсыг Бурханы нүдээр хардаг болох хэрэгтэй. Арван туршуулыг Амлагдсан газар руу явахаас жилийн өмнөөс л Израилийн хүүхдүүд аль хэдийнээ гомдол урсгаад эхлэхсэн байжээ. Тэдний үзэл бодол хэдийнээ муудаж, ямар ч журам хэрэгсэхээ больсон байв. Тиймээс Бурхан тэдэнд сүү, балаар халгисан нутгийг үзүүлэхээс ч өмнө тэд харсан үзсэнээ эсэргүүцээд эхлэхсэн, Канааны үлэмж хүмүүсийг хараад эхлэхсэн байж.

Цөлийг (бөгөөд цөлийг дагаж ирдэг бэрхшээлийг) хардаг хүмүүс цөлдөө л үхнэ. Амлагдсан газрыг ширтэж, өмнөө буй Бурханы алсын харааг хардаг хүмүүс цөлөөс Амлагдсан газрыг байлдан дагуулсан, ариусгагдсан дайчид болон гарцгаана.

Тиймээс бид зүрх алддаггүй. Хэдийгээр гаднах хүн маань ялзарч байгаа ч доторх нь өдрөөс өдөрт шинэчлэгдэж байна. Учир нь агшин төдий ялихгүй зовлон нь бидэнд алдрын мөнхийн жинг үлэмж арвижуулж байна. Бид үзэгдэх юмсыг бус, харин үл үзэгдэх юмсыг хардаг. Учир нь үзэгдэх юмс бол цаг зуурынх, харин үл үзэгдэх юмс мөнх билээ. (2Коринт 4:16-18)

Цөлийн урт, зовлон бэрхшээл нь - ирэх ашигтайгаа харьцуулахад түрхэн зуурын, хөнгөхөн бэрхшээл юм. Цөлд байгаа хүн цөлийн цаана юу хүлээж байгааг мэдэж байгаа бол, цаг зуурын энэ бэрхшээлийг аминдаа тултал авч үзэхгүй.

Цөл надад хөнгөн шингэн, богинохон байгаагүй ээ. “Энэ бүхэн дуусах болов уу? Бурханы амлалт хэзээ нэгэн цагт биелэх болов уу?” хэмээн бодогдох үе зөндөө. Тэр үед би тийм бодлыг бушуухан эсэргүүцээд, өөрийгөө Эзний дотор урамшуулах хэрэгтэй болдог байлаа. Тэгээд надад өгсөн урьд урьдын эш үзүүллийг санаад, түүгээр хүчтэй тулаан хийнэ (1Тимот 1:18-ыг үзнэ үү). Тэдгээр эш үзүүлэл нь Бурханы Үгээр дамжин Ариун Сүнсээр надад илчлэгдсэн Бурханы алсын хараа байсан юм.

Сэтгэл бол цөлийн тулааны талбар. Сэтгэл нь оюун, сэтгэл мэдрэмж, хүслээс тогтоно. Хүсэл нь Бурханы замыг дагах уу, биеийнхээ замыг дагах уу гэдгийг шийдвэрлэгч сэтгэлийн бүтэц юм. Петр “Хайртууд аа, сэтгэлийн чинь эсрэг дайтдаг махбодын хүсэл тачаалуудыг цээрлэхийг ирмэл агаад түр суурьшигч та нараас би гуйя” (1Петр 2:11) гэж бичсэн.

Энэ бүхний цөм нь таны харааны төвд Эзэн байна уу, та өөрөө байна уу гэдэг асуулт болно. Оюун, сэтгэлд чинь дайн хийдэг махан биеийн хүсэл чинь амь, ашгаа бодсон сонирхол дээр л суурьшина. Бурханы замууд нь амиа боддог бус, өөрийгөө няцаадаг замууд учраас, амиа эрэлхийлэгч замуудтай чинь зөрчилдөнө.

Өнөөдөр олон хүний номлож, итгэж байгаа Сайн мэдээ нь махан биед тун таатай Сайн мэдээ болжээ. Гол номнол сургаал нь биднийг махан биеэ цовдлохыг ятгах бус, харин ч Есүс Христтэй баталгаажих туйлын зорилготой дайсагнадаг хүслүүдийг маань аргадаж бордоно. Бид “Бурхан надаас юу хүсч байна?” гэж асуухын оронд “Бурхан надад юу хийж өгөх бол?” гэж асуудаг. Энэ хялбаршуулсан Сайн мэдээ нь Христийг дагахад ирдэг бодит зовлонгийн талаар дурьдахгүй. Энэ нь олон хүнийг өөртөө цадгалдсан амьдралын хэв маяг дээр тогтоход хүргэж байна. Ийм Сайн мэдээ нь итгэгч нарыг Бурханы цэргүүд болгож хөгжүүлдэггүй.

Элч Паул дагалдагч Тимотдоо бичсэн захидалдаа энэ сэдвийг хөнджээ:

Христ Есүсийн сайн цэрэг адил надтай хамт зов. Ямар ч цэрэг цэрэгт татагчдаа таалагдахын тулд аж амьдралын явдалд хутгалддаггүй. (2Тимот 2:3-4)

“Ийм хялбар Сайн мэдээний” гороор бид эсэргүүцэл, бэрхшээлтэй тулгарахдаа урдаас нь мөргөж очоод, урагшаа давшихын оронд зугтаж зайлах зам хайдаг. Хялбар Сайн мэдээнээс “тэнгэрийн юмуу эш үзүүллийн алсын хараа” бус, “аминч алсын хараа” бий болдог.

Энэ талаар Паул ч бичсэн:

Агрипп хаантан, тиймээс би тэнгэрлэг үзэгдэлд дуулгаваргүй байж болсонгүй. Харин эхлээд Дамаск болон Иерусалимд, дараа нь Иудейн бүх нутгаар тэрчлэн харийнханд хүртэл “Та нар гэмшиж, Бурхан өөд

эргэн, гэмшилд дүйцэх үйлс бүтээгтүн” гэж тунхаглаж байлаа. Ийм шалтгаанаас иудейчүүд намайг сүм дотор барьж авч алахыг оролдсон. (Үйлс 26:19-21)

Дэлхий олон алсын хараатай бол, “тэнгэрт ганц л алсын хараа” байдаг нь Аавын хүсэл болой! Паул “иудейчүүд намайг сүм дотор барьж авч алахыг оролдсон” (Үйлс 26:19-21) гэж хэлсэн байгааг анхаарна уу. Паул тэнгэрийн харааг мөшгихдөө, том эсэргүүцэлтэй тулгарчээ. Паул өнөөгийн олон хүмүүсийн номлож, итгэдэг хялбар Сайн мэдээнд итгэдэг байсан бол, алсын харааныхаа биеллийг хэзээ ч үзэхгүй байж.

Аян замд аминд орох арга

#12 Сайн тэмдэглэгээ хий

Өнөөдөр би 59-тэй. Хурдан юм аа! Эргээд харахад, тухайн үедээ ахихгүй, арагшлаад байгаа мэт санагдаж байсан ч, би цөлд л хамгийн их өссөн байдаг. Тиймээс л миний хуучны анд Иов „Гэвч Тэр миний замыг мэддэг. Тэр намайг шалгасан бөгөөд би алт мэт урагш гарч ирнэ” (Иов 23:10) гэсэн билээ.

Үнэндээ, бичсэн хорин номынхоо ерэн хувийг нь би халгиж цалгиж явахдаа бус, харин цөлд байхдаа л сурсан байдаг юм. Тиймээс цөлд байхдаа сайтар тэмдэглэгээ хий гэж л зөвлөө! Энэ улиралд сурсан эрдэм чинь бусдад болоод нас дээр гарах үед чинь том хүч болно. Тэгээд энэ бүх туршлага чинь хэзээ нэгэн цагт ном болж төрөх ч юм билүү, хэн мэдлээ!

Найз минь, би яг одоо таны дээр эш үзүүлмээр байна! Үгийг минь анхааралтай сонсоно уу: Хэрэв та цөлийн улиралдаа Бурханаар ажлыг нь хийлгэх юм бол, цаг нь ирэхээр Бурхан таны амьдралд олон хүнд нөлөөлөх, гүн зүйл хийнэ. Тэр нөлөөнд чинь олон хүн автаж, та ч дуулгавартай байдлынхаа үр жимсийг үзэх тоолондоо, өнө мөнхөд баясна. Та шалгуурыг даван, хүчирхэг бөгөөд шижир болон гарч ирнэ.

Хэрвээ Паул өөрт нь тулгарсан бүх эсэргүүцлээс зугтаад байсан бол, Агрипп хаантай ч уулзахгүй байсан.

Тэнгэрийн алсын харааг хөөж, дуулгавартай байсныхаа хариуд аман бөгөөд оюуны асар их хавчлага үзсэн, Библийн өөр нэгэн баатар бол Иеремиа. Тэрбээр нэгэн өдөр цөхрөөд, жаахан гомдол гаргажээ: “Хэргээ мэдүүлэхэд ямагт шударга байдаг ЭЗЭН минь. Тантай шударга ёсны хэргүүдийн талаар ярих зүйл байна. Буруутуудын зам яагаад цэцэглэсэн юм бэ? Итгэлгүй хүмүүс яагаад амар тайван байна вэ?” (Иеремиа 12:1)

Бурхан түүнд хөөрхийлсөн хариу өгөөгүй. Харин: “Явганыг дагаж гүйгээд ядарлаа гэвэл Чи, морьтонтой хэрхэн уралдах болж байна? Амгалангийн газар унаж тусаж байвал Иорданы шугуйд чи яах билээ?” (Иеремиа 12:5) гэж хариулсан байна. Өөрөөр хэлбэл: “Иеремиа, чи Диаволын шатрын хүүд ялагдаж байж, их цэрэгтэй нь яаж тулалдах билээ?” гэжээ.

Дайнд дайтдаг юм

Том тулаан үгүй бол, том ялалт ч үгүй. Иеремиагийн байдал улам л дордож байв. Мань хүнийг хэл амаар доромжилж, шоронд хийж, сүүлдээ үхүүлэхээр гянданд хаясан. Тэгтэл эцсийн дүнд Бурхан Иеремиаг бүх зовлон зүдгүүр, хавчлагаас нь аварчээ.

Өнөөдөр Христийн бие доторх дийлэнх хүмүүс Паулд тулгарсан шиг бие махбодын хавчлагад бус, харин оюун санааны тулаанд ордог. Эсэргүүцэл өөрчлөгдбөл, бид яах вэ? Өнөөдөр бидний туулж буй зовлон биднийг хэтийн илүү том тулаанд бэхжүүлэх үүрэгтэй.

Цөл нь хэтийн тулаанд бэлтгэх хээрийн сургууль юм. Улс цэргүүдээ хээрийн сургуулиар бэлтгэдэг шиг, Бурхан ч цэргүүдээ цөлийн сургуулиар бэлтгэдэг. Хээрийн сургуулиар цэргүүд айдас, сул дорой чанар, урамгүй байдлаа ялан дийлэх ёстой болдог. Тэгвэл цөлийн сургуулийн бэлтгэл маань сэтгэлийн талбар дээр л өрнөдөг.

Урамгүй байдал бол бидний ялан дийлэх ёстой хамгийн том дайсны нэг юм. Намайг нэг удаа залбирч байтал Эзэн: “Урмын дайсан юу вэ?” гэж асуув.

Би ч: “Мэдээж айдас” гэж хариуллаа.

Гэтэл Бурхан: “Урамгүй байдал” хэмээн шивээнэв. Би хэзээ ч ингэж бодож явсангүй! Тэр үед л яагаад Иошуад “хүчтэй бөгөөд

урамтай байгаарай!” (Тооллого 13:20, Дэд хууль 31:6,7, 23; Иошуа 1:6,7,9,18) гэж наймын найман удаа хэлснийг ойлгов. Учир нь урам алдрах нь Иошуагийн хамгийн том дайсан болохыг Эзэн мэдэж байжээ. Хүн цөлд юмуу тулаан дунд Бурхан дээр юмуу даалгавар дээрээ төвлөрөлгүй, өөр дээрээ төвлөрөх үед энэ дайсан гарч ирдэг.

Дайсан төвлөрлийг тан дээр л тааруулах санаатай. Тэр Есүсийг ч ингэх гэж оролдсон. Есүс дөч хоног юм идээгүй учраас өвчүү, цорой нь наалдаж байсан байх. Тэгтэл Диавол ирээд: “Та Бурханы Хүү мөн л юм бол, энэ чулуунд талх бол гэж тушаа” (Матай 4:1-11) гэжээ. Дайсан Бурханы хүчийг Бурханы хүслийг бус, махан биеийн хэрэгцээг хангах хэрэгсэл болгохыг зорьжээ. Гэтэл Бурхан бидэнд бэлэг өгөхдөө, үүнтэй хамт бэлэгийг нь завхруулалгүй, гагцхүү Түүний хүслийн дагуу захиран зарцуулах хариуцлага давхар ноогдуулдаг. Бурхан Есүсийн хэрэгцээг баттай хангадаг байсан. Гэхдээ Өөрийнхөө арга замаар хангадаг байв. Тийнхүү Диаволыг явахад тэнгэрэлч нар ирээд, Есүст үйлчилжээ.

Бүгдээрээ дахиад Есүс үйлчлэлийнхээ талаар юу хэлснийг харцгаая:

Үнэнээр үнэнээр Би та нарт хэлье. Эцэгээс хийж харуулсныг нь л Хүү хийхээс Хүү юуг ч Өөрөөсөө хийдэггүй. Учир нь Эцэг юу хийнэ, Хүү нь бас эдгээрийг түүнчлэн хийдэг. (Иохан 5:19)

“Харуулсныг” гэдэг үгийг анхаарна уу. Есүс Бурханы хүслээс гадуур юу ч хийгээгүй.

Цөлд бид Бурханы үйлдлийг хүлээхийн оронд өөрийнхөөрөө үйлдэх өдөөлтөнд их ордог. Өөрөөр хэлбэл Бурханы тогтоосон цагаас өмнө Бурханы хүчээр өөрийнхөө юмыг хийх гэж оролдох. Даргынхаа тушаалыг дагалгүй, дураараа байлдаж байгаа цэрэг шиг л. Тэр цэрэг өөртөө ч, бусад цэргүүддээ ч гай тарина. Уг нь тэр бүх цэргийн эрдэм, хээрийн сургууль нь түүнд өөртөө ч, өрөөлд ч гай болохгүйн тулд тушаалыг дагах ёстой гэдгийг л сургасан.

Тэнгэр бидэнд юу илчилснийг бүү март. “Надад яг одоо хариулт хэрэгтэй байна! Эс бөгөөс би өөрийнхөө нүүдлийг хийлээ. Одоо л хөдлөхгүй бол, оройтлоо!” гэж бодогдох үе зөндөө. Бурхан дуугарахгүй байгаа нь Бурхан ярихгүй байна гэсэн үг биш. Бурхан бидэнтэй янз бүрийн аргаар харилцдаг. Энэ тохиолдолд Бурхан бидэнд: “Янз бүрийн юм бүү хий” л гэж “хэлж” байгаа юм. Тиймээс янз бүрийн юм хийлгүй, Эзэнийг хүлээ!

ЭЗЭНийг хүсэн хүлээгтүн! Тууштай байж, зүрхээ зоригжуулагтун! Тийм ээ, ЭЗЭНийг хүсэн хүлээгтүн!
(Дуулал 27:14)

Бид Бурхан дээр бус, өөр дээрээ төвлөрөхдөө урамгүй байдал, дарамтанд автана. Анхаарал маань сарниж, “зовлонгийн гэрэл” дээр төвлөрнө. Гэтэл уг нь бид “Учир нь агшин төдий ялихгүй зовлон нь бидэнд алдрын мөнхийн жинг үлэмж арвижуулдаг” (2Коринт 4:17) гэрэл дээр төвлөрөх ёстой юм.

Энэ бол бидний анхаарлыг олзлох ёстой, бидний өмнө буй баяр хөөр билээ.

ӨМНӨХ ГЭРЭЛ

Ах дүү нар минь, элдвийн сорилтод орохдоо үүнийг бүрэн баяр хөөр гэж үз. Итгэлийн чинь шалгуур хатуужилд хүргэдгийг та нар мэдэх билээ. Хатуужил нь төгс үйл байг. Тэгвэл та нар төгс, бүтэн юугаар ч дутахгүй байна. (Иаков 1:2-4)

Баяр хөөр нь зовлон, сорилыг даван туулахад маань тэсч гарах хүчийг өгдөг сүнсний хүч юм. Бурханы Үг “(Бүгдийг) баяр хөөрт тооц” гэсэн байдгийг анхаарна уу. “Зарим нэгийг нь баяр хөөрт, заримыг нэгийг нь зовлонд тооц” гэж хэлээгүй. Ингэж төсөөлье: Таны гинжний ерэн есөн хэлхээ нь баяр хөөрөөс, ганц хэлхээ нь гунигаас тогтох ажээ. Гэтэл та зуун хэлхээ нь зуугуулаа баяр хөөрөөс тогтсон гинжтэй болж байж л сэтгэл ханах гээд байдаг.

Амьдрал сайхан үед энэ гинжний гунигийн ганц хэлхээг хэрэгсэлгүй, бүхэлд нь “баяр хөөрийн” гинжинд тооцох амархан. Гэтэл бичвэр ингэж хэлээгүй байна. Бичвэр цөл, хавчлага, бэрхшээл, зовлон, сорилын цаг - энэ бүгдийг “баяр хөөрт тооц” гэжээ. “Эзэний баяр баясал таны хүч чадал” гэдгийг Бурхан мэддэг учраас л ингэж хэлжээ. Энэ нь бидний хүчийг сэлбэдэг, Бурхантай тогтоох харилцааны баяр баясал юм.

Гэр бүл минь - гэргий, хөвгүүд, бэрүүд, ач нар маань миний амьдралын баяр баясал! Би гэрээсээ хол явахдаа, тэднийхээ зургийг үзэх бүрийд нүүрэнд минь мишээл, зүрхэнд минь баясал төрж, хүч ордог.

Нехемиа эрчүүддээ үүнийг л хэлжээ. Бэрхшээлтэй тулгарсан

Нехемиа: “Дайсагналаас болж бүү гунь. Эзэнийг ширт. Эзэнд ойртбол, зүрх чинь баяраар дүүрч, энэ баяр та нарын хүч болно” гэсэн утгатай үг хэлжээ.

Магтаал хүний харааг Эзэн дээр эргүүлж тавьдаг. Сорил шалгуурын дарамтанд орсон хүн хараагаа Эзэнээс буулгах амархан. Давидын ихэнх магтаал зовлон дунд л төрсөн байдаг.

Давид Бурханаа магтахдаа л зовлон дунд хүчтэй байжээ.

Исаиа 61:3 дээр Бурхан бидэнд “...гашуудлын оронд баяр хөөрийн тосыг, Гаслант сүнсний оронд магтаалын хувцас өгнө” гэдэг.

Энэ ишлэлийн хүчээр л би халуун цөлийг даван туулсан билээ. Нэг удаа гэртээ ганцаараа байж байтал, гэнэт учиргүй их дарамт буугаад ирэв. Библиэ уншъя гэв ч, уншиж чадахгүй. Залбирья гэв ч, залбирч чадсангүй. Гэтэл Ариун Сүнс “Магтаалын дуу тавь” гэх шиг болсон тул хөгжим байдаг өрөөндөө ороод, магтаалын дуу тавиад, дагаж дуулаа. Дотор бачуураад байж ядсандаа Эзэний өмнө бүжиглэх гэж оролдсон ч, усан дотор бүжиглэж байгаа мэт хүнд байлаа. Ямар хэцүү байсныг яаж тайлбарлахаа ч мэдэхгүй байна.

Дуунууд явж дууссаны дараа дахиад тоглуулмаар санагдлаа. Энэ удаа би өөрийнхөө дуу хоолойг сонсохтойгоо болов. Тэгтэл гэнэт зүрх минь сэнтийдээ залран суугаа Есүсийг, Түүний үлэмж хайрыг үзэх шиг болов. Сэтгэлд баяр хөөр цогиж, хөл дэвхцэж, хараа маань дээшилсээр, Есүсийн цог жавхлант чанарт дээр тогтжээ. Ийнхүү би хагас цаг хэртээ умгар гэрээ дотроо галзуу хүн шиг л дуулж, цовхчиж, тойрон бүжив. Дарамт зайлж, би амь орж, хагас цагийн өмнө ор сураггүй байсан хүч одоо дотроос минь гадагшаа хальж байлаа.

Бурханыг магтах үед хараа маань эргээд Бурхан дээр тогтжээ. Исаиагийн “Та нар авралын худгаас баяртайгаар ус татна” (Исаиа 12:3) гэдэг үг амьдралд маань биелж, би Эзэний баяр хөөрөөр авралын худгаасаа хүч олборложээ.

Бид Эзэнийг магтахдаа, эргэн тойрынхоо нөхцлийг бус, угтах баяр хөөрөө хардаг.

Тиймээс бид өөрсдийг минь хүрээлэн буй үүл мэт үлэмж их гэрч нартай тул аливаа саад тогтор ба амархан урхиддаг нүглийг хажуу тийш нь тавьж, өмнөө тавигдсан уралдаанд тэвчээртэйгээр гүйцгээе. Итгэлийг Эхлүүлэгч бөгөөд Төгсгөгч болох Есүс өөд харцгаая. Тэрээр өмнө нь тавигдсан баяр баясгалангийн төлөө гутамшгийг эс тоомсорлон, загалмайг тэвчсэн бөгөөд

Бурханы сэнтийн баруун гарт заларсан юм. Сэтгэлээр унахгүй байж тэнхээгээ барахгүйн тулд Өөрийнх нь эсрэг нүгэлтнүүдээс тийм эсэргүүцлийг тэвчсэн Түүнийг санагтун. Нүглийн эсрэг тэмцэлдээ цус урсгах хүртэлээ та нар хараахан эсэргүүцээгүй байгаа. (Еврей 12:1-4)

Есүс угтах баяр хөөрийг буюу үхлийн дараа өрнөх амиллыг харснаараа хэзээ ч, хэний ч *туулаагүй* бас *туулахгүй* аймшигтай том сорилыг давж гарсан юм. Энэ дуулгавартай үйлдлээрээ Есүс олон хөвгүүд, охидыг буюу тэр дундаа та, бид хоёрыг Бурханы хаанчлалд нэвтрүүлэх алдрыг авчрах байв!

Есүсийн мөрөөр дагадаг бид ч ингэх ёстой. *Амиллын амьдрал* нь өөрийгөө няцааж, махан биеэ цовдлохыг шаардана. Есүстэй дотно харилцаа тогтоох явдал нь махан биеэ цовдлохоос ч ихийг шаардана! Паул “Энэ цагийн зовлонгууд бидэнд илчлэгдэх тэрхүү алдрын дэргэд юу ч биш гэж би боддог” (Ром 8:18) гэсэн билээ.

Эзэнийг эргэж ирэхээс өмнө Бурханы алдар чуулган дотор илчлэгдэх болно. Энэ жинтэй алдрын нөлөөгөөр хот, үндэстнүүд авралд хүрнэ. Бурханаар цэвэрлүүлэхийг зөвшөөрсөн Христийн дагалдагч нар урьд хожид үзэгдээгүй их хүчийг дэлхийд харуулна. Аугаа ургац авчрах Бурханы Сүнсний энэ цутгаланд хүний суртчилгаа хэрэггүй. Үүнийг Бурхан Өөрөө хүч, алдраараа суртчилна!

Хайртай хүмүүс минь, та нарыг сорихын тулд дунд чинь ирдэг галт сорилтод ямар нэгэн хачирхалтай юм та нарт тохиолдсон мэт бүү гайх. Харин Христийн зовлонг хуваалцдагтаа баярла. Ингэснээр мөн Түүний алдар илчлэгдэхэд та нар хөөрөн баярлах юм. (1Петр 4:12-13)

Би дахиад асууя: Бидний өмнө буй баяр хөөр гэж юуг хэлнэ вэ? Энэ нь Христийг дуулгавартай дагаснаасаа болоод зовсон хүмүүст Бурханы алдар илчлэгдэх явдал юм. Тэд зовсон хэмжээгээрээ баяр хөөрийг эдлэх тул том эсэргүүцэл байх тусам, том алдар ирнэ гэдгийг мэдээрэй.

Амиа алд

Найз минь, эсэргүүцэл ирэх үед Бурханыг дагасаар бай! Бурхан таныг хүнд бэрх нөхцөлд угаасаа оруулна. Учир нь тулаан том

байх тусам, хаанчлалын болоод таны ялалт том байна. Тулаан дунд дараах баталгааг бүү мартаарай:

Та нарт учирсан сорилт нь хүнд тохиолддог л зүйл.
Бурхан итгэмжтэй, Тэр та нарыг хэр чинь хэтэртэл
соригдохыг зөвшөөрдөггүй, харин дааж гарахын
тань тулд сорилттой хамт мөн гарцыг ч буй болгоно.
(1Коринт 10:13)

Ямар ч сорил нүүрлэсэн - үүнийг бут цохиод, амжилтаа дуудуулсаар, алдраа гийгүүлсээр гараад ирэх хүч нь танд угаасаа бий. Эс бөгөөс Бурхан үүнийг зөвшөөрөхгүй, та ийм байдалтай тулгарахгүй байсан!

Аминдаа *хайртай* хүн хэцүү үед дандаа бууж өгдөг. Бурханы араас явахад больж, үр жимсгүй амьдралаар амьдрахаар шийддэг.

Илчлэл 12:11 дээр “Тэд түүнийг Хурганы цус, өөрсдийн гэрчлэлийн үгээр ялжээ. Тэд үхэн үхтлээ амиа хайрлаагүй юм” гэдэг.

Бурханы Үгд бус, өөртөө санаа тавьдаг хүмүүс нь амиа хайрлагсад бөгөөд Есүс “Хэн амиа аврахыг хүснэ, тэр түүнийгээ алдана. Харин хэн Миний төлөө амиа алдана, тэр түүнийгээ олно” (Матай 16:25) хэмээн айлдсан буюу.

Айсуй зүйлсийг тэсвэрлэх цорын ганц зам нь амиа алдах юм. Би таныг “Өндрөөс, дээрээс маань Сүнс цутгах хүртэл, Зэлүүд газар нь үржил шимтэй талбай болж, Үржил шимтэй талбай нь ой мод мэт болтол” (Исаиа 32:15) давшаарай гэж ятгамаар байна.

Цөл нь зэвсгээ тавиад, бууж өгдөг цаг биш! Энэ нь хүчтэй, хатуужилтай, урамтайгаар Эзэний хүслийг биелүүлдэг цаг. Энэ нь өөрийгөө Бурханд даатгаад, Диаволыг тууштай эсэргүүцдэг цаг.

Та яг одоо цөлд байгаа бол, Бурхан танд зүрхэнд чинь юу байгааг мэдүүлэхээр цөлд авчирчээ. Диаволаас эхтэй гэж бодож байсан олон юмс Христэд захируулах ёстой амьдралын маань далд хэсгүүд байсныг би хожим ойлгосон.

Тэнгэрийн шагналын төлөө зогсолтгүй явахдаа, дараах үгийг санаарай:

“Биднийг Христ дотор ямагт ялуулдаг... Бурханд харин талархал нь байг” (2Коринт 2:14).

Хэн биднийг Христийн хайраас салгах юм бэ? Гамшиг уу, шахалт уу, хавчлага уу, өлсгөлөн үү, нүцгэрэл үү, аюул уу, илд үү?... Харин бид энэ бүхний дотор биднийг хайрладаг Түүгээр дамжин давуулан дийлдэг. (Ром 8:35, 37)

Харин Эзэн Есүс Христээр маань бидэнд ялалт өгдөг Бурханд талархал нь байх болтугай. (1Коринт 15:57)

Эзэнийхээ араас явсаар бай. Битгий зогс. Нөхцөл байдал хаашаа ч эргэсэн - Бурханаас ирсэн алсын харааг сахисаар бай.

Эхлээд нүхэнд хаягдаад, хожим харийн гянданд хаягдсан Иосефын хувьд найдвар тасарсан. Амьдрал нь дууссан л мэт харагдаж байв. Түүнд ямар ирээдүй байв? Тийм боловч “Энэ нь хүмүүст боломжгүй боловч Бурханы хувьд өөр. Учир нь Бурханд бүх юм боломжтой” (Марк 10:27) гэдгийг санаарай.

Нөхцөл байдал яаж ч уруудан доройтсон, “Итгэдэгт нь бүх юм боломжтой” (Марк 9:23) гэдгийг бас санаарай.

Угтах баяр хөөрөө буюу таны дотор илэрхийлэгдсэн Бурхан алдрыг ширт. Энэ танд сорилыг ялах хүчийг өгнө. Бүх зүрхээрээ Бурханыг хайсаар, танд Үгээрээ дамжуулан Ариун Сүнсээрээ хэлсэн Бурханы Үгд итгэсээр бай. Итгэх аваас цөлд ялалт байгуулна.

Та нарыг бүдрэхээс хамгаалж, Өөрийнхөө алдрын оршихуйд үлэмжийн баяр хөөртэйгөөр, өө сэвгүйгээр зогсоож чадах Түүнд, бидний Аврагч болох цорын ганц Бурханд, бидний Эзэн Есүс Христээр алдар суу, сүр жавхлан, сүр хүч, эрх мэдэл нь бүх цагаас өмнө, эдүгээ болоод мөнхөд байх болтугай. Амен. (Иуда 1:24-25)

ХЭЛЭЛЦЭХ АСУУЛТ

Хэрэв та номоо “Цөлд” цогц сургалтын хөтөлбөрөөр нь судлаж байгаа бол, долоо хоног тутмын видео хичээлээ үзэж сонсоод, тухайн хэсгийн хэлэлцэх асуултын дагуу хоорондоо ярилцаарай. Видео хичээл нь номын гол, гол сэдвийг хөндөх учраас, оролцогч нарын хувьд хичээлээ үзээд, номоо уншаад явах нь хамгийн зүйтэй юм.

Хичээл 1

1-ээр бүлгийг уншина уу.

1. Бурхан хаа сайгүй оршдог. Гэхдээ үүнээс гадна бас оршихуйгаа илчилдэг. Энэ хоёр оршихуй нь ямар ялгаатай вэ? Ялгааг нь ойлгох нь яагаад чухал вэ?
2. Өнөөгийн улирлаа ойлгож, цөлийн улиралд яваа эсэхээ мэдэх нь яагаад чухал вэ?
3. Сатан яагаад чухам цөлд биднийг санаатайгаар нүгэл үйлдэхэд юмуу итгэлээсээ няцахад өдөөдөг вэ?
4. Бурхан яагаад бидэнд цөлийн улирлыг зөвшөөрдөг вэ?

Хичээл 2

2, 3-аар бүлгийг уншина уу.

1. Цөл нь хэд хэдэн зорилготой. Энэ хичээл дээр дурьдсан долоон зорилгоос аль нь танд хамгийн гүн нөлөөлөв? Яагаад?

2. Цөлд Бурханд дуулгавартай байх нь яагаад сүнсээр өсгөдөг вэ?
3. Цөл нь өөрийгөө таньж мэдэх цаг юм. Цөлд өөрийнхөө талаар болоод Бурхантай тогтоосон харилцааныхаа талаар юу сурав?
4. Даруусах улиралдаа Бурханы дотор яаж хүчтэй байх вэ?

Хичээл 3

4-ээр бүлгийг уншина уу.

1. Амлалт хийгээд биеллийн хооронд үйл явц гэж бий. Энэ үйл явц яагаад чухал вэ?
2. Амьдралд чинь амлалтын үйл явц аль хэр ахицтай явж байна?
3. Бурхан таныг үйл явц дундуур гаргахаасаа өмнө яагаад амлалт өгдөг гэж бодож байна?
4. Амьдралдаа таван жилийн төлөвлөгөө гаргаж байснаас Бурханы амлалттай байсан нь яагаад илүү чухал вэ?

Хичээл 4

5, 6-аар бүлгийг уншина уу.

1. Саул, Давид хоёрын амьдралын харьцуулалтаас Бурхан биднийг цөлөөр дамжуулан цэвэршүүлдэг үйл явцсыг хэрхэн ойлгож авав?
2. Цэвэршүүлсэн алт уян хатан болдог шиг Бурханы цэвэрлэгээ биднийг Бурханд илүү мэдрэг болгодог. Энэ ямар утгатай болохыг өөрийнхөө үгээр тайлбарлана уу.
3. Бурханы цэвэршүүлэх үйл явц бидний далд нүглийг юмуу сул талыг ил болгоход, бид хэрхэн хариу үйлдэх ёстой вэ?

4. Цэвэршүүлэх үйл явц яаж биднийг Есүсийг илүү тодорхой илчлэн харуулах байр сууринд гаргадаг вэ?

Хичээл 5

7-аар бүлгийг уншина уу.

1. Бурхан яагаад гомдол гаргахыг үзэн яддаг вэ? Таны амьдралд гомдол байна уу?
2. Малахи ном дээр гомдол гаргагсад болоод Иеремиагийн гомдол нь ямар ялгаатай вэ? Бурхан яагаад Малахийн хүмүүст уурссан атлаа Иеремиагийн гомдолд хариулсан бэ?
3. Шүүх нь ял биш, шийдвэр юм. Бурхан гэрээ шүүхдээ, хэн нь Түүний үйлчлэлд зохистой болохыг шийднэ. Бурхан юун дээр үндэслэж шийдвэрээ гаргах бол?
4. Бурхан Өөрт нь үйлчлэх зохистой савыг хайж байна. Дуудагдсан байх, сонгогдсон байхын ялгааг дүрслэн ярина уу?

Хичээл 6

8-аар бүлгийг уншина уу.

1. “Зовлон - бэлэг” гэдэг ойлголтыг анх сонсоход ямар санагдсан? Хичээлийн дараа үзэл бодол чинь хэрхэн өөрчлөгдөв?
2. Бурхан таныг хэмжээнээс чинь хэтэртэл шалгахгүй. Энэ үг танд урам болж байна уу?
3. Бурхан таныг одоогийн чинь нөхцөлд орхихгүй. Энэ нь таны амьдралд хандсан Бурханы төлөвлөгөөний талаар юу сургаж байна?

4. Бурхан биднийг маргаашийн дарамтанд бэлтгэхийн тулд өнөөдөр сорил дундуур гарахыг зөвшөөрдөг. Сорил дунд нухлагдаж байхад чинь итгэл найдвар хайрладаг Бурханы амлалт - үг танд бий юү?

Хичээл 7

9-ээр бүлгийг уншина уу.

1. Бурханыг дагахад ойлгомжгүй үе зөндөө. Бурхан тогтсон, уламжлалт арга барилыг “зөрчөөд” байхад, Түүнд итгэх хэцүү байдаг. Яагаад тэр вэ?
2. Бурхан таны цагийн хуваарийн дагуу үйлдэхгүй үед ямар санагддаг уу? Бурханы амлалт саатах үед та ямар дарамт, өдөөлт мэдэрдэг вэ?
3. Махан бие дотор төрснийг махан биеэр л авч явах ёстой гэдэг үнэнийг та амьдрал дээрээ харсан уу? Энэ нь Бурханаас төрсөн зүйлээс ямар ялгаатай байдаг вэ?
4. Та Бурханы замаар явж байгаа гэдэгтээ юун дээр үндэслэн баттай итгэдэг вэ?

Хичээл 8

10-аар бүлгийг уншина уу.

1. Цөлд Бурхан Өөрийгөө илчилдэг. Тийм юм бол, яагаад цөлд байхад Бурхан хол санагддаг вэ?
2. Бурханы ерөөлийг бус, Бурханыг Өөрийг нь дагана гэж яахыг хэлдэг вэ?
3. Дуудлага, амлалтыг Бурханаас дээр тавих нь яагаад аюултай вэ?

4. Бурхан Өөрийгөө Бичээсийн баатруудад илчилсэн загварыг харахаар цөлийн талаарх үзэл бодол чинь хэрхэн өөрчлөгдөж байна?

Хичээл 9

11-ээр бүлгийг уншина уу.

1. Сэтгэлээ хаана онгойлгохдоо бодолтой хандах нь яагаад чухал вэ? Ялангуяа цөлийн улиралд?
2. Залбирмааргүй, уншмааргүй үед залбирал, Бичээс хоёрт гүнзгийрэх нь бидний сүнслэг үндсийг хэрхэн бэхжүүлдэг вэ?
3. Их ургацын босгон дээр л таны ургацыг устгах гэсэн хүчтэй түрлэг ирдэг гэвэл, урам орж байна уу?
4. Бурханы итгэмжтэй байдал дээр төвлөрөх нь яагаад цөлийн улирлыг өөрчилдөг вэ?

Хичээл 10

12-аар бүлгийг уншина уу.

1. Цөл таныг яаж улирлын өөрчлөлтөд бэлтгэдэг вэ?
2. Өөрчлөгдөх яагаад хэцүү байдаг вэ? Өөрчлөлтөд дасан зохицоход хамгийн том саад чинь юу вэ?
3. Дарсны тулмыг шинэтгэх үйл явцаас юу нь хамгийн сонирхолтой санагдав? Яагаад сонирхолтой санагдав?
4. Шинийг хүлээж авахын тулд хуучнаа орхих хэрэгтэй. Тэгвэл таны хувьд шинийг хүлээж авах үүднээс орхих шаардлагатай ямар, ямар хуучин зүйл байна?

ХАВСРАЛТ

Бүгдэд нээлттэй аврал

Хэрэв та Есүсийг Эзэн гэж амаараа хүлээн зөвшөөрч, Бурхан Түүнийг үхэгсдээс амилуулсан гэдэгт зүрхэндээ итгэвэл, аврагдах болно. Хүн зүрхэндээ итгэн зөвт байдалд хүрч, амаараа хүлээн зөвшөөрч авралд хүрнэ.

—Ром 10:9-10

Бурхан таныг бүрэн дүүрэн амьдраасай гэж хүсдэг. Тэрбээр таныг гэхээр л сэтгэл нь дүрэлздэг бөгөөд амьдралд чинь хандсан төлөвлөгөө зэхсэн байдаг. Гэхдээ хувь тавиландаа хүрэх замыг эхлүүлэх цорын ганц арга нь: Бурханы Хүү Есүс Христээр дамжин авралыг хүлээн авах.

Есүсийн үхэл, амиллаар дамжуулан Бурхан таныг Өөрийнхөө хайртай хүү, охин болгон хаанчлалдаа угтан авах зам гаргажээ. Есүсийн загалмай дээрх тахил нь танд мөнхийн баялаг амьдралыг нээж өгчээ. Аврал нь танд өгсөн Бурханы бэлэг бөгөөд та авралыг юугаар ч олж авч чадахгүй.

Энэ үнэт бэлэгийг хүлээн авахын тулд эхлээд Бүтээгчээсээ тусгаар, дураараа амьдарсан нүглээ хүлээн зөвшөөр. Энэ нь таны хийсэн нүглийн хамаг үндэс юм. Энэ гэмшил нь авралыг хүлээн авахад амин чухал хэсэг болно. Үйлс ном дээр таван мянган хүн аврагдсан тэр өдөр Петр үүнийг тодорхой хэлсэн: “Иймээс гэмшицгээ. Гэм нүглээ үгүй болгохын тулд эргэцгээ” (Үйлс 3:19). Хүн бүр нүглийн боол болж төрснийг Бичээс мэдэгддэг. Энэ боолчлол нь санаатай дуулгаваргүй байдлын үлгэр загварыг эхлүүлсэн Адамын нүглээс үндэстэй. Гэмшил нь өөртөө бөгөөд худалчдын эцэг Сатанд дуулгавартай байх явдлаас салж, таны төлөө амиа өгсөн, шинэ Эзэнтэн Есүс Христ рүүгээ дуулгавартай эргэх сонголт юм.

Та Есүсийг Эзэнээ болгож, амьдралынхаа жолоог атгуулах ёстой. Есүсийг “Эзэн” болгоно гэдэг нь өөрт байгаа, өөрийн гэх бүхнээ - амьдралынхаа (сүнс, сэтгэл, биеийнхээ) мэдлийг өгнө гэсэн үг юм. Тэр таны амьдрал дээр төгс мэдлээ тогтооно. Үүнийг хиймэгц, Бурхан таныг харанхуйгаас чөлөөлж, Хаанчлалынхаа гэрэл, алдарт гаргана. Та үхлээс амь руу нэвтэрч, Түүний хүүхэд болно!

Хэрэв та Есүсээр дамжих авралыг хүлээн авмаар байвал, дараах залбирлыг хэлнэ үү:

*Тэнгэрийн Бурхан минь, би өөрийгөө нүгэлтэн бөгөөд
Таны зөвт байдлаас хол дутна гэдгээ хүлээн зөвшөөрч
байна. Би нүглээсээ болж мөнхийн шийтгэл авах
зохистой хүн. Гэхдээ Та намайг энэ чигээр минь
үлдээгээгүйд баярлалаа. Та миний төлөө Өөрийнхөө
цорын ганц хайртай Хүү Есүс Христийг илгээсэн.
Тэр онгон Мариагаас мэндлэж, миний төлөө миний
шийтгэлийг үүрэн Загалмай дээр үхсэн. Гэвч Тэрбээр
гурав дахь өдрөө дахин амилуулагдаж, одоо миний Эзэн
бөгөөд Аврагч болон Таны баруун гарт залран суугаа
гэдэгт би итгэж байна. Тиймээс энэ өдөр би Танаас
тусгаар, дураараа байдлаа гэмшин, амьдралаа бүхлээр
нь Есүс Эзэний мэдэлд өргөж байна.*

*Есүс ээ, Та одоо миний Эзэн бөгөөд Аврагч.
Сүнсээрээ амьдралд маань ирээд, намайг Бурханы
хүүхэд болгооч. Би урьд нь холбоотой байсан харанхуйн
юмсаасаа бүрэн салж, өнөөдрөөс эхлэн өөрийнхөө*

*төлөө амьдралгүй, харин Таны нигүүлслээр намайг
мөнх амьдруулахын төлөө Өөрийгөө өгсөн Таны төлөө
амьдарна.*

*Эзэн минь, баярлалаа. Одоо миний амьдрал бүхлээрээ
Таны гарт очлоо. Тиймээс Таны хэлснээр би одоо хэзээ ч
ичихгүй. Есүсийн нэрээр. Амень.*

Бурханы гэр бүлд тавтай морилно уу! Өөрийнхөө баярт мэдээг бусад итгэгч нартайгаа хуваалцаарай. Библид итгэдэг нутгийн чуулганд хамрагдаж, шинэ итгэлийг чинь урамшуулан дэмждэг хүмүүстэй холбогдох нь чухал шүү.

Ийнхүү та хамгийн ер бусын аян замд гарлаа. Өдөр өдрөөр Бурхантай илчлэл, нигүүлсэл, нөхөрлөлөөр өсөх болтугай!

ӨНӨ МӨНХӨӨР ХӨТЛӨГДӨХҮЙ

*Өнөөдөр ч, үүрд мөнхөд ч
үнэ цэнэтэй байх амьдрал*



Энэ амьдралын нөгөө талд юу ч байхгүй гэж хүмүүс боддог. Гэтэл Бичээс “Хүн энэ ертөнцөд хэрхэн амьдарснаараа нөгөө ертөнцөд хэрхэн амьдрахаа шийднэ” гэх. Энд л хэрхэн амьдарснаараа, тэнд авах шагнал, шийтгэлээ шийдүүлнэ.

Жон Бивэр бидэнд 2Коринт 5:9-11 дээрх зарчмыг сануулаад, хүн бүр Христийн өмнө үйлсийнхээ дагуу шүүгдэж, олон хүн мөнх насгүй зүйлд хамаг амьдралаа зориулсанаа ойлгоод цочирдохыг хэлжээ. Тэгвэл хүн яаж ач холбогдолтой амьдрах вэ? “Өнө мөнхөөр хөтлөгдөхүй” ном таныг амьдралынхаа дуудлагыг олох, хүлээж авсан бүхнээ өсгөн үржүүлэх мөнхийн зарчимд сургаж, өөрийгөө өнө мөнхөд үнэлэгдэх ажилд зориулахад чинь чиглүүлнэ.

АФФАБЕЛ

Өнө мөнх рүү өнгийх цонх
(Сонсдог жүжиг)



“Аффабел” нь Жон Бивэрийн бичсэн сонсдог жүжиг юм. Үүнд энэ дэлхийн амьдралаас цааших бодит амьдралыг өгүүлэх бөгөөд үүгээр Бурханы хаанчлалын олон үнэнийг тусган харуулдаг. Итгэгч хүмүүс өнө мөнхийн хараатай амьдрах ёстой ч, олон хүн өнө мөнх гэж юу болохыг ч мэддэггүй.

Энд та Аугаа хаан Жэйлинтэй, харанхуйн хар санаат эзэн Дагонтай, Өгөөмөр, Бие даагч тэргүүтэй гол дүрүүдтэй, Аффабел хэмээх ер бусын нутагтай бас Ганц хэмээх аймшигт хөсөр газартай танилцаарай. Гол дүрүүдийн амьдралаар дамжин зүрхний чинь үнэн төрх илчлэгдэх үед та өөрийнхөө амьдралын талаар нэгийг бодох буй за. “Аффабел” сонсдог жүжиг нь сонсогчийг нэгэнт ухааруулахын төлөө бүтээгдсэн “Өнө мөнхөөр хөтлөгдөхүй” номын жүжигчилсэн хэлбэр болно.

САТАНЫ УРХИ

*Өстөн дайсныхаа үхлийн занганаас
эрх чөлөөтэй амьдар*



“Сатаны урхи” ном нь ерөөсөө л гомдлын талаар өгүүлнэ. Гомдол нь итгэгч хүмүүсийг Бурханы хүслээс гаргахдаа тогтмол ашигладаг, дайсны хайртай урхи ажээ. Олон хүн энэ урхинд мэдээгүй явж орчихоод, орсон хойноо ч мэддэггүй.

Хүн энэ дэлхий дээр байгаа цагтаа гомдлоос дархлаатай оршиж чадахгүй ч, гомдох эс гомдохоо сонгож чадна. Гомдлыг шийдвэрлэсэн хүн л хорслыг даваад, улам хүчирхэгжиж, Бурхантай саадгүй харилцана.

Хорсол, бухимдал, хар сэр, үл итгэлцлээс чөлөөлөгдөж, Бурханы хүсэл дор алхлан, амьдралаа Бурханд бүрэн даатгаж, уучлал, эвлэрэл, баяр хөөрөөр дүүрэн амьдрахын нууцыг эндээс сураарай.

САТАНЫ УРХИ

Өстөн дайсныхаа үхлийн занганаас
эрх чөлөөтэй амьдар
(Монгол бичгээр)



“Мараната” үйлчлэл Өвөр Монгол дахь Христийн чуулганы итгэгч хүмүүсийг итгэлд бэхжүүлэхийн төлөө мөн Монгол бичгээр унших хүсэлтэй бүх хүнд зориулж зохиолч Жон Бивэрийн Монгол хэл дээрх (кирилл бичиг дээрх) номуудыг Монгол бичиг дээр хөрвүүлэн буулгаж байгаа бөгөөд анхны бүтээл болох “Сатаны урхи” номоо та бүхэнд өргөн барьж байна.

Энэ номыг CloudLibrary.org хаяг дорх “Монгол бичиг” гэсэн хэсгийг сонгоод, үнэ төлбөргүй татаж авна уу. Монгол чуулганы энэ бэлэгийг Өвөр Монгол дахь Христийн итгэл нэгт ах, эгч дүүдээ болоод Монгол бичигт нэвтэрсэн бүх хүнд түгээн дэлгэрүүлээрэй!

CloudLibrary.org  зочлоорой!

САЙНЫГ ҮҮ, БУРХАНЫГ ҮҮ?

Бурхангүй “сайн” сайн биш байдгийн учир



Сайн л бол, Бурханаас байх учиртай. Тийм үү? Өнөөдөр “сайн” хийгээд “Бурхан” гэдэг хоёр үгийг ижил утгатай үгс шиг хэрэглэх болжээ. Бид “сайн” гэж үздэг зүйлсээ Бурханы хүсэлтэй төгс эгнэх учиртай гэж итгэдэг. Өгөөмөр, даруу, шударга зан чанар нь сайн юмс. Амиа хоохойлох, тоомжиргүй зан, харгислал нь муу юмс. Ядах юмгүй ялгачихмаар харагдаж байна. Гэхдээ ингээд л боллоо юу? Сайныг ялгахад тийм амархан юм бол, Библи яагаад сайн, мууг ялгах хараатай бай гэж хэлсэн юм бол?

Энэ ном нь бас л нэгэн төрлийн хувь хүний хөгжлийн гарын авлага биш юм. Энэ ном танаас зүгээр нэг сайн сайхан, зөв хүн болохыг шаардахгүй. Энэ ном таны Бурхантай тогтоосон харилцааг хэзээ ч байгаагүй өндөрлөгт гаргаж, амьдралыг чинь эд эсээр нь ширхэглэн сэгсэрч, үндсээр нь эргүүлнэ.

ГЭРЛЭЛТИЙН ТҮҮХ

Гэрлэлтээ авар



Эртээ урьдын цагт... Гэрлэлт бол үүрд өнө зүйл. Энэ нь нэг эрэгтэй, нэг эмэгтэйг холбож зангиддаг гэрээ бүхий харилцаа юм. Энэ холбоо тэднийг бүтээгдсэн анхны зорилгоор нь хөглөж, хүчирхэгжүүлнэ. Тэд тусдаа биш, хамтдаа байхдаа л хүчтэй. Харин энэ бүхний эхлэл нь хурим юм. Хурим нь амар сайхандаа жаргахын төлөө амьдралын босгыг давж буй, ариун нандин үйл явдал болой. Энэ амьдралын төлөөх сонголт бүр, үйлс бүр чухал. Зүрхээрээ нийлж, гараараа хөтлөлцсөн нөхөр, эхнэр хоёр тааж мэдэшгүй ирээдүйг чиглэн Бүтээгчийн хайраар амьдралаа сүндэрлүүлнэ.

Гэтэл бид энэ хайрын түүхээс хагацжээ. Тэгвэл “Гэрлэлтийн түүх” номоороо Жон, Лиза хоёр гэрлэлтэд хандсан Бурханы анхны төлөвлөгөөг дэлгэж байна. Та гэрлэсэн байна уу, гэрлэж амжаагүй байна уу, сүй тавьсан байна уу – Бурханы их хайрын түүхийн нэгээхэн хэсэг мөн болой.

АЙДСЫГ ЯЛАХУЙ

Өөрийгөө яллахгүйгээр, “Үгүй” гэж хэлж сур. Хүнд таалагдахын төлөө бус, өөртөө итгэлтэй байж сур



Айж сүрдэж үзээгүй хүн байхгүй. Хэрхэн айдаг, хэрхэн айдсаас сэргийлэхийг мэдэх үү? Энэ амин асуудлыг шийдэх л хэрэгтэй.

Хөшөөж байгаа сүрдүүлэгтэй халз тулсан хүн л өөртөө итгэлтэй, зоригтой амьдарна. 2Тимот 1:7 дээр “Бурхан бидэнд айдсын сүнсийг өгөөгүй” гэдэг. Тиймээс Христийн өгсөн эрх чөлөөн дор зоригтой амьдар.

Энэ ном айдсын уг үндсийг тайлна. Айдас сүрдүүлгийг тасдаж, Эзэний өгсөн бэлэг авьяасыг хэрэглэж, эрх чөлөөгөөр нь амьдар. Зовнил, сэтгэлийн дарамт, цөхрөл, эргэлзээ самуурлаас эрх чөлөөтэй амьдар. “Айдсыг ялахуй ном” танд Бурханы эрх мэдэл дор хүчирхэг амьдрахыг зааж өгнө.

МЯТРАШГҮЙ

Хэзээ ч бууж өгөхгүй байх хүч



Хүн бүр бэрхшээлтэй тулгардаг. Хүн зовлонг яаж туулдгийг та сайн мэднэ. Зогсоод, атгаа чангалаад, амьд л гарчих юмсан гэсэн горьдлогоор зовлонгийн хөлгүй далайд шидэгддэг. “Амьд л гарбал болох минь тэр.” Гэхдээ энэ бүх сорил таны амьдралыг өөрчлөхийн тулд ирсэн байвал яах уу? Танд нүүрлэсэн дайсагнал нь таныг итгэл, төлөвшлийн дараагийн төвшинд дэвшүүлэх зорилготой байвал яах уу? Та зовлон дундаас амьд гарахаар барахгүй, ялагч болоод гарахаар бүтээгдсэн байвал яах уу?

Энэ ном танд Бурханы Үг, залбирал, зовлон, эсэргүүцэл, Бурханаас танд хандсан хувь тавилангийн биеллийн талаар амьдрал өөрчлөгч үнэнийг зааж өгнө. Бурханы хүүхэд та дайсагналыг хүчээ болгон ашиглаж, амьдралаа сайнаар өндөрлөх чадалтай!

АРИУН СҮНС

Түүнтэй танилцахуй



Анхны дагалдагч нар Есүстэй 3 жил хамт байж, Түүний заасан бүхнийг сонсож байсан. Харин загалмайд цовдлогдохынхоо өмнө Есүс: “Би явж Ариун Сүнс ирэх нь та нарт илүү дээр юм” гэжээ. Хэрэв Есүстэй өдөр бүр байсан дагалдагч нарт Ариун Сүнс амин хэрэгтэй байсан юм бол, бидэнд бүр их хэрэгтэй бус уу?

Жон Бивэр танд Ариун Сүнсийг танилцуулж, Ариун Сүнсний мөн чанар, хүч чадлыг заажээ. Таны итгэлийн төлөвшил ямар ч төвшинд байсан “Ариун Сүнс: Түүнтэй танилцахуй” ном танд Бурханыг улам ихээр дотно танин мэдүүлнэ.

СЭЛЭМТЭЙ ОХИД

Загалмайгаа жинхэнэ баатар шиг үүрье



Бурханы Үг болох илдний тухай судлах нь илдийг сугалж хэрэглэхээс амархан бөгөөд таатай байдаг. Охид бид тэнгэрийг газартай холбох цаг болжээ. Дэлхий даяар эмэгтэйчүүд алив гадуурхал, бэлгийн мөлжлөг, хүчирхийлэлийн бай болсоор байна. Лиза Бивэр энэ номдоо эмэгтэйчүүдийн өнгөрснийг биш, харин ирээдүйг өгүүлжээ.

Тиймд Бурханы дайчин охид оо, эр зоригтойгоор босоод, ялгах чадвараа ашиглан, уучилж, мэргэн байж, сэлмээ эргүүлэн баатарлаг үйлсийг бүтээгээрэй.

КРИПТОНИТЫГ УСТГА

Хүчийг чинь сорогч зүйлийг устга



Супермэнд дайснаа дарах ер бусын хүч байдаг шиг, Христийн дагалдагч бидэнд ч тийм нэгэн хүч бий. Гэвч криптонит гэгч нэгэн бодис Супермэний хүчийг ч, дагалдагч бидний хүчийг ч ховх сордог. Мэдээж Супермэн, криптонит хоёр зохиомол зүйлс боловч, сүнсний криптонит нь жинхэнэ зүйл юм.

Анхны чуулганы итгэгч нарт байсан тэнгэрийн хүч яагаад өнөөгийн бидэнд байхгүй байгааг энэ ном тайлбарлана. Түүнчлэн криптонит гэж юу болох, яаж үйлчилдэг болох бас үүнийг хэрхэн устгахыг зааж өгнө.

Энэ номыг амьдралаа жинхэнээсээ өөрчлөх хүсэлтэй Христийн дагалдагч нарт зориулав. Уншсан шиг уншаарай!


CloudLibrary.org



зочлоорой!



Жон Бивэрийн Facebook
хуудсанд тавтай морилно уу!



Та манай хуудсанд  дарж, хэрэгтэй
мэдээлмээ цаг алдалгүй хүлээн авна уу.

facebook.com/JohnBevereMongolia/



МЕССЕНЖЕР ИНТЕРНЭЙШНЭЛ нь Бурханы өөрчлөгч хүчийг хувь хүн, гэр бүл, чуулган, үндэстэнд ухааруулж, бодитоор харахад нь туслах зорилготой байгууллага болно. Энэ ухаарал нь хүчирхэгжсэн амьдрал, өөрчлөгдсөн нийгэм, дэлхий дээрх шударга бус зүйлст хариу барих эрч хүчтэй үйлсийг дагуулдаг.



Cloud Library нь даян дэлхийн пастор, удирдагч нарт зориулагдсан, төрөлх хэлээрээ танилцаж болох онлайн дижитал сургалтын сан юм.

CloudLibrary.org хаягаар нэвтэрч, Жон, Лиза Бивэрийн **цахим ном, видео, аудио, сургаал, сонсдог ном, Библи, сонсдог жүжиг** зэрэг 100 гаруй хэл дээрх сургалтын материалтай танилцаарай!

QR коодыг сканердаж илүү их мэдээллийг олж аваарай
CloudLibrary.org



БУРХАН МИНЬ, ТА ХААНА БАЙНА?!

ЦОГЦ СУРГАЛТЫН МАТЕРИАЛ

Таны уншиж байгаа ном нь Жон Бивэрийн бичсэн “*Бурхан минь, Та хаана байна?!*” цогц сургалтын материалын нэг хэсэг юм. Номоо уншиж, дагалдах DVD бүхий сургалтын материал, CloudLibrary.org хаягаас татаж авч хэрэглэхэд зориулагдсан сургалтын материалыг хэрэглэснээрээ, та энэхүү амьдрал өөрчлөгч, эрч хүчтэй сургаалын хэсэг бүрийг өөрийн болгож чадна. Зүй ёсоор суралцах аваас, энэ нь таны Христэд итгэх амьдралд нөлөөлж, Бурханы төлөө илүү ихийг хийж чадвартай болгоно.

“Бурхан минь, Та хаана байна?!” цогц сургалтын материалд дараах зүйлс багтсан болно:

- “Бурхан минь, Та хаана байна?!” ном
Цаасан хэвлэл бүхий ном
PDF цахим ном
- “Бурхан минь, Та хаана байна?!” DVD
Номыг дагалдах диск дээр энэхүү цогц сургалтын материалыг тэр чигээр нь дижитал хэлбэрээр хэвлэсэн болно. Энэхүү диск нь гэрийн DVD тоглуулагч дээр уншигдахгүй, зөвхөн таблет, компьютер юмуу ухаалаг утас дээр л уншигдана.
- “Бурхан минь, Та хаана байна?!” сонсдог ном
“Бурхан минь, Та хаана байна?!” сонсдог ном нь Монгол хэл дээр уншигдсан, MP3 форматтай, 12 бүлэг бүхий ном болно.
- “Бурхан минь, Та хаана байна?!” видео сургаал
MP4 форматаар бичсэн, 11 бүлэг бүхий видео хичээл.
- Нэмэлт материал
Эдгээрээс гадна DVD дотор “Аффабел” сонсдог жүжиг, “Өнө мөнхөөр хөтлөгдөхүй”, “Сайныг уу, Бурханыг уу?” цахим ном зэрэг бусад материалыг багтаасан болно.



ЭНЭ БҮХ ЦОГЦ СУРГАЛТЫН МАТЕРИАЛ НЬ ТАНД БАРЬЖ БУЙ БЭЛЭГ ШҮҮ!



Энэхүү DVD дээрх бүх материалыг чөлөөтэй хувилж, тарааж, найзууддаа имэйлээр илгээж, хуулж, Word документ дээр хуулж, сургаалыг нь чуулгандаа илгээж, бусдын хэрэглээнд зориулж интернет дээр тавьж болно. Эдгээрийг Бурханы үгийн сайн сургаал, хүчтэй итгэлийн амьдралаар дутагдаж байгаа газар бүрт хүргэж, тараагаарай.

“Бурхан минь, Та хаана байна?!” цогц сургалтын материалын нэмэлт тайлбар:



DVD дээрх файл нь ахуйн хэрэглээнд зориулагдсан видео тоглуулагч дээр уншигдахгүй, гагцхүү компьютер, дижитал тоглуулагч дээр л уншигдана.



MP4 видео файл нь таблет, компьютер дээр уншигдана.



MP3 аудио файл нь аудио медиа тоглуулагч, ухаалаг утас, компьютер дээр уншигдана.



PDF дижитал файл нь таблет, компьютер дээр уншигдана.

Олон улсын хэл дээрх материалыг дараах цахим хуудаснаас татаж авах боломжтой.




CloudLibrary.org

БУРХАН МИНЬ, ТА ХААНА БАЙНА?!

СУРГАЛТЫН DVD

ЗӨВХӨН
КОМПЬЮТЕРТ
ХЭРЭГЛЭНЭ



Бусад видеог дараах
цахим хуудаснаас үзэх,
татаж авах боломжтой:



CloudLibrary.org

ЖОН БИВЭР



MESSENGER
INTERNATIONAL
MessengerInternational.org



Жон, Лиза Бивэрийн энэхүү болоод бусад цогц сургалтын материал нь Мессенжер Интернэйшнэлийн үнэ төлбөргүй видео суваг дээр болон доорх цахим хуудас дээр бий.



CloudLibrary.org

Монгол болоод бусад хэл дээрх материалыг Youtube.com
Youku.com тэргүүтэй бүхий л олон нийтийн медиа
хуудсаас үзэж болно.

ТА ХЭЦҮҮ ҮЕИЙГ ТУУЛАХДАА ЗАРИМДАА УЧРАА ОЛОХГҮЙ ТӨӨРӨЛДӨӨД: “БУРХАН МИНЬ, ТА ХААНА БАЙНА?!” ГЭЖ ГАЙХШИРДАГ УУ?

Өмнө нь Бурхан ярьдаг байснаа одоо таг дуугүй болжээ. Өмнө нь та итгэлээр явдаг байсан бол, одоо Бурханы оршихуй бараа сураггүй болжээ. Тэгвэл Бурханаас амлалт хүлээж аваад, энэ амлалт биелэхийг харах хоёрын дунд оршдог дамжин өнгөрөхөд тавтай морил.

Гэхдээ энэ нь ямар ч зорилгогүй хөсөр газар биш юм. Бурхан цөлөөр дамжуулан биднийг хувь тавиланд маань бэлтгэн, боловсруулдаг - гэхдээ гагцхүү та зөв хариу үйлдсэн тохиолдолд шүү. Олон хүний боддог шиг - энэ улирлаар туулах нь зүгээр л Бурханыг хүлээгээд суух явдал биш юм. Цөл дундуур жолоогоо зөв залахад таны үүрэг оройл их. Морин тойруулгаар эргэлдэж цагаа гарздах гээгүй л юм бол, цөлийг мэддэг байх хэрэгтэй.

Нүд тайлсан энэхүү номоороо бестселлер зохиолч Жон Бивэр таныг хуурай, бэрх улиралдаа жолоогоо зөв залсаар, Бурханы зэхсэн бүхэнд нэвтрэхэд чинь туслах Библийн түлхүүр болсон ухаарал, гүн түүхээр өсгөн боловсруулж байна.



СУРГАЛТЫН DVD-Д ХАВСАРГАВ



ЖОН БИВЭР нь Мессенжер Интернэйшнэл байгууллагын үндэслэн байгуулагч бөгөөд Бурханы найраагүй үнэнийг халуун сэтгэлээр, зоригтой заадаг номлогч төдийгүй, шилдэг борлуулалттай номын зохиолч хүн билээ. Газар газрын, үндэстэн үндэстний, боломжтой боломжгүй чуулган, удирдагч нарыг Бурханы үгээр хангах нь Жоны чин хүсэл. Өнөөгийн байдлаар Жоны материал 100 гаруй хэл дээр орчуулагдан, сая сая хувиар тараагдан, даян дэлхийн пастор, удирдагч нарын гарт хүрээд байна.



Cloud Library

Бусад материалыг дараах цахим хуудаснаас:
CloudLibrary.org



MESSENGER
INTERNATIONAL
MessengerInternational.org

Энэ ном нь танд зориулсан
зохиолчийн бэлэг бөгөөд
ХУДАЛДАХЫГ ХОРИГЛОНО

ИЛҮГ ЭНДЭЭС

